



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ

АНХАН ШАТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ШАЛГУУР



2026 он

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:

Б.Болортуяа	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Тусламж, үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэлийн албаны дарга
Л.Бор	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Тусламж, үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэлийн албаны ахлах мэргэжилтэн
А.Баярзаяа	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Тусламж, үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэлийн албаны мэргэжилтэн
Б.Болорчимэг	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Тусламж, үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэлийн албаны мэргэжилтэн
Д.Мягмарцэрэн	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ерөнхий мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Өрхийн анагаах ухааны тэнхимийн эрхлэгч, Монгол-Японы эмнэлгийн үйлчлүүлэгчийг дэмжих албаны дарга, Анагаах ухааны доктор, профессор
Т.Алимаа	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Клиникийн профессор
Л.Баярцэцэг	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Гурван гал нэгдсэн эмнэлгийн эмнэлзүй эрхэлсэн захирал
Б.Дулмаа	Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны чанарын менежер
Ж.Нямсүрэн	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Халдварт өвчний тандалт, судалгааны албаны дарга
С.Оюунгэрэл	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн албаны халдвар судлаач эмч
Э.Долгорсүрэн	Баянгол дүүргийн Учрахуй өрхийн эрүүл мэндийн төвийн Эмнэлгийн тусламж, үйлчилгээ чанар, аюулгүй байдлын багийн дарга, хүүхдийн их эмч
П.Ариунзаяа	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Өрхийн анагаах ухааны тэнхимийн багш

ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:

М.Наранпүрэв	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Анагаах ухааны доктор, Дэд профессор
М.Одгэрэл	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал
Н.Дашдондов	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн

**АНХАН ШАТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ШАЛГУУР**

I ХЭСЭГ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ/ӨВЧТӨН ТӨВТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

БҮЛЭГ 1. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ/ӨВЧТӨН ТӨВТЭЙ СОЁЛ

БҮЛЭГ 2. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ТАСРАЛТГҮЙ БАЙДАЛ

БҮЛЭГ 3. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДМЭЛ БАЙДАЛ

БҮЛЭГ 4. ДҮРС ОНОШИЛГОО, ЛАБОРАТОРИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

БҮЛЭГ 5. МЭС ЗАСЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

БҮЛЭГ 6. ЭМИЙН МЕНЕЖМЕНТ БА ХЭРЭГЛЭЭ

II ХЭСЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТ

БҮЛЭГ 7. ЗАСАГЛАЛ, УДИРДЛАГА, МАНЛАЙЛАЛ

БҮЛЭГ 8. ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ

БҮЛЭГ 9. ЧАНАР БА ГҮЙЦЭТГЭЛИЙН САЙЖРУУЛАЛТ

БҮЛЭГ 10. ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ БА ХЯНАЛТ

БҮЛЭГ 11. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

БҮЛЭГ 12. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН БА БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН МЕНЕЖМЕНТ,
АЮУЛГҮЙ БАЙДАЛ

БҮЛЭГ 13. МЭДЭЭЛЛИЙН МЕНЕЖМЕНТ

ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Энэхүү магадлан итгэмжлэлийн баримт бичиг нь эрүүл мэндийн байгууллага болон үнэлгээний шинжээчдэд ашиглахад хялбар, ойлгомжтой байх үүднээс дараах шатлал бүхий тогтсон бүтэцтэйгээр боловсруулагдсан.

Бүлэг: Нийт 13 бүлэгтэй. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлын бүхий л хэсгийг цогцоор нь хамарсан үндсэн чиглэлүүд.

Шалгуур: Тухайн бүлгийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагын хүрэх ёстой зорилт болон тавигдах үндсэн шаардлага.

Хэмжих үзүүлэлт: Тухайн шалгуурыг бодитоор хэрхэн хэрэгжүүлж байгааг нотлон харуулах, хэмжиж үнэлэх боломжтой үзүүлэлтүүд.

Эдгээр 13 бүлэг нь хамтдаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдал, чанар, аюулгүй байдлын бүхий л бүрэлдэхүүн хэсгийг цогцоор нь хамарна.

Доорхи хүснэгтэд бүлэг бүрт хамаарах шалгуур болон хэмжих үзүүлэлтийн тоог нэгтгэн харуулав.

№	Бүлгийн нэр	Шалгуурын тоо	Хэмжих үзүүлэлтийн тоо
I ХЭСЭГ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ/ӨВЧТӨН ТӨВТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ			
1.	Үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй соёл	9	42
2.	Тусламж, үйлчилгээний хүртээмж, тасралтгүй байдал	9	43
3.	Тусламж, үйлчилгээний нэгдмэл байдал	23	163
4.	Дүрс, оношилгоо, лабораторийн тусламж, үйлчилгээ	9	79
5.	Мэс заслын тусламж, үйлчилгээ	14	52
6.	Эмийн менежмент ба хэрэглээ	13	58
II ХЭСЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТ			
7.	Засаглал, удирдлага, манлайлал	11	53
8.	Хүний нөөцийн менежмент	8	35
9.	Чанар ба гүйцэтгэлийн сайжруулалт	8	35
10.	Халдварын сэргийлэлт ба хяналт	12	62
11.	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	8	42
12.	Хүрээлэн буй орчин ба барилга байгууламжийн менежмент, аюулгүй байдал	9	44
13.	Мэдээллийн менежмент	12	61
Нийт		145	769

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-д эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг олон улсын жишигт хүргэж, иргэн бүрд ээлтэй, хүртээмжтэй тогтолцоог бэхжүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Уг зорилтын хүрээнд магадлан итгэмжлэлийн тогтолцоог шинэчлэн сайжруулах, эрүүл мэндийн байгууллагуудад чанарын тасралтгүй хөгжлийн соёлыг төлөвшүүлэх шаардлагад үндэслэн эмнэлгийн магадлан итгэмжлэх энэхүү шинэчилсэн шалгуурыг боловсрууллаа.

Энэхүү баримт бичгийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн "GAHAR" байгууллагын анхан шатны эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн үзэл баримтлал, үндсэн зарчимд тулгуурлан боловсруулсан бөгөөд олон улсын стандартыг Монгол Улсын эрүүл мэндийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, хууль эрх зүйн орчин, хүний нөөц болон дэд бүтцийн онцлогт нийцүүлэн боловсруулснаараа онцлогтой.

Шалгуурын үндсэн зорилго нь эмнэлгийг зөвхөн "шалгах, хянах" бус, харин байгууллага дотоод үйл ажиллагаагаа эргэн харах, өвчтөний аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, улмаар "Тасралтгүй сайжрах соёл"-ыг эмнэлгийн бүхий л түвшинд төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Шинэчилсэн магадлан итгэмжлэх шалгуур нь байгууллагын үйл ажиллагааг цогцоор нь үнэлэх зорилгоор 2 үндсэн хэсгээс бүрдэж байна.

I ХЭСЭГ: ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ/ӨВЧТӨН ТӨВТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ. Энэ хэсэгт үйлчлүүлэгч эмнэлэгт хандахаас эхлээд эмнэлгээс гарах хүртэлх бүх үйл явц дахь хүртээмж, тасралтгүй байдал, өвчтөний үнэлгээ, эрх, аюулгүй байдлын олон улсын зорилтууд болон эмийн менежментийг үнэлэх бүлгүүд багтсан.

II ХЭСЭГ: ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТ. Энэ хэсэгт байгууллагын засаглал ба манлайлал, барилга байгууламж болон дэд бүтцийн аюулгүй байдал, эрүүл мэндийн технологи, мэдээлэл болон хүний нөөцийн удирдлага, халдварын сэргийлэлт хяналт, чанар болон өвчтөний аюулгүй байдал зэрэг эмнэлгийн менежментийн тогтолцоог үнэлэх шалгуурууд багтсан болно.

I ХЭСЭГ
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ/ӨВЧТӨН ТӨВТЭЙ
ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

БҮЛЭГ 1. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ/ӨВЧТӨН ТӨВТЭЙ СОЁЛ

Тойм

Үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй тусламж, үйлчилгээ бол үйлчлүүлэгч/өвчтөнийг дээдэлдэг орчин үеийн хандлага юм. Энэ хандлага нь өвчин, эмгэг болон эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадварт тулгуурладаг уламжлалт арга барилаас ялгаатай ба үйлчлүүлэгч/өвчтөний хэрэгцээ, хүсэл сонирхол, үнэт зүйлсийг эрхэмлэхийн зэрэгцээ тэднийг тусламж, үйлчилгээний идэвхтэй оролцогч гэж үздэг.

Үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй соёлыг төлөвшүүлэхэд эрүүл мэндийн байгууллагын бүх түвшний оролцоог хангах шаардлагатай. Үүнд: эрүүл мэндийн ажилтныг үр дүнтэй харилцааны ур чадварт сургах, үйлчлүүлэгч/өвчтөний хүсэл, сонголтыг дээдэлсэн тусламж, үйлчилгээний заавар боловсруулах, үйлчлүүлэгч/өвчтөний эрх, үүрэг, хараат бус, бие даасан байдлыг дэмжсэн орчныг бүрдүүлэх зэрэг багтана.

Эрүүл мэндийн ажилтан нь үйлчлүүлэгч/өвчтөний өвөрмөц хэрэгцээ, үнэт зүйлс, итгэл үнэмшил, шашин шүтлэг, хувийн бусад хүчин зүйлийг хүндэтгэн үзэж, тусламж, үйлчилгээтэй холбоотой шийдвэр гаргахад харгалзан үзэх үүрэгтэй.

Үйлчлүүлэгч/өвчтөн нь тусламж, үйлчилгээний боломжит хувилбар болон гарах үр дүнгийн талаар үнэн зөв, бүрэн мэдээлэл авснаар эмчилгээтэй холбоотой шийдвэр гаргахад оролцох нөхцөл бүрдэнэ.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад таатай уур амьсгал бүрдүүлснээр үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй тусламж, үйлчилгээг тогтвортойгоор үзүүлэх боломжтой юм. Хүндэтгэлтэй харилцаа үүсгэх, үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийг тусламж, үйлчилгээнд татан оролцуулах, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах зэрэг нь үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, эмчилгээний үр дүн, тусламж, үйлчилгээний чанарт эерэг нөлөө үзүүлдэг.

Үнэлгээний явцад тухайн байгууллага нь үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй соёлыг хэрхэн тодорхойлж, хэрэгжүүлж, тогтвортой байдлыг хангаж байгааг үнэлнэ. Үнэлгээг холбогдох баримт бичгийг хянах, үйлчлүүлэгч/өвчтөнийг мөшгөн үнэлгээ хийх, эрүүл мэндийн ажилтан болон эмнэлгийн удирдлагатай ярилцах замаар хийнэ. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад сумын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төв, тосгоны эрүүл мэндийн төвийг хамруулах ба цаашид “Төв” гэнэ.

Энэ бүлэгт хамаарах шалгуурыг хүснэгтэд нэгтгэн харуулав.

1.1	Удирдлага болон ажилтан нь үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй соёлыг төлөвшүүлж, дэмжин ажиллана.
1.2	Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийн эрхийг хамгаалж, үүргийг хэрэгжүүлэх боломжоор хангана.
1.3	Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлд зориулсан сургалт зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр хангасан байна.
1.4	Зарим ажилбарын өмнө үйлчлүүлэгч/өвчтөнөөс таниулсан зөвшөөрөл авна.

1.5	Үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй тусламж, үйлчилгээний хүлээлгийн орчинг бүрдүүлнэ.
1.6	Тусламж, үйлчилгээний явцад үйлчлүүлэгч/өвчтөний нэр төр, хувийн нууцыг хамгаална.
1.7	Үйлчлүүлэгч/өвчтөний эд зүйлстэй холбоотой байгууллагын хүлээх хариуцлага
1.8	Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийн санал, хүсэлтэд үндэслэн тусламж, үйлчилгээг сайжруулна.
1.9	Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүл нь амаар болон бичгээр гомдол гаргах боломжтой байна.

ШАЛГУУР, АГУУЛГА, ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур 1.1

Удирдлага болон ажилтан нь үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй соёлыг төлөвшүүлж, дэмжин ажиллана.

Агуулга

Үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд оновчтой төлөвлөлт, үр дүнтэй хэрэгжилт, шат дараалсан хяналт-шинжилгээ чухал ач холбогдолтой. Үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй соёлыг бэхжүүлэх үндсэн нөхцөл нь байгууллагын ажилтанд шаардлагатай мэдээлэл, мэдлэгийг олгон, оролцоог нь хангах явдал юм.

Чанарын баг нь үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй соёлыг төлөвшүүлэх зорилгоор үйлчлүүлэгч/өвчтөний туршлага, сэтгэл ханамж, санал, гомдолтой холбоотой дүрэм, журам болон зохицуулалтын хүрээний асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргах үүрэг хүлээнэ.

Төв нь үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй тусламж, үйлчилгээг нэвтрүүлэх санал, санаачилгыг дэвшүүлж, хэрэгжүүлэх стратегийг тодорхойлон, эрүүл мэндийн ажилтны оролцоотойгоор хэрэгжүүлнэ. Энэ үйл ажиллагааны хүрээнд журам боловсруулан, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг төлөвлөн, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах ажлыг зохион байгуулна. Төв нь үйлчлүүлэгч/өвчтөнд мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй тусламж, үйлчилгээний соёлыг бүрдүүлэхэд тулгамдаж буй асуудал болон эрсдэлийг илрүүлэн, бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Соёлыг өөрчлөх зорилгоор богино хугацааны үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлж, өдөр тутмын үйл ажиллагаанд төлөвшүүлэхийг зорих нь зүйтэй.

Үнэлгээ хийх чиглэл

- Төвийн удирдлагатай ярилцаж, үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй соёлыг бүрдүүлэх чиглэлээр баталсан журам, үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлсэн арга хэмжээ, гарсан үр дүнгийн талаар тодруулна.

- Эрүүл мэндийн ажилтантай ярилцаж, үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй тусламж, үйлчилгээний соёлыг төлөвшүүлэх талаар гарсан санаачилга, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг нь асууж үнэлнэ.
- Чанарын багийн чиг үүрэгт үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй соёлыг бүрдүүлэх үйл ажиллагаа туссан эсэх, чиг үүргийн хүрээнд хийсэн хуралдааны тэмдэглэл, хугацаа зэргийг үзнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Чанарын багийн төлөвлөгөөнд үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг тусгасан байна.©
	2	Чанарын баг нь улирал тутам хуралдаж, хурлын тэмдэглэл хөтөлсөн байна.©
	3	Эрүүл мэндийн ажилтан нь үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй соёлын зарчим, хэрэгжилтийн талаар мэдлэгтэй байна.
	4	Удирдлага нь эрүүл мэндийн ажилтны санаачилга, оролцоог дэмжиж, үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.
	5	Үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй тусламж, үйлчилгээний чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тогтмол үнэлж, зөвлөмжийг тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулахад ашигладаг.

Шалгуур 1.2

Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийн эрхийг хамгаалж, үүргийг хэрэгжүүлэх боломжоор хангана.

Агуулга

Үйлчлүүлэгч/өвчтөн нь өөрт хуулиар олгосон эрх, үүргийн талаар мэдлэгтэй байх ёстой бөгөөд мэдэхгүй бол төв нь түүнд мэдлэг олгох үүрэг хүлээнэ.

Эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүл нь өөрийн эрх зөрчигдсөн талаар нээлттэй мэдээлэх боломжтой байх ёстой.

Төв нь эрүүл мэндийн ажилтанд үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийн эрхийг хамгаалахад тэдний гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон зааварчилгаа өгч, эрхийг нь хамгаалах үүрэгтэй. Эрүүл мэндийн ажилтан нь үйлчлүүлэгч/өвчтөний соёл, сэтгэл зүй, шашин шүтлэг болон бусад хувийн онцлогт хүндэтгэлтэй хандана. Шаардлагатай тохиолдолд эрэгтэй болон эмэгтэй хүнд зориулсан өрөөнд үйлчилгээ үзүүлнэ.

Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүл нь тусламж, үйлчилгээнд өөрийн хүлээх үүргийг ойлгож, хэрэгжүүлэх боломжоор хангагдсан байх ёстой.

Төв нь эрүүл мэндийн ажилтанд үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийн эрхийг хамгаалах, үүргийг хэрэгжүүлэх боломжоор хангахад шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох зорилгоор журам боловсруулж, хэрэгжүүлнэ.

Журамд үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийн эрхийг дараах байдлаар тусгасан байна.Үүнд:

- а) Байгууллагын дүрэм, журам, ёс зүйн хэм хэмжээнд үйлчлүүлэгч/өвчтөн болон гэр бүлийн эрхийг тусгасан байх

- b) “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчимд тулгуурлах
- c) Тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн ажилтны нэрийг мэдэх эрх
- d) Хувь хүний үнэт зүйл, итгэл үнэмшил, хүсэл сонирхол, сонголтыг хүндэтгэсэн тусламж, үйлчилгээ авах эрх
- e) Эмчилгээ, асаргаа, сувилгаатай холбоотой мэдээлэл авах, энэ талаар шийдвэр гаргахад оролцох эрх
- f) Тусламж, үйлчилгээ, эмчилгээнээс татгалзах эрх
- g) Аюулгүй байдал, нэр төр, хувийн нууц, хувийн орон зайг хамгаалуулах эрх
- h) Өвдөлтийг үнэлүүлэх болон намдаах үйлчилгээ авах эрх
- i) Санал, гомдол гаргах, шийтгэл, дарамтад өртөхгүй байх эрх

Үйлчлүүлэгч/өвчтөн болон тэдний гэр бүлийн хүлээх үүргийг журамд дараах байдлаар тусгана. Үүнд:

- a) Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүл нь эмнэлгийн ажилтанд өвчний түүхийн талаар үнэн зөв, тодорхой мэдээлэл өгөх үүрэгтэй.
- b) Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүл нь эрүүл мэндийн байгууллагын дүрэм, журмыг дагаж мөрдөх үүрэгтэй.
- c) Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүл нь эрүүл мэндийн ажилтан ба бусад үйлчлүүлэгч/өвчтөнг хүндэтгэх үүрэгтэй.
- d) Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүл нь эмчийн заавар, зөвлөмжийг дагаж мөрдөх үүрэгтэй.

Үнэлгээ хийх чиглэл

- Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийн эрх, үүргийг тусгасан журмыг үнэлнэ.
- Эрүүл мэндийн ажилтантай ярилцаж, журмын талаарх мэдлэгийг үнэлнэ.
- Үйлчлүүлэгч/өвчтөний эрх, үүргийн талаарх мэдээллийг ил тод байршуулсан эсэхийг ажиглаж үнэлнэ.
- Үйлчлүүлэгч/өвчтөний эрхийг хэрхэн хангаж байгааг бодитоор үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийн эрх, үүргийг тусгасан журамтай байна.®
	2	Ажилтан нь үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийн эрх, үүргийн талаар мэдлэгтэй, тэдний эрхийг хамгаалах үүргээ ухамсарласан байна.
	3	Үйлчлүүлэгч/өвчтөний эрх, үүргийн тухай мэдээллийг ил тод байршуулсан байна.
	4	Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлд эрх, үүргийн талаарх мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр хүргэдэг байна.
	5	Үйлчлүүлэгч/өвчтөний эрх, үүрэг зөрчсөн тохиолдлыг бүртгэж, дүн шинжилгээ хийн, арилгах чиглэлээр төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллана.

Шалгуур 1.3

Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлд зориулсан сургалт зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр хангасан байна.

Агуулга

Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлд зориулсан сургалт зохион байгуулснаар тэдэнд тусламж, үйлчилгээний үйл явцыг ойлгоход дэмжлэг үзүүлж, мэдээлэлд тулгуурласан шийдвэр гаргах чадамжийг нь нэмэгдүүлдэг. Эрүүл мэндийн боловсрол олгох үйл явц нь эмч, сувилагч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн зэрэг олон хүний оролцоонд тулгуурлана.

Төв нь үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлд эрүүл мэндийн боловсрол олгох үйл явцыг тодорхойлсон журам боловсруулж, хэрэгжүүлэх ёстой. Журам нь дараах агуулгатай байна. Үүнд:

- a) Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийн сургалтын хэрэгцээг тодорхойлох
 - 1. Өвчний онош болон одоогийн биеийн байдал
 - 2. Эмчилгээний төлөвлөгөө
 - 3. Бусад эрүүл мэндийн байгууллагаас шилжиж ирсэн талаарх мэдээлэл
- b) Эрүүл мэндийн боловсрол олгоход эмнэлгийн мэргэжилтнүүд багаар ажиллах
- c) Сургалтын арга, хэлбэр нь үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийн үнэт зүйл, мэдээлэл хүлээн авах чадварт нийцсэн, тэдэнд ойлгомжтой байх
- d) Сургалтын үйл явцыг баримтжуулсан байх (сургалтын удирдамж, хөтөлбөр, бүртгэл, зураг, бичлэг, тайлан, сургалт зохион байгуулсан ажилтан, сургалтын хэлбэр зэрэг мэдээлэл).

Үнэлгээ хийх чиглэл

- Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулах журам байгаа эсэхийг үнэлнэ.
- Эмнэлгийн мэргэжилтэнтэй ярилцаж, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын талаарх мэдлэгийг нь үнэлнэ.
- Өвчний түүх, өвчтөний хяналтын карт, цахим бүртгэлийг үзэж, сургалтад хамрагдсан талаарх бүртгэлийг үзэж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийг сургалтад хамруулах журамтай (агуулгын a–d заалт) байна.®
	2	Эмнэлгийн мэргэжилтэн нь сургалтын талаар мэдлэгтэй байна.
	3	Үйлчлүүлэгч/өвчтөн өөрийн өвчин, эмгэгт хамааралтай сургалтад хамрагдсан байна.
	4	Сургалтад хамрагдсан тухай баримтжуулалт хийгдсэн байна.®

Шалгуур 1.4

Зарим ажилбарын өмнө үйлчлүүлэгч/өвчтөнөөс таниулсан зөвшөөрөл авна.

Агуулга

Үйлчлүүлэгч/өвчтөний оролцоог илтгэх үндсэн зарчмуудын нэг нь таниулсан зөвшөөрөл өгөх явдал юм. Өвчтөнөөс зөвшөөрөл авахын тулд эмнэлгийн мэргэжилтэн нь түүнд төлөвлөсөн тусламж, үйлчилгээтэй холбоотой олон талын мэдээллийг зайлшгүй өгөх ёстой. Энэ мэдээлэлд тулгуурлан үйлчлүүлэгч/өвчтөн шийдвэр гаргах боломжтой болно.

Таниулсан зөвшөөрлийг өвчтөнд ажилбар хийхээс өмнө авдаг ба зөвшөөрөл нь ажилбар хийх хугацааны туршид хүчин төгөлдөр байна.

Төв нь холбогдох дүрэм, журмын дагуу таниулсан зөвшөөрөл авах журам боловсруулж, хэрэгжүүлнэ.

Журам нь дараах агуулгатай байна. Үүнд:

а) Өвчтөнөөс таниулсан зөвшөөрлийг тодорхой ажилбарын өмнө авна.

I. Дараах тохиолдолд таниулсан зөвшөөрөл авна. Үүнд:

1. Шүд авах
2. Мэс ажилбар
3. Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх
4. Гэр бүл төлөвлөлттэй холбоотой ажилбар
5. Гэрэл зураг авах болон сурталчилгаа хийх
6. Жирэмсэн эмэгтэйд зайлшгүй шаардлагаар хийх рентген шинжилгээ

II. Ажилбар амжилттай байх магадлал, гарах үр дүн, ажилбарыг хийгээгүй үед үүсэж болох эрсдэл, эмчилгээний бусад боломжит хувилбар зэрэг мэдээллийг таниулсан зөвшөөрөлд тусгах

III. Холбогдох дүрэм, журмын дагуу өвчтөний оронд өөр хүнээс таниулсан зөвшөөрөл авч болох тохиолдол, түүнийг хэрхэн авах, баримтжуулах

IV. Эмнэлгийн мэргэжилтэнд таниулсан зөвшөөрөл авах арга зүйн сургалт зохион байгуулах

V. Зөвшөөрлийн маягтыг шаардлагатай байршилд бэлэн байлгах

VI. Зөвшөөрөл хүчин төгөлдөр байх

б) Эмчийн зөвлөсөн эмчилгээ, үйлчилгээнээс татгалзах, эмчилгээг зогсоох шийдвэр гаргах үед таниулсан зөвшөөрөл авна.

I. Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийн тусламж, үйлчилгээнээс татгалзах шийдвэрийг баримтжуулна.

II. Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлд өвчтөний эрүүл мэндийн байдлын талаар мэдээлэл өгсөн байна.

III. Гаргасан шийдвэрийн үр дагаврын талаар үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлд хэлж, ойлгуулсан байна.

IV. Эмчилгээний бусад боломжит хувилбарын талаар үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлд мэдээлэл өгсөн байна.

Үнэлгээ хийх чиглэл

<ul style="list-style-type: none"> • Үйлчлүүлэгч/өвчтөнөөс таниулсан зөвшөөрөл авах үйл явцыг зохицуулсан (агуулгын а–b заалт) журмыг үзэж үнэлнэ. • Таниулсан зөвшөөрөл авах шаардлагатай тусламж, үйлчилгээний жагсаалттай танилцаж үнэлнэ. • Таниулсан зөвшөөрлийг өвчний түүх, үзлэгийн карт, цахим бүртгэлд хавсаргасан эсэхийг үнэлнэ. • Таниулсан зөвшөөрлийн маягт нь шаардлагатай байршилд хангалттай хэмжээгээр байгаа эсэхийг үнэлнэ. 		
Хэмжих үзүүлэлт	1	Таниулсан зөвшөөрөл авах үйл явцыг зохицуулсан (агуулгын а–b заалт) журамтай байна.©
	2	Таниулсан зөвшөөрлийн маягыг шаардлагатай байршилд хангалттай хэмжээгээр бэлэн байлгах ба маягтад зөвшөөрлийг хэдийд авах, зөвшөөрөл олгосноор гарах эрсдэл, үр дагавар, эмчилгээ, үйлчилгээний бусад боломжит хувилбаруудын талаарх мэдээллийг тусгасан байна.
	3	Таниулсан зөвшөөрлийн маягт өвчтөнд энгийн, ойлгомжтой байна.
	4	Таниулсан зөвшөөрлийн маягыг өвчтөнөөр бүрэн бөглүүлж, гарын үсэг зуруулан, өвчний түүхэнд хадгалсан байна.
	5	Таниулсан зөвшөөрлийн хуудсанд эмнэлгийн мэргэжилтэн гарын үсэг зурна.
	6	Холбогдох дүрэм, журмын дагуу зөвшөөрөл олгосон хүн өвчтөний өмнөөс таниулсан зөвшөөрөл өгч болно.

Шалгуур 1.5

Үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй тусламж, үйлчилгээний хүлээлгийн орчин

Агуулга

Хүлээлгийн танхим нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний хамгийн чухал хэсэг юм. Тусламж, үйлчилгээ хүлээж буй үйлчлүүлэгч/өвчтөн ихэвчлэн сэтгэл түгшил, айдас, төөрөгдөл, бухимдалтай байдаг. Энэ нь таагүй орчин, тухгүй суудал, хэт ачаалал зэрэг нөлөөллөөс болж улам нэмэгддэг. Хүлээлгийн танхим нь үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийн хэрэгцээнд тохирсон, тав тухтай байна.

Үнэлгээ хийх чиглэл

1. Хүлээлгийн хэсэгт тав тухтай орчин бүрдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслээр хангасан эсэхийг үнэлнэ. Хүлээлгийн танхимын ариун цэврийн өрөө болон ундны усны хүртээмжтэй байдлыг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Хүлээлгийн танхим нь гэрэлтүүлэг, агааржуулалт сайтай, цэвэр, аюулгүй байна.
	2	Хүлээлгийн танхим нь үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүл багтахаар зай талбайтай байна.
	3	Хүлээлгийн танхим нь ариун цэврийн өрөө, ундны ус зэрэг хүний анхан шатны хэрэгцээг хангасан байна.

	4	Үйлчлүүлэгч/өвчтөнд тусламж, үйлчилгээг хүлээх хугацааны талаар мэдээлэл өгдөг байна.
--	---	---

Шалгуур 1.6

Тусламж, үйлчилгээний явцад үйлчлүүлэгч/өвчтөний нэр төр, хувийн нууцыг хамгаална.

Агуулга

Хүндэтгүүлэх, нэр төрөө эрхэмлэх нь хүний чухал хэрэгцээний нэг юм. Эмнэлгийн мэргэжилтэн нь тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгч/өвчтөний хувь хүний үнэ цэн, нэр төрд хүндэтгэлтэй хандах үүрэгтэй. Үйлчлүүлэгч/өвчтөнтэй ярилцах, үзлэг, эмчилгээ, ажилбар хийх, зөвлөгөө өгөх үед өвчтөний нууцыг хадгалах нь чухал юм. Үйлчлүүлэгч/өвчтөн нь эмнэлгийн ажилтан, бусад үйлчлүүлэгч/өвчтөн болон өөрийн гэр бүлийн гишүүнээс хувийн нууцыг хамгаалахыг хүсэж болно. Төв нь тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад өвчтөний хувийн нууцыг хамгаалах, хүндэтгэх ёстой.

Үнэлгээ хийх чиглэл

Тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад өвчтөний хувийн нууцыг хадгалж, хамгаалж байгааг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгч/ өвчтөний нэр төр, үнэ цэнд хүндэтгэлтэй хандана.
	2	Тусламж, үйлчилгээний бүх үе шатанд өвчтөний нууцлал, хувийн орон зайг хүндэтгэнэ.
	3	Үйлчлүүлэгч/өвчтөн нь түүний тусламж, үйлчилгээний үйл явцад хэн оролцохыг өөрөө шийдэх эрхтэй.

Шалгуур 1.7

Үйлчлүүлэгч/өвчтөний эд зүйлстэй холбоотой байгууллагын хүлээх хариуцлага

Агуулга

Үйлчлүүлэгч/өвчтөний эд зүйлд нүдний шил, үнэт эдлэл, цахилгаан төхөөрөмж, бэлэн мөнгө, банкны карт болон бусад зүйлс багтана. Төв нь үйлчлүүлэгч/өвчтөний алдсан, олсон эд зүйл болон амь тэнссэн, яаралтай тусламж, шаардлагатай өвчтөний эд зүйлийг аюулгүй хадгалах журам, үйл явцын зураглал боловсруулан хэрэгжүүлнэ. Журамд дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:

- Үйлчлүүлэгч/өвчтөний эд зүйлстэй холбоотой байгууллагын хариуцлагын хүрээг тодорхойлох
- Үйлчлүүлэгч/өвчтөн ба түүний гэр бүлийн эд зүйлтэй холбоотой байгууллагын хүлээх хариуцлагын талаар мэдээлэх
- Үйлчлүүлэгч/өвчтөний эд зүйлийг хариуцах ажилтан
- Үйлчлүүлэгч/өвчтөний эд зүйлийг хадгалах хугацаа, байршил, бүртгэл, буцаан олгох
- Олсон болон алдсан эд зүйлийн зохицуулалтыг тодорхой тусгана.

Үнэлгээ хийх чиглэл

1. Үйлчлүүлэгч/өвчтөний эд зүйлтэй холбоотой төвийн хүлээх хариуцлагыг тодорхойлсон журмын хэрэгжилтийг үнэлнэ.
2. Ажилтантай ярилцлага хийж, журмын талаарх мэдлэгийг үнэлнэ.
3. Журмын талаар өвчтөнд мэдээлэл өгөх зурагт хуудас, товхимол гм байгаа эсэхийг ажиглаж үнэлнэ.
4. Үйлчлүүлэгч/өвчтөний эд зүйлийг хадгалах шүүгээ, эд зүйлийн бүртгэл бусад тэмдэглэл зэргийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Үйлчлүүлэгч/өвчтөний эд зүйлтэй холбоотой төвийн хүлээх үүргийг тодорхойлсон журамтай (агуулгын а-е заалт) байна.®
	2	Ажилтан журмын талаар мэдлэгтэй байна.
	3	Үйлчлүүлэгч/өвчтөний эд зүйлийг хадгалах тухай мэдээллийг үйлчлүүлэгч/өвчтөн түүний гэр бүлд өгнө.
	4	Журмын дагуу үйлчлүүлэгч/өвчтөний эд зүйлийг бүртгэж, хадгална.
	5	Олсон болон гээсэн эд зүйлийг бүртгэж, хадгалж, хамгаалж, буцаан олгоно.

Шалгуур 1.8

Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийн санал, хүсэлтэд үндэслэн тусламж, үйлчилгээг сайжруулна.

Агуулга

Анхаарал татсан асуудал, үйлчлүүлэгч/өвчтөний талархал, гомдол, сэтгэл ханамжийн судалгаанаас гарсан санал зэрэг нь эмнэлзүйн болон эмнэлзүйн бус тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг сайжруулах боломжийг олгоно. Улмаар тусламж, үйлчилгээний чанар сайжирч, үйлчлүүлэгч/өвчтөний сэтгэл ханамж нэмэгдэнэ. Үйлчлүүлэгч/өвчтөнөөс санал, хүсэлт авах олон арга бий. Үүнд: утсаар, цаасаар, цахимаар, зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага гм. Ихэнх эрүүл мэндийн байгууллага нь санал, хүсэлтийг бичгээр авах аргыг ашигладаг бөгөөд энэ нь зардал багатай, найдвартай арга юм. Төв нь үйлчлүүлэгч/өвчтөний санал, хүсэлттэй холбоотой үйл явцыг зохицуулсан журам боловсруулж хэрэгжүүлэх ёстой. Журам нь дараах агуулгатай байна. Үүнд:

- а) Амбулаторийн тусламж, үйлчилгээтэй холбоотой санал, хүсэлтийг үнэлэх
- б) Яаралтай тусламжтай холбоотой санал, хүсэлтийг үнэлэх

Санал, хүсэлтийг шийдвэрлэхийн тулд үйлчлүүлэгч/өвчтөний туршлага болон сэтгэл ханамжийг үнэлнэ.

Өвчтөний туршлага гэдэг нь тусламж, үйлчилгээг шат дарааллын дагуу цаг хугацаанд нь үзүүлсэн эсэх, эмнэлгийн мэргэжилтний харилцаа ойлгомжтой байсан тухай үнэлгээ юм.

Харин өвчтөний сэтгэл ханамж гэдэг нь тусламж, үйлчилгээ өвчтөний хүлээлтэд хүрсэн эсэхийн тухай үнэлгээ юм. Ижил тусламж, үйлчилгээ авсан хоёр хүн өөр хүлээлттэй байж болох тул тэдний сэтгэл ханамжийн үнэлгээ ялгаатай байж болно.

Санал, хүсэлтийг зөвхөн хэмжих нь хангалтгүй. Төв нь санал, хүсэлтийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг илрүүлэн, сайжруулах боломжийг тодорхойлж, цаашдын төлөвлөлтөд ашиглана.

Үнэлгээ хийх чиглэл

- Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийн санал, хүсэлтийг шийдвэрлэх үйл явцыг зохицуулсан журмын хэрэгжилтийг үнэлнэ.
- Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийн санал, хүсэлтийг үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулахад ашиглаж байгаа эсэхийг тодруулах зорилгоор байгууллагын удирдлагатай ярилцаж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийн санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл явцыг тусгасан журамтай байна. ©
	2	Санал, хүсэлтийг хүлээн авч, дүн шинжилгээ хийдэг байна.
	3	Санал, хүсэлтийн талаар холбогдох ажилтанд мэдээлсэн байна.
	4	Санал, хүсэлтийн дагуу тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

Шалгуур 1.9

Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүл нь амаар болон бичгээр гомдол гаргах боломжтой байна.

Агуулга

Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүл нь амаар болон бичгээр гомдол гаргах боломжтой байна. Төв нь гомдлыг хянан үзэж, шийдвэрлэдэг байх ёстой.

Төв нь үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлийн гомдлыг хүлээн авах, хянах, шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх талаар журам боловсруулж, хэрэгжүүлэх бөгөөд журам нь дагаж мөрдөхөд хялбар, хяналт-үнэлгээ, шинэчлэлт, сайжруулалт хийх боломжтой байх шаардлагатай. Журамд доорх агуулгыг тусгасан байна. Үүнд:

- a) Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлд хаана, хэрхэн гомдол гаргах талаар мэдээлэл өгөх
- b) Гомдлыг бүртгэх, хянах үйл явц
- c) Гомдлыг шийдвэрлэх үүрэг, хариуцлагыг тодорхойлох
- d) Гомдлын хариу өгөх хугацааг тогтоох
- e) Гомдлын мэдээлэлд хяналт-шинжилгээ хийн, үйл явцыг хянах, шийдвэрлэх
- f) Гомдлын тайлан, мэдээг холбогдох байгууллагад хугацаанд нь илгээх

Үнэлгээ хийх чиглэл

1. Үйлчлүүлэгч/өвчтөний гомдлыг шийдвэрлэх журмын хэрэгжилтийг үнэлнэ.
2. Удирдлагатай ярилцаж, гомдлыг тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, төвийн үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөнд тусгаж буй байдлыг үнэлнэ.
3. Үйлчлүүлэгч/өвчтөний гомдлыг шийдвэрлэх үйл явцыг мөшгөх замаар үнэлнэ.

Хэмжих	1	Үйлчлүүлэгч/ өвчтөний гомдлыг шийдвэрлэх (агуулгын а-f заалт) журамтай байна. ©
---------------	----------	---

үзүүлэлт	2	Эмнэлгийн мэргэжилтэн нь журмын талаар мэдлэгтэй байна.
	3	Гомдол гаргах үйл явц олон нийтэд нээлттэй байна.
	4	Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлд гомдол гаргах боломжийг бүрдүүлсэн байна.
	5	Гомдлыг судалж, дүн шинжилгээ хийн, хугацаанд нь шийдвэрлэдэг байна.
	6	Яаралтай зохицуулах шаардлагатай гомдлыг нэн даруй шийдвэрлэж, үйлчлүүлэгч/өвчтөн, түүний гэр бүлд шуурхай хариу өгнө.

БҮЛЭГ 2. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ТАСРАЛТГҮЙ БАЙДАЛ

Тойм

Хүртээмж гэдэг нь үйлчлүүлэгч/өвчтөний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломж бүрдэх үйл явцыг хэлнэ. Хүртээмжийг хангах үйл явц нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай нөөцийг ашиглах бодит боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ. Тусламж, үйлчилгээний хүртээмж нь олон талт, нийлмэл ойлголт бөгөөд үндсэн 4 зарчимд тулгуурлана. Үүнд:

1. Боломжит байдал (Availability)
2. Санхүүгийн хүртээмж (Affordability)
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал (Acceptability)
4. Тусгай хэрэгцээт иргэдэд ээлтэй орчин (Physical Accessibility) орно.

Хүн амын насжилт нэмэгдэхийн хэрээр тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлын ач холбогдол ихэсч байна. Ахмад настанд олон өвчин хавсарвал түүний нийгмийн болон сэтгэлзүйн эмзэг байдал нь мэдэгдэхүйц нэмэгддэг. Үйлчлүүлэгч/өвчтөнийг шилжүүлэх гэдэг нь өвчтөний биеийн байдал, тусламж, үйлчилгээний хэрэгцээ өөрчлөгдөх үед нэг байгууллага/нэгжээс нөгөөд, нэг шатлалаас өөр шатлалд, эрүүл мэндийн мэргэжилтэн хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх үед тусламж, үйлчилгээний уялдаа холбоо, тасралтгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэлнэ. ДЭМБайгууллагаас хүн бүр амьдралын туршид хэрэгцээт тусламж, үйлчилгээг тэгш хүртэх эрхтэй гэдгийг тунхагласан. Тусламж, үйлчилгээ нь өвчтөний хэрэгцээнд нийцсэн, уялдаа холбоотой, аюулгүй, үр дүнтэй, хүлээгдэлгүй, үр ашигтай, хүлээн зөвшөөрөгдсөн, цогц байх ёстой. Мөн эрүүл мэндийн ажилтан нь урам зоригтой, чадварлаг, бөгөөд дэмжлэгт орчинд ажиллах боломжтой байна.

Үйлчилгээний хүртээмжийн бүх хэмжигдэхүүнийг цогцоор нь авч үзэх шаардлагатай. Төв нь өвчтөний урсгалыг зохицуулах журам батлан хэрэгжүүлэх шаардлагатай ба үйлчилгээний саатал, хүндрэл үүсгэж буй цэгийг тодорхойлон, тусламж, үйлчилгээг тасралтгүй зохион байгуулах, нөөцийг үр ашигтай хуваарилах нь чухал ач холбогдолтой. Үйлчлүүлэгч/өвчтөнийг нэг тасаг/нэгжээс нөгөөд саадгүй шилжих нөхцөлийг бүрдүүлж, тохирсон тусламжийг цаг алдалгүй үзүүлснээр өвчтөн илгээх,

шилжүүлэх тогтолцоо үр дүнтэй байна гэж үзнэ. Тогтолцоо нь нөөцийг оновчтой ашиглах боломжийг бүрдүүлэн, эмчилгээ, үйлчилгээний үр дүнг сайжруулахад чиглэнэ.

Телемедицин гэдэг нь харилцаа холбооны технологийг ашиглан өвчтөнийг алсаас оношлох, эмчлэх үйл явцыг хэлдэг. Энэ нь үйлчлүүлэгч/өвчтөнд байгаа газраас үл хамааран цахимаар цаг алдалгүй тусламж, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлдэг.

Телемедицин нь чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх үр ашигтай арга тул эрүүл мэндийн тогтолцооны бүх түвшинд өргөнөөр ашиглаж байна. Лавлагаа шатлалд телемедициний хэрэглээ нэмэгдэж байгаа ч, төвийн түвшинд хэрэглээг нэмэгдүүлэх шаардлагатай. Цахим эрүүл мэнд нь анхан шатны тусламж, үйлчилгээнд олон давуу талыг бий болгодог. Үүнд: алслагдсан бүс нутгийн иргэдэд саадгүйгээр тусламж, үйлчилгээ үзүүлэх, өвчтөнийг хянах, эрүүл мэндийн боловсрол олгох, шаардлагагүй тусламж, үйлчилгээг бууруулах, эмнэлэгт очих давтамжийг багасгах зэрэг орно. Үнэлгээний явцад тусламж, үйлчилгээний урсгал болон үйл явцыг үнэлнэ. Эмнэлгийн мэргэжилтэнтэй ярилцлага хийх, холбогдох журмыг үнэлэх замаар тусламж, үйлчилгээний тэгш, хүртээмжтэй, үр нөлөөтэй, үр ашигтай байдал хангагдсан эсэхийг үнэлнэ.

Энэ бүлэгт хамаарах шалгуурыг хүснэгтэд нэгтгэн харуулав.

2.1	Төв нь холбогдох дүрэм, журам, шалгуурт нийцсэн үйлчлүүлэгч/өвчтөнийг хүлээн авах журамтай, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг байна.
2.2	Үйлчлүүлэгч/өвчтөнийг бүртгэх ээлтэй, аюулгүй орчинг бүрдүүлсэн байна.
2.3	Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулдаг байна.
2.4	Үйлчлүүлэгч/өвчтөний урсгалыг зохицуулсан байна.
2.5	Тусламж, үйлчилгээтэй холбоотой чиг үүргийг зохицуулсан байна.
2.6	Олон нийт болон холбогдох байгууллагатай хамтран иргэнд ээлтэй, хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ.
2.7	Үйлчлүүлэгч/өвчтөний хэрэгцээнд нийцүүлэн тээвэрлэх үйл ажиллагааг зохицуулна.
2.8	Өвчтөнийг илгээх (шилжүүлэх) үйл явц тодорхой байна.
2.9	Телемедициний хүртээмж, хүрээг тодорхойлж, тусламж, үйлчилгээнд ашиглах боломжтой технологийг тодорхойлсон байна.

ШАЛГУУР, АГУУЛГА, ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур 2.1

Төв нь холбогдох дүрэм, журам, шалгуурт нийцсэн үйлчлүүлэгч/өвчтөнийг хүлээн авах журамтай, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг байна.

Агуулга

Тусламж, үйлчилгээний хүртээмж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг (жишээлбэл, биемахбодын бэрхшээл) олон талаас авч үзэх хэрэгтэй. Төв нь тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулахын тулд үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлд тусламж, үйлчилгээ авах шалгуурыг мэдээлэх үүрэгтэй. Шалгуурыг холбогдох хуулв, тогтоомжийн дагуу тусламж, үйлчилгээг санхүүжүүлэгч байгууллага урьдчилан тодорхойлдог. Төв нь үйлчлүүлэгч/ өвчтөний тусламж, үйлчилгээ авах журам боловсруулж, хэрэгжүүлэх ёстой. Журам нь дараах агуулгатай байна. Үүнд:

- a) Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үлгэрчилсэн дүрэм, яаралтай тусламж шаардлагатай өвчтөнийг эрэмбэлэх зааврыг холбогдох журмын дагуу мөрдөж ажиллана.
- b) Яаралтай тусламж шаардлагатай өвчтөнийг хүлээн авах, шилжүүлэх үйл явц нь өвчтөний биеийн байдлын онцлогт тохирсон, аюулгүй, тасралтгүй байна.
- c) Амбулаторийн тусламж, үйлчилгээ нь батлагдсан цагийн хуваарьтай, цаг товлох үйлчилгээг нэвтрүүлсэн байна.
- d) Өвчтөний эрүүл мэндийн хэрэгцээ нь төвийн үйл ажиллагааны цар хүрээнээс давсан үед холбогдох шатлалын эрүүл мэндийн байгууллагад шилжүүлнэ.

Үнэлгээ хийх чиглэл

1. Төвийн цаг товлох үйлчилгээний журмыг хянаж, үнэлнэ.
2. Үйлчлүүлэгч/өвчтөний бүртгэлийн хэсэгт (жишээлбэл, цахим бүртгэл, хүлээн авах, яаралтай тусламжийн нэгж, амбулатори гм) очиж, бүртгэлийн үйл явц хэрхэн өрнөж байгааг ажиглаж үнэлнэ.
3. Үйлчлүүлэгч/өвчтөнтэй ярилцаж, төвийн ажиллах цагийн хуваарь, үйлчилгээний өртөг, үйлчилгээ авах дарааллын талаарх мэдлэг, ойлголтыг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Үйлчлүүлэгч/ өвчтөнийг хүлээн авах, цаг товлох, бүртгэх (агуулгын a-d заалт) журамтай байна.©
	2	Үйлчлүүлэгч/ өвчтөнд төвийн ажиллах цагийн хуваарь, үзүүлэх тусламж, үйлчилгээний төрөл, үйлчилгээний дарааллын талаарх мэдээллийг ойлгомжтой байдлаар хүргэнэ.
	3	Үзлэгийн цагийн хүлээгдлийг (өдрөөр сараар) зохицуулах арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.
	4	Тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг үйлчлүүлэгч/ өвчтөний мэдээлэл хүлээн авах чадварт (тусгай хэрэгцээт) нийцүүлэн, нээлттэй байдлаар хүргэнэ.
	5	Үйлчлүүлэгч/өвчтөний хэрэгцээ нь төвийн үйлчилгээний хүрээнээс давсан тохиолдолд бусад шатлалд илгээх, шилжүүлэх зохицуулалтыг хийдэг байна.©

Шалгуур 2.2

Үйлчлүүлэгч/өвчтөнийг бүртгэх ээлтэй, аюулгүй орчинг бүрдүүлсэн байна.

Агуулга

Төв нь харьяаллын хүн амын бүртгэлд бүртгэгдсэн иргэдэд өөрийн хүчин чадлын хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ. Төв нь үйлчлүүлэгч/өвчтөнийг бүртгэх үйл явцыг зохицуулах журам боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай. Журам дараах агуулгыг тусгана. Үүнд:

- а) Үйлчилгээний хамрах хүрээг тодорхойлон, үзүүлсэн тусламж, үйлчилгээ бүрийн тэмдэглэлийг хөтөлдөг байх
- б) Үйлчлүүлэгч/өвчтөнг бүртгэхэд шаардлагатай хүн ам зүйн мэдээллийг тодорхойлох, харьяаллын хүн амын бүртгэлийг тогтмол шинэчилдэг байх
- с) Бүртгэлийн үйл явц, үйлчилгээний урсгал нь үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүлд тодорхой, ил тод байх

Үнэлгээ хийх чиглэл

1. Бүртгэлийн үйл явцыг зохицуулах журмыг хянаж, үнэлнэ.
2. Хариуцсан ажилтантай ярилцаж, журмын талаарх мэдлэг, ойлголтыг үнэлнэ.
3. Төвийн үйлчлүүлэгч/өвчтөнг бүртгэх нэгжид (цахим бүртгэл, хүлээн авах, сувилагчийн пост, яаралтай тусламжийн нэгж, амбулатори гм) ажиглалт хийж, журмын хэрэгжилтийг үнэлнэ.
4. Бүртгэлийн үйл явц болон үйлчлүүлэгч/өвчтөний урсгалтай холбоотой мэдээллийг (товхимол, постер, цахим мэдэгдэл, тайлбар гм) ил тод байршуулсан, хүртээмжтэй байгаа эсэхийг ажиглан үнэлнэ.
5. Үйлчлүүлэгч/өвчтөний бүртгэлийн үйл явцыг ажиглаж, журмын дагуу хэрэгжиж буй эсэхийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Үйлчлүүлэгч/өвчтөний бүртгэлийг зохицуулах журамтай (агуулгын a-d заалт) байна.©
	2	Хариуцсан ажилтан нь журмын талаар мэдлэг, ойлголттой байна.
	3	Бүртгэлийн үйл явц болон үйлчлүүлэгч/өвчтөний урсгалтай холбоотой мэдээллийг ил тод байршуулсан байна.
	4	Үйлчлүүлэгч/өвчтөний бүртгэл болон урсгал зохицуулах үйл явц нь журмын дагуу хэрэгждэг байна.©
	5	Тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зорилгоор үйлчлүүлэгч/өвчтөний бусад эрүүл мэндийн байгууллагаас авсан тусламж, үйлчилгээний мэдээллийг хүлээн авч, өвчний түүх, цахим бүртгэлд хадгална.

Шалгуур 2.3

Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулдаг байна.

Агуулга

Танин тодруулаагүй үйлчлүүлэгч/өвчтөнд тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмчилгээ хийх нь ноцтой тохиолдол бөгөөд аюултай үр дагаварт хүргэх эрсдэлтэй. Үйлчлүүлэгчийг тусламж, үйлчилгээ үзүүлэхээс өмнө зөв танин тодруулах ба

танин тодруулгад зохистой гэж үзсэн хоёроос доошгүй аргыг ашиглана. Төв нь үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах үйл явцыг зохицуулах журам боловсруулж, хэрэгжүүлнэ. Журам дараах агуулгыг тусгана. Үүнд:

- a) Хувь хүний хоёроос доошгүй өвөрмөц мэдээллийг танин тодруулгад ашигладаг байх
- b) Үйлчлүүлэгч/өвчтөний зөв танин тодруулах шаардлагатай тохиолдлыг тодорхой болгох
- c) Онцгой нөхцөл байдалд нэр нь үл мэдэгдэх олон тооны хохирогчдын хувьд өвчтөнийг зөв таних үйл явцыг дагаж мөрдөхгүй байж болно.

Үнэлгээ хийх чиглэл

1. Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журмыг хянаж үнэлнэ.
2. Эмнэлгийн мэргэжилтэнтэй ярилцаж, журмын талаарх мэдлэг, журмын хэрэгжилтийг үнэлнэ.
3. Үйлчлүүлэгч/ өвчтөний цахим бүртгэлд хувь хүний хоёроос доошгүй өвөрмөц мэдээлэл байгаа эсэхийг шалгаж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах үйл явцыг зохицуулах журамтай (агуулгын а–с заалт) байна.©
	2	Төвийн ажилтан бүр журмын талаар мэдлэг, ойлголттой байна.
	3	Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах үйл явц нь батлагдсан журмын дагуу хэрэгждэг байна.©
	4	Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулахад ашигласан мэдээллийг өвчтөний цахим бүртгэлд баримтжуулсан байна.
	5	Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах үйл явцыг тогтмол хянаж, шаардлагатай тохиолдолд сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Шалгуур 2.4

Үйлчлүүлэгч/өвчтөний урсгалыг зохицуулсан байна.

Агуулга

Өвчтөний урсгал гэдэг нь тухайн эмнэлэгт хандаж буй өвчтөнийг хүлээн авах, оношилгоо, эмчилгээ, хэвтэн эмчлүүлэх, дараагийн шатлалд шилжүүлэх хүртэлх бүх үйл ажиллагааны дараалал, хөдөлгөөнийг хэлнэ. Энэ нь үр дүнтэй, түргэн шуурхай, халдвараас сэргийлсэн шат дараалсан үйл явц байх ёстой. Харин урсгал тодорхой бус байх нь зардлын өсөлт, үйлчилгээний чанар муудах, өвчтөний сэтгэл ханамж буурах зэрэг үр дагаварт хүргэдэг. Тасралтгүй урсгалыг хангах зорилт нь байгууллага хоорондын уялдаа холбооноос хамаардаг. Эрсдэлийн үнэлгээ нь боломжит аюул, эрсдэлийг системтэйгээр үнэлэх, шинжлэх үйл явц бөгөөд сөрөг үр дагаварт хүргэх эрсдэлийг тодорхойлдог. Төв нь үйлчлүүлэгч/өвчтөний урсгалд үүсэх хүндрэлийг илрүүлж, эрсдэлийн үнэлгээг хийнэ. Үйлчлүүлэгч/өвчтөний урсгалыг сайжруулах аргачлалтай, өвчтөний хэрэгцээ, саналд тулгуурлан асаргаа, сувилгааны үйл явцыг дахин зохион байгуулж, богино хугацаанд шийдвэрлэн, эрүүл мэндийн нөөцийг оновчтой ашиглах боломжийг бүрдүүлнэ.

Үнэлгээ хийх чиглэл

1. Үйлчлүүлэгч/өвчтөний урсгалд үүсэх эрсдэлийн үнэлгээний журмыг хянаж, үнэлнэ.
2. Үйлчлүүлэгч/өвчтөний урсгалыг сайжруулах үйл ажиллагааны талаар холбогдох ажилтантай ярилцаж, үнэлнэ.
3. Тусламж, үйлчилгээний ачаалал ихтэй хэсгийг ажиглаж, байгууллагын эрсдэлийн үнэлгээний журамтай харьцуулан, үнэлгээ бүрэн, бодитой хийгдсэн эсэхийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төвийн бүх нэгжид үйлчлүүлэгч/өвчтөний урсгалын эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.©
	2	Холбогдох ажилтан үйлчлүүлэгч/өвчтөний урсгалын эрсдэлийн үнэлгээг хийхэд идэвхтэй оролцдог байна.
	3	Үйлчлүүлэгч/өвчтөний урсгалд хүндрэл, ачаалал үүсгэж буй хэсгийг тодорхойлсон байна.
	4	Үйлчлүүлэгч/өвчтөний урсгалыг сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.©

Шалгуур 2.5

Тусламж, үйлчилгээтэй холбоотой чиг үүргийг зохицуулсан байна.

Агуулга

Харъяалах хүн амын эрүүл мэндийн байдал нь төвийн суурь тулгуур бөгөөд оновчтой тусламж, үйлчилгээ үзүүлэхэд чиглэнэ. Төвийн эмнэлгийн мэргэжилтэн нь хамрах хүрээний хүн амын эрүүл мэндийг хариуцаж, үйлчлүүлэгч/өвчтөний эрүүл мэндийн хэрэгцээнд тулгуурласан чанартай, аюулгүй, тасралтгүй тусламж, үйлчилгээг үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Журам нь дараах агуулгыг багтаасан байна. Үүнд:

- a) Харъяалах өрхийн хүн амын бүртгэл мэдээлэл, өрхийн жагсаалт
- b) Эмч, сувилагч бүр харъяалах хүн амын өрхийн бүртгэл, судалгаатай байх
- c) Эмч, сувилагчийг түр орлон ажиллах хуваарьтай байна.
- d) Тусламж, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах нөхцөл, шалгуурыг тогтооно.
- e) Үйлчлүүлэгч/өвчтөний биеийн байдал, тусламжийн төлөвлөгөөтэй холбоотой мэдээллийг нэг эмчээс нөгөөд шилжүүлэх дараалал, хөтлөх баримтжуулалтыг тодорхойлно.
- f) Тусламж, үйлчилгээний хариуцлага шилжих үйл явцад оролцогч талуудын хооронд хариуцлагын зааг, баталгааг хэрхэн хангах үйл явцыг тогтооно.

Үнэлгээ хийх чиглэл

1. Үйлчлүүлэгч/өвчтөнд тусламж, үйлчилгээ үзүүлэх хариуцлагыг хуваарилах үйл явцыг зохицуулах журмыг хянаж, үнэлнэ.
2. Эрүүл мэндийн ажилтантай ярилцлага хийж, журмын талаарх мэдлэг, ойлголтыг үнэлнэ.
3. Үйлчлүүлэгч/өвчтөний цахим бүртгэлийг санамсаргүйгээр түүвэрлэж үнэлнэ. Өвчтөний түүх, карт, цахим бүртгэл дэх мэдээллийн уялдаа, нийцлийг хянаж үнэлнэ.
4. Тусламж, үйлчилгээний хариуцлагыг шилжүүлэх үйл явц хэрхэн хэрэгжиж

байгааг ажиглана.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад тусгасан үйлчлүүлэгч/өвчтөнд тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг зохицуулах журамтай (a-f заалт) байна.᠖
	2	Эмнэлгийн мэргэжилтэн журмын агуулгын талаар мэдлэг, ойлголттой байна.
	3	Эмч, сувилагч нь харъяалах хүрээний өрх, хүн амын бүртгэлтэй байна.᠖
	4	Цахимд бүртгэлд үйлчлүүлэгч/өвчтөнийг хариуцсан эмчийн нэрийг тэмдэглэсэн байна.
	5	Үйлчлүүлэгч/өвчтөнтүүний гэр бүлд хариуцсан эмч сувилагчийн талаарх мэдээллийг ойлгомжтойгоор хүргэсэн байна.
	6	Хуваарийн дагуу түр орлон ажилладаг байна.

Шалгуур 2.6

Олон нийт болон холбогдох байгууллагатай хамтран иргэнд ээлтэй, хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ.

Агуулга

Үйлчлүүлэгч/өвчтөнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийг хязгаарладаг төрөл бүрийн саад, бэрхшээлтэй тулгардаг. Хүртээмжийг хангахын тулд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шууд авах боломжтой байх ёстой. Орон нутагт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нөөц хангалттай бүрдсэн ч хүртээмжийн хувьд анхаарах бусад хүчин зүйлс байдаг.

Тухайлбал, алслагдсан байршилд байрлах тусламж, үйлчилгээнд хүрч очих тээврийн хэрэгслийн хүртээмж чухал үүрэгтэй. Төрийн болон орон нутгийн байгууллагатай хамтран ажиллаж, нийтийн тээврийн хүртээмж, тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан налуу зам, тэргэнцэрийг саадгүй, аюулгүй нэвтрэх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана.

Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүл ихэвчлэн сэтгэлзүйн дарамттай байдалд байдаг. Иймд дуугүй хөтөч, тэмдэг, тэмдэглэгээ нь ойлгомжтой, хялбар байна. Дуугүй хөтөч, тэмдэг, тэмдэглэгээ нь үйлчлүүлэгч/өвчтөний нас, хэл, тусгай хэрэгцээ, боловсролын түвшинд тохирсон байвал зохино. Гадна байршуулсан дуугүй хөтөч, тэмдэг, тэмдэглэгээ нь гэрэлтүүлэгтэй, цаг уурын бүх нөхцөлд уншигдахуйц байх шаардлагатай. Мэдээллийн онцлогт тохируулан өнгө, тэмдэг, дүрст тэмдэгтийг түлхүү ашиглана.

Үнэлгээ хийх чиглэл

1. Төвийн тусламж, үйлчилгээний хүртээмжтэй байдлыг ажиглаж, ойролцоо нийтийн тээврийн хэрэгсэл, суваг, шуудуу зэрэг саад байгаа эсэх, байгууллага дотор өвчтөний хөдөлгөөнийг чиглүүлэх дуугүй хөтөч, тэмдэглэгээ дутмаг эсэх зэргийг үнэлнэ.
2. Налуу зам, тэргэнцэр, тэрэгний бэлэн байдал, ашиглах боломжийг ажиглан үнэлнэ.

3. Төвийн дуугүй хөтөч, тэмдэг, тэмдэглэгээ нь Үйлчлүүлэгч/өвчтөн түүний гэр бүлд ойлгомжтой байгаа эсэхийг ажиглан үнэлнэ.		
Хэмжих үзүүлэлт	1	Үйлчлүүлэгч/өвчтөн саадгүй нэвтрэх боломж, тав тухыг хангахад чиглэсэн хэрэгцээний үнэлгээ хийсэн байна.
	2	Тэргэнцэр болон бусад туслах хэрэгслийн бэлэн байдлыг хангана.
	3	Тусгай хэрэгцээт үйлчлүүлэгч/өвчтөнд тусламж, үйлчилгээ үзүүлэх бэлэн байдал хангах чиглэлээр сайжруулалт хийсэн байна.
	4	Дуугүй хөтөч, тэмдэг, чиглүүлэх тэмдэглэгээ тодорхой харагдахуйц, хангалттай гэрэлтүүлэгтэй байна.
	5	Өнгөөр ялгасан тэмдэглэгээ ашигласан тохиолдолд өнгө бүрийн утга, зориулалтыг тайлбарласан заавартай байна.
Шалгуур 2.7		
Үйлчлүүлэгч/өвчтөний хэрэгцээнд нийцүүлэн тээвэрлэх үйл ажиллагааг зохицуулна.		
Агуулга		
<p>Өвчтөний тээвэрлэлт нь тусламж, үйлчилгээний чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Өвчтөний тээвэрлэлт гэдэг нь эрүүл мэндийн ажилтны хяналтын дор өвчтөнийг өргөх, байрлуулах, нэг цэгээс нөгөөд шилжүүлэх үйл ажиллагааг хэлнэ. Тээвэрлэлтийг журамд заасан хугацаанд зохион байгуулна. Өвчтөний тээвэрлэлт нь боломжит нөөцөд тулгуурлан хялбар, уялдаатай хэрэгжих шаардлагатай. Үйлчлүүлэгч/өвчтөний тээвэрлэлтийг зохицуулах журам боловсруулж хэрэгжүүлнэ.</p> <p>Журамд дараах шаардлагыг тусгана. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> Өвчтөнийг зөөврийн ор, дамнуурга, тэргэнцэр болон бусад тээвэрлэх хэрэгслээс аюулгүйгээр шилжүүлэх, тээвэрлэх зохицуулалт Өвчтөнийг өргөх, зөөвөрлөх үеийн ажилтны аюулгүй байдал Тээвэрлэлтийн баг, ажилтны ур чадвар Үйлчлүүлэгч/өвчтөнтээвэрлэх заалт, шалгуурыг тодорхойлсон байна. 		
<u>Үнэлгээ хийх чиглэл</u>		
<ol style="list-style-type: none"> Өвчтөнийг аюулгүй тээвэрлэх журмыг үнэлнэ. Эрүүл мэндийн мэргэжилтэнтэй ярилцаж, журмын талаарх мэдлэг, ойлголтыг үнэлнэ. Өвчтөнийг өргөх, зөөвөрлөх, тээвэрлэх үйл явцыг ажиглаж үнэлнэ. Өвчтөнийг өргөх, зөөвөрлөх, тээвэрлэхэд ашиглаж буй тоног төхөөрөмжийн бэлэн байдал, тохиромжтой байдлыг ажиглан үнэлнэ. 		
Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (a–d заалт) тусгасан өвчтөний хэрэгцээнд нийцүүлэн тээвэрлэлтийг зохицуулах журамтай байна.©
	2	Өвчтөний тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцдог бүх ажилтан журмын талаар мэдлэг, ойлголттой байна.

	3	Сургалтанд хамрагдсан ур чадвартай баг, ажилтан өвчтөнийг өргөх, зөөвөрлөх, тээвэрлэхэд оролцоно.
	4	Өвчтөний тээвэрлэлт нь аюулгүй, журмын дагуу хэрэгждэг байна.©

Шалгуур 2.8

Өвчтөнийг илгээх (шилжүүлэх) үйл явц тодорхой байна.

Үйлчлүүлэгч/өвчтөнийг илгээх, шилжүүлэх үр дүнтэй тогтолцоо нь өвчтөнд хугацаа алдахгүй оновчтой тусламж, үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ эрүүл мэндийн байгууллагын хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангах чухал хэрэгсэл болдог. Үйлчлүүлэгч/өвчтөнийг илгээх, шилжүүлэхтэй холбоотой эргэн мэдээллийг бүртгэх, хариу арга хэмжээ авах нь тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангана. Өвчтөний хэрэгцээнд тулгуурлан, эмнэлзүйн удирдамж, зааврын дагуу, тохирох шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээх журам боловсруулж хэрэгжүүлнэ.

Журам нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- a) Үзлэг, оношилгоо хийн, илгээх заалт, шалгуурыг хангасан тохиолдолд Үйлчлүүлэгч/өвчтөншилжүүлэх үйл явцыг төлөвлөж эхэлнэ. Шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийн гэр бүлийг оролцуулна.
- b) Үйлчлүүлэгч/өвчтөншилжүүлэх ажилтанг тодорхой болгоно.
- c) Лавлагаа шатлалд илгээх, шилжүүлэх заалт, шалгуурыг тодорхой тусгана.
- d) Үйлчлүүлэгч/өвчтөнийг илгээх, шилжүүлэх байгууллагатай харилцан уялдаа холбоог (гэрээ) хангаж ажиллана.
- e) Үйлчлүүлэгч/өвчтөнийг илгээх, шилжүүлэх хуудас нь дараах мэдээллийг агуулна. Үүнд:
 - i. Өвчтөний хувийн мэдээлэл
 - ii. Илгээх, шилжүүлэх заалт
 - iii. Өвчтөний үнэлгээ болон үзүүлсэн тусламжийн мэдээлэл
 - iv. Эмчилгээ, хэрэглэж буй эмийн мэдээлэл
 - v. Тээвэрлэлт болон шаардлагатай хяналт (хамаарах тохиолдолд)
 - vi. Илгээх, шилжүүлэх үеийн өвчтөний биеийн байдал
 - vii. Хүлээж авах эрүүл мэндийн байгууллагын нэр
 - viii. Өвчтөнийг илгээх, шилжүүлэх шийдвэр гаргасан эмчийн нэр

Үнэлгээ хийх чиглэл

1. Үйлчлүүлэгч/өвчтөнийг илгээх, шилжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан журмыг үнэлнэ.
2. Эрүүл мэндийн мэргэжилтэнтэй ярилцаж, Үйлчлүүлэгч/өвчтөнийг илгээх, шилжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан журмын талаарх мэдлэг, ойлголтыг үнэлнэ.
3. Ажилтны Үйлчлүүлэгч/өвчтөнийг илгээх, шилжүүлэх ур чадварыг ажлын байранд ажиглаж үнэлнэ.
4. Илгээсэн, шилжүүлсэн өвчтөний эмнэлгийн бичиг баримтыг хянаж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (a–e заалт) тусгасан үйлчлүүлэгч/өвчтөнийг илгээх, шилжүүлэхтэй холбоотой журамтай байна. ©
------------------------	---	--

2	Үйлчлүүлэгч/өвчтөн илгээх, шилжүүлэх үйл ажиллагаанд оролцдог ажилтан журмын талаар мэдлэг, ойлголттой байна.
3	Үйлчлүүлэгч/өвчтөн илгээх, шилжүүлэх хуудсыг өвчтөний түүх, цахим картанд тодорхой, бүрэн тэмдэглэсэн байна.®
4	Үйлчлүүлэгч/өвчтөн илгээх, шилжүүлэх маягтын мэдээлэл бүрэн (i–viii заалт), өвчтөний түүх, цахим картад хадгалсан байна.®
5	Илгээсэн өвчтөний талаарх эргэн мэдээллийг бүртгэж, гарын үсгээр баталгаажуулсан байна.

Шалгуур 2.9

Телемедициний хүртээмж, хүрээг тодорхойлж, тусламж, үйлчилгээнд ашиглах боломжтой технологийг тодорхойлсон байна.

Агуулга

Телемедицин гэдэг нь харилцаа холбооны технологийг ашиглан өвчтөнийг алсаас оношлох, эмчлэх үйл явцыг хэлнэ. Эмнэлгийн мэргэжилтэн нь видео хурал, утасны дуудлага, платформ, эсвэл бусад виртуал харилцааны хэрэгслийг ашиглан Үйлчлүүлэгч/өвчтөнэмнэлгийн байгууллагад биечлэн очих шаардлагагүйгээр тусламж, үйлчилгээ авах боломжийг олгодог бөгөөд энэ нь тусгай хэрэгцээт болон алслагдсан бүс нутагт амьдардаг иргэдэд онцгой ач холбогдолтой. Телемедициний платформыг олон мэргэжилтний хамтарсан багийн хэлэлцүүлэгт ашиглаж болно. Телемедициний үйлчилгээг тогтвортой, чанартай, үр ашигтай хүргэх зорилгоор тухайн байгууллага нь телемедициний хөтөлбөрийг боловсруулна. Хөтөлбөр нь телемедициний тоног төхөөрөмж болон эрүүл мэндийн мэдээллийн системийн сонголт, уялдаа холбоо, хамтран ажиллах чадвар, үр нөлөөг хангахуйц зохих удирдлага, хяналтыг бүрдүүлэхэд чиглэнэ.

Үүнд:

- a) Телемедицин ашиглах хүрээ, технологийн хэлбэр, аргачлалыг тодорхойлох
- b) Телемедициний тохиромжтой платформ, гар утас эсвэл интернетэд суурилсан аппликейшн, бусад дагалдах төхөөрөмжийг тодорхойлох
- c) Телемедициний эмнэлзүйн үйлчилгээг тогтвортой хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг тодорхойлох
- d) Телемедицин үйлчилгээнд ажиллах ажилтанд зориулсан сургалт
- e) Гэрээт телемедициний үйлчилгээ, чиг үүргийг хянах, удирдах үйл явцыг тодорхойлох
- f) Өвчтөнийг телемедициний үйлчилгээг авах арга зүйгээр хангах
- g) Телемедицин уулзалтын үед Үйлчлүүлэгч/өвчтөн болон эмнэлгийн мэргэжилтний таних мэдээлэл, бодит байршлыг баталгаажуулах, баримтжуулах үйл явцыг тодорхойлох
- h) Нотолгоонд суурилсан удирдамжийг мөрдөх
- i) Амбулаторийн тусламж, үйлчилгээ рүү илгээх эмнэлзүйн шалгуурыг тодорхойлох

- j) Холбогдох хууль, дүрэм, журмын дагуу эрүүл мэндийн мэдээллийн нууцлал, цахим аюулгүй байдлыг хангах үйл явцыг тодорхойлох
- к) Телемедициний тусламж, үйлчилгээний хүртээмж, үр нөлөө, сэтгэл ханамж зэрэг чанарын үзүүлэлтэд тулгуурлан тогтмол үнэлж, сайжруулах

Үнэлгээ хийх чиглэл

1. Телемедициний үйл ажиллагааг зохицуулах журмыг хянаж, үнэлнэ.
2. Телемедицин хариуцсан ажилтны мэргэжлийн ур чадвар, шаардлага хангаж буй эсэхийг үнэлэх зорилгоор ярилцаж, хувийн хэрэг, баримт бичгийг үнэлнэ.
3. Холбогдох ажилтантай ярилцаж, хөтөлбөрийн талаарх мэдлэг, ойлголттой эсэхийг баталгаажуулна.
4. Телемедициний үйлчилгээг тогтвортой үзүүлэхэд шаардлагатай нөөц (хүний нөөц, техник хэрэгсэл, дэд бүтэц)-ийн бэлэн байдлыг ажиглан үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (a–k заалт) тусгасан телемедициний хөтөлбөртэй байна.©
	2	Телемедициний үйлчилгээг тогтвортой үзүүлэхэд шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.
	3	Телемедициний үйлчилгээнд оролцож буй бүх ажилтнууд хөтөлбөрийн талаар мэдлэг, ойлголттой бөгөөд шаардлагатай сургалтад хамрагдсан байна.
	4	Телемедициний үйлчилгээг тогтмол хугацаанд үнэлж, чанарыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

БҮЛЭГ 3. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДМЭЛ БАЙДАЛ

Тойм

Үйлчлүүлэгч/өвчтөн нь эрүүл мэндийн асуудлаар эхний ээлжинд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад (цаашид Төв гэх) ханддаг. Төв нь нэг дор олон төрлийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг тул удирдлагын менежмент, багт суурилсан хандлагыг бий болгох нь маш чухал юм. Нэгдмэл тусламж, үйлчилгээнд илрүүлэг, үнэлгээ, давтан үнэлгээ, лавлагаа, зөвлөгөө, үйлчлүүлэгч/өвчтөний эмийн болон мэс заслын эмчилгээний төлөвлөгөөг боловсруулж, өвчтөнийг мэдээллээр хангах зэрэг цогц үйл ажиллагаа хамаарна. Энэ нь хувь хүний эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн үйлчлүүлэгч/өвчтөн төвтэй тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжийг олгоно.

Илрүүлэг гэдэг нь шинж тэмдэг илрээгүй өвчнийг оношлох зорилгоор хийх цаг хугацаа хэмнэсэн үйл ажиллагаа юм. Үнэлгээ нь цогц үйл явц бөгөөд өвчтөнөөс асуумж авах, өвчний түүхийн талаар мэдээлэл цуглуулах, харж ажиглах, тэмтрэх, тогших, чагнах зэрэг арга техник юм. Үнэлгээнээс гарсан эмнэлзүйн дүгнэлт нь цаашид шаардлагатай үзлэг, оношлогооны хүрээг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Хувь хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээний төлөвлөгөөг олон мэргэжилтний үнэлгээнд үндэслэн, өрхийн эмчийн хяналтан дор боловсруулна. Тусламж, үйлчилгээний зохицуулалтыг сайжруулснаар эрүүл мэндийн зардал буурч, өвчтөний сэтгэл ханамж

нэмэгдэж буй нь судалгаагаар нотлогдсон. Төв нь эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Эх, хүүхдийн эрүүл мэндийн хөтөлбөр нь эх, нялхсын өвчлөл, эндэгдлийг бууруулах, гэр бүлийг эрүүл мэндийн зөв дадал зуршилтай болгох, улмаар эх, хүүхдийн амьдралын чанарыг сайжруулах зорилготой юм. Дархлаажуулалт, эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн арга хэмжээний талаар энэ бүлэгт багтсан болно.

Доорх жагсаалтад энэ бүлэгт хамаарах шалгуурыг нэгтгэн харуулав.

3.1	Тусламж, үйлчилгээг ижил тэгш үзүүлнэ.
3.2	Төв нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрт илрүүлэг зохион байгуулна.
3.3	Үйлчлүүлэгч/өвчтөний эрүүл мэндийн байдлын анхны үнэлгээг хийсэн байна.
3.4	Эрүүл мэндийн үзлэгийн хуудсыг бүрэн хөтөлнө.
3.5	Сувилахуйн тусламж, үйлчилгээний үнэлгээ, төлөвлөлт, гүйцэтгэлийг үнэлдэг байна.
3.6	Амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулна.
3.7	Үйлчлүүлэгч/өвчтөний унах эрсдэлийг илрүүлж, үнэлж, удирдана.
3.8	Тусламж, үйлчилгээний захиалга ба хүсэлтийн мэдээллийг илгээдэг байна.
3.9	Өвдөлтийг үнэлж, тохирсон менежментийг хэрэгжүүлнэ.
3.10	Эмчилгээний төлөвлөгөөг бүртгэж баримтжуулсан байна.
3.11	Үйлчлүүлэгч/өвчтөнөөс амаар, утсаар мэдээлэл авах, өгөх үйл явцыг тодорхойлж, баталгаажуулсан, хэрэгжүүлдэг байна.
3.12	Яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээ нь холбогдох хууль тогтоомжийн дагуу явагдана.
3.13	Амь тэнссэн үеийн тусламж, үйлчилгээг журмын дагуу үзүүлдэг байна.
3.14	Дархлаажуулалтын арга хэмжээг хууль, журмын дагуу хэрэгжүүлнэ
3.15	Заавал хийх дархлаажуулалтын арга хэмжээг хууль, журмын дагуу хэрэгжүүлнэ.
3.16	Сайн дурын дархлаажуулалтын арга хэмжээг хууль, журмын дагуу хэрэгжүүлнэ.
3.17	Хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь үр дүнтэй хэрэгжиж, бүх насны хүүхдийг хамарсан байна.
3.18	Эхийн эрүүл мэндийн арга хэмжээг тушаал, заавар, эмнэлзүйн удирдамжийн дагуу хэрэгжүүлнэ.
3.19	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн арга хэмжээг хууль, журмын дагуу хэрэгжүүлнэ.
3.20	Халдварт бус өвчний тусламж үйлчилгээг хууль эрх зүй, эмнэлзүйн удирдамж, зааварын дагуу хэрэгжүүлнэ.
Халдварт өвчний тусламж, үйлчилгээ	
3.21.1	Халдварт өвчний тусламж үйлчилгээг үзүүлдэг байна.

3.21.2	ХДХВ/ДОХ, БЗДХ-ийн тусламж үйлчилгээг үзүүлдэг байна.
3.21.3	Сүрьеэ өвчний тусламж үйлчилгээг үзүүлдэг байна.
3.21.4	Вируст гепатитын тусламж үйлчилгээг үзүүлдэг байна.
3.22	Тусгай хэрэгцээт үйлчлүүлэгч/өвчтөний бүлэгт зориулсан илрүүлэг, үзлэг, давтан үнэлгээ болон тусламж, үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгийг нарийвчлан тодорхойлсон байна.
Эмчилгээний хоол (СЭМТ хамаарна)	
3.23.1	Хоол үйлдвэрлэлийн нэгжийг байгуулж, эмчилгээний хоолоор үйлчлэх зохион байгуулалтыг хийн, мэргэшсэн мэргэжилтнээр хангасан байна.
3.23.2	Хоолны технологи, нормыг мөрдөж, аюулгүй байдлыг ханган, эмчилгээний хоолны чанарт хяналт тавьдаг байна.
3.23.3	Хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн шаардлагыг мөрддөг байна.

ШАЛГУУР, АГУУЛГА, ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур 3.1

Тусламж, үйлчилгээг ижил тэгш үзүүлнэ.

Агуулга

Төв нь өвчтөний гарал үүсэл, хэл соёл, шашин шүтлэг, эдийн засгийн байдал, боловсролын түвшин, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхалгүй, адил тусламж, үйлчилгээ үзүүлэх зарчмын талаар журамд тусгасан байна. Эмнэлзүйн удирдамж, заавар нь эмнэлгийн мэргэжилтнийг нотолгоонд суурилсан мэдээллээр хангана.

Үнэлгээ хийх чиглэл:

- Бүх өвчтөнд ижил тэгш тусламж, үйлчилгээ үзүүлэх журамтай эсэхийг үнэлнэ.
- Эрүүл мэндийн ажилтантай ярилцаж журмын талаарх мэдлэгийг үнэлнэ.
- Эрүүл мэндийн ажилтантай ярилцаж, эмнэлзүйн удирдамж, зааврын дагуу ижил тэгш тусламж, үйлчилгээ үзүүлэх талаар асууж үнэлнэ.
- Бүх өвчтөнд ижил тэгш тусламж, үйлчилгээ үзүүлэх журмын хэрэгжилтийг ажиглаж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Бүх өвчтөнд ижил тэгш тусламж, үйлчилгээ үзүүлэх журамтай, журмын хэрэгжилтийг хянадаг байна.®
	2	Эрүүл мэндийн ажилтан журмын талаар мэдлэгтэй байна.
	3	Тусламж, үйлчилгээний ижил тэгш байдлыг хангах зорилгоор эмнэлзүйн удирдамж, зааврыг мөрдлөг болгон ажилладаг.
	4	Өвчтөний биеийн байдлын хүнд, хөнгөн, хувь хүний гарал үүсэл, байршил болон цаг хугацаанаас үл хамааран ижил түвшний тусламж, үйлчилгээг тэгш хүртэнэ.

Шалгуур 3.2

Төв нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрт илрүүлэг зохион байгуулна.

Агуулга

Эрт илрүүлэг гэдэг нь өвчний шинж тэмдэг илрээгүй хүн амд оношлогдоогүй байж болзошгүй өвчнийг илрүүлэх зорилгоор хэрэглэдэг арга хэрэгсэл юм.

Үйлчлүүлэгч/өвчтөнд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарыг хангах нэг чухал хэсэг нь үзлэг, оношилгоо хийх эрх бүхий эмнэлгийн мэргэжилтнийг тодорхойлох явдал юм. Төв нь хууль тогтоомжийн дагуу үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн бүх хэрэгцээг тодорхойлохын тулд мэргэшсэн ажилтнаар илрүүлэг, үнэлгээг хийлгэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

Үнэлгээ хийх чиглэл:

1. Төвийн эрүүл мэндийн ажилтан бүрийн албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг үнэлнэ.
2. Эрүүл мэндийн ажилтантай ярилцлага хийж албан тушаал, ажил үүргийн талаарх мэдлэгийг үнэлнэ.
3. Үйлчлүүлэгч/өвчтөний үнэлгээтэй нийцэж байгаа эсэхийг үнэлэхийн тулд өвчний түүх, өвчтөний хяналтын карт, цахим бүртгэлийг хянаж үнэлнэ.

Нэмэлт тайлбар:

4. **Илрүүлэг (Screening):** Ямар нэгэн шинж тэмдэг илрээгүй байгаа хүмүүст өвчний эрсдлийг тодорхойлох зорилгоор хүн амын дунд хийгдэж буй арга хэмжээ.
5. **Үнэлгээ (Assessment):** Өвчтөний биеийн байдал, сэтгэцийн эрүүл мэнд, нийгмийн нөхцөл байдлыг тодорхойлох цогц үйл явц.
6. **Хамтын тусламж, үйлчилгээ (Collaborative care):** Өвчтөний хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээг үзүүлэхийн тулд эрүүл мэндийн мэргэжилтнүүд хоорондоо хамтран ажиллах үйл явц.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь эрт илрүүлэг, үнэлгээ хийх эмнэлгийн мэргэжилтнийг тодорхойлсон байна.®
	2	Эрт илрүүлэг болон үнэлгээнд ажилтан бүрийн хэрэгжүүлэх чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтоор баталгаажуулсан байна.®
	3	Эрт илрүүлэг үнэлгээг өвчтөний хяналтын карт, цахим бүртгэлд тэмдэглэсэн байна.®

Шалгуур 3.3

Үйлчлүүлэгч/өвчтөний эрүүл мэндийн байдлын анхны үнэлгээг хийсэн байна.

Агуулга

Эрүүл мэндийн байдлын анхны үнэлгээ нь эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой шийдвэр гаргах үндэс, суурь болдог. Энэ нь өвчний хүнд, хөнгөнийг тодорхойлох, яаралтай тусламжийн үеийн эрэмбэлэн ангилалт хийхэд тусалдаг. Өвчтөний хэрэгцээнд нийцсэн чанартай тусламж үзүүлэхийн тулд анхны үнэлгээ нь стандарт, удирдамжийн дагуу, иж бүрэн, тодорхой заасан хугацаанд хийгдсэн байна. Төв нь анхны үнэлгээний зорилго болон гүйцэтгэх хугацааг тодорхойлсон журмыг боловсруулж хэрэгжүүлнэ. Анхны үнэлгээний журамд дараах агуулгыг багтаана. Үүнд:

- а) Үйлчлүүлэгч/өвчтөний хувийн мэдээлэл

- b) Нийгмийн байдал
- c) Гэр бүлийн мэдээлэл
- d) Амьдралын түүх
- e) Өвчний түүх
- f) Хоол тэжээлийн хэрэгцээ ба эрсдэл
- g) Хөдөлгөөний чадвар болон сэргээн засах хэрэгцээ
- h) Сэтгэцийн эрүүл мэндийн байдал
- i) Бүтэн биеийн тойм үзлэг
- j) Удирдамжийн дагуу хийгдэх шаардлагатай шинжилгээ, оношилгоо
- k) Дүгнэлт эсвэл эмнэлзүйн урьдчилсан онош

Үнэлгээ хийх чиглэл:

1. Эрүүл мэндийн байдлын анхны үнэлгээ хийх журмыг хянаж үнэлнэ.
2. Ажилтантай ярилцаж, журмын талаарх мэдлэгийг үнэлнэ.
3. Үйлчлүүлэгч/өвчтөний тусламж үйлчилгээ авах үйл явцыг мөшгөн шалгаж, хэрэгжилтийг үнэлнэ.
4. Өвчний түүх, хяналтын карт, цахим бүртгэлийг хянан үзэж, анхны үнэлгээ хийх журмын хэрэгжилтийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (а–к заалт) тусгасан журамтай байна.©
	2	Эмч, мэргэжилтэн журмын талаар мэдлэгтэй байна.
	3	Үзлэг, үнэлгээ, шинжилгээ болон үр дүнг үйлчлүүлэгч/өвчтөний өвчний түүх, хяналтын карт, цахим бүртгэлд тогтоосон хугацаанд бүртгэж, тэмдэглэсэн байна.©

Шалгуур 3.4

Эрүүл мэндийн үзлэгийн хуудсыг бүрэн хөтөлнө.

Агуулга

Эрүүл мэндийн үзлэгийн хуудас нь оношийг баталгаажуулах, эмчилгээний үндэслэлийг тодорхойлох, тусламж үйлчилгээний залгамж холбоог хангах, эмчилгээний явц, үр дүнг тэмдэглэх болон хууль тогтоомжийн шаардлагыг хангах зэрэг үндсэн зорилтуудад нийцсэн дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан байна.

Давтан үзлэг нь өвчтөний эрүүл мэндийн байдлыг дахин үнэлж, эмчилгээг өөрчлөх/шинэчлэх, анхны буюу хамгийн сүүлийн үзлэгээс хойш гарсан өөрчлөлтийг тодорхойлох, хэрэгцээг дахин тодорхойлох зорилготой.

Үзлэгийн хуудсанд дараагийн үзлэгийн хугацааг тэмдэглэнэ. Үзлэгийн хуудсанд дараах агуулгыг оруулна. Үүнд:

- a) Гол зовуурь
- b) Одоогийн өвчний дэлгэрэнгүй мэдээлэл
- c) Амьдралын түүх: хэрэглэсэн эм, эмийн гаж нөлөө, харшил, нийгэм, сэтгэл зүй, зан авир, гэр бүлийн анамнез; өмнөх хэвтэн эмчлүүлсэн, мээ засал, болон инвазив ажилбар хийлгэсэн тухай мэдээлэл
- d) Онош
- e) Хийгдсэн шинжилгээ

- f) Ач холбогдол бүхий эмнэлзүйн өөрчлөлт
- g) Эмчилгээ
- h) Эмчийн нэр болон гарын үсэг

Үнэлгээ хийх чиглэл:

- Өвчтөнд эмнэлзүйн үнэлгээ хийх журмыг үнэлнэ.
- Холбогдох ажилтантай ярилцаж, журмын талаарх мэдлэгийг үнэлнэ.
- Өвчний түүх, өвчтөний хяналтын карт, цахим картын хөтлөлтийг хянан үзэж, журмын шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (a–h заалт) тусгасан үзлэгийн хуудас/маягттай байна.©
	2	Эмч, эмнэлгийн мэргэжилтэн журмын талаар мэдлэгтэй байна.
	3	Ач холбогдол бүхий эмнэлзүйн өөрчлөлт болон шинжилгээний үр дүнг үзлэгийн хуудсанд тэмдэглэсэн байна.
	4	Эрүүл мэндийн үзлэгийн хуудсанд эмчийн нэр болон гарын үсэг байна.
	5	Үзлэг, үнэлгээ, шинжилгээ болон үр дүнг өвчний түүх, хяналтын карт, цахим бүртгэлд тогтоосон хугацаанд бүртгэж, тэмдэглэсэн байна.©

Шалгуур 3.5

Сувилахуйн тусламж, үйлчилгээ, сувилахуйн үнэлгээ, төлөвлөлт, гүйцэтгэлийг үнэлдэг байна.

Агуулга

Сувилахуйн тусламж, үйлчилгээг байгууллагын удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн удирдлага, эмнэл зүйн практик, үйлчлүүлэгч болон ажилтны аюулгүй байдал, тоног төхөөрөмж ба орчны аюулгүй ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлэх, нотолгоонд суурилсан, стандартчилагдсан үйл ажиллагааг хэвшүүлэхэд оршино.

Сувилахуйн тусламж, үйлчилгээний төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ, сайжруулалтын мөчлөгийг тодорхойлж, сувилагч болон тусгай мэргэжилтний мэргэшил, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тохиолдол мэдээлэх тогтолцоог бэхжүүлэхэд анхаарна.

Сувилахуйн анхны үнэлгээ гэж мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй сувилагч өвчтөний физиологи, сэтгэл зүй, нийгэм болон оюун санааны байдлын талаар мэдээлэл цуглуулахыг хэлэх ба энэ нь сувилахуйн тусламж, үйлчилгээний эхний шат юм. Сувилахуйн давтан үнэлгээ нь өвчтөний биеийн байдал, онош, эмчилгээнээс хамаарч харилцан адилгүй байж болно. Төв нь сувилахуйн үнэлгээний журмыг боловсруулж, хэрэгжүүлнэ. Сувилахуйн анхны үнэлгээний журамд дараах үйл ажиллагааг багтаана. Үүнд:

- a) Амин үзүүлэлт
- b) Өвдөлт
- c) Нэмэлт хэмжилт (жишээ нь: өндөр, жин гм)
- d) Эрсдэлийн үнэлгээ

е) Өвчний зовуурь, эрхтэн тогтолцооны өөрчлөлттэй холбоотой нарийвчилсан сувилахуйн үнэлгээ

Үнэлгээ хийх чиглэл

1. Сувилахуйн алба/баг байгуулсан тушаал, эрх үүрэг, албан тушаалын тодорхойлолтыг үзэж үнэлнэ.
2. Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлт, үр дүнг үнэлнэ.
3. Сувилахуйн тусламжийн стандарт, удирдамж, технологийг мөрддөг.
4. Гардан үйлдлийн ур чадварыг тогтмол үнэлж, сайжруулдаг.
5. Сувилахуйн онош, сувилгааны түүхийг бүрэн, үнэн зөв хөтөлдөг.
6. Эмнэл зүйн хэлэлцүүлэг, багийн хамтын ажиллагаа тогтмол явагддаг.
7. Сувилахуйн тусламж, үйлчилгээг төвийн стратеги төлөвлөгөөнд тусгасан, хэрэгжилт, үр дүнг тогтмол үнэлдэг эсэхийг үзэж үнэлнэ.
8. Сувилахуйн үнэлгээ хийх журмыг үнэлнэ. ⑤
9. Сувилагчтай ярилцаж, журмын талаарх мэдлэгийг үнэлнэ.
10. Сувилахуйн үнэлгээг журамд заасан хугацаанд хийдэг эсэхийг үнэлнэ.
11. Сувилахуйн үнэлгээг журмын дагуу хийдэг эсэхийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Сувилахуйн алба/баг байгуулж, хариуцсан мэргэжилтэнг томилж, ажил үүргийн хуваарийг баталсан, мөрдөж ажилладаг байна.
	2	Төвийн стратеги төлөвлөгөөнд сувилахуйн тусламж, үйлчилгээний үйл ажиллагааг тусгасан байна.
	3	Сувилахуйн тусламж, үйлчилгээний батлагдсан төлөвлөгөө тайлантай байна. Төлөвлөгөөнд чанар, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр ажил тусгагдсан байна.
	4	Сувилахуйн тусламж, үйлчилгээний жагсаалтыг батлуулж хэрэгжүүлдэг байна.
	5	Жирэмсэн болон төрсөн эх, нярай, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй болон хөнгөвчлөх тусламж шаардлагатай хүнд тусламж үйлчилгээг үзүүлж, зөвлөгөө өгч, анхан шатны маягтыг хөтөлж бүртгэл, мэдээ, тайлантай.
	6	Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын нийтлэг, өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг баталсан
	7	Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтэд жил бүр дүн шинжилгээ хийж, удирдлагын зөвлөлд танилцуулж, хэлэлцүүлдэг байх
	8	Сувилахуйн тусламж, үйлчилгээтэй холбоотой анхан шатны бүртгэлийн маягтын жагсаалттай, маягтын хөтлөлт, хяналт үр дүнг тооцсон тайлантай байна.
	9	Хяналт, үнэлгээний батлагдсан хуваарьтай, хяналтыг хийдэг байна.
	10	Тусламж, үйлчилгээний чиглэл бүрээр боловсруулсан хяналтын хуудастай, нэр төрлийг нэмэгдүүлдэг байна.

	11	Үнэлгээнд тулгуурлан сайжруулах зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнг тооцдог
	12	Агуулгад (а–е заалт) тусгасан сувилахуйн анхны үнэлгээний журамтай байна. ⑥
	13	Сувилагч нь сувилахуйн үнэлгээний журмын талаар мэдлэгтэй байна.
	14	Сувилахуйн үнэлгээг тодорхой хугацаанд бүртгэж, тэмдэглэн баримтжуулсан байна. ⑥

Шалгуур 3.6

Амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулна.

Агуулга

Амны хөндийн эрүүл мэнд нь хүний эрүүл мэндийн чухал үзүүлэлт юм. Үүнд шүд цоорох, буйлны өвчин, шүд унах, амны хөндийн гэмтэл зэрэг өвчин эмгэг багтана. Төв нь амны хөндийн эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах журам боловсруулж, хэрэгжүүлнэ.

Журам нь дараах агуулгатай байна. Үүнд:

- a) Амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах шаардлагатай зорилтот бүлгийг тодорхойлох
- b) Амны хөндийн эрүүл мэндийн үзлэг хийх заавар

Үнэлгээ хийх чиглэл:

- Амны хөндийн эрүүл мэндийн аюулгүй тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг үнэлнэ.
- Амны хөндийн эрүүл мэндийн картыг үзэж, журмын шаардлага хангаж байгаа эсэхийг үнэлнэ.
- Ажилтантай ярилцлага хийж, журмын талаарх мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлнэ.
- Амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ажиглаж, үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (а–е заалт) тусгасан журамтай байна. ⑥
	2	Холбогдох ажилтан журмын талаар мэдлэгтэй байна.
	3	Амны хөндийн эрүүл мэндийн үзлэгийг журмын дагуу хэрэгжүүлсэн байна.
	4	Амны хөндийн эрүүл мэндийн үзлэгийг өвчтөний хяналтын карт, цахим бүртгэлд бүртгэж, баталгаажуулсан байна. ⑥

Шалгуур 3.7

Үйлчлүүлэгч/өвчтөний унах эрсдэлийг илрүүлж, үнэлж, удирдана.

Агуулга

Бүх үйлчлүүлэгч/өвчтөн унах эрсдэлтэй байдаг ч зарим нь илүү өртөмтгий байдаг. Илүү өртөмтгий үйлчлүүлэгч/өвчтөнийг унахаас урьдчилан сэргийлэх Зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийнэ. Төв нь унах эрсдэлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх үйл

явцыг удирдан чиглүүлэх журмыг боловсруулж, хэрэгжүүлэх ёстой. Журам нь дараах агуулгатай байна. Үүнд:

- a) Төвийн гадаад, дотоод орчинд үйлчлүүлэгч/өвчтөний унах эрсдэлийг эмч, сувилагч илрүүлэх
- b) Эмийн болон бусад эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх
- c) Эрсдэлийг журамд заасан хугацаанд хийх
- d) Унах эрсдэлийн давтан үнэлгээг хийх
- e) Гэрэлтүүлэг, ханын бариул, угаалгын өрөөний бариул, түгжээтэй тэргэнцэр зэрэг унах эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ
- f) Хувь хүний унах эрсдэлийн үнэлгээнд тохирсон асаргаа сувилгааны төлөвлөгөө

Үнэлгээ хийх чиглэл:

- Унах эрсдэлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх үйл явцыг зохицуулах журмыг үзэж үнэлнэ.
- Унах эрсдэлийн үнэлгээг өвчний түүх, өвчтөний хяналтын карт, цахим бүртгэлд тэмдэглэсэн эсэх, унах эрсдэлийн үнэлгээнд тохирсон асаргаа сувилгааны төлөвлөгөөг үнэлнэ.
- Унах эрсдэлийн үнэлгээ, хэрэглэж буй эмийн жагсаалт болон үйлчлүүлэгч/өвчтөн, түүний гэр бүлд зориулсан унахаас урьдчилан сэргийлэх сурталчилгааны материал зэргийг үнэлнэ.
- Эрүүл мэндийн ажилтантай ярилцаж, журмын талаарх мэдлэгийг үнэлнэ.
- Өвчтөн болон түүний гэр бүлтэй ярилцаж, унах эрсдэл, унахаас урьдчилан сэргийлэх талаарх ойлголт, мэдлэгийг үнэлнэ.
- Унахаас урьдчилан сэргийлэх нийтлэг арга хэмжээ (гэрэлтүүлэг, ханын бариул, угаалгын өрөөний бариул, түгжээтэй тэргэнцэр, анхааруулга, үйлчлүүлэгч/өвчтөнд ойлгомжтой таних тэмдэг, тэмдэглэгээ) хэрэгжүүлсэн эсэхийг ажиглаж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (a–f заалт) тусгасан журамтай байна.©
	2	Ажилтан журмын талаар мэдлэгтэй байна.
	3	Үйлчлүүлэгч/өвчтөн болон түүний гэр бүл унах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдлэгтэй, хэрэгжүүлдэг байна.
	4	Унах эрсдэлийн үнэлгээний талаар өвчний түүх, өвчтөний хяналтын карт, цахим бүртгэлд тэмдэглэсэн байна.©
	5	Унах эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ болон асаргаа, сувилгааны төлөвлөгөөг өвчний түүх, хяналтын карт, цахим бүртгэлд тэмдэглэсэн байна.

Шалгуур 3.8

Тусламж, үйлчилгээний захиалга ба хүсэлтийн мэдээллийг илгээдэг байна.

Агуулга

Тусламж, үйлчилгээний захиалга болон хүсэлт гэдэг нь эмч, эмнэлгийн мэргэжилтний зүгээс өвчтөнд үзүүлэх тодорхой тусламж, үйлчилгээг чиглүүлсэн харилцаа юм.

Тусламж, үйлчилгээний захиалга болон хүсэлтийг бичгээр, утсаар, амаар, цахимаар өгнө.

Тусламж, үйлчилгээний захиалга болон хүсэлтийн мэдээлэл нь гүйцэтгэх ажилтан болон өвчтөнд тодорхой, ойлгомжтой байна. Тусламж, үйлчилгээний захиалга, хүсэлтийн хуудсанд дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- a) Захиалга өгсөн эмнэлгийн ажилтны нэр
- b) Захиалгын огноо, цаг, минут
- c) Үйлчлүүлэгч/өвчтөний овог, нэр, нас, хүйс
- d) Захиалга, хүсэлтийн эмнэлзүйн заалт
- e) Бэлтгэх үйл ажиллагаанд тавигдах шаардлага
- f) Эрсдлээс сэргийлэх арга хэмжээ
- g) Дүрс оношилгооны үед байршил болон тал (баруун, зүүн)-ыг тодорхой заах
- h) Захиалга болон хүсэлтийг эмнэлгийн ажилтан яаралтай баталгаажуулах (нэр, гарын үсэг/ цахим гарын үсэг)

Үнэлгээ хийх чиглэл:

- Өвчтөний эмнэлгийн түүхээс санамсаргүй түүвэр авч, захиалга, хүсэлт нь бүрэн, үнэн зөв эсэхийг үнэлнэ.
- Эмнэлгийн ажилтантай ярилцаж, захиалга, хүсэлтийн шаардлагын талаар мэдлэгтэй эсэхийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Эмнэлгийн ажилтан нь тусламж, үйлчилгээний захиалга, хүсэлтийн шаардлагыг мэддэг байна.
	2	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний захиалга, хүсэлтийн хуудсанд (агуулгад a–h заалт) шаардлагатай мэдээллийг тусгасан байна.®
	3	Тусламж, үйлчилгээний захиалга, хүсэлтийн хуудсыг бүрэн, үнэн зөв хөтөлсөн эсэхийг үнэлдэг байна.
	4	Тусламж, үйлчилгээний захиалга, хүсэлтийн хуудас тодорхой бус, дутуу үед шаардлагатай мэдээллийг тодруулсан байна.

Шалгуур 3.9

Өвдөлтийг үнэлж, тохирсон менежментийг хэрэгжүүлнэ.

Агуулга

Өвчтөн бүр өвдөлтгүй амьдрах эрхтэй. Өвдөлтийг зүй зохистой удирдсанаар үйлчлүүлэгчийн ая тухтай байдал хангагдаж, биеийн үйл ажиллагаа сэргэн, тусламж, үйлчилгээний сэтгэл ханамж дээшилнэ. Өвдөлтийг илрүүлэх, үнэлэх, давтан үнэлэх болон менежмент хийх журмыг боловсруулан хэрэгжүүлнэ. Журамд дараах агуулгыг тусгана. Үүнд:

- a) Өвдөлтийг илрүүлэх, хэмжих арга хэрэгсэл
- b) Өвдөлтийн үнэлгээ (шинж чанар, байршил, хүнд хөнгөний зэрэг гм)
- c) Өвдөлтийг давтан үнэлэх хугацаа
- d) Өвдөлтийн менежментийн удирдамж, заавар

Үнэлгээ хийх чиглэл:

- Өвдөлтийг илрүүлэх, үнэлэх, давтан үнэлэх болон менежмент хийх журмыг үнэлнэ.

- Ажилтантай ярилцаж, журмын талаарх мэдлэгийг үнэлнэ.
- Өвчтөний түүх, хяналтын карт, цахим бүртгэлийг хянаж, өвдөлтийн үнэлгээ, удирдах төлөвлөгөө, дахин үнэлгээ зэрэг баримтжуулалтыг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (a–d заалт) тусгасан журамтай байна.©
	2	Ажилтан журмын талаар мэдлэгтэй байна.
	3	Өвдөлт үнэлсэн өвчтөний бүртгэл, судалгаатай байна.
	4	Өвдөлтийн менежментийг хийсэн байна.
	5	Өвдөлтийн үнэлгээ, дахин үнэлгээ, удирдах төлөвлөгөөг өвчтөний түүх, өвчтөний хяналтын карт, цахим бүртгэлд тэмдэглэсэн байна.

Шалгуур 3.10

Эмчилгээний төлөвлөгөөг бүртгэж баримтжуулсан байна.

Агуулга

Тусламж, үйлчилгээний төлөвлөгөө нь үйлчлүүлэгч, түүний гэр бүл болон олон нийтэд шаардлагатай эрүүл мэндийн тусламжийн төрөл, чиглэлийг тодорхойлох үндсэн арга зам болно.

Тусламж, үйлчилгээний төлөвлөгөө нь стандарт эмнэлзүйн заавар, удирдамжийн дагуу, нотолгоонд суурилсан цогц тусламжийг үзүүлэхэд оршино. Төлөвлөгөөг албан ёсоор баримтжуулах нь эмч, сувилагч болон бусад эрүүл мэндийн мэргэжилтний хийсэн үзлэг, үнэлгээний үр дүнг нэгтгэх, улмаар үйлчлүүлэгчийн биеийн байдалд тохирсон хамгийн оновчтой арга замыг нэгдмэл ойлголттойгоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг. Олон мэргэжилтний багийн хамтын ажиллагаа нь тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах бөгөөд мэргэжилтэн хоорондын уялдаа холбоог сайжруулж эмчилгээ, сувилгааны үр дүнг нэмэгдүүлнэ.

Эмчилгээний төлөвлөгөөнд тавих шаардлага:

- Холбогдох мэргэжилтнүүд хамтран өрхийн эмчийн хяналтан дор тусламж, үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулах
- Үзлэг, шинжилгээний үр дүнд үндэслэх
- Өвчтөн, түүний гэр бүлийг оролцуулан, хамтран шийдвэр гаргах
- Өвчтөний хэрэгцээ, сонголтонд нийцүүлэн шинэчлэх
- Хүлээж буй үр дүн, хугацаа тодорхой байх
- Өвчтөний давтан үнэлгээний дагуу шинэчилдэг байх
- Эмчилгээ, үйлчилгээний зорилго, хүссэн үр дүн, өвчтөний сайжралыг явцыг хянадаг байх

Үнэлгээ хийх чиглэл:

- Эмчилгээний төлөвлөгөөнд тавих шаардлагыг хангаж байгаа эсэхийг өвчний түүх, хяналтын карт, цахим бүртгэлээр үнэлнэ.
- Эмчилгээний төлөвлөгөөг боловсруулахад өвчтөн болон түүний гэр бүлийн оролцоог хангасан эсэхийг ярилцлага хийж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Холбогдох мэргэжилтэн нь өөрийн хийсэн үнэлгээнд үндэслэн өвчтөний эмчилгээний төлөвлөгөөг боловсруулахад оролцсон байна.
------------------------	----------	---

	2	Агуулгад (а-г заалт) тусгасан эмчилгээний төлөвлөгөөг өвчний түүх, хяналтын карт, цахим бүртгэлд баримтжуулсан байна.©
	3	Эмчилгээний төлөвлөгөөг боловсруулахад өвчтөн болон түүний гэр бүлийн оролцоог хангасан байна.
	4	Өвчтөний биеийн байдал өөрчлөгдсөн үед давтан үнэлгээ хийж, эмчилгээний төлөвлөгөөг өөрчилж, шинэчилсэн байна.

Шалгуур 3.11

Үйлчлүүлэгч/өвчтөнөөс амаар болон утсаар мэдээлэл авах, өгөх үйл явцыг тодорхойлж, баталгаажуулан хэрэгжүүлдэг байна.

Агуулга

Эмнэлзүйн харилцааны алдаа нь үл ойлголцлын хамгийн түгээмэл шалтгаан болдог. Мэдээллийг хүлээн авч буй эрүүл мэндийн ажилтан бүрэн бичиж аваад унших нь харилцааны алдааг багасгаж, тодорхой бус яриа, нэр томъёо, дуудлагаас үүдэлтэй алдааг бууруулдаг. Төв нь үйлчлүүлэгч/өвчтөнөөс амаар болон утсаар мэдээлэл авах, өгөх журмыг боловсруулж, хэрэгжүүлдэг байна.

Журамд дараах агуулгыг тусгана. Үүнд:

- Амаар болон утсаар зааварчилгаа өгөх боломжтой тохиолдлыг тогтооно.
- Амаар болон утсаар авах, өгөх мэдээллийг хүлээн авагч баримтжуулна.
- Амаар болон утсаар авч, өгсөн мэдээллийг хүлээн авагч буцааж уншдаг байна.
- Амаар болон утсаар авч, өгсөн мэдээллийг ажилтан баталгаажуулна.

Үнэлгээ хийх чиглэл:

- Амаар болон утсаар мэдээлэл, /үзлэгийн захиалга/ авах, өгөх журмыг үнэлнэ.
- Ажилтантай ярилцаж, журмын талаарх мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлнэ.
- Амаар болон утсаар авч, өгсөн мэдээллийг бүртгэсэн эсэхийг шалгахын тулд өвчтөний түүх, өвчтөний хяналтын карт, цахим бүртгэлийг хянаж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (а–d заалт) тусгасан журамтай байна.©
	2	Ажилтан журмын талаар мэдлэгтэй байна.
	3	Амаар болон утсаар авч, өгсөн мэдээллийг тогтоосон хугацаанд эрүүл мэндийн бүлгээр ялгаж бүртгэсэн байна.
	4	Амаар болон утсаар авч, өгсөн мэдээллийн тайланг хянаж, сайжруулахын тулд зохих арга хэмжээ авдаг байна.©

Шалгуур 3.12

Яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээ нь холбогдох хууль, тушаал, журмын дагуу явагдана.

Агуулга

Төв нь хууль, тушаал, журамд нийцсэн яаралтай тусламжийн үйлчилгээг үзүүлж, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллаж, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулна. Яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээний журмыг боловсруулж хэрэгжүүлнэ.

Журамд дараах агуулгыг тусгана. Үүнд:

- a) Ажилтан бүр ажлын байр дээр яаралтай тусламжийн сургалтад хамрагдсан байна.
- b) Яаралтай тусламжийн эрэмбэлэн ангилалтыг зөвшөөрөгдсөн загвараар тодорхойлсон байна.
- c) Үнэлгээ, давтан үнэлгээ, тусламж, үйлчилгээний менежментийг батлагдсан эмнэлзүйн заавар, удирдамжийн дагуу үзүүлнэ.
- d) Яаралтай тусламжийн хуудас нь дараах агуулгатай байна:
 - I. Ирсэн, эрэмбэлсэн, эмч үзсэн, шийдвэрлэсэн, нийт цаг
 - II. Анхны үзлэг, эрт сэрэмжлүүлэх үнэлгээ
 - III. Тархвар судлалын асуумж
 - IV. Бодит үзлэг
 - V. Шинжилгээний төлөвлөгөө
 - VI. Урьдчилсан, ялгах онош
 - VII. Шийдвэрлэсэн байдал
 - VIII. Эмчилгээ
 - IX. Эмчийн нэр, гарын үсэг

Үнэлгээ хийх чиглэл:

- a) Яаралтай тусламж өвчтөний бүртгэлийг үнэлнэ.
- b) Яаралтай тусламжийн хуудсыг хянаж үнэлнэ.
- c) Эрүүл мэндийн ажилтны яаралтай тусламжийн сургалтад хамрагдсан тухай баталгаажуулалтыг үнэлнэ.
- d) Эрүүл мэндийн ажилтны яаралтай тусламж үзүүлэх гардан үйлдлийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (a–d заалт) тусгасан журамтай байна.©
	2	Сургалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтан яаралтай тусламж үзүүлдэг байна.
	3	Яаралтай тусламж үзүүлсэн өвчтөний бүртгэл байна.©
	4	Яаралтай тусламжийн хуудас i-ix заалтыг агуулсан байна.

Шалгуур 3.13

Амь тэнссэн үеийн тусламж, үйлчилгээг журмын дагуу үзүүлдэг байна.

Агуулга

Төвд үйлчлүүлж буй өвчтөнд яаралтай тусламж шаардсан амь тэнссэн нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй. Яаралтай тусламж, үйлчилгээний сайн үр дүнд хүрэхэд цаг хугацаа болон ур чадвар нэн чухал. Амилуулах суурь тусламжийн сургалтад хамрагдсан ажилтан ямар ч гэнэтийн нөхцөл байдалд хариу арга хэмжээ авахад бэлэн байна. Төв нь амь тэнссэн үед аюулгүй менежментийг хангахын тулд журам боловсруулж, хэрэгжүүлнэ.

Журамд дараах агуулгыг тусгана. Үүнд:

- Насанд хүрсэн үйлчлүүлэгч/өвчтөн болон хүүхдийн амь тэнссэн нөхцөл байдлыг оношлох/таних шинж тэмдэг
- Ажилтнуудыг тухайн шинж тэмдгийг таних чиглэлээр сургах
- Яаралтай тусламжийн багт ажиллах ажилтныг томилох
- Яаралтай тусламжийн баг дуудах, кодын менежмент
- Хариу арга хэмжээ авах тогтоосон хугацаа
- Хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах
- Авсан хариу арга хэмжээг хөтлөх/баримтжуулах
- Яаралтай тусламжийн багаж хэрэгсэл, эмийн нөөцийн удирдлага

Тухайлбал:

- Хууль, журам, стандартад нийцсэн шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт (жишээ нь: дефибриллятор, даралтын аппарат, чагнуур, төрөл бүрийн хэмжээтэй амьсгалын аппарат (амбу маск) багтсан байна)
- Тоног төхөөрөмж, хэрэгсэл нь насны онцлогт тохирсон байх
- Ашигласны дараа, эсвэл хугацаа дууссан, эвдэрсэн тохиолдолд даруй солих.
- Тодорхой байршилд бэлэн байлгаж, өдөр бүр шалгаж байх

Үнэлгээ хийх чиглэл:

- Амьсгал, зүрх зогсолтын үеийн аюулгүй менежментийг зохицуулсан журмыг үнэлнэ.
- Ажилтантай ярилцаж, журмын талаарх мэдлэг үнэлнэ.
- Амь тэнссэн үеийн тусламж, үйлчилгээний тэмдэглэлийг шалгахын тулд өвчтөний түүх, өвчтөний хяналтын карт, цахим бүртгэл түүвэрлэлт хийж хянаж үнэлнэ.
- Холбогдох ажилтны мэргэшил болон сургалтад хамрагдсан бүртгэлийг шалгахын тулд хувийн хэргийн бүрдэлтэй танилцаж үнэлнэ.
- Насны онцлогт тохирсон яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, эм, хэрэгслийн бэлэн байдал болон ажиллагааг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (a–h заалт) тусгасан журамтай байна.®
	2	Ажилтан журмын талаар мэдлэгтэй байна.
	3	Амилуулах суурь тусламжийн сургалтад хамрагдсан ажилтан амь тэнссэн нөхцөл байдлыг удирдах үүрэгтэй байна.
	4	Насны онцлогт тохирсон яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, эм, хэрэгсэл бэлэн байна.

	5	Тоног төхөөрөмж, хэрэгслийг өдөр бүр шалгаж, ашигласан нэг удаагийн хэрэгслийг сольдог байна.
	6	Амь тэнссэн үеийн менежментийн явцыг өвчний түүх, хяналтын карт, цахим бүртгэлд тэмдэглэсэн байна.©

Шалгуур 3.14

Дархлаажуулалтын арга хэмжээг хууль, журмын дагуу хэрэгжүүлнэ.

Агуулга

Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, алдаанаас урьдчилан сэргийлэхийн тулд дархлаажуулалтын арга хэмжээний журмыг мөрдөж ажиллана.

Шаардлагатай дархлаажуулалтад бүрэн хамрагдах, мөн дархлаажуулалтаас хоцорсон шалтгааныг тодорхойлж, арилгахын тулд хоцорсон болон тасалсан үйлчлүүлэгчийг эргэн хянадаг байна.

Дархлаажуулалтын өрөө нь стандартад нийцсэн урсгал, бүтэц, тоног төхөөрөмжтэй байх бөгөөд хүүхэд болон үйлчлүүлэгчдэд үзүүлэх тусламж, үйлчилгээнд тохирсон байна. Дархлаажуулалтын үйл явцыг хуулийн дагуу зөв зохион байгуулна. Үүнд: дархлаажуулалтын хуваарь, зөв тунгаар, зөв талбайд тарих, хүүхдийг зөв байрлалд барих зэрэг орно.

Үнэлгээ хийх чиглэл:

- Дархлаажуулалтын товллын дагуу хамрагдсан болон хоцорсон өвчтнийг хянах зааврыг үнэлнэ.
- Ажилтантай ярилцлага хийж, журмын талаарх мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлнэ.
- Дархлаажуулалтын өрөөний байршил, хаалга, гарын ариун цэврийн хэрэгсэл, шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслийн бэлэн байдлыг үнэлнэ.
- Дархлаажуулалтаас хоцорсон үйлчлүүлэгчийн хувь хэмжээг хянаж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Дархлаажуулалт хийх эрүүл ахуйн шаардлага хангасан өрөөтэй байна.
	2	Гарын ариун цэврийн хэрэгсэл, мөс, хөргөгч, термометр, хөргөгчний температурын хяналтын хуудас байрлана.
	3	Орон тоогоор болон орлон ажиллах вакцилотар сувилагчийг сургаж, бэлтгэсэн.
	4	Үндэсний дархлаажуулалтын арга хэмжээний дагуу вакцины хамралтын хувь хэмжээг тогтмол тооцож, бүртгэх бөгөөд дархлаажуулалтаас хоцорсон үйлчлүүлэгчийн тоо, хувийг тооцно.©
	5	Дархлаажуулалтаас хоцорсон үйлчлүүлэгчийг нөхөн дархлаажуулсан байна.©

Шалгуур 3.15

Заавал хийх дархлаажуулалтын арга хэмжээг хууль, журмын дагуу хэрэгжүүлнэ.

Агуулга

Заавал хийх дархлаажуулалт хийлгэхээр ирсэн хүүхдийг үзлэгт хамруулж, дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах журам боловсруулна. Журамд дараах агуулгыг тусгана. Үүнд:

- a) Үзлэгээр хүүхдийн эрүүл мэндийн байдлыг үнэлж, эцэг эхээс хүүхдийн биеийн байдал, вакцины эсрэг заалтын талаар тодруулна.
- b) Эрүүл мэндийн ажилтан эцэг эхчүүдэд дархлаажуулалтын ач холбогдол, урьдчилан сэргийлэх өвчнүүд, вакцины товллол, вакциныг насанд нь хийлгэхийн ач холбогдол, хүүхдийн дархлаажуулалтын картын талаар тайлбарлаж өгнө.
- c) Үзлэгээр өмнөх дархлаажуулалтын дараах урвал хүндрэл, одоогийн эсрэг заалтыг тодорхойлно.
- d) Нэг өдөр хийх вакцины талаар тусгасан байна.
- e) Дархлаажуулалтын бүртгэлийг үнэн зөв, бүрэн хийнэ.
- f) Эцэг эхийг дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн мэдээллийг өгөх дадалд сургадаг байна.

Үнэлгээ хийх чиглэл:

- Заавал хийх дархлаажуулалтын арга хэмжээг удирдах журмыг үнэлнэ.
- Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тайланг үнэлнэ.
- Дархлаажуулалтын бүртгэлийг үнэлнэ.
- Эцэг эхтэй ярилцаж, хүүхдийн дархлаажуулалтын талаарх өөрийн туршлага, авсан мэдээллийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (a–f заалт) тусгасан журамтай байна. ⑥
	2	Эмч, мэргэжилтэн хүүхдийн дархлаажуулалтын байдлыг шалгаж, шаардлагатай бол вакцин хийнэ.
	3	Эмч, мэргэжилтэн эцэг эхэд дархлаажуулалтын талаар мэдээлэл өгч, эсрэг заалтын талаар асууж, вакцин хийхийн өмнө тухайн вакцины эрсдэл, ашиг тус, гаж нөлөөг тодорхой тайлбарлаж өгнө.
	4	Эмч, мэргэжилтэн товлолын дагуу вакциныг хийх бөгөөд зөвхөн эсрэг заалттай тохиолдолд татгалзах буюу хугацааг түр хойшлуулна.
	5	Эмч, мэргэжилтэн дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг шуурхай, үнэн зөв, бүрэн мэдээлнэ.

Шалгуур 3.16

Сайн дурын дархлаажуулалтын арга хэмжээг хууль, журмын дагуу хэрэгжүүлнэ.

Агуулга

Иргэдэд сайн дурын дархлаажуулалтын ашиг тус, эрсдэлийн талаар мэдээллээр хангаж, тэдний эрх, боломжийг нэмэгдүүлнэ. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид тухайн өвчтөний нас, эрүүл мэндийн байдал, амьдралын хэв маяг, ажил мэргэжил болон бусад эрсдэлт хүчин зүйлсийг харгалзан, яагаад зөвлөж буй вакцин нь тэдэнд тохиромжтой болох талаарх шалтгааныг тухайн хүнд нь зориулан тусгайлан тайлбарлах шаардлагатай. Эмч, мэргэжилтэн вакцины ач холбогдлыг

бататгах, түүнд итгэх итгэлийг бэхжүүлэх зорилгоор вакцинтай холбоотой эерэг туршлагыг шаардлагатай үед онцлон хуваалцаж болно. Вакцины гаж нөлөө, аюулгүй байдал, үр дүнгийн талаарх өвчтөний асуулт, санаа зовнилыг энгийн, ойлгомжтой хэлээр тайлбарлаж өгнө.

Төвийн эмч, мэргэжилтэн вакцины хадгалалт, тээвэрлэлт, хэрэглээний талаар сургалтад хамрагдаж, боловсрол эзэмшсэн байх бөгөөд өвчтөнд зохих тусламж үзүүлэх чадвартай байх шаардлагатай. Төв нь дархлаажуулалт зайлшгүй шаардлагатай иргэдийн бүлгийг тодорхойлж жагсаалт гаргана. Үүнд: жирэмсэн эмэгтэйчүүд, халдварт өвчин тархсан бүс нутагт амьдардаг хүмүүс, халдварт өвчин тархсан бүс нутаг руу зорчигчид, тодорхой халдварт өвчний ойрын хавьтал, үндэсний аянд хамрагдах зорилтот бүлгүүд болон бусад хүмүүс багтана.

Үнэлгээ хийх чиглэл:

- a) Сайн дурын дархлаажуулалтын арга хэмжээг удирдах журмыг үнэлнэ.
- b) Вакцин бүрийн зааврыг харж үнэлнэ.
- c) Сайн дурын дархлаажуулалтын бүртгэлийг харж үнэлнэ.
- d) Үйлчлүүлэгч/өвчтөнтэй ярилцаж, сайн дурын дархлаажуулалтын туршлага, авсан мэдээллийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Сайн дурын дархлаажуулалтын аюулгүй, үр дүнтэй хэрэгжүүлэх батлагдсан журамтай байна.©
	2	Ажилтан журмын талаар мэдлэгтэй байна.
	3	Вакцины зааврыг ил байршуулна.
	4	Иргэн вакцины талаар энгийн, ойлгомжтой хэлээр мэдээлэл авдаг.
	5	Дархлаажуулалтын бүртгэл үнэн зөв, ашиглахад хялбар байна.©

Шалгуур 3.17

Хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь үр дүнтэй хэрэгжиж, бүх насны хүүхдийг хамарсан байна.

Агуулга

Хүүхэд нас бол өвчлөл болон эндэгдэлтэй холбоотой амьдралын хамгийн эгзэгтэй үе юм. Эрүүл мэндийн оновчтой тусламж үйлчилгээ авах нь хүүхдийн үндсэн эрх юм. Тогтвортой хөгжлийн зорилтод хүрэхийн тулд хүүхдийн эрүүл мэндийг дэмжихэд анхаарал хандуулах шаардлагатай. Эмч нярайн эрүүл мэндийн асуудлыг (жишээ нь төрөлхийн гажиг, бамбай булчирхайн дутагдал, нүдний салст бүрхэвчийн үрэвсэл) илрүүлэх болон хяналт тавихад чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүүхдийн өсөлт, хөгжлийг тогтмол хянах нь тэдний эрүүл мэндийг хамгаалахаас гадна эмнэлгийн шаардлагагүй ачааллыг бууруулж, тусламж үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлдэг. Хүүхэд бүрийг өсөлт, хөгжлийн хувьд тогтмол үнэлж, хэвийн түвшинд байгаа эсэхийг баталгаажуулах шаардлагатай.

Тогтмол үзлэг, үнэлгээ нь хүүдийн өсөлт, хоол тэжээл, эрүүл мэндийн өөрчлөлтийг эрт илрүүлж, зохистой удирдах боломжийг бүрдүүлдэг. Үнэлгээнд гэр бүл, эх, хүүхдийн эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэхийг багтаана. Эрүүл мэндийн өндөр эрсдэлт хүчин зүйлтэй болон нийгмийн халамж, хамгаалал сул орчинд буй

хүүхдүүдийг илрүүлж, зохих үйлчилгээ болон эрх бүхий байгууллагад холбон зуучлах чухал үүрэгтэй. хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгох, урьдчилан сэргийлэх болон эмчлэн эдгэрүүлэх тусламжийг үзүүлэхийн зэрэгцээ нийгмийн эрүүл мэндийн хүчин зүйлсийг харгалзан үзэж, эцэг эхчүүдэд хүүхдээ эрүүл өсгөх мэдлэг, чадвар олгоход анхаарна.

Уг үйлчилгээг шууд үзүүлдэггүй байсан ч харьяа нутаг дэвсгэрийнхээ хүүхдүүдийг эдгээр тусламжид заавал хамруулах механизмыг бүрдүүлсэн байх үүрэгтэй.

Төв нь хүүхдийн эрүүл мэндийн арга хэмжээг өөрийн байгууллагын онцлогт тохируулан зохион байгуулах журам боловсруулж, дараах зүйлсийг заавал тусгасан байна:

- a) Бүртгэл: Хүүхэд бүрийг эрүүл мэндийн тогтолцоонд албан ёсоор бүртгэж, хувийн хэрэг нээх
- b) Нярайн эрүүл мэндийн асуудлыг илрүүлэх: Төрсний дараах эхний үед гарч болох эмгэг, согогийг эрт илрүүлэх
- c) Тогтмол үзлэг, өсөлт хөгжилтийн үнэлгээ: Хүүхдийн бие бялдрын өсөлт (жин, өндөр) болон сэтгэц-хөдөлгөөний хөгжлийг насны товллын дагуу тогтмол хянах
- d) Эрүүл мэндийн боловсрол: Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхэд арчилгаа, аюулгүй байдал, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох
- e) Хоол тэжээлийн тусламж үйлчилгээ: Насанд тохирсон зөв хооллолт, хөхөөр хооллолтыг дэмжих, тэжээлийн дутагдлаас сэргийлэх.
- f) Хүүхдийн өвчлөлийн менежмент, зонхилон тохиолдох өвчнийг эмчлэх эсвэл биеийн байдлын үнэлгээнээс хамааран шатлал ахиулан илгээх
- g) Эргэн хяналт
- h) Эрүүл мэнд, нийгмийн талаас өндөр эрсдэлтэй хүүхдийг илрүүлэх, тусгайлан хянах, шаардлагатай бол мэргэжлийн байгууллагад илгээх

Үнэлгээ хийх чиглэл:

1. Хүүхдийн эрүүл мэндийн хөтөлбөртэй танилцаж, хяналт үнэлнэ.
2. Хүүхдийн өсөлтийн муруй болон үр дүнг өвчний түүх, хяналтын карт, цахим бүртгэлд тэмдэглэсэн эсэхийг үнэлнэ.
3. Хүүхдийн хяналтын карт, цахим бүртгэл, өсөлт хөгжлийн үнэлгээ, дархлаажуулалтын бүртгэлийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (a–h заалт) тусгасан журамтай байна.©
	2	Ажилтан хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон эмнэлзүйн заавар, удирдамжийн талаар сургалтад хамрагдсан байна.
	3	Хүүхэд бүрийн өсөлт, хөгжлийг өсөлтийн муруйгаар хянаж, үр дүнг өвчтөний түүх, өвчтөний хяналтын карт, цахим бүртгэлд тэмдэглэсэн байна.©

4	Хүүхэд бүрийг өсөлт хөгжлийг үнэлгээний хуудас ашиглан (хөдөлгөөн, хэл яриа, танин мэдэхүй, нийгмийн болон сэтгэлзүйн байдал) үнэлж, үр дүнг хүүхдийн карт, цахим бүртгэлд тэмдэглэнэ. ⑤
5	Тав хүртэлх насны хүүхэд бүрийн дархлаажуулалтын байдлыг шалгаж, үр дүнг хүүхдийн карт, цахим бүртгэлд тэмдэглэнэ. ⑥
6	Эрсдэлтэй хүүхдийг эмнэлзүйн заавар илрүүлж, удирдана.

Шалгуур 3.18

Эхийн эрүүл мэндийн арга хэмжээг тушаал, заавар, эмнэлзүйн удирдамжийн дагуу хэрэгжүүлнэ.

Агуулга

Эх барихын тусламж нь эцэг эхэд зөвлөгөө өгөх, жирэмсний хяналт, өндөр эрсдэлтэй жирэмслэлтийн менежмент, хэвийн төрөлтийн удирдлага болон төрсний дараах үеийн тусламж үйлчилгээг багтааж болно. Эцэг эхчүүдэд удамших магадлалтай өвчтэй хүүхэд төрөх эрсдэл байгаа эсэхийг үнэлнэ. Зөвлөгөө өгөх нь эцэг эхчүүдэд тухайн нөхцөл байдал, хүлээгдэж буй эрсдэлийг ойлгоход тусалдаг ба тусгай хэрэгцээт хүүхэд төрөхөд тэднийг бэлтгэдэг. Эрүүл мэндийн боловсрол нь жирэмсний хяналтын чухал хэсэг бөгөөд энэ нь эмэгтэйчүүдэд жирэмсэн үеийн эрүүл мэндийн асуудлаар мэдээлэлтэй шийдвэр гаргах боломжийг олгож, аюулгүй төрөлтийг баталгаажуулдаг.

Жирэмсний хяналт нь эрүүл мэндийн ажилтны хувьд жирэмсэн эмэгтэйг зөв үнэлэх, тусламж үйлчилгээ, мэдээлэл, дэмжлэгээр хангах, ингэснээр аюулгүй төрж, эрүүл саруул, гүйцэд хүүхэд төрүүлэхэд нь туслах нэн чухал боломж юм. Жирэмсний хяналтын давтан үзлэг нь жирэмсний явцыг аюулгүй байлгах, тулгарч буй асуудлыг эрт илрүүлэх, жирэмсэн эмэгтэй болон гэр бүлд нь дэмжлэг, итгэл үнэмшил төрүүлэх ач холбогдолтой. Эх болон ургийн эрсдэлийг тодорхойлохын тулд хэд хэдэн оношилгооны сорил, шинжилгээг жирэмсэн эмэгтэйд зөвлөдөг. Жирэмсэн үед эрсдэлт хүчин зүйлсийг эрт илрүүлэх нь эх, хүүхдийн аюулгүй байдал, жирэмсний үр дүнг сайжруулахад чухал үүрэгтэй. Эрсдэлт хүчин зүйлийг анхны үзлэгээр эсвэл дараагийн давтан үзлэгээр илрүүлж болно.

Журамд дараах агуулгыг тусгана. Үүнд:

- a) Эхийн эрүүл мэндийн цогц тусламж: Эхийн эрүүл мэндийг дэмжих, хүндрэлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, сэтгэл зүйн болон сэтгэл заслын дэмжлэг үзүүлэх цогц үйлчилгээ
- b) Жирэмсний хяналтын карт: Жирэмсний явцыг картаар хөтлөх бөгөөд үүнд үзлэгийн товлал, шаардлагатай бодит үзлэг, лабораторийн шинжилгээ, дархлаажуулалт, сургалт болон зөвлөгөө өгөх хуваарийг хүснэгтээр тусгасан байна
- c) Жирэмсэн эмэгтэйн иж бүрэн үнэлгээ: Асуумж авах, эрсдэлт хүчин зүйлийн илрүүлэг, сэтгэл зүй болон хоол тэжээлийн үнэлгээ, бодит үзлэг, лабораторийн шинжилгээ болон заалтаар хэт авиан оношилгоо хийх

- d) Стандарт тусламж үйлчилгээ: Тогтмол үзлэгт хамруулах, дархлаажуулалт хийх, жирэмсэн үеийн хооллолт, аюултай шинж тэмдэг, эм бэлдмэлийн хэрэглээний талаар эрүүл мэндийн боловсрол олгох
- e) Өндөр эрсдэлтэй тохиолдлын тусламж: Эрсдэлтэй жирэмсний үеийн тусгайлсан хяналт, менежмент
- f) Хяналтаас гарсан (тасалсан) хүмүүсийг эргэж дуудах: Хөтөлбөрөөс хоцорсон эсвэл тасалсан эмэгтэйчүүдтэй холбогдож, эргэх хяналтад хамруулах үйл явц

Үнэлгээ хийх чиглэл:

1. Эхийн эрүүл мэндийн арга хэмжээний журмыг үнэлнэ.®
2. Ажилтантай ярилцлага хийж, журмын талаарх мэдлэг болон эрсдэлт хүчин зүйл илрүүлэх чадварыг үнэлнэ.
3. Өндөр эрсдэлтэй жирэмсний хяналт удирдамжийн дагуу хийгдсэн эсэхийг жирэмсэн эмэгтэйн хөтөч карт, цахим бүртгэлд үндэслэн үнэлнэ.
4. Жирэмсний болон төрсний дараах үзлэгийн хяналт, бүртгэлийг үзэж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (a–f заалт) тусгасан журамтай байна.®
	2	Ажилтан эхийн эрүүл мэндийн арга хэмжээ болон эрсдэлт хүчин зүйл илрүүлэх талаар сургалтад хамрагдсан байна.
	3	Жирэмсний хяналтын давтан үзлэгийн товлол болон тусламж үйлчилгээг тогтмол гүйцэтгэж, явцыг нь хянаж, баримтжуулан бүртгэсэн байна.
	4	Өндөр эрсдэлтэй жирэмсний менежмент: Өндөр эрсдэлтэй жирэмслэлтийг эмнэлзүйн удирдамжийн дагуу удирдах эсвэл шаардлагатай бол дараагийн шатлал руу илгээнэ.
	5	Төрсний дараах тусламжийг эх болон нярайд үзүүлж, бүртгэнэ.
	6	Жирэмсний болон төрсний дараах үзлэгийн тайлан мэдээллийг хянаж, шаардлагатай тохиолдолд үйл явцыг сайжруулах арга хэмжээ авна.

Шалгуур 3.19

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн арга хэмжээг хууль, журмын дагуу хэрэгжүүлнэ.

Агуулга

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол, зөвлөгөө нь үйлчлүүлэгчдийн хэрэгцээг тодорхойлох, шаардлагатай мэдээллээр хангаж, эрүүл мэндийн асуудлаар зөв шийдвэр гаргахад нь туслах зорилготой. Энэ нь гэр бүлийн хүсэл, хэрэгцээг тодорхойлж, эрүүл мэндийн ажилтан гэр бүлийн гишүүдтэй хамтран харилцаж, зөв шийдвэр гаргахад чиглэнэ.

Журамд дараах агуулгыг тусгана. Үүнд:

- a) Нөхөн үржихүйн эрүүл мэнд болон гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө.
- b) Гэрлэхийн өмнөх хосын үзлэг (шаардлагатай тохиолдолд)
- c) Гэр бүл төлөвлөлт

- d) Нөхөн үржихүйн замын халдвар болон бэлгийн замын халдварт өвчин
- e) Үргүйдэл
- f) Жирэмсэлтээс хамгаалах хэрэгсэл тавих, авах

Үнэлгээ хийх чиглэл:

1. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг үнэлнэ.
2. Өвчний түүх, хяналтын карт, цахим бүртгэлийг шалгаж, нөхөн үржихүйн эрүүл мэнд болон гэр бүл төлөвлөлтийн журмын хэрэгжилтийг үнэлнэ.
3. Ажилтантай ярилцаж, журмын талаарх мэдлэгийг үнэлнэ.
4. Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, авсан тусламж үйлчилгээний туршлагыг өвчтөн болон тэдний гэр бүлийн гишүүдтэй ярилцаж үнэлнэ.
5. Нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн талаар зөвлөгөө өгөх орчныг ажиглаж, гарын авлага, үзүүлэн таниулах материал, хэрэгслийг шалгаж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (a–f заалт) тусгасан журамтай байна.©
	2	Ажилтан нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн талаар сургалтанд хамрагдсан байна.
	3	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь батлагдсан журмын дагуу хэрэгждэг байна.
	4	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролд шаардлагатай мэдээлэл, гарын авлага, үзүүлэн таниулах материал, хэрэгслүүд бэлэн байна.
	5	Нөхөн үржихүйн эрүүл мэнд болон гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө, боловсрол олгох тусгай өрөөтэй байна.

Шалгуур 3.20

Халдварт бус өвчний тусламж үйлчилгээг хууль эрх зүй, эмнэлзүйн удирдамж, зааварын дагуу хэрэгжүүлнэ.

Агуулга

Иргэдийг эрт илрүүлэгт хамруулах нь халдварт бус өвчнийг шинж тэмдэггүй, эрт үед нь оношлоход чухал ач холбогдолтой. Өвчний эрт илрүүлэг нь эмчилгээний үр дүнг сайжруулж, дундаж наслалтыг нэмэгдүүлдэг. Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд хүн амын дунд архаг өвчнийг (хавдар, чихрийн шижин, даралт ихсэлт, цусны өөх тосны эмгэг, сонсголын согог, нярайн эмгэгүүд) илрүүлэх тогтмол скрининг шинжилгээ хийх нь зүйтэй. Төв нь үйлчлэх хүрээний хүн амд халдварт бус өвчнийг илрүүлэх журам боловсруулж хэрэгжүүлнэ.

Журамд дараах агуулгыг тусгана. Үүнд:

- a) Халдварт бус өвчнөөр өвдөх магадлалтай хүн амын хэсэг, эрсдэлт бүлгийг тодорхойлох.
- b) Дараах чиглэлээр зорилтот түвшин тогтоох:
 - i. Тамхины хэрэглээг бууруулах: Хүн амын дундах тамхидалтыг багасгах
 - ii. Халдварт бус өвчнийг хожуу оношлох тохиолдлыг бууруулах
 - iii. Удамшлын өвчнийг эрт илрүүлэх

iv. Зүрхний шигдээс, харвалт, мөч тайрах болон бөөрний дутагдалд орох эрсдэлийг багасгах

v. Халдварт бус өвчний нас баралтын түвшинг бууруулах

vi. Цочмог эмгэг, хүндрэлээс урьдчилан сэргийлэх

vii. Зүрх судасны өвчин, чихрийн шижин, багтраа, уушгины архаг бөглөрөлтөт өвчтэй хүмүүсийн дахилтгүй, тогтвортой үеийн хугацааг уртасгах.

с) Өвчтөний бүртгэл хөтлөх: харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хяналтад хамрагдах өвчтөний нэгдсэн бүртгэл хөтлөх

д) Сургалт, мэдээллээр хангах: бүртгэлтэй өвчтөнд өвчнийхөө талаар мэдлэгтэй болоход нь туслах эрүүл мэндийн боловсрол олгох

е) Эргэн хяналт тавих: Өвчтөнүүд эмчилгээний төлөвлөгөөгөө мөрдөж буй эсэх болон биеийн байдлын ахиц дэвшлийг тогтмол хянах

Үнэлгээ хийх чиглэл:

- Халдварт бус өвчнийг илрүүлэх, хянах журмыг үнэлнэ.
- Халдварт бус өвчний эрсдэлт бүлгийн өвчтөний эрт илрүүлгийг явцыг үнэлнэ.
- Өвчтөн болон гэр бүлийн гишүүдтэй ярилцаж, тэдний эрт илрүүлэгт хамрагдсан талаар мэдээллийн баталгаажилтыг үнэлнэ.
- Өвчний түүх, хяналтын карт, цахим бүртгэлийг шалгаж, журмын хэрэгжилтийг үнэлнэ.
- Халдварт бус өвчний хяналтын хөтөлбөрийн тайланг жил бүр үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (1–5 заалт) тусгасан журамтай байна.©
	2	Эрсдэлт бүлгийн хүмүүс халдварт бус өвчний илрүүлэгт хамрагдсан байна.
	3	Илрүүлгээр өвчлөл тогтоогдсон тохиолдол бүрт эмнэлзүйн удирдамжийн дагуу зохих арга хэмжээг (эмчилгээ, хяналт) авна.
	4	Эрсдэлт бүлгийн иргэдийн дундах халдварт бус өвчинтэй өвчтөний хувь хэмжээг тогтмол хянаж, мониторинг хийнэ.
	5	Халдварт бус өвчний менежментийн хөтөлбөрийн үр нөлөөг жил бүр үнэлж, дүгнэлт гаргана.

Шалгуур 3.21.1

Халдварт өвчний тусламж үйлчилгээг үзүүлдэг байна.

Агуулга

Төв нь стандартад заасан халдварт өвчний тусламж үйлчилгээг үзүүлдэг байна. Халдварт өвчний чиглэлээр гарсан үндэсний хөтөлбөр, журам, эмнэлзүйн зааварыг хэрэгжүүлж ажиллана. Халдварт өвчний тусламж үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай үзүүлж, тусгаарлах, оношлох, эмчлэх, хүндрэлээс сэргийлэх, бусдад халдвар дамжихаас сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулна. Халдварт өвчний тусламж үйлчилгээг үзүүлэх шаардлагатай тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, хүний нөөцийн бэлэн байдлыг хангана. Халдварт өвчний

өвчлөлийн байдалд дүн шинжилгээ хийж урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Үнэлгээ хийх чиглэл:

1. Халдварт өвчний эмнэлзүй, оношилгоо, эмчилгээний жагсаалтыг үзнэ.
2. Байгууллагын төлөвлөгөөнд халдварт өвчнийг бууруулах, хариу арга хэмжээ авах талаар тусгасан эсэхийг үзнэ.
3. Халдварт өвчний бүртгэл, мэдээлэл, тайланг харна.

Хэмжих үзүүлэлт	1	Халдварт өвчний эмнэлзүй, оношилгоо, эмчилгээний жагсаалтыг баталсан байна.©
	2	Халдварт өвчнийг бууруулах, хариу арга хэмжээ авах талаар байгууллагын төлөвлөгөөнд тусгасан байна.
	3	Төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүр дүгнэж, хэрэгжилтийн хувь гаргасан©
	4	Халдварт өвчний тусламж үйлчилгээ авсан тохиолдол бүрийг бүртгэсэн бүртгэл, өвчлөлийн байдалд дүн шинжилгээ хийсэн тайлан ©
	5	Дараагийн шатлалын эмнэлэгт илгээсэн, зөвлөгөө авсан бүртгэл©

Шалгуур 3.21.2

ХДХВ/ДОХ, БЗДХ-ийн тусламж үйлчилгээг үзүүлдэг байна.

Агуулга

Төв нь БЗДХӨ, ХДХВ/ДОХ-ын халдвараас сэргийлэх, халдвар илэрсэн тохиолдолд эмчлэх, хавьтлын судалгаа хийх, үйл ажиллагааг зохион байгуулдаг байна. БЗДХӨ, ХДХВ/ДОХ-ын халдвар илрүүлэх оношилгоог стандартад заасны дагуу хийж бүртгэлжүүлнэ, шаардлагтай тохиолдолд баталгаажуулах шинжилгээг дараагийн шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээнэ. Жирэмсэн эх бүрт ХДХВ/ДОХ, тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээг удирдамжын дагуу хийж эхээс урагт халдвар дамжихаас сэргийлнэ. БЗДХӨ-ний халдвар илэрсэн тохиолдолд эмчилж эрүүлжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, мөн хавьтагчыг илрүүлэн эмчилнэ. Хувь хүний нууцыг чанд хадгална. БЗДХӨ-ний талаарх сургалт, мэдээллээр хангах, эрүүл мэндийн мэргэжилтнийг сургах, мэргэжил дээшлүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. БЗДХӨ-с сэргийлэх зөвлөгөө, зөвлөмжийг ард иргэдэд тогтмол зохион байгуулна. Тушаалын дагуу дараагийн шатлалд мэдээ тайланг илгээдэг байна.

Үнэлгээ хийх чиглэл:

1. ХДХВ/ДОХ, БЗДХӨ оношлогдсон, эмчилгээнд хамрагдсан үйлчүүлэгчдийн бүртгэлийг үзнэ.
2. БЗДХӨ-ний халдвар илрүүлэх оношлуурын бэлэн байдлыг шалгана.
3. БЗДХӨ-с сэргийлэх зөвлөгөө, зөвлөмж гаргасан, сургалт зохион байгуулсан байдлыг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	ХДХВ/ДОХ, БЗДХӨ оношлогдсон, эмчилгээнд хамрагдсан үйлчүүлэгчдийн бүртгэл ⑥
	2	ХДХВ, тэмбүү, бусад БЗДХӨ-ний халдвар илрүүлэх оношлуурын бэлэн байдал хангагдсан байдал
	3	ХДХВ, тэмбүү, бусад БЗДХӨ-ний халдвар илэрсэн тохиолдолд эмчилгээ хийсэн бүртгэл, эм тарианы бэлэн байдал
	4	Хавьтал судалгааг хийж, оношилгоо, эмчилгээнд хамруулсан бүртгэл ⑥
	5	Жирэмсэн эхчүүдэд халдвар илрүүлэх шинжилгээг хийсэн бүртгэл⑥
	6	БЗДХӨ-с сэргийлэх зөвлөгөө, зөвлөмж гаргасан, сургалт зохион байгуулсан тоо, бүртгэл⑥

Шалгуур 3.21.3

Сүрьеэ өвчний тусламж үйлчилгээг үзүүлдэг байна.

Агуулга

Төв нь сүрьеэ өвчнийг оношлох, халдвараас сэргийлэх, халдвар илэрсэн тохиолдолд эмчлэх, хавьтлын судалгаа хийх, үйл ажиллагааг зохион байгуулна.

Онош баталгаажуулах шинжилгээг хийх, сорьц тээвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулна. Төрөлжсөн мэргэжлийн эмчийн зөвлөгөө зааврыг авч хяналт эмчилгээг хийнэ. Хавьтлын үзлэг оношилгоог хийж халдвараас сэргийлэх үйл ажиллагааг тушаалын дагуу зохион байгуулна. Хувь хүний нууцыг чанд хадгална.

Сүрьеэ өвчний эмнэлзүй, оношилгоо, эмчилгээний талаарх сургалт, мэдээллээр хангах, эрүүл мэндийн мэргэжилтнийг сургах, мэргэжил дээшлүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. Сүрьеэ өвчнөөс сэргийлэх зөвлөгөө, зөвлөмжийг ард иргэдэд тогтмол зохион байгуулна. Тушаалын дагуу дараагийн шатлалд мэдээ тайланг илгээсэн байх

Үнэлгээ хийх чиглэл:

1. Сүрьеэ өвчин оношлогдсон, эмчилгээнд хамрагдсан үйлчүүлэгчдийн бүртгэлийг үзнэ.
2. Сүрьеэ өвчин онош батлагдсан тохиолдолын хавьтал судлалын үзлэг, оношилгоо хийсэн, эмчилгээнд хамруулсан бүртгэлийг үзнэ
3. Сүрьеэ өвчин онош батлагдсан тохиолдолын эмчилгээний үр дүн /эмнэлзүй болон лабораторын шинжилгээгээр/
4. Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, зөвлөмж гаргасан, сургалт зохион байгуулсан байдлыг үнэлнэ.

БЗДХӨ-с сэргийлэх зөвлөгөө, зөвлөмж гаргасан, сургалт зохион байгуулсан байдлыг үнэлнэ

	1	Сүрьеэ өвчин оношлогдсон, эмчилгээнд хамрагдсан үйлчүүлэгчдийн бүртгэл ⑥
	2	Сорьц тээвэрлэсэн бүртгэлтэй байна.⑥

Хэмжих үзүүлэлт	3	Хавьтал судалгааг хийж, оношилгоо, эмчилгээнд хамруулсан бүртгэл ⑥
	4	Тушаалын дагуу дараагийн шатлалд мэдээ тайланг илгээсэн байна. ⑥
	5	Сүрьеэгийн халдвар батлагдсан өвчтөнүүдийн эмчилгээний хяналт, үр дүнг тооцсон байдал

Шалгуур 3.21.4

Вируст гепатитын тусламж үйлчилгээг үзүүлдэг байна.

Агуулга

Эрүүл мэндийн байгууллага нь цочмог болон архаг вируст гепатитын халдвар илрүүлэх, эмчлэх, мэдээлэх, тандах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулна. Харьяа хүн амын дунд цочмог болон архаг вируст гепатитын халдварын халдвар илрүүлэх, эмчлэх, мэдээлэх, тандах, тархалтыг тогтоох, урьдчилан сэргийлэх, ГВВ, ГСВ, ГДВ-ийн архаг халдвартай өвчтөнүүдэд элэгний цирроз, хавдраас сэргийлэх вирусийн эсрэг эмчилгээнд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулна. Эхээс урагт гепатитын вирусийн халдвар дамжихаас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах.

Үнэлгээ хийх чиглэл:

1. Гепатитын цочмог болон архаг вирусийн халдвартай, вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчдийн бүртгэлтэй байх
2. Гепатитын вирусийн халдвар эхээс урагт халдвар дамжихаас сэргийлэх үйл ажиллагааг тушаал журмыг хэрэгжүүлсэн байдлыг үнэлэх
3. ГВВ, ГСВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээг хийсэн бүртгэл, оношилгоо хийх урвалж оношлуурын бэлэн байдлыг стандартын дагуу хангасан байдал
4. Гепатитын вирусийн халдвараас сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байх

Хэмжих үзүүлэлт	1	Вируст гепатит оношлогдсон, хяналтанд байгаа үйлчлүүлэгчдийн бүртгэл ⑥
	2	Архаг вируст гепатит В, С, Дельта-ын вирусийн эсрэг эмчилгээнд хамруулсан эмчилгээний үр дүнг тооцсон бүртгэл, хяналт ⑥
	3	Эхээс урагт дамжих халдвараас сэргийлэх ГВВ-ийн эсрэг вакцин болон иммуноглобулин хэрэглэсэн хүүхдийн бүртгэл ⑥
	4	ГВВ-ийн халдвараас сэргийлэх оношилгоог хийж, вакцин хийлгэсэн үйлчлүүлэгчдийн бүртгэл ⑥
	5	Элэгний хатуурал, хавдрын өвчлөл, нас баралтад гепатитын вирусийн халдварын шалтгааны эзлэх хувь ⑥

3.22 Тусгай хэрэгцээт үйлчлүүлэгч/өвчтөний бүлэгт зориулсан илрүүлэг, үзлэг, давтан үнэлгээ болон тусламж, үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгүүд нарийвчлан тодорхойлсон байна.

Агуулга

Тусгай хэрэгцээт иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний менежмент оновчтой бус тохиолдолд эрүүл мэндийн тогтолцооны зардал ихээхэн нэмэгддэг. Энэ бүлэгт тусламж үйлчилгээ авахад тулгардаг өвөрмөц саад бэрхшээлийг харгалзан үзэж, түүнийг нийтлэг тусламж үйлчилгээний гадна үлдээхгүй байхад анхаарах ёстой. Тусгай хэрэгцээт өвчтөнийг үнэлэх, хянах, тусламж үзүүлэх бодлогодоо дараах үндсэн чиглэлүүдийг заавал тусгасан байна.

Төв нь тусгай хэрэгцээт үйлчлүүлэгч/өвчтөнийг илрүүлэх, үнэлэх, дахин үнэлэх, хянах журам боловсруулж хэрэгжүүлнэ.

Журамд дараах агуулгыг тусгана. Үүнд:

а) Тусгай хэрэгцээт үйлчлүүлэгч/өвчтөний бүлгийг тодорхойлох. Үүнд:

i. Өсвөр үеийнхэн

ii. Ахмад настан

iii. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс

iv. Дархлаа дарангуйлагдсан хүмүүс

v. Халдварт өвчтэй хүмүүс

vi. Архаг өвдөлттэй хүмүүс

vii. Хүчирхийлэл, үл хайхралд өртсөн хүмүүс

б) Тусгай хэрэгцээт үйлчлүүлэгч/өвчтөний бүлгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн үнэлгээний аргыг өөрчилж, зохицуулалт хийнэ

с) Тусгай хэрэгцээг хувь хүний онцлогт тохирсон тусламжийн төлөвлөгөө боловсруулж ажиллах

Үнэлгээ хийх чиглэл:

1. Тусгай хэрэгцээт үйлчлүүлэгч/өвчтөнийг илрүүлэх, үнэлэх, давтан үнэлэх, хянах журмыг үнэлнэ.

2. Ажилтантай ярилцаж, журмын талаарх мэдлэгийг нь үнэлнэ.

3. Өвчний түүх, хяналтын карт, цахим бүртгэлийг шалгаж, тусгай хэрэгцээт үйлчлүүлэгч/ өвчтөний хэрэгцээг хянаж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (1–5 заалт) тусгасан журамтай байна.©
	2	Ажилтан журмын талаар мэдлэгтэй байна.
	3	Тусгай хэрэгцээт үйлчлүүлэгч/өвчтөний хэрэгцээг үнэлж, зохих тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.
	4	Тусгай хэрэгцээт үйлчлүүлэгч/өвчтөний хэрэгцээг үнэлсэн болон хянасан мэдээллийг өвчний түүх, хяналтын карт, цахим бүртгэлд тэмдэглэсэн байна.©

Эмчилгээний хоол

3.23.1 Хоол үйлдвэрлэлийн тасаг, нэгжийг зохион байгуулж, эмчилгээний хоолоор үйлчлэх зохион байгуулалтыг хийж, мэргэшсэн мэргэжилтнээр хангасан байна.

Агуулга

Стандартын дагуу хоол үйлдвэрлэлийн урсгал чиглэлийг зохион байгуулж, өвчтөнд хооллох тав тухтай, эрүүл ахуйн шаардлага хангасан орчин бүрдүүлсэн байна. Төв нь эмнэлзүйн хоол эмчилгээний чиглэлээр мэргэшсэн баг (хоол эмчилгээний эмч, эмнэлзүйн хоол зүйч, технологич, тогооч, туслах ажилтан) ажиллуулна. Байгууллагын удирдлага нь хоолны цэс, хоолны технологийн картыг баталж, хоол эмчилгээ, үйлчилгээний зохион байгуулалт, холбогдох дүрэм, заавар, стандартыг мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж, эмнэлзүйн хоол эмчилгээ, үйлчилгээндээ эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлсэн байна.

Үнэлгээ хийх чиглэл:

- Хоол үйлдвэрлэлийн байрны урсгал чиглэлийг тойрон үзлэг хийх явцдаа ажиглах байдлаар үнэлнэ.

Хоол эмчилгээний эмч, эмнэлзүйн хоол зүйч, технологич, тогоочийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг баримт, бичгээс үзэж үнэлнэ.®

Хэмжих үзүүлэлт	1	Зориулалтын, технологи урсгалын дагуу зөв зохион байгуулагдсан байртай
	2	Агуулах, бэлтгэл, аяга таваг угаалга, халуун боловсруулалт, хооллох танхимууд урсгалын дагуу зохион байгуулагдсан
	3	Тасаг, нэгжид хэвтэн эмчлүүлэгчид хооллох тав тухтай орчин бүрдүүлсэн байна.
	4	Хоол үйлдвэрлэлийн хэсгийн хана, тааз, шалыг угааж цэвэрлэхэд хялбар материалаар хийсэн
	5	Халуун боловсруулах хэсэг нь уур сорогчтой
	6	Шавж, мэрэгч үүрлээгүй
	7	Эмнэлгийн мэргэжилтнүүд хүчинтэй хугацаа бүхий мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй мэргэжлийн тогооч, хоол үйлдвэрлэлийн технологич, хоол зүйч зэрэг боловсон хүчнээр хангагдсан байна.
	8	Байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартад заасан орон тооны хангалтын хувь /Эмнэл зүйн хоол эмчилгээний эмч, сувилагч, хоол зүйч, технологич, хоол эмчилгээний тогооч/
	9	Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлдэг.®

3.23.2 Хоолны технологи, нормыг мөрдөж, аюулгүй байдлыг ханган, эмчилгээний хоолны чанарт хяналт тавьдаг байна.

Агуулга

Төв нь эмчилгээний хоолны илчлэг, тэжээллэг чанар, хүртээмж, аюулгүй байдалд тогтмол хяналт тавих дотоод хяналтын багийг ажиллуулна. Дотоод хяналтын багийн бүрэлдэхүүнд хоол эмчилгээний эмч, эмнэлзүйн хоол зүйчийг оруулж, хоолны амт, хэм, порцын хэмжээнд хяналт тавьж, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжид суурилсан сайжруулалтыг тогтмол хийнэ.

Хоолны чанар, хүртээмж, эрүүл ахуй аюулгүй байдалд дотоод хяналтын баг өдөр тутам хяналт тавьж, тэмдэглэл хөтөлнө. Дотоод хяналтын баг үйлчлүүлэгчийн өвчний онцлогт тохирсон эмчилгээний хоолыг технологийн картын дагуу илчлэг, шимт бодисыг тооцож хоол эмчилгээ хийж байгаа эсэх, хоолны нэр төрөл, технологи ажиллагаа, заавар, зөвлөмжийн дагуу хийгдэж байгаа эсэх, хүнсний бүтээгдэхүүний хоногийн хэрэглээний зөвлөмж хэмжээг зөв мөрдөж байгаа эсэхэд хяналт тавина. Үйлчлүүлэгчийн хоолны тэжээллэг чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг улирал тутамд хянуулж, мэргэжлийн хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулсан байна. Тухайн байгууллагын эмч, ажилтан нарт эмнэлзүйн хоол эмчилгээний эрүүл ахуй аюулгүй байдлын талаарх сургалтыг тогтмол зохион байгуулна. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн байдалд хяналт тавьж ажиллана.

Дотоод хяналтын баг хоолны чанарыг хянахдаа доор дурдсан асуултын дагуу хоол тус бүр дээр үнэлгээ өгч, үнэлгээний дүнг бүртгэлд бичиж, гарын үсэг зурна. Үүнд:

- Хоол батлагдсан цэсийн дагуу хийгдсэн эсэх
- Хоолыг бэлтгэсэн болон боловсруулсан технологи ажиллагаа зөв эсэх
- Гадны хольц, бохирдуулагч байсан эсэх (ажиглалтаар)
- Хүнсний бүтээгдэхүүн, хоолны чанар (амт, өнгө, үзэмж, үнэр)
- Хоолны хэмжээ (жин) норм тохирсон эсэх (хэмжилтээр)
- Хоолны гүний хэм тохиромжтой эсэх (хэмжилтээр)
- Хоол хийсэн тогоочийн нэр
- Хоол хэрэглэхийг зөвшөөрсөн эсэх
- Үнэлгээ өгсөн огноо, цаг, минут, гарын үсэг

Хоолны илчлэг, шим тэжээллэг чанарт тооцооны аргаар сард нэг удаа үнэлгээ хийж, тэмдэглэл хөтөлнө.

Үнэлгээ хийх чиглэл:

- Эмчилгээний хоолны цэс, технологийн карт болон хяналтын үйл ажиллагаа, сургалтыг баримт, бичгээс үзэж үнэлнэ.

Үйлчлүүлэгчийн хоолны аюулгүй байдал, үйлчлүүлэгчийг зөв таних аргыг ашиглах эсэхийг тойрон үзлэг хийх явцдаа ажиглах байдлаар үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Үйлчлүүлэгчид зориулсан эмчилгээний хоолны цэсийг өвчний нэршлээр боловсруулж баталсан ⑤
	2	Өдөрт 3-аас доошгүй удаа халуун хоолоор үйлчилдэг
	3	Эмчийн заасан эмчилгээний хоолоор үйлчилдэг
	4	Хоол тус бүрээр технологи карттай, аргачлалын дагуу хийдэг
	5	Үйлчлүүлэгчдэд олгож байгаа орц, хэмжээ, хоолны илчлэг, шимт бодисыг тооцдог байх
	6	Эмчилгээний хоолтой үйлчлүүлэгчийг зөв таньж хүргэдэг /үйлчлүүлэгчийг зөв таних аргыг ашигладаг/
	7	Хоол зөөх явцад асгарах, хоол бохирдох эрсдлээс сэргийлэгдсэн
	8	Тасаг нэгжид хүргэхдээ халуунаар хүргэх нөхцлийг бүрдүүлсэн

9	Үйлчлүүлэгчийн хоолны аюулгүй байдлыг хангасан /тээвэрлэх сав, аяга... гэх мэт/
10	Хүнд, хүндэвтэр үйлчлүүлэгчийг хооллоход зориулсан гуурсаар, судсаар хооллох тэжээл болон хооллох хэрэгсэлтэй
11	Хоолны зориулалтын жин, термометртэй
12	Хоолны дундаж хэмжээ, хэмийг үзсэн тэмдэглэлтэй ⑥
14	Хоол эмчилгээг үйлчлүүлэгчийн өвчний онцлогт тохирсон технологи ажиллагаа, заавар зөвлөмжийн дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавьдаг
15	Хоол эмчилгээтэй үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн байдалд тандалт судалгаа хийдэг ⑥
16	Амбулаториор болон хэвтэн эмчлүүлэгчид хоол эмчилгээний сургалт хийдэг, зөвлөгөө өгдөг, сургалт хийж, зөвлөгөө өгсөн хүний тоо, бүртгэлтэй ⑥

3.23.3 Хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн шаардлагыг мөрддөг байна.

Агуулга

“Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага”, MNS 4946:2005 болон “Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал” MNS CAS RCP 39:2011 стандартын шаардлагад нийцсэн зориулалтын өрөө тасалгаа, тоног төхөөрөмжтэй байх ба хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар журмыг мөрдөж ажиллана.

Үйлчлүүлэгчийн биеийн байдал зөвхөн эмчилгээний хоолноос өөр хоол унд хэрэглэх шаардлагагүй, гаднаас халдвар дамжин орж болзошгүй тохиолдолд эмчлэгч эмчийн зөвлөснөөс бусад төрлийн хоол хүнсийг эргэлтээр авахыг хориглох ба үйлчлүүлэгчийн ар гэрээс эргэлтээр оруулах хоол хүнсний зүйлийг нэр заан хязгаарлалт тогтооно.

Төвд эрүүл ахуй, халдвар судлалын шинжилгээний бичигтэй түүхий эд, бүтээгдэхүүнийг хэрэглэнэ.

Хоол үйлдвэрлэлийн ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж, ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн хэрэглээг хэвшүүлнэ. Түүхий эдээс эцсийн бүтээгдэхүүн хүртэлх бүх шатанд эрүүл ахуйн шаардлага хангаж, дээж авалт болон хадгалалтын горимыг чанд мөрдөнө.

Тоног төхөөрөмжийн хангалт, ашиглалт, аюулгүй ажиллагааг хангасан байна. Шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн хангалтыг бүрдүүлж, тэдгээрийн хэвийн ажиллагаа болон аюулгүй байдлыг хангана.

Үнэлгээ хийх чиглэл:

- Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний бичиг, ажилчдын эрүүл мэндийн үзлэгийг баримт, бичгээс үзэж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнийг баталгаат газраас шинжилгээний бичиг дүгнэлтийг үндэслэн худалдан авдаг ⑥
------------------------	----------	--

2	Хоол үйлдвэрлэх, хадгалах, зөөх сав, хэрэгсэл нь эрүүл ахуйн шаардлага хангасан, хүнсний зориулалтын
3	Хоолны дээжийг нэг порц хэмжээтэй авч, хөргөгчид +2+8 хэмд 48 цаг хадгалан бүртгэл хөтөлдөг. ©
4	Түргэн муудах бүтээгдэхүүнийг зөв хадгалдаг
5	Ундны усны стандарт шаардлага хангасан
6	Хоол үйлдвэрлэлд ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт зааврын дагуу хамруулдаг ©
7	Ажилчид ажлын хувцас (халад, цамц, гутал, хормогч, бээлий, үсийг бүрэн халхалхуйц толгойн өмсгөл г.м)- аар хангагдсан, бүрэн өмсөж хэвшсэн
8	Тусламж, үйлчилгээнд шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангасан байх
9	Тоног төхөөрөмжийн жагсаалттай ©
10	Тоног төхөөрөмжөөр хангасан, хэвийн ажиллагаатай
11	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангадаг

БҮЛЭГ 4. ДҮРС ОНОШИЛГОО, ЛАБОРАТОРИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Тойм

Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний байгууллагын оношилгоо болон дэмжих үйлчилгээ нь үйлчүүлэгч/өвчтөнд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, эрүүл мэндийн цогц удирдлагыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Дэмжих үйлчилгээнд лаборатори болон дүрс оношилгооны тусламж, үйлчилгээ хамарна.

Лаборатори, дүрс оношилгооны тусламж, үйлчилгээ нь өвчин, эмгэгийг үнэн зөв оношлох, эмчилгээг үр дүнтэй төлөвлөх, эмчилгээний үр дүнг хянахад зайлшгүй шаардлагатай байдаг. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагад оношилгоог цаг алдалгүй, хүртээмжтэй хийснээр үйлчүүлэгч/өвчтөнд үзүүлэх тусламж, үйлчилгээний үе шат, дамжлагыг оновчтой болгож, хүлээгдлийн хугацааг багасгах, эмчилгээний үр дүнг дээшлүүлэх боломжтой.

Дүрс оношилгоо болон лабораторийн тусламж, үйлчилгээ нь анхан шатны тусламж, үйлчилгээний суурь зарчим болох урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээний амин чухал бүрэлдэхүүн хэсэг мөн. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, лаборатори болон дүрс оношилгоо нь аливаа өвчин эмгэг хүндэрч, эрүүл мэндийн ноцтой асуудал үүсэхээс сэргийлэх, өвчний эхний үе шат, эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох, урьдал нөхцөл, цус багадалт, шимэгч хорхойн халдвар зэрэг өвчнийг илрүүлэх, улмаар урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хариу арга хэмжээ авах стратегийг хэрэгжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой.

Анхан шатны тусламж, үйлчилгээний түвшинд эрт илрүүлгийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр эрүүл мэндийн мэргэжилтнүүд хүүхдийн бие бялдар, оюун ухааны хөгжилд сөргөөр нөлөөлж болзошгүй бамбай булчирхайн үйл ажиллагааны дутагдал (гипотиреодизм) эсвэл ихсэх (гипертиреодизм) зэрэг эмгэгүүдийг илрүүлэх боломжтой болно. Эрт оношилж, шаардлагатай тусламж, үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх нь эмчилгээний үр дүнг сайжруулж, хүндрэлээс сэргийлэх төдийгүй хүүхэд эрүүл өсөж, хөгжих нөхцөлийг бүрдүүлдэг. Үүнээс гадна, эцэг эх, асран хамгаалагчдад бамбай булчирхайн үйл ажиллагааны алдагдлын үед илрэх шинж тэмдгүүдийн талаар мэдээлэл өгөх нь тэднийг эмнэлгийн тусламж, зөвлөгөөг цаг алдалгүй авахад тусална.

Эрүүл мэндийн анхан шатны байгууллагад хүүхдийн өсөлт хөгжилт, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй шимэгч хорхойн халдварыг илрүүлэх шинжилгээ хийх нь тус эмгэгийг эрт үед нь илрүүлж, эмчлэхэд чухал ач холбогдолтой юм.

Дэмжих төрлийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд үйлчүүлэгч/өвчтөн, эмч, мэргэжилтний хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах хүрээнд байгууллага нь аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Ялангуяа ионжуулагч цацраг, рентген туяа, лабораторийн химийн бодисоос үүсэх эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулна. Аюулгүй ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд аюултай материалыг аюулгүй ашиглах, хадгалах, устгах журам, зааврыг мөрдсөнөөр хүн хордох болон орчин бохирдох эрсдэл буурна. Эмч, ажилтанд зориулсан сургалт, танин мэдэхүйн боловсрол олгох замаар учирч болох эрсдэлийг тодорхойлох, тэдгээрийг шийдвэрлэх чадамжийг олгож, аюулгүй ажиллагааны соёлыг төлөвшүүлнэ.

Энэ бүлгийн хамрах хүрээ нь дараах оношилгоо болон дэмжих үйлчилгээг хамарна. Үүнд:

- **Дүрс оношилгоо:**

- Рентген оношилгоо (Шүдний дүрс оношилгоог оролцуулна).
- Хэт авиан оношилгоо (Эхо).

- **Лабораторийн оношилгоо:**

- Сорьц цуглуулах
- Биохимийн шинжилгээ
- Цусны шинжилгээ (Гематологи)
- Паразитологи (Шимэгч судлал)
- Цитологи (Эсийн шинжилгээ)
- Үйлчилгээ үзүүлэх цэгт гүйцэтгэх шинжилгээ

Оношилгоо, шинжилгээний үйл явц нь дараах гурван үе шатаас бүрдэнэ:

1. **Шинжилгээний өмнөх үе шат:** Үйлчүүлэгч/өвчтөнийг оношилгоо, шинжилгээнд бэлтгэх, танин тодруулах, сорьц авах, хаяглах, тээвэрлэн лабораторид хүргэх үйл явцыг хамарна.

2. **Шинжилгээний үе шат:** Лабораторид сорьцыг хүлээн авч, шалгах, боловсруулах, шинжилгээ болон дотоод хяналт хийх үйл явцыг хамарна.
3. **Шинжилгээний дараах үе шат:** Оношилгоо, шинжилгээний хариуг үйлчүүлэгч/өвчтөн болон тусламж, үйлчилгээ үзүүлж буй эмч, мэргэжилтэнд мэдээлэх, илгээх, яаралтай сэрэмжлүүлэх хариуг шуурхай хүргэх, сорьц хадгалах, чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрт хамрагдах үйл явцыг хамарна.

Шинжилгээний явцын үе шат бүрд гарсан алдаа нь өвчнийг оношлох, хянахад шууд нөлөөлдөг тул төөрөгдүүлсэн, буруу хариу гарах эсвэл алдаатай мэдээлэл өгөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай.

Оношилгооны эмч, мэргэжилтэн нь шинжилгээний мэдээллийн үнэ цэн болон шинжилгээний өвөрмөц чанарыг эмч нарт таниулах үрэгтэй бөгөөд үүнд эмнэлзүйн эмч мэргэжилтэн, оношилгооны мэргэжилтэн хоорондын байнгын үр дүнтэй харилцаа холбоо нэн чухал байдаг. Оношилгоо, шинжилгээний хариу нь зөвхөн өвчтөний эмчилгээ, тусламж, үйлчилгээнд ашиглагдахуйц байх тохиолдолд л үнэ цэнтэй байдаг. Тиймээс шинжилгээний хариуг өвчтөний эмнэлзүйн шинж тэмдэгтэй нэгтгэн дүгнэх боломжийг олгохын тулд оношилгооны эмч, мэргэжилтэн нь хариуг эмчлэгч эмчид цаг алдалгүй, шуурхай хүргэх үүрэгтэй.

Магадлан итгэмжлэлийн шинжээч нь мэдээллийн харилцан солилцооноос гадна шинжилгээний хариуны үнэн зөв байдал болон өвчтөн, ажилтан, эмнэлгийн аюулгүй байдалд анхаарна.

Оношилгооны тусламж, үйлчилгээг аюулгүй, үр дүнтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн байдлыг дараах чиглэлээр үнэлнэ. Үүнд:

1. Дүрс оношилгооны аюулгүй, үр дүнтэй тусламж, үйлчилгээ.
2. Эмнэлзүйн лабораторийн аюулгүй, үр дүнтэй тусламж, үйлчилгээ

Эрүүл мэндийн анхан шатны байгууллага сум, өрхийн эрүүл мэндийн төв (цаашид “СЭМТ, ӨЭМТ” гэнэ)

Доорх жагсаалтад энэхүү бүлэгт хамаарах бүх шалгуурыг нэгтгэн харуулав.

4.1	Дүрс оношилгоог холбогдох хууль тогтоомж, дүрэм журам болон эмнэлзүйн удирдамжын дагуу нэгдсэн байдлаар төлөвлөж, зохион байгуулна.
4.2	Дүрс оношилгоо, шинжилгээний гүйцэтгэл, арга, аргачлалыг стандартчилсан байна.
4.3	Дүрс оношилгооны хариуг өвчний түүх, цахим карт, бүртгэлд тусгана.
4.4	Цацрагийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.
4.5	Лабораторийн тусламж, үйлчилгээг холбогдох хууль, дүрэм, журам, удирдамжийн дагуу төлөвлөж, зохион байгуулна
4.6	Лабораторийн урвалж, дагалдах хэрэгсэл бусад материалыг удирдах үйл явцтай байна
4.7	Лабораторийн техникийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг стандартчилсан байна.

4.8	Лабораторийн шинжилгээний хариуг тогтоосон стандарт хугацаанд гаргана.
4.9	Лабораторийн аюулгүй ажиллагааны цогц хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

ШАЛГУУР, ЗОРИЛГО, ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур 4.1

Дүрс оношилгооны үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам болон эмнэлзүйн удирдамжын дагуу нэгдсэн байдлаар төлөвлөж, зохион байгуулна.

Агуулга

Чанартай, сайн зохион байгуулалттай, үр ашигтай, дүрс оношилгоо нь өвчтөнд үзүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулж, улмаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлдэг. Дүрс оношилгооны тасаг/нэгжийн байршил нь үйлчлүүлэгч/өвчтөнд хүртээмжтэй, ойр байх нь чухал юм. Төв нь үйлчлүүлэгчийн ангилал, үзүүлж буй эмнэлзүйн тусламж, үйлчилгээний төрөл болон эмнэлгийн мэргэжилтний хэрэгцээнд нийцүүлэн дүрс оношилгооны үйлчилгээ үзүүлэх тогтолцоог төлөвлөж, зохион байгуулна.

Төв нь зарим үйлчилгээг эсвэл бүгдийг нь өөрийн байран дээрээ буюу дотооддоо үзүүлж болохоос гадна бусад үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай гэрээ байгуулах эсвэл илгээх замаар гүйцэтгүүлж болно. Дүрс оношилгооны тусламж, үйлчилгээ нь хууль тогтоомж, дүрэм, журам болон холбогдох удирдамж, зааварт нийцсэн байна. Өөрийн төвд болон гэрээт байгууллагаар гүйцэтгүүлсэн дүрс оношилгооны хариуг тухайн байгууллагаас баталсан хугацаанд багтаан эмчлэгч эмчид хүргэдэг байна. Дүрс оношилгоо нь шүдний рентген, хэт авиа оношилгоо зэрэг хэлбэрээр байна. Дүрс оношилгооны тусламж, үйлчилгээг зориулалтын радиологийн тасгаас гадна үзүүлж байгаа тохиолдолд (жишээ нь, шүдний өрөөнд) төвийн бусад тасагт мөрдөгддөг хууль тогтоомж, дүрэм журам, удирдамж болон аюулгүй ажиллагааны зааврыг нэгэн адил дагаж мөрдөх шаардлагатай.

Тусламж, үйлчилгээний хүрээнд хийгдэх дүрс оношилгооны хэсгийг зөв зохион байгуулж, ажиллах орчин, үйлчлүүлэгч/өвчтөн болон эмч, мэргэжилтний аюулгүй байдлыг хангасан байна. Төвийн удирдлага нь дүрс оношилгооны тусламж, үйлчилгээг үндсэн үйл ажиллагааны салшгүй хэсэг гэж үзэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл бололцоогоор хангах, тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах үүрэг хүлээнэ.

Үнэлгээ хийх чиглэл

- Дүрс оношилгооны зохион байгуулалт, тусгай зөвшөөрөл бусад баримт бичигтэй танилцаж, үнэлнэ.©
- Тусламж, үйлчилгээний тогтвортой, жигд байдал болон стандартчилалыг шалгах зорилгоор дүрс оношилгооны тасаг/нэгжид тойрон үзлэгийн үед биеэр очиж үнэлнэ.
- Гэрээт ажил үйлчилгээний гэрээг холбогдох баримт бичиг, тайлан, нотлох баримт бичигтэй тулгаж үнэлнэ.©

Хэмжих үзүүлэлт	1	Байгууллагын дотор эсвэл гадны гэрээт байгууллагаар үзүүлж буй дүрс оношилгооны тусламж, үйлчилгээ нь хууль тогтоомж, дүрэм, журам, холбогдох удирдамж, зааварт нийцсэн байна
	2	Дүрс оношилгооны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй байна.©
	3	(Рентгентэй бол) Цацрагийн аюулгүй байдлын дүгнэлттэй байна.©
	4	Дүрс оношилгооны үйлчилгээг цаг хугацаа, байршлаас үл хамааран нэгдсэн стандартын дагуу тогтмол жигд үзүүлдэг байна.
	5	Шинжилгээний бэлтгэл хангах, ажиллах цагийн хуваарийг ил тод байршуулсан, дотоод гадаад үйлчүүлэгч, хэрэглэгч мэдээлэл авах боломжтой байна
	6	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (лиценз)-тэй, мэргэшсэн эмч, техникч ажиллана. Эмч, мэргэжилтэн зохих боловсрол, мэргэшлийн бэлтгэл болон чадамжтай байна©
	7	Жил бүр мэргэжлийн чиглэлийн цацрагийн аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалтад хамрагдсан байна. Ажилтны чадамжийн үнэлгээг тогтмол хийж, үр дүнгийн баримтжуулалттай байна.©
	8	Дүрс оношилгооны тусламж, үйлчилгээнд жил бүр үнэлгээ хийсэн тухай нотолгоо болон үр дүнг төвийн удирдлагуудын түвшинд хэлэлцсэн тайлантай байна.©

Шалгуур 4.2

Дүрс оношилгоо, шинжилгээний гүйцэтгэл, арга, аргачлалыг стандартчилсан байна.

Агуулга

Дүрс оношилгооны тусламж, үйлчилгээ нь оношилгооны олон төрлийн арга техник, төхөөрөмж болон үйл явцыг хамардаг тул хүн амын бүх бүлгийн эрүүл мэндийг хамгаалах, сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Түүнчлэн, дүрс оношилгоо нь нэгэнт оношлогдсон болон эмчлэгдэж буй өвчний явцыг хянахад гол үндэслэл болдог. Урьдчилан бэлтгэсэн үйл ажиллагааг гүйцэтгэх, стандарт ажиллагааны заавар нь дүрс оношилгооны үйлчилгээний чанарын баталгаажуулалтын хөтөлбөрийн суурь болно. Үүний зорилго нь чанарыг эрхэмлэхийн зэрэгцээ үйл ажиллагааны тогтвортой, жигд байдлыг (стандарт түвшинг) хангахад оршино.

Үйл ажиллагааг гүйцэтгэх стандарт ажиллагааны зааврыг дараах зорилгоор ашиглана. Үүнд:

- Шинжилгээг хэрхэн гүйцэтгэх үе шат бүрийг тодорхойлж, баримтжуулах;
- Шинэ ажилтнуудыг сургах;
- Ховор захиалагддаг шинжилгээг хэрхэн гүйцэтгэх зааврыг ажилтнуудад сануулах;
- Шинжилгээ хийх явцад үүссэн техникийн асуудлыг шийдвэрлэх (troubleshoot);
- Ажилтнуудыг үнэлэх үед гүйцэтгэлийн зохистой түвшнийг хэмжих.

Дүрс оношилгооны тасаг/нэгж нь бүх төрлийн шинжилгээнд зориулсан техник, үйл ажиллагааны аргачлалыг боловсруулна. Дүрс оношилгооны техник, үйл ажиллагааны зааварчилгаа нь ажилтанд ойлгомжтой хэлээр бичигдсэн, хүртээмжтэй

байршилд байх ёстой. Энэ нь цаасан, цахим эсвэл вебд суурилсан хэлбэртэй байж болно.

Төв нь дүрс оношилгооны тоног төхөөрөмжүүдийн аюулгүй байдал болон ашиглалтын бэлэн байдлыг хангах журмыг боловсруулж хэрэгжүүлнэ. Төхөөрөмж тус бүрийн үйл ажиллагааны стандарт, ажиллагааны заавар нь дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:

- a) Хамрах хүрээ болон ерөнхий тойм.
- b) Шинжилгээний өмнөх, шинжилгээний явц болон шинжилгээний дараах үе шатны үйл ажиллагааны дараалал.
- c) Тоног төхөөрөмжийн тайлбар, үзүүлэлт.
- d) Арчилгаа, үйлчилгээ, засвар үйлчилгээний заавар.
- e) Чанарын хяналт.
- f) Аюулгүй ажиллагааны заавар.

Үнэлгээ хийх чиглэл

- Дүрс оношилгооны үйл ажиллагаанд мөрдөж байгаа баримт бичгүүдээс түүвэрлэн танилцаж, тэдгээрийн хүртээмжтэй байдал, ашиглах боломжийг хянаж үнэлнэ.
- Эмч, мэргэжилтэн, ажилтантай ярилцлага хийж, тэдний үйл ажиллагаанд мөрдөж байгаа журам, зааврын талаарх мэдлэгийг магадлан үнэлнэ.
- Дүрс оношилгооны тусламж, үйлчилгээ үзүүлж буй хэсэгт биеэр очиж, стандарт, удирдамж, зааврын шаардлагын хэрэгжилттэй танилцаж, үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Үндэсний стандарт, эмнэлзүйн удирдамж, технологийн картын дагуу оношлогоог хийдэг байна.©
	2	Дүрс оношилгооны тасаг нь шинжилгээний төрөл бүрт зориулсан, бичгээр баталгаажуулсан үйл ажиллагааг гүйцэтгэх стандарт ажиллагааны заавартай байна. Стандарт ажиллагааны заавар нь дээр заасан (a)-(e) хүртэлх бүх заалтуудыг агуулсан байна.©
	3	Үйл ажиллагааг гүйцэтгэх стандарт ажиллагааны заавар болон аюулгүй ажиллагааны заавар нь дүрс оношилгооны эмч, мэргэжилтэнд хүртээмжтэй, ажлын байранд, ашиглах боломжтой байна.
	4	Аюултай болон сэрэмжлүүлэх хариуг мэдээлэх журамтай байна.©
	5	Дүрс оношилгооны тоног төхөөрөмж байршуулах зориулалтын өрөөтэй, аюулгүй байдлыг хангасан байна.
	6	Тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэгч байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг дүгнэсэн байна.©
	7	Жил бүр стандартчилал хэмжилзүйн газар болон цөмийн энергийн комиссоос техникийн аюулгүй байдлын гэрчилгээ авсан байна.©
	8	Дүрс оношилгооны тоног төхөөрөмжийн хэвийн, аюулгүй ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх, шалгалт тохируулгад хамруулах болон гэрээт инженерийн үйл ажиллагааг зохицуулах журмыг холбогдох эрх зүйн баримтыг үндэслэн боловсруулж баталсан, дагаж, мөрддөг байна.©

	9	Тоног төхөөрөмжийн асуудлыг хариуцан хавсран гүйцэтгэх ажилтныг тушаалаар томилж, эсвэл гэрээгээр ажиллуулдаг.©
	10	Тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны сургалтыг багаж, тоног төхөөрөмжийг ажиллуулах эмнэлгийн мэргэжилтэнд зохион байгуулж баримтжуулсан байна.©
	11	Үйлдвэрлэгчийн зааврын дагуу арчилгаа үйлчилгээ, шалгалт тохируулга хийсэн баримтжуулалттай, техникийн үзлэг, засвар хийсэн тайлантай.©
	12	Дүрс оношлогооны тоног төхөөрөмжийн эрсдэл, аюулгүй байдлын үнэлгээ хийсэн, сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлсэн, хяналтын хуудас хөтөлсөн.©

Шалгуур 4.3

Дүрс оношилгооны хариуг өвчний түүх, цахим карт, бүртгэлд тусгана.

Агуулга

Дүрс оношилгооны бичгээр гаргасан тайлан нь дүрс оношилгооны эмч болон илгээгч эмнэлгийн мэргэжилтэн хоорондын эмнэлзүйн харилцааны чухал хэрэгсэл юм. Энэ нь өвчтөний өвчний түүх, картанд бичигдэх, хавсаргах чухал баримт бөгөөд шинжилгээний үр дүнг эмнэлзүйн нөхцөл байдал, үндэслэлтэй уялдуулан тайлбарладаг байна. Дүрс оношилгооны үр дүн/хариу нь ойлгомжтой, эмнэлзүйн ач холбогдолтой байх нь өвчтөнд үзүүлэх чанартай тусламж, үйлчилгээний үндэс болдог. Хэт авиан оношилгооны дүгнэлт эсвэл тайлбарыг өвчний түүх, картанд заавал баримтжуулна. Дүрс оношилгооны үр дүн/хариу нь дараах зүйлсийг заавал агуулна:

- a) ЭМАШБ-ын нэр.
- b) Хуудас бүр дээрх өвчтөнийг танин тодруулах мэдээлэл (нэр, регистр г.м)
- c) Шинжилгээний төрөл.
- d) Шинжилгээний үр дүн/ хариу.
- e) Хариу гаргасан огноо, цаг, минут
- f) Хариу бичсэн эмнэлгийн мэргэжилтний нэр, гарын үсэг.

Үнэлгээ хийх чиглэл

- Өвчтөний өвчний түүх, картыг үзэж, дүрс оношилгооны үр дүн/ хариуны бүрдэл бүрэн эсэхийг үнэлнэ.
- Эмч, сувилагч, дүрс оношилгооны мэргэжилтэн болон бусад мэргэжилтэнтэй ярилцлага хийж, үр дүн/ хариуны бүрдэлд тавигдах шаардлага болон үр дүн/ хариу мэдээлэл дутуу тохиолдолд авах арга хэмжээний талаар тодруулж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Дүрс оношилгооны үр дүн/ хариу (a)-аас (e) хүртэлх бүх асуудлыг багтаан бүрэн гүйцэд гаргадаг байна.©
	2	Үр дүн/хариуг тайлбарлах, мэдээлэх үйл явцад мэргэшсэн эмч, мэргэжилтэн оролцдог байна. Зургийг дижитал хэлбэрээр (CD, онлайн линк) болон мэргэжлийн эмчийн дүгнэлтийн хамт шуурхай өгдөг

3	Шинжилгээний хариуг урьдчилж тогтоосон стандарт хугацаанд гаргадаг байна.
4	Дүрс оношилгоо болон хэт авиан оношилгооны дүгнэлтийг өвчтөний өвчний түүх/ картанд тэмдэглэдэг баримтжуулдаг байна.
5	Тайлан дутуу тохиолдолд хариу гаргасан эмнэлгийн мэргэжилтэнд мэдэгдэх болон залруулах арга хэмжээ авах үйл явцыг хэрэгжүүлдэг байна.
6	Аюултай, сэрэмжлүүлэх хариуны бүртгэлтэй, шуурхай арга хэмжээг хэрэгжүүлж баримтжуулсан байна
7	Дүрс оношилгооны зургийг хадгалах, эргэж дуудах боломжтой систем (PACS эсвэл архив) бүрдүүлсэн байна.®
8	Тусламж, үйлчлигээ авсан үйлчүүлэгчийн мэдээлэл, дүрс оношлогооны хариуг мөшгөн тогтоох боломж бүрдүүлсэн байна.®

Шалгуур 4.4

Цацрагийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

Агуулга

Цацрагийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр нь цацрагийн аюул осол, биологийн нөлөөлөл болон хамгаалалтын арга хэмжээ, мэдээлэл, сургалтыг хамарна. Рентген болон дүрс оношилгооны төхөөрөмжийг аюулгүй ашиглах журмыг боловсруулж мөрддөг, холбогдох дүрэм журмын нийцлийг хангаж, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний үед ч тусламж үзүүлдэг байна.

Жирэмсний эхний гурван сартайд цацраг туяанд өчүүхэн төдий өртөх нь ч үр хөврөлд туйлын аюултай, жирэмсэн үед рентген туяаны нөлөөлөлд өртөх нь урагт гажиг үүсгэх эрсдэлтэй. Иймд оношилгооны өөр ямар ч арга замгүйгээс бусад тохиолдолд цацраг туяаны нөлөөллөөс сэргийлэх хэрэгтэй. Олон улсын атомын энергийн агентлагийн (IAEA) стандартад жирэмсэн өвчтөний дүрс оношилгооны стандартыг ердийн цацрагийн хамгаалалтын стандартаас тусад нь онцгойлон заахыг шаарддаг. Рентген аппаратын өрөө болон бусад хэсэгт анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ, мөн улаан гэрлэн дохио байрлуулж, ионжуулагч цацрагт хүн, ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүд болон хүүхдүүд санамсаргүй байдлаар өртөхөөс сэргийлэх ёстой.

Дүрс оношилгооны үйлчилгээг байгууллага дотроо үзүүлж буй тохиолдолд орчны цацрагийн аюулгүй байдлын арга хэмжээ, хувийн тунгийн хяналтын төхөөрөмж, дозиметрийн үр дүн болон эмч мэргэжилтнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, цусны ерөнхий шинжилгээний үр дүнг тогтмол хянаж, баримтжуулан хадгална. ЭМАШБ нь байгууллагын орчин, ажилтан, үйлчүүлэгч/өвчтөн, тэдний гэр бүлийг цацрагийн аюулаас хамгаалахын тулд цацрагийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэхүү хөтөлбөрийг жил бүр хянаж, шинэчилдэг байна.

Цацрагийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрт дараах зүйлсийг тусгана. Үүнд:

- Хууль тогтоомж, дүрэм, журам, удирдамж, зааврын нийцлийг хангах.
- Бүх цацрагийн төхөөрөмжид засвар үйлчилгээ, шалгалт тохируулгыг (калибровка) тогтмол хийх.
- Ажилтнуудын хувийн хяналтын хэрэгслүүд (дозиметр г.м).
- Ажилтнуудад зориулсан хувийн хамгаалах хэрэгсэл (XXX).

е) Өвчтөний цацрагийн аюулгүй байдлыг хангах урьдчилан сэргийлэх арга хэмжээ

f) Ионжуулагч цацрагт санамсаргүй өртөхөөс сэргийлэх анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг ил тод байршуулсан байх

Үнэлгээ хийх чиглэл

- Цацрагийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг хянаж, хууль тогтоомжийн нийцэл, хамгаалалтын аргууд болон ажилтан, үйлчүүлэгч/ өвчтөний аюулгүй байдлын шаардлагыг хянаж үнэлнэ.
- Орчны цацрагийн хэмжилт, ажилтнуудын термолюминесцент дозиметр (TLD) болон тэмдэгт фильмин үр дүн, цусны ерөнхий шинжилгээний хариу, тугалган хормогчны үзлэг зэргийг хянаж үнэлнэ.
- Эмч, мэргэжилтэн, ажилтнаас ярилцлага авч, тэдний мэдлэг, хандлагыг үэлнэ.
- Дүрс оношилгооны тасаг/нэгжийн тусламж, үйлчилгээний явцад ажиглалт хийж, цацрагийн аюулгүй байдлын урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь (а)-аас (е) хүртэлх бүх элементийг багтаасан, бичгээр баталгаажуулж, шинэчилсэн, батлагдсан цацрагийн аюулгүй ажиллагааны хөтөлбөртэй байна.©
	2	Дүрс оношилгооны эмч, мэргэжилтэн цацрагийн аюулгүй байдлын арга хэмжээний талаар мэдлэгтэй байх ба шинэ заавар, төхөөрөмж ашиглах тухай сургалтад тогтмол хамрагддаг байна.
	3	Цацрагийн аюулгүй байдлын тодорхойлсон эрсдлийг үйл явц, хамгаалалтын тоног төхөөрөмж, хэрэгслийн тусламжтайгаар ажилтан болон үйлчүүлэгч/өвчтөний хувьд бууруулсан байна.
	4	Төв нь өвчтөний цацрагт өртөх тунгийн хэмжээг хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөгдөх дээд хязгаараас хэтрүүлээгүй болохыг баталгаажуулсан байна.
	5	Төв нь цацрагийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн өгөгдөл, үр дүнд хяналт тавьж, үйл явцыг сайжруулах эсвэл хянах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Шалгуур 4.5

Лабораторийн тусламж, үйлчилгээг холбогдох хууль, дүрэм, журам, удирдамжийн дагуу төлөвлөж, зохион байгуулна

Агуулга

Төв нь хүн амд чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээ үзүүлэхэд эмнэлзүйн лаборатори нь нэн чухал үүрэгтэй. Сүүлийн жилүүдэд лабораторийн тусламж, үйлчилгээнд ихээхэн ахиц дэвшил гарч байгаа хэдий ч анхан шатны түвшинд хангалтгүй хэвээр байна.

Төвийн тогтолцоог цогцоор нь бэхжүүлэхийн тулд лабораторийн төлөвлөлт, хангамж, үйл ажиллагааг үр дүнтэй хөгжүүлэх шаардлага тулгарч байна. Төв нь өөрийн үйлчлэх хүрээний хүн ам, эмнэлзүйн тусламж, үйлчилгээний төрөл, эмнэлгийн мэргэжилтний хэрэгцээ болон байгууллагын эрхэм зорилгод нийцүүлэн лабораторийн тогтолцоог боловсронгуй болгож, бэхжүүлнэ.

Лабораторийн тусламж, үйлчилгээг хууль тогтоомж, дүрэм журам болон холбогдох удирдамжид нийцүүлнэ. Лабораторийн тусламж үйлчилгээний хамрах хүрээг жагсаалтаар гаргаж, үйлчүүлэгч/өвчтөн, ажилтан, эмнэлгийн мэргэжилтэнд нээлттэй ил тод байлгана. Лаборатори нь төвийн бусад үйл ажиллагаанаас тусгаарлагдсан байх ёстой бөгөөд лабораторийн бүх үйл ажиллагааг багтаасан, тэр дундаа сорьц цуглуулах тусдаа хэсэгтэй байна.

Лабораторийн зориулалтын өрөө тасалгаанд үйл ажиллагаа явуулснаар тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал хангагдана. Лабораторийн эмч нь бусад ажилтны аюулгүй, эрүүл, үр бүтээлтэй ажиллах орчныг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Лаборатори нь ажилтнуудын ур чадварын үнэлгээг хийх, баримтжуулах журмыг боловсруулна.

Лаборатори нь үйлчүүлэгч/өвчтөний дэргэд буюу Үйлчилгээ үзүүлэх цэгт гүйцэтгэх шинжилгээг аюулгүй, зөв гүйцэтгэх, үнэн зөв байдлыг баталгаажуулах үйл ажиллагааг хариуцна.

Төв нь "Зөв хүнд, Зөв шинжилгээг, Зөв цагт нь, Зөв аргаар хийж, Зөв үр дүнг, Зөв хүргэх" тогтолцоог бүрдүүлнэ.

Үнэлгээ хийх чиглэл

- Лабораторийн тусламж, үйлчилгээний хамрах хүрээг хянаж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамтай нийцэж буйг үнэлнэ.
- Лабораторийн ажилтны хувийн хэрэг дэх ур чадварын үнэлгээг хянан үзнэ.
- Лабораторийн тусламж, үзүүлэхэд дагаж мөрдөх стандарт, удирдамж, заавраар хангагдсан, ашиглах боломжыг үнэлнэ.
- Эмч, мэргэжилтэнтэй ярилцаж, лабораторийн үйл ажиллагаанд мөрдөх стандарт, удирдамж, журмын талаарх мэдлэгийг үнэлнэ.
- Ажиллах хуваарь, шинжилгээний бэлтгэл хангах талаар мэдээлэл өгөх зурагт хуудас, товхимол, бусад хэрэгсэл байгаа эсэхийг ажиглаж үнэлнэ.
- Лабораторийн өрөө, байршил, урсгал, тоног төхөөрөмж, урвалж, оношлуурын хадгалалт, үйл ажиллагаанд хөтөлж байгаа баримт бичгийн хөтлөлтийг ажиглаж, нотлох баримтыг үзэж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Лабораторийн тусламж, үйлчилгээ нь үндэсний хууль тогтоомж, дүрэм журамд бүрэн нийцсэн байна.®
	2	Лабораторийн тусламж, үйлчилгээ нь төвийн эрхэм зорилго болон үйлчлэх хүрээний хүн амын хэрэгцээг хангахуйц байна.®
	3	Байгууллагад хийгддэг шинжилгээний нэр төрөл, зорилго, арга, аргачлалыг тодорхойлж баталгаажуулсан байна. Гадаад, дотоод үйлчлүүлэгчид ил тод мэдээлсэн байна.
	4	Лабораторийн зориулалтын талбайг бусад үйл ажиллагаанаас тусгаарласан байх бөгөөд сорьц цуглуулах тусгай хэсэгтэй байна. төвийн стандартад нийцсэн байна
	5	Лабораторийн урсгалыг зөв зохион байгуулж, шинжилгээ хийх орчин нөхцлийг бүрдүүлсэн байна. /цахилгааны эх үүсвэр, гэрэлтүүлэг, агааржуулалт, дуу чимээ, ус, гар угаах боломж, хог хаягдал цуглуулах, халдваргүйжүүлэлт, устгал, эмч, ажилчдын хувцас солих, ажиллах, амрах өрөөний зохион байгуулалт/

6	Лаборатори нь үйл ажиллагааны хүрээнд нийцсэн мэргэшсэн эмч, мэргэжилтэнгээр хангагдсан байна.
7	Ажилтнуудын ур чадварын үнэлгээг тогтмол хийж, үр дүнг хувийн хэрэгт нь тэмдэглэж баримтжуулсан байна.᠖
9	Үйлчлэх цэгт гүйцэтгэх шинжилгээний үр дүн аюулгүй, найдвартай байхыг хангах үйл явцтай байна.
10	Шинжилгээний нэр төрөл, ажиллах цагийн хуваарийг ил тод байршуулсан, дотоод гадаад үйлчлүүлэгч, хэрэглэгч мэдээлэл авах боломжтой байна.
11	Үйл ажиллагааны төлөвлөгөөтэй, хэрэгжилтийг ханган, дүгнэлт өгч ажилласан байна.᠖

Шалгуур 4.6

Лабораторийн оношлуур, урвалж, дагалдах хэрэгсэл бусад материалыг удирдах үйл явцтай байна

Агуулга

Лабораторийн оношлуур, урвалж, дагалдах хэрэгсэл бусад материалыг зөв удирдах нь зардлыг мэдэгдэхүйц бууруулах, шинжилгээний үр дүнд шууд нөлөөлдөг оношлуур, урвалжын чанар, аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой. Мөн лабораторийн удирдлагыг үр ашигтай ажиллуулах, бүтээмжийг нэмэгдүүлэх боломжийг олгодог.

Төв нь лабораторийн оношлуур, урвалж, дагалдах хэрэгсэл болон бусад материалын менежментийн үйл явцыг зохицуулсан журмыг боловсруулж хэрэгжүүлнэ. Журамд дараах зүйлсийг тусгана. Үүнд:

- а) Нийлүүлсэн оношлуур, урвалж, дагалдах хэрэгслийг шалгах, хүлээн авах болон буцаах (хүлээн авахаас татгалзах) шалгуур үзүүлэлтүүд.
- б) Лабораторид байгаа бүх оношлуур, урвалжийг таньж тогтоох, бүртгэх, хаягжуулах аргууд.
- в) Оношлуур, урвалжийн чанар болон хүчинтэй хугацааг үнэлэх арга.
- д) Хугацаа нь дууссан оношлуур, урвалж, дагалдах хэрэгсэл, материалыг ашиглахгүй байдлыг хангах арга хэмжээ.
- е) Оношлуур, урвалж болон дагалдах материалын хадгалалтын зохистой нөхцөл.
- ф) Лабораторийн хэрэгцээнд үндэслэн оношлуур, урвалж, дагалдах хэрэгсэл, материалыг дахин захиалж, нөхөн хангалт хийх, байнга байлгах нөөцийн доод хэмжээг тогтоох.
- г) Оношлуур, урвалж, дагалдах хэрэгсэл, материалыг захиалах, олгох, түгээх үйл явц болон хариуцах ажилтан.

Үнэлгээ хийх чиглэл

- Баримт бичиг, журмыг хянаж үнэлнэ.
- Оношлуур, урвалж, дагалдах хэрэгсэл бусад материалын жагсаалтыг танилцаж үнэлнэ
- Оношлуур, урвалж, дагалдах хэрэгсэл бусад материалын хадгалалт, хаягжуулалт, ашиглалт болон чанарыг шалгах үйл явцыг ажиглаж, нотлох баримтыг үзэж үнэлнэ.᠖

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгын (а)-аас (г) хүртэлх бүх элементийг багтаасан, батлагдсан журамтай байна. ⑥
	2	Шинжилгээний бүх үйл явцад ашиглагддаг оношлуур, урвалж, бодис, дагалдах хэрэгслийн жагсаалттай, шинэчилдэг байна.
	3	Оношлуур, урвалж, дагалдах хэрэгсэл бусад материалыг батлагдсан шалгуурын дагуу шалгаж, хүлээн авдаг эсвэл буцаадаг байна. ⑥
	4	Оношлуур, урвалж, дагалдах хэрэгсэл бусад материалыг ашиглахын өмнө чанар, хүчинтэй байдлыг нь үнэлдэг байна. Оношлуур, урвалж, бодисын чанарын баталгааны гэрчилгээг баримтжуулалтыг авч хянаж, үнэлдэг байна. ⑥
	5	Оношлуур, урвалж, дагалдах хэрэгсэл бусад материалыг үнэн зөв бүртгэж, хаягжуулсан байна. ⑥
	6	Оношлуур, урвалж, дагалдах хэрэгсэл бусад материалыг батлагдсан журмын дагуу захиалж, олгож, түгээдэг байна. ⑥
	7	Оношлуур, урвалж, бодисын зөв нөхцөлд хадгалдаг, хадгалалтын нөхцөлийг баримтжуулж хянадаг байна. ⑥

Шалгуур 4.7

Лабораторийн бүх үе шатанд хийгдэх үйл ажиллагааны гүйцэтгэлийг стандартчилсан байна.

Агуулга

Лабораторийн тусламж, үйлчилгээ нь шинжилгээний олон төрлийн арга, ажилбар, үйл явцыг хамардаг тул үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Мөн нэгэнт оношлогдсон болон эмчлэгдэж буй өвчний явцыг хянахад лабораторийн шинжилгээ нь гол үндэслэл болдог. Урьдчилан боловсруулсан үйл явцыг удирдах журам, үйл ажиллагааг гүйцэтгэх стандарт ажиллагааны заавар (САЗ) нь лабораторийн чанарын баталгаажуулалтын хөтөлбөрийн үндэс суурь болдог. САЗ-ын зорилго нь чанар, үйл ажиллагааны тогтвортой нэг ижил жигд байх байдлыг хангахад оршино. Стандарт ажиллагааны зааврыг дараах зорилгоор ашиглаж болно:

- Шинжилгээг хэрхэн гүйцэтгэхийг тодорхой зааварчлан, гүйцэтгэлийг баримтжуулах.
- Шинэ ажилтнуудыг сургах.
- Ховор захиалагддаг шинжилгээг хэрхэн гүйцэтгэх зааврыг ажилтнуудад сануулах.
- Шинжилгээний явцад гарсан асуудлыг шийдвэрлэх (troubleshoot).
- Ажилтнуудыг үнэлэх үед шинжилгээний гүйцэтгэлийн зохистой түвшнийг хэмжих.

Лаборатори нь бүх төрлийн шинжилгээний нэр төрөл, арга, аргачлалд зориулсан стандарт ажиллагааны зааврыг боловсруулна. Эдгээр заавар нь ажилтнуудад цаасан болон цахим суурилсан хэлбэрээр хүртээмжтэй байна.

Лаборатори нь стандарт ажиллагааны зааврыг тогтмол мөрдөж, үе шаттайгаар хянан шалгаж байх ёстой. САЗ-д дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:

- а) Шинжилгээний зарчим болон эмнэлзүйн хэрэглээний ач холбогдол

- b) Үйлчүүлэгч өвчтөнийг шинжилгээнд бэлтгэх шаардлага, сорьцын төрөл, сорьц цуглуулах болон хадгалах заавар. Сорьцыг хүлээн авах эсвэл татгалзах (буцаах) шалгуур үзүүлэлтүүд.
- c) Ашиглах урвалж болон тоног төхөөрөмж.
- d) Шинжилгээний явц, үүнд дотоод хяналт хийх, тооцоолол хийх болон үр дүнг тайлбарлах заавар.
- e) Чанарын хяналтын арга хэмжээнүүд.

Үнэлгээ хийх чиглэл

- Лабораторийн үйл ажиллагааны стандарт ажиллагааны заавар, шинжигээ хийх арга зүйг хянан үнэлнэ.
- Лабораторийн шинжилгээ өгч буй үйлчүүлэгч/өвчтөнийг дагаж ажиглалт хийх замаар шинжилгээний өмнөх үе шатны үйл явцыг үнэлж болно.
- Лабораторийн эмч, мэргэжилтэнтэй ярилцлага хийж, тэдний шинжилгээний үйл явц, стандарт ажиллагааны зааврын талаарх мэдлэгийг үнэлнэ.
- Лабораторийн хэсгүүдээр явж, тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга (калибровка), урвалжийн ашиглалт, хэмжих хязгаар болон үр дүнг ажиглаж үнэлнэ.
- Чанарын хяналтын журам болон бүртгэлүүд, чанарын хяналтын өгөгдөлд тогтмол хийсэн дүн шинжилгээ, мөн хэвийн бус үзүүлэлт (outliers) эсвэл хандлага (trends) илэрсэн үед авсан арга хэмжээг хянан үзэж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Лаборатори нь шинжилгээний нэр төрөл, арга, аргачлал бүрт зориулсан, (a)-аас (e) хүртэлх бүх элементийг тусгасан, холбогдох ажилтнуудад хүртээмжтэй, бичгээр баталгаажуулсан заавартай байна, тодорхой давтамжаар хянаж, шаардлагтай шинэчлэлт өөрчлөлтийг хийдэг байна.©
	2	Лабораторийн эмч, мэргэжилтэн үйл явц, үе шатыг удирдах журам, стандарт ажиллагааны зааврын сургалтад хамрагдаж, мэдээллээ тогтмол шинэчилдэг байна.
	3	Шинжилгээний өмнөх үе шат зөв хэрэгждэг байна. Үүнд: зохицуулсан журамтай, журмын дагуу шинжилгээний бэлтгэл зөв хангах талаар мэдээлэллийг эмч, үйлчүүлэгч/ өвчтөнд и тод нээлттэй байршуулах, ойлгомжтой, байж мэдээллээр бүрэн хангагддаг, шинжилгээнд илгээх маягыг бүрэн бөглөх, үйлчүүлэгч/өвчтөнийг зөв танин тодруулах, сорьц зөв авах, сорьцыг зөв хаяглах болон зөв тээвэрлэх үйл явцыг хамруулж үнэлнэ. Сорьц хүлээн авсан, буцаасан бүртгэл хөтөлсөн байна.©
	4	Шинжилгээний явц зөв хэрэгждэг байна. Энэ үе шатыг зохицуулах журамтай, журмыг тогтмол мөрддөг байна. Үүнд: шинжилгээ бүрийг хийх стандарт, ажиллагааны зааврыг баримтжуулсан, дагаж мөрддөг, чанарын дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж, үр дүнг үнэлдэг, биологийн жишиг/ лавлах хэмжээг тодорхойлох үйл явцыг хамруулж үнэлнэ. Шинжилгээний нэр төрөл бүрээр протокол бүрэн хөтөлсөн байна. Шинжилгээний хариуг давхар шалгаж, холбогдох эмч, мэргэжилтнээр хянуулсан байна.©
	5	Шинжилгээний дараах үе шат зөв хэрэгждэг байна. Энэ үе шатыг зохицуулах журамтай, журмыг тогтмол мөрддөг байна Үүнд: сорьц

	хадгалах үйл явц, лабораторийн хариуг хадгалах хугацааг тогтоох болон шинжилгээний үр дүн/хариуг эрх бүхий хүлээн авагчид хүргэх болон аюултай, сэрэмжлүүлэх хариуг цаг алдалгүй зөв хүргэх үйл явцыг хамруулж үнэлнэ.
6	Чанарын дотоод болон гадаад хяналтын арга хэмжээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг үе шаттайгаар хянан хэлэлцэж, шаардлагатай залруулах, сайжруулах арга хэмжээг авдаг байна.᠖
7	Хамтран ажиллах байгууллагатай гэрээ хийн хийлгэх шинжилгээний нэр төрлийг тохирсон байна. Гадны байгууллагаар хийсэн шинжилгээний бүртгэлтэй байна.᠖
8	Лаборатори өөр дээрээ болон гадны байгууллагаар хийлгэсэн шинжилгээний нэр төрөл бүрээр тайланг гаргаж дүгнэн, холбогдох эмч мэргэжилтэн, удирдлагад танилцуулсан байна.᠖

Шалгуур 4.8

Лабораторийн шинжилгээний хариуг тогтоосон стандарт хугацаанд гаргана.

Агуулга

Шинжилгээ хийж гүйцэтгэх буюу хариу гарах хугацаа (ТАТ) гэдэг нь шинжилгээний хүсэлт илгээсэн мөчөөс эхлэн үйл явц бүрэн дуусч хариу гарах хүртэлх хугацааны интервал юм. Лаборатори нь шинжилгээ тус бүрийн хийж гүйцэтгэх хугацааг тодорхойлсон байна. Лаборатори нь шинжилгээг хийж, гүйцэтгэх хугацааг хэмжих үйл явцтай байх бөгөөд үүнд хяналт тавьж, хэмжилт хийх хариуцлагатай ажилтнуудыг томилно. Энэхүү үйл явц нь шинжилгээ хийж, гүйцэтгэх хугацааг зөвшөөрөгдөх хугацааны хязгаарт багтаах арга хэрэгслүүдийг агуулна. Нэг буюу хэд хэдэн шинжилгээний гүйцэтгэх хугацаа шаардлага хангахгүй буюу зөвшөөрөгдөх хугацаанаас хэтэрсэн тохиолдолд лабораторийн удирдлагууд тухайн өгөгдөлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай бол шинжилгээний үйл явцыг үнэлэн, хариу гаргах үйл явцыг өөрчлөх эсвэл илүү бодит хугацааны стандарт тогтоох арга хэмжээ авна. Лабораторийн шинжилгээний үр дүнг/ хариуг өвчтөний өвчний түүх, эмнэлгийн бүртгэлд баримтжуулах бөгөөд дараах зүйлсийг заавал тусгана. Үүнд:

- a) Шинжилгээний нэр, төрлийг тодорхой заах.
- b) Шинжилгээг хийсэн лабораторийн нэр.
- c) Өвчтөнийг танин тодруулах мэдээлэл.
- d) Шинжилгээ захиалсан (илгээсэн) эмчийн нэр.
- e) Анхдагч сорьц цуглуулсан огноо болон цаг, минут
- f) Анхдагч сорьцын төрөл.
- g) Биологийн жишиг, лавлах хэмжээ болон эмнэлзүйн шийдвэр гаргахад ашиглах утгууд.
- h) Шаардлагатай тохиолдолд шинжилгээний үр дүнгийн тайлбар болон зөвлөмжүүд.
- i) Үр дүнг хянаж, тайлан гаргахыг зөвшөөрсөн хянаж, баталгаажуулсан ажилтны мэдээлэл.
- j) Тайлан бэлэн болсон огноо болон хариу олгосон цаг, минут

Лаборатори нь шинжилгээний хариу саатсан тохиолдолд захиалагч эмч эсвэл үйлчлүүлэгч/өвчтөнд мэдэгдэх тогтсон үйл явцтай байна.

Үнэлгээ хийх чиглэл

- Лабораторийн тусламж, үйлчилгээ авч буй үйлчүүлэгч/өвчтөнийг дагаж ажиглалт хийх (мөшгөх) замаар шинжилгээний хүсэлт илгээсэн, сорьц авсан, шинжилгээ гүйцэтгэсэн болон хариу гаргасан хугацааг хянан үзэж үнэлнэ.
- Өвчтөний өвчний түүх, картанд хяналт хийж, лабораторийн шинжилгээний хариуг бүртгэсэн хугацааг үнэлж болно.
- Эмч, сувилагч, эмнэлгийн ажилтан болон бусад мэргэжилтнүүдтэй ярилцлага хийж, лабораторийн хариу гарах хугацааны талаарх тэдний туршлага, санал сэтгэгдлийг тодруулж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь лабораторийн шинжилгээ тус бүрийн нийт гүйцэтгэх хугацаа болон түүнийг хэмжих аргачлалыг тодорхойлсон үйл явцтай байна. ⑥
	2	Лабораторийн шинжилгээний үр дүн/хариу нь (а)-аас (й) хүртэлх бүх шаардлагатай мэдээллийг агуулсан байна. ⑥
	3	Лабораторийн тайлан дахь жишиг/ лавлах хэмжээг жилд нэгээс доошгүй удаа шинэчилдэг байна. ⑥
	4	Лабораторийн шинжилгээний хариу гаргах хугацааны өгөгдөлд хяналт тавьж, үйл явцыг сайжруулах эсвэл хянах арга хэмжээг шаардлагатай бол авч хэрэгжүүлдэг байна. ⑥
	5	Шинжилгээ гүйцэтгэх хугацаа саатсан тохиолдолд захиалагч/хэрэглэгч эмч, үйлчүүлэгч/өвчтөнд заавал мэдэгддэг байна.
	6	Яаралтай горимоор шинжилгээг хийх журамтай, хариу гарах хугацаанд хяналт үнэлгээг хийдэг байна. ⑥

Шалгуур 4.9

Лабораторийн аюулгүй ажиллагааны цогц хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

Агуулга

Лабораторийн орчин нь өндөр эрсдэлтэй бүс бөгөөд лабораторийн ажилтнууд химийн, биологийн, физикийн аюул занал, түүнчлэн булчин, араг ясны ачаалал зэрэг олон төрлийн болзошгүй эрсдэлд өртөж байдаг. Лабораторийн аюулгүй байдлыг дүрэм, журам, сайн туршлага нэвирүүлэх замаар зохицуулдаг. Лабораторийг ажилтны аюулгүй байдлыг хангах зорилгоор олон төрлийн заавар, удирдамж гарч олон удаа шинэчлэгдэж ирсэн.

Лабораторийн удирдлага нь нийт ажилтан, үйлчүүлэгч/өвчтөн болон тэдний гэр бүлд аюулгүй орчныг бүрдүүлэх аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг боловсруулна. Лабораторийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр болон лабораторийн эрсдэлийн үнэлгээг жил бүр нэгээс доошгүй удаа, эсвэл шинэ тоног төхөөрөмж, үйлчилгээ нэвтрүүлэх, лабораторийн арга зүй, арга аргачлалд өөрчлөлт орох тутамд хийж, хянаж, шинэчилдэг байна. Лаборатори нь үндэсний шаардлагын дагуу лабораторийн барилга байгууламж, орчны аюулгүй байдлын арга хэмжээг тодорхойлсон баримтжуулсан хөтөлбөртэй байна. Энэхүү хөтөлбөрийг жил бүр хэрэгжүүлж, хянаж, шинэчилнэ. Лабораторийн аюулгүй ажиллагааны цогц хөтөлбөрт эрсдэлийн үнэлгээ, лабораторийн эмч мэргэжилтний удаан зогсох, ижил хөдөлгөөн байнга давтан хийх зэргээс үүсэх эрүүл мэндийн эрсдэл зэргийг хамруулна. Хөтөлбөрт дараах зүйлс багтана. Үүнд:

- а) Эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн аюулгүй байдал: Лабораторийн ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах зааварчилгаа.
- б) Сорьцын аюулгүй байдал: Шинжилгээний сорьцыг гэмтээхгүй, чанарыг алдагдуулахгүй, бохирдуулахгүй байх арга хэмжээ.
- с) Орчин болон тоног төхөөрөмжийн аюулгүй байдал: Лабораторийн барилга байгууламж, техник хэрэгслийг аюулгүй ашиглах заавар.
- д) Лабораторийн химийн бодис болон аюултай материалын жагсаалт: Ашиглагдаж буй бүх хортой, аюултай бодисуудын нэгдсэн бүртгэл.
- е) Осол, зөрчлийг шийдвэрлэх болон шаардлагатай үед залруулах, сэргийлэх арга хэмжээ авах: Гарсан осол бүрийг бүртгэж, дахин гаргахгүй байх арга замыг тодорхойлох.
- ф) Лабораторийн хог хаягдлыг зохистой устгах: Биологийн болон химийн аюултай хог хаягдлыг ангилан устгах журам.
- г) Аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудасад тавигдах шаардлага: Химийн бодис бүрийн хор аюулын мэдээллийг агуулсан аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудсыг бэлэн байлгана.
- х) Химийн болон биологийн шингэний асгаралтыг цэвэрлэх, шийдвэрлэх: Асгаралт үүссэн үед авах хариу арга хэмжээний зааварчилгаа.
- и) Хувийн хамгаалах хэрэгслийг (ХХХ) ашиглах зааварчилгаа: Халат, бээлий, нүдний шил зэрэг хэрэгслийг хэрхэн зөв хэрэглэх тухай үерэг цогц асуудлыг хамруулсан байна.

Үнэлгээ хийх чиглэл

- Лабораторийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг хянаж үнэлэх бөгөөд үүнд дараах зүйлс заавал багтсан байна: химийн бодис болон аюултай материалын жагсаалт, асгаралттай ажиллах заавар, аюулгүй байдлын шаардлагууд, зохистой хувийн хамгаалах хэрэгсэл (ХХХ), лабораторийн эрсдэлийн үнэлгээ, аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудасны шаардлага, эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ болон шалгалт тохируулга, хог хаягдлыг зохистой устгах үйл явц.
- Лабораторийн аюулгүй байдлын тайлангууд, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, химийн бодисын хадгалалт, хаягжуулалт болон хог хаягдал устгах үйл явцыг хянан үзэж үнэлнэ.
- Лабораторийн эмч, мэргэжилтэн, ажилтнуудтай ярилцлага хийж, тэдний лабораторийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийн талаарх мэдлэг, мэдээллийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Лаборатори болон лабораторийн үйлчилгээний аюулгүй байдлын арга хэмжээг тодорхойлсон, (а)-аас (и) хүртэлх бүх элементийг багтаасан, баталгаажуулсан хөтөлбөртэй, тогтмол хугацаанд хянаж шинэчилдэг байна.®
	2	Лабораторийн ажилтнууд лабораторийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийн чиглэлээр сургалтад хамрагдсан байна.
	3	Эмч, мэргэжилтэн, ажилтан хөтөлбөрийн дагуу аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх зааварчилгааг мөрдөж ажилладаг байна.
	4	Лабораторийн эрсдэлийн үнэлгээг тогтмол хийдэг, сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, үр дүнг үнэлдэг байна.

5	Лабораторийн үйл ажиллагааны тохиолдлыг бүртгэн, засах, сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, үр дүнг үнэлдэг байна.
6	Химийн бодис, оношлуур, урвалж, бодистой зөв харьцах, аюулгүй ажиллагааг хангах журам, зааврыг мөрддөг байна.©
7	Лабораторийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг зөв ангилж, зөв хадгалан устгалд хүлээлгэн өгч баримтжуулсан байна.©
8	Хувийн хамгаалах хэрэгсэлээр бүрэн хангагдсан байна.
9	Лабораторийн тоног төхөөрөмжийн жагсаалттай.©
10	Ханган нийлүүлэгч байгууллагатай гэрээ байгуулж, дүгнэсэн байна
11	Үйлдвэрлэгчийн зааврын дагуу боловсруулсан тоног төхөөрөмж, ажиллуулах болон аюулгүй ажиллагааны заавартай, мөрддөг байна
12	Эмч, мэргэжилтэнг сургаж, ур чадвар эзэмшүүлсэн бүртгэлтэй.©
13	Үйлдвэрлэгчийн зааврын дагуу арчилгаа үйлчилгээ, шалгалт тохируулга хийсэн баримтжуулалттай.©
14	ЭМАШТҮБ нь лабораторийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийн тайлангийн өгөгдөлд хяналт тавьж, үйл явцыг сайжруулах эсвэл хянах арга хэмжээг шаардлагатай бол авч хэрэгжүүлдэг байна.©

БҮЛЭГ 5. МЭС ЗАСЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Тойм

Мэс засал болон инвазив ажилбар гэдэг нь арьсыг зүсэх, цоолох, ямар нэгэн багаж, хэрэгсэл ашиглах замаар бүрэн бүтэн байдлыг нь алдагдуулж, өвчин эмгэгийг оношилдог, эмчилдэг арга юм.

Оёдол тавих, буглаанд урсгуур тавих, шүд авах, умайд ерөндөг тавих зэрэг нь төвд түгээмэл хийдэг жижиг инвазив ажилбарт багтана.

Эдгээр ажилбарыг төвд хийж гүйцэтгэснээр өвчтөнийг дараагийн шатны байгууллагад шилжүүлэлгүйгээр тухайн орон нутагт нь эмчилж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмж, үр дүнг нэмэгдүүлдэг.

Энэ бүлэг нь төвийн нэгжид мэдээгүйжүүлэгтэй болон мэдээгүйжүүлэггүй хийх бүх төрлийн мэс засал болон инвазив ажилбаруудад хамааралтай.

Шинжээч нь мэс засал ба инвазив ажилбар хийгддэг бүх нэгжид (жишээлбэл, шүдний кабинет, яаралтай тусламжийн өрөө, гэр бүл төлөвлөлтийн кабинет гм) үнэлгээ хийж, эрүүл мэндийн ажилтны ур чадвар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж буй эсэхийг баталгаажуулна.

Доорх жагсаалтад энэ бүлэгт хамаарах шалгуурыг нэгтгэн харуулав.

5.1	Эмнэлэг нь хууль тогтоомж, журамд нийцүүлж, өвчтөний хэрэгцээнд тохирсон тайвшруулалт, мэдээгүйжүүлэгийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
5.2	Тайвшруулга өгөх үйл явц нь эмнэлгийн хэмжээнд нэгдсэн журмаар зохион байгуулагдана.

5.3	Тайвшруулгыг хийх эмч болон өвчтөнийг хянах үүрэгтэй ажилтнууд нь мэргэшсэн, чадамжтай байна.
5.4	Тайвшруулга болон өвчтөний хяналтыг эмнэл зүйн заавар, стандарт удирдамжийн дагуу гүйцэтгэж, өвчний түүхэнд тэмдэглэж, баримтжуулна.
5.5	Тайвшруулгатай холбоотой эрсдэл, давуу тал, бусад сонголтын талаар өвчтөн, түүний гэр бүл эсвэл шийдвэр гаргах эрх бүхий хүмүүстэй ярилцаж танилцуулна.
5.6	Мэргэшсэн эмч нь мэдээгүйжүүлгийн өмнөх болон мэдээгүйжүүлэг эхлэхийн өмнөх үнэлгээг хийнэ.
5.7	Мэдээгүйжүүлгийн төлөвлөгөөг өвчтөн түүний асран хамгаалагчид танилцуулж ярилцах ба шийдвэрийг өвчний түүхэнд баримтжуулна.
5.8	Мэдээгүйжүүлэг ба мэс заслын явцад өвчтөний биеийн байдлыг стандарт, зааврын дагуу тасралтгүй хянаж, өвчний түүхэнд баримтжуулна.
5.9	Мэдээгүйжүүлгийн дараа өвчтөний биеийн байдлыг хянаж, мэргэшсэн эмчийн шийдвэрээр эсвэл батлагдсан шалгуурын дагуу сэрээх өрөөнөөс шилжүүлнэ.
5.10	Мэс засал болон инвазив ажилбар нь холбогдох журам, эмнэлзүйн удирдамж, зааврын дагуу хийгддэг байна.
5.11	Мэс засал болон инвазив ажилбарын өмнө үзлэг, шинжилгээ болон сувилахуйн үнэлгээг хийдэг байна
5.12	Эмч нь мэс засал болон инвазив ажилбарын талбайн тэмдэглэгээг өвчтөн болон түүний гэр бүлийн оролцоотой хийдэг байна.
5.13	Мэс засал, ажилбарын өмнө шаардлагатай баримт бичиг, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж бүрэн, хэвийн ажиллагаатай байгаа эсэхийг урьдчилан шалгадаг байна.
5.14	Мэс засал болон ажилбар эхлэхийн өмнө зөв өвчтөнд, зөв ажилбарыг, зөв талбайд хийж буй эсэхийг баталгаажуулдаг байна.

ШАЛГУУР, АГУУЛГА, ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур 5.1

Эмнэлэг нь хууль тогтоомж, журамд нийцүүлж, өвчтөний хэрэгцээнд тохирсон тайвшруулалт, мэдээгүйжүүлэгийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.

Агуулга

Тайвшруулалт болон мэдээгүйжүүлэг нь ихэвчлэн хөнгөн тайвшруулалтаас бүрэн нойрсуулах эмчилгээ рүү шилжих тасралтгүй процесс гэж үздэг. Тайвшруулалт болон мэдээгүйжүүлэг нь үнэлгээ, хяналт, сэрээх бүх үйл явцыг хамруулдаг. Энэ тусламж үйлчилгээг мэргэшсэн мэргэжилтэн хариуцаж хууль, стандарт, журмын дагуу үзүүлэх ба яаралтай тусламжийн үед тайвшруулалт, мэдээгүйжүүлэг өгөх бэлэн байдлыг хангасан байна. Эмнэлгийн байгууллага нь мэдээ алдуулалтын тусламж үйлчилгээг гэрээт хэлбэрээр зохион байгуулж болно. Энэ нь тусламж үйлчилгээ үзүүлэх эмнэлэг нь дээрх чиглэлд гадны мэргэжлийн байгууллага эсвэл хувь мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах үйл явц юм. Тусламж үйлчилгээний зохион байгуулалтаас үл хамаарч чанар, аюулгүй байдлыг хангаж ажиллах ёстой байдаг.

Гэрээт үйлчилгээг сонгох үйл явцын гол үе шатууд:

1. Мэргэжлийн ур чадварын үнэлгээ: Гэрээт эмч, мэргэжилтнүүд нь зохих тусгай зөвшөөрөл, сертификатай эсэхийг баталгаажуулах.
2. Чанарт тавих шаардлага: Гэрээт тал нь эмнэлгийн дотоод журам, аюулгүй ажиллагааны стандарт болон эмнэлзүйн удирдамжийг бүрэн дагаж мөрдөх.
3. Гүйцэтгэлийн хяналт: Үйлчилгээ үзүүлж эхэлсний дараа тэдний ажлын үр дүн, өвчтөний аюулгүй байдлыг хангах байдалд тогтмол үнэлгээ хийх.
4. Тоног төхөөрөмж ба Эм тарианы зохицуулалт: Гэрээт тал өөрийн багаж хэрэгслээр үйлчилгээ үзүүлэх үү, эсвэл эмнэлгийн нөөцийг ашиглах уу гэдгийг тодорхой болгож, тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

Үнэлгээ хийх чиглэл:

- Мэдээгүйжүүлэг, тайвшруулга хийх тусламж үйлчилгээний журмыг үнэлнэ.
- Мэргэшсэн мэргэжилтэн мэдээгүйжүүлэг, тайвшруулга хийх тусламж үйлчилгээ хийсэн бүртгэлийг үзэж үнэлнэ.
- Гэрээт ажилтантай бол гэрээг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Хууль тогтоомж, журамд нийцүүлж, эмнэлзүйн зааврын дагуу өвчтөний хэрэгцээнд тохирсон тайвшруулалт, мэдээгүйжүүлэгийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.
	2	Эмнэлэгт Мэдээгүйжүүлэгийн тусламж үйлчилгээг мэргэшсэн мэргэжилтэн хариуцна. Үүнд: <ul style="list-style-type: none">• Тусламж, үйлчилгээний журмыг боловсруулан, нэвтрүүлж, шинэчилдэг байна.• Тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.• Тайвшруулалт, мэдээгүйжүүлэгийн тусламж үйлчилгээнд хяналт, үнэлгээ хийнэ.
	3	Мэргэшсэн мэргэжилтэн нь доорх мэдээгүйжүүлгийн тусламж үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:

	<ul style="list-style-type: none"> • Тайвшруулах болон мэдээгүйжүүлгийн тусламж үйлчилгээ нь эмнэлгийн хэмжээнд нэгдсэн аргачлалтай байна. • Яаралтай тусламжийн үед тайвшруулалт, мэдээгүйжүүлэгийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд бэлэн байна. • Тайвшруулалт, мэдээгүйжүүлэгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн тохиолдол бүрт хяналт тавьж, үнэлгээ хийнэ.
4	<p>Эмнэлэг нь мэдээгүйжүүлэг, тайвшруулах тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх байгууллагыг сонгох журамтай байх ба үүнд дараах зүйлс багтана. ⑤</p> <ul style="list-style-type: none"> • Мэдээгүйжүүлэг, тайвшруулах үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үед эмнэлгийн удирдлагууд болон мэргэшсэн ажилтны баталсан 'Гэрээт мэдээгүйжүүлгийн үйлчилгээний шинэчлэгдсэн жагсаалт'-ыг ашиглана • Гэрээг гүйцэтгэгч нь ажлын гүйцэтгэлийн бүртгэлтэй байх ба холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрддөг байна • Эмнэлэг нь гэрээгээр тусламж үйлчилгээ үзүүлж буй ажилтан бүрийн мэргэшсэн, зөвшөөрөлтэй байдлын тухай бүртгэлтэй байна <p>Мэдээгүйжүүлэг, тайвшруулах үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэсэн байна.</p>

Шалгуур 5.2

Тайвшруулга өгөх үйл явц нь эмнэлгийн хэмжээнд нэгдсэн журмаар зохион байгуулагдана.

Агуулга

Эмнэлгийн орчинд "Тайвшруулга" нь өвчтөнд оношилгоо, эмчилгээний явцад айдас, түгшүүр, өвдөлтийг багасгах зорилгоор хэрэглэдэг арга юм. Энэ нь өвчтөнд тухайн ажилбарын үеэр илүү тайван, аюулгүй мэдрэмж төрүүлэхэд чиглэнэ. Тайвшруулга нь эмийн болон эмийн бус аргаа хийгдэх бөгөөд ихэнх тохиолдолд амьсгал, зүрх судасны үйл ажиллагааг хэвийн хадгалах боломжтой болдог.

Тайвшруулга нь ихэнхдээ мэс заслын өрөөнд хийгддэг боловч эмнэлгийн бусад нэгжүүдэд ч өргөн хийгддэг байна.

Эмнэлэг нь тайвшруулгын арга хэрэгслийг хэрхэн, хаана ашиглаж болох талаар тодорхой зааварчилгаа, журам боловсруулдаг. Тайвшруулга хийх ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, эмнэлгийн тоног төхөөрөмж, материалууд болон хяналт нь эмнэлгийн аль ч хэсэгт ижил байх ёстой.

Үнэлгээ хийх чиглэл:

- Тайвшруулга хийх тусламж үйлчилгээний журмыг үнэлнэ.
- Мэргэшсэн мэргэжилтэн ярилцаж, мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлнэ.
- Тусгай тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг үнэлнэ.

- Таниулсан зөвшөөрлийн хуудастай танилцаж үнэлнэ.
- Мэргэшсэн мэргэжилтэн нь амилуулах суурь тусламжийн сургалтад хамрагдсан гэрчилгээтэй байна.

Хэмжих үзүүлэлт	1	Эмнэлэг нь тайвшруулга хийх тухай журамтай байх ба стандартыг баримтлана.©
	2	<p>Тайвшруулга өгөх тухай журам болон гардан үйлдлийг бүх эмч, мэргэжилтнүүд бүрэн ойлгосон байх бөгөөд дээрх журам нь дараах зүйлсийг заавал тусгасан байна:©</p> <ul style="list-style-type: none"> • Тайвшруулга хийж болох эмнэлгийн тасаг нэгж, байршил • Тайвшруулгын үйл явцад оролцох ажилтны мэргэшсэн байдал болон ур чадвар • Хүүхэд, насанд хүрэгч, ахмад настан зэрэг өвчтөний онцлогт тохирсон эмийн тун, хэрэглээ болон шаардлагатай тусгай тоног төхөөрөмжийн бэлэн байдал • Ажилбар болон тайвшруулга өгөхтэй холбоотой таниулсан зөвшөөрөл авсан байна <p>Мэдээгүйжүүлэг, тайвшруулалт авч буй өвчтөнд амилуулах лавшруулсан тусламж үзүүлэх тохиолдолд сургалтад хамрагдсан мэргэжилтэн бэлэн байна.</p>

Шалгуур 5.3

Тайвшруулгыг хийх эмч болон өвчтөнийг хянах үүрэгтэй ажилтнууд нь мэргэшсэн, чадамжтай байна.

Агуулга

Тайвшруулгын үйлчилгээнд оролцож буй ажилтнуудын мэдлэг, ур чадварыг баталгаажуулж, өвчтөний аюулгүй байдлыг хангасан байна.

Тайвшруулга өгөх мэргэжилтэн нь ур чадварыг эзэмшсэн байна.

- Тайвшруулгын төрөл, арга техник
- Тайвшруулах эмийн мэдлэг, саармагжуулах эмийн хэрэглээ
- Тайвшруулгын үед өвчтөнг хянах
- Хүндрэлийн үед авах хариу арга хэмжээ
- Амьсгалын замыг үнэлэх

Тайвшруулгын явцад өвчтөнийг хянах ажилтан нь дараах ур чадвартай байна:

- Тайвшруулга эхлэх үеэс сэрээх үеийг дуустал өвчтөнг хянах
- Хүндрэлийн үед авах хариу арга хэмжээ
- Тайвшруулах эм, саармагжуулах эмийн хэрэглээ
- Сэрээх болон сэрээх өрөөнөөс гаргах үеийн шалгуур
- Амьсгалын замыг үнэлэх

Хэмжих үзүүлэлт	1	Тайвшруулга өгөх мэргэжилтэн нь агуулгын а-е заалтын ур чадварыг эзэмшсэн байна.
------------------------	----------	--

	2	Тайвшруулгын явцад өвчтөнийг хянах ажилтан нь i-v заалтын ур чадвартай байна
	3	Тайвшруулах үйлчилгээнд оролцож буй бүх ажилтны ур чадварын үнэлгээг хувийн хэрэгт нь баримтжуулсан байна.©

Шалгуур 5.4

Тайвшруулга болон өвчтөний хяналтыг эмнэл зүйн заавар, стандарт удирдамжийн дагуу гүйцэтгэж, өвчний түүхэнд тэмдэглэж, баримтжуулна.

Агуулга

Ажилбарын өмнөх үнэлгээ нь тайвшруулах эмэнд хариу үзүүлэхэд нөлөөлж болзошгүй ямар нэгэн хүчин зүйлийг илрүүлэхэд тусалдаг бөгөөд өвчтөний хяналтын үед илэрч болох чухал өөрчлөлтийг тодорхойлоход тусалдаг. Төлөвлөсөн тайвшруулга нь хөнгөнөөс гүн түвшинд шилжих боломжтой байна. Мэргэшсэн мэргэжилтэн нь өвчтөнийг бүрэн сэргэтэл хяналт хийнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Тайвшруулгын өмнөх үнэлгээнд дараах шалгуурыг багтаасан байна: <ul style="list-style-type: none"> • Тайвшруулгын төрлийг сонгоход нөлөөлж болохуйц амьсгалын замын асуудлыг тодорхойлох • Өндөр эрсдэлтэй өвчтөнийг үнэлж, тайвшруулга тохиромжтой эсэхийг шийдвэрлэх
	2	Тайвшруулгын өмнөх болон тайвшруулгын үеийн үнэлгээг мэргэшсэн мэргэжилтэн хийж, өвчний түүх/карт/-нд тэмдэглэж, баримтжуулна. ©
	3	Өвчтөнг сэрээх өрөөнд оруулах болон шилжүүлэх шалгууртай байна. Мэдээгүйжүүлэгийн эмчээс гадна эрх бүхий мэргэшсэн мэргэжилтэн нь өвчтөнг тус шалгуураар шалгаж, шилжүүлнэ.

Шалгуур 5.5

Тайвшруулгатай холбоотой эрсдэл, давуу тал, бусад сонголтын талаар өвчтөн, түүний гэр бүл эсвэл шийдвэр гаргах эрх бүхий хүмүүстэй ярилцаж танилцуулна.

Хэмжих үзүүлэлт	1	Өвчтөн, түүний гэр бүл болон шийдвэр гаргагч талуудад тайвшруулгын эрсдэл, ач холбогдол болон бусад сонголт, хувилбаруудын талаар мэдээлэл, зөвлөгөө өгнө.
	2	Өвчтөн, түүний гэр бүл болон шийдвэр гаргагч талуудад ажилбарын дараах сэргэх үйл явц болон өвдөлт намдаах эмчилгээний талаар мэдээлэл, зөвлөгөө өгнө.
	3	Мэргэшсэн ажилтан тухайн мэдээлэл, зөвлөгөөг өгч, эрүүл мэндийн түүхэнд баримтжуулна.©

Шалгуур 5.6

Мэргэшсэн эмч нь мэдээгүйжүүлгийн өмнөх болон мэдээгүйжүүлэг эхлэхийн өмнөх үнэлгээг хийнэ.

Агуулга

Мэдээгүйжүүлэг нь өндөр эрсдэлтэй тусламж үйлчилгээ тул мэргэшсэн мэргэжилтэн хариуцаж ажиллана.

Мэдээгүйжүүлгийн өмнөх үнэлгээ

Төлөвлөгөөт хагалгаанаас хэдэн хоногийн өмнө эсвэл хагалгааны өглөө, яаралтай хагалгааны үед мэдээгүйжүүлэг эхлэхийн өмнөх үед өвчтөний ерөнхий биеийн байдлыг цогцоор нь үнэлж, мэдээгүйжүүлэг өгөх, сэрээх, хагалгааны дараах өвдөлт намдаах эмчилгээ гэх мэт төлөвлөгөө гаргах үе шат юм.

Мэдээгүйжүүлэг эхлэхийн өмнөх үнэлгээ

Өвчтөнийг хагалгааны ширээн дээр хэвтүүлж, мэдээгүйжүүлэг эхлэхийн өмнөхөн хийх эцсийн хяналт юм. Яаралтай хагалгааны үед дээрх үнэлгээнүүд хамт хийгдэж болох боловч тусдаа тэмдэглэгдэх ёстой байна.

Хэмжих үзүүлэлт	1	Мэдээгүйжүүлгийн өмнө доорх үнэлгээг хийсэн байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> ● Амьсгалын замын төвөгтэй байдал ● Эрсдэлтэй өвчтөнд тохирох мэдээгүйжүүлгийн арга ● Мэдээгүйжүүлгийн төрөл, төлөвлөгөө ● Өвчтөний үнэлгээ, эрсдэл, мэс заслын хэлбэрээс хамаарч мэдээгүйжүүлгийг удирдах ● Мэдээгүйжүүлгийн явц болон сэрээх үед өвчтөнийг хяналтын үзүүлэлтэд дүгнэлт өгөх ● Хагалгааны дараах өвдөлт намдаалтын талаар мэдээлэл өгөх
	2	Урьтал мэдээгүйжүүлгийн өмнө өвчтөний биеийн байдлыг дахин үнэлнэ.
	3	Мэдээгүйжүүлгийн өмнөх болон урьтал мэдээгүйжүүлгийн үнэлгээг мэргэшсэн мэргэжилтэн гүйцэтгэх бөгөөд өвчний түүхэнд баримтжуулна.®
	4	Үзлэгийг стандарт, журам, эмнэл зүйн зааварт үндэслэн хийнэ.®

Шалгуур 5.7

Мэдээгүйжүүлгийн төлөвлөгөөг өвчтөн түүний асран хамгаалагчид танилцуулж ярилцах ба шийдвэрийг өвчний түүхэнд баримтжуулна.

Агуулга

Мэдээгүйжүүлэг нь өвчтөн болон ар гэр, шийдвэр гаргах этгээдэд үүсч болох эрсдэл давуу тал, бусад сонголтуудын тухай мэдээлэл өгөх үйл явцыг хамруулна.

Мэс заслын дараах өвдөлт намдаах эмчилгээ нь мэдээгүйжүүлгийн төлөвлөгөөний нэг хэсэг байх бөгөөд бусад мэргэжилтэнтэй ярилцаж хамтын шийдвэрийг баримтжуулсан байна. Мэдээгүйжүүлгийн бодис, тун, арга, мэргэжилтэний тухай өвчний түүхэнд тэмдэглэсэн байна.

	1	Мэргэшсэн эмч нь мэдээгүйжүүлгийн тусламж үйлчилгээг төлөвлөж, өвчний түүхэнд баримтжуулна.®
--	----------	--

Хэмжих үзүүлэлт	2	Өвчтөн түүний асран хамгаалагчид мэдээгүйжүүлгийн эрсдэл, ач холбогдол, орлуулах боломжит аргуудын талаар мэдээлэл, зөвлөгөө өгнө.
	3	Мэс засал хийхээс өмнө мэс заслын дараах өвдөлт намдаах аргын талаар өвчтөн түүний асран хамгаалагчид мэдээлэл өгч, баримтжуулна.⑥
	4	Мэдээгүйжүүлгийн тэмдэглэлд хэрэглэсэн эм, тун, мэдээгүйжүүлгийн аргыг тэмдэглэнэ.⑥
	5	Мэдээгүйжүүлэгч эмч, бусад эрх бүхий мэргэшсэн мэргэжилтэн мэдээгүйжүүлэг өгөх ба мэдээгүйжүүлгийн тэмдэглэлд баримтжуулсан байна.⑥
	6	Мэдээгүйжүүлэг ба өвчтний хяналтыг нь стандарт, журам, эмнэл зүйн зааврын дагуу хийнэ.⑥

Шалгуур 5.8

Мэдээгүйжүүлэг ба мэс заслын явцад өвчтөний биеийн байдлыг стандарт, зааврын дагуу тасралтгүй хянаж, өвчний түүхэнд баримтжуулна.

Агуулга

Мэдээгүйжүүлэг болон сэрээх үед өвчтний амин үзүүлэлтийг хянаж тэмдэглэсэн байна. Хяналт нь мэс заслын үед болон мэс заслын дараах үед эргэн мэс засал хийх, бусад тасагруу шилжүүлэх зэрэг шийдвэр гаргахад чухал нөлөө үзүүлнэ. Мэдээгүйжүүлгийн өмнөх үнэлгээ, мэдээгүйжүүлгийн хэлбэр, мэс засал, ажилбарын онцлогоос хамаарч өвчтөний хяналтын аргыг сонгоно. Хяналтыг стандарт удирдамжийн дагуу хийх ба эмнэлгийн журамд тусгасан байна.

Хэмжих үзүүлэлт	1	Мэдээгүйжүүлэг болон мэс заслын үеийн өвчтөний хяналтын төрөл, давтамжийг мэдээгүйжүүлгийн өмнөх үнэлгээ, мэдээгүйжүүлгийн төрөл болон хийгдэж буй мэс засалд үндэслэнэ.
	2	Өвчтөний биеийн байдлын хяналтыг стандарт, эмнэл зүйн зааврын дагуу хийнэ.
	3	Өвчтөний хяналтыг өвчний түүхэнд тэмдэглэнэ.⑥

Шалгуур 5.9

Мэдээгүйжүүлгийн дараа өвчтөний биеийн байдлыг хянаж, мэргэшсэн эмчийн шийдвэрээр эсвэл батлагдсан шалгуурын дагуу сэрээх өрөөнөөс шилжүүлнэ.

Агуулга

Мэдээгүйжүүлгийн үеийн хяналт нь сэрээх үеийн хяналтын суурь болно. Хянах амин үзүүлэлтүүдийн төрөл, хэмжилтийн давтамж, баримтжуулалт, сэрэх үеийн үзүүлэлтүүд нь өвчтөний хяналтын үед хамаарна.

Сэрээх үеийн хяналтыг удирдамж болон эмнэлгийн журамд заасны дагуу мэргэшсэн мэргэжилтэн хариуцна. Хяналтын мэдээлэлд сэрээх үеийн хяналтын зогсоох, тасгаас шилжүүлэх шийдвэр зэргийг хамруулсан байна.

Өвчтөнийг мэс заслын өрөөнөөс сэрээх өрөө, бусад тасагруу шилжүүлэх үед хяналтын мэдээллийг өвчний түүхэнд баримтжуулсан байна.

Хэмжих үзүүлэлт	1	Мэдээгүйжүүлгийн дараа өвчтөнийг сэрээх хугацаанд стандарт, эмнэл зүйн заавар, эмнэлгийн дотоод журмын дагуу хянаана.⑥
	2	Өвчтөний хяналтыг өвчний түүхэнд тэмдэглэнэ.
	3	Өвчтөнийг сэрээх өрөөнөөс тохирох тасаг, нэгжид шилжүүлэх эсвэл сэрээх үеийн хяналтыг зогсоох шийдвэрийг мэдээгүйжүүлгийн эмч эсвэл мэргэшсэн сувилагч, эрх бүхий мэргэжилтэн гаргаж өвчний түүхэнд тэмдэглэнэ
	4	Сэрээх өрөөнд ирсэн, шилжүүлсэн цагийг өвчний түүхэнд тэмдэглэнэ.⑥

Шалгуур 5.10

Мэс засал болон инвазив ажилбар нь холбогдох дүрэм, журам, эмнэлзүйн удирдамж, зааврын дагуу хийгддэг байна.

Агуулга

Холбогдох дүрэм, журам, удирдамжаар мэс засал ба инвазив ажилбартай холбоотой барилга байгууламж, дэд бүтэц, өвчтөний урсгал, эмнэлгийн хог хаягдлын урсгал, шаардлагатай тоног төхөөрөмж, хүний нөөцийн зохих шаардлагыг зохицуулсан байдаг.

Төв нь холбогдох дүрэм, журмын дагуу мэс засал болон инвазив ажилбарыг аюулгүй хийж гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

Үнэлгээ хийх чиглэл

- Шинжээч нь шүдний кабинет, яаралтай тусламжийн өрөө, гэр бүл төлөвлөлтийн кабинет гм мэс засал болон инвазив ажилбар хийх бүх нэгжийн барилга байгууламж, дэд бүтэц, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүний нөөцийн хангалтыг үнэлнэ.
- Өвчтөний урсгал, эмнэлгийн ариун хэсэг болон хог хаягдлын урсгалын талаар эмнэлгийн ажилтнаас асууж тодруулна.
- Мэс засал ба инвазив ажилбар хийдэг ажилтны мэргэшил, ур чадварын гэрчилгээ гм материалыг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Мэс засал ба инвазив ажилбар хийх нэгж нь шаардлагатай зай талбай, дэд бүтэцтэй, агааржуулалтын асуудлыг шийдвэрлэсэн байна.
	2	Мэс засал ба инвазив ажилбар хийдэг нэгжийг шаардлагатай тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслээр хангасан байна
	3	Мэс засал ба инвазив ажилбар хийх ажилтан мэргэшсэн, ур чадвартай байна.

Шалгуур 5.11

Мэс засал болон инвазив ажилбарын өмнө үзлэг, шинжилгээ болон сувилахуйн үнэлгээ хийдэг байна.

Агуулга

Мэс заслын өмнө өвчтөний үзлэгийг бүрэн хийж, онош баталгаажуулах, эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлох, өвчтөний эрүүл мэндийн өнөөгийн байдлыг үнэлэхэд шаардлагатай шинжилгээ, оношилгоог хийнэ.

Өвчтөнд эрсдэлийн үнэлгээ хийж, анхаарах асуудлыг тодорхойлох ба өвчтөн болон түүний гэр бүлд мэс заслын хүлээгдэж буй үр дүнгийн талаар мэдээлэл өгнө.

Мэс засал болон инвазив ажилбарыг хойшлуулсан эсвэл цуцалсан тохиолдолд өвчтөний үнэлгээг давтан хийх шаардлагатай.

Бүх төрлийн инвазив ажилбар хийхээс өмнө шаардлагатай шинжилгээг хийж, оношийг баталгаажуулсан байна.

Үнэлгээ хийх чиглэл

- Мэс засал, инвазив ажилбарт орсон өвчтөний амбулаторийн карт болон өвчний түүхийг сонгож, өвчтөний үзлэг, үнэлгээ бүрэн хийгдсэн эсэх, шаардлагатай шинжилгээний хариу бүрэн байгаа эсэх, мэс засал, инвазив ажилбарын эрсдэлийг тодорхойлсон эсэх, таниулсан зөвшөөрлийн хуудас байгаа эсэх, эрсдэлт хүчин зүйлийн менежмент хийгдсэн эсэхийг үнэлнэ.

- Мэс засал болон инвазив ажилбарын эмч, сувилагчтай ярилцаж, мэдлэгийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Мэс засал болон инвазив ажилбарт орох өвчтөний иж бүрэн үнэлгээг хийдэг байна.©
	2	Мэс засал болон инвазив ажилбарт орох өвчтөний иж бүрэн сувилахуйн үнэлгээ хийдэг байна.©
	3	Эмнэлгийн ажилтан нь мэс засал, инвазив ажилбарын өмнө өвчтөний <u>шинжилгээний</u> хариуг харах боломжтой байна.
	4	Мэс засал, инвазив ажилбарын өмнө эрсдэлт хүчин зүйлсийг удирдах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна
	5	Үзлэг, шинжилгээ, үнэлгээг өвчтөний түүхэнд тэмдэглэдэг байна.©

Шалгуур 5.12

Эмч нь мэс засал болон инвазив ажилбарын талбайн тэмдэглэгээг өвчтөн болон түүний гэр бүлийн оролцоотой хийдэг байна.

Агуулга

Зөв өвчтөнд, зөв талбайд, зөв мэс засал хийх нь мэс заслын аюулгүй байдлын үндсэн зорилго юм. Мэс заслын талбайд тэмдэглэгээ хийх нь алдааг бууруулах стратегид хамаарна.

Төв нь мэс заслын талбайн тэмдэглэгээ хийх журам боловсруулж, хэрэгжүүлнэ.

Журамд дараах агуулгыг тусгана. Үүнд:

- а) Мэс засал хийх хамгийн ойр байрлалд нэг стандарт тэмдэглэгээ хийх
- б) Мэс заслын талбайн тэмдэглэгээг хийх үндэслэлийг тодорхойлох
- с) Мэс засал болон инвазив ажилбар хийх эмч нь тэмдэглэгээг хийх үүрэгтэй
- д) Өвчтөн болон түүний гэр бүлийг оролцуулах
- е) Талбайн тэмдэглэгээ хийхгүй байж болох мэс засал болон ажилбарын жагсаалт гаргах
- ф) Талбайн тэмдэглэгээг хийх тохиромжтой хугацааг тодорхойлох
- г) Талбайн тэмдэглэгээ хийх үйл явцыг хянах

Үнэлгээ хийх чиглэл

- Шинжээч нь мэс засал болон инвазив ажилбарын талбайн тэмдэглэгээ хийх үйл явцыг зохицуулсан журмыг үзнэ.

- Холбогдох ажилтантай ярилцаж, журмын талаарх тэдний мэдлэг, ойлголтыг үнэлнэ.
- Мэс засал, ажилбарт орох өвчтөнд арилдаггүй маркераар гаргацтайгаар талбайн тэмдэглэгээ хийсэн эсэхийг үзнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь мэс заслын талбайн тэмдэглэгээ хийх үйл явцыг зохицуулах журамтай байх ба журам нь агуулгад дурдсан (a–g заалт) байна.©
	2	Холбогдох ажилтнууд журмын талаар мэдлэгтэй байна.
	3	Талбайн тэмдэглэгээ нэг загвартай, ажилбар хийх эмч нь тэмдэглэгээг хийдэг байна.
	4	Талбайн тэмдэглэгээтэй холбоотой тайлан, мэдээг хянаж, шаардлагатай тохиолдолд үйл явцыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

Шалгуур 5.13

Мэс засал, ажилбарын өмнө шаардлагатай баримт бичиг, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж бүрэн, хэвийн ажиллагаатай байгаа эсэхийг урьдчилан шалгадаг байна.

Агуулга

Төв нь шинжилгээний хариу, ажилбарт шаардлагатай зүйлс бэлэн байгаа эсэхийг мэс заслын өмнө хянан, баталгаажуулж, өвчтөний аюулгүй байдлыг хангаж ажиллана. Тоног төхөөрөмжийн бэлэн байдал, хэвийн ажиллагааг хангах нь тоног төхөөрөмж эвдэрснээс ажилбарыг цуцлах, алдаа гарах эрсдэлийг бууруулдаг. Эмнэлгийн тоног төхөөрөмжийг мэргэжлийн ажилтан хяналтын хуудсаар тогтмол үнэлэх нь тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах арга юм.

Төв нь мэс засал, инвазив ажилбар эхлэхийн өмнө шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдал, хэвийн ажиллагааг хангах үүрэгтэй. Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь ажилбарын төрлөөс хамаарч өөр байдаг. Төв нь ажилбараас өмнө өвчтөний баримт бичиг болон бусад холбогдох зүйлсийн бэлэн байдлыг хянаж, баталгаажуулах үйл явцыг хэрэгжүүлэх ёстой.

Үнэлгээ хийх чиглэл

- Шинжээч нь ярилцах замаар мэс заслын өмнөх баталгаажуулах үйл явцын талаар эрүүл мэндийн ажилтны мэдлэг, ойлголтыг үнэлнэ. Мөн мэс засал болон ажилбарт орсон, орох гэж буй өвчтөнийг дагаж мөшгөж, баримт бичиг, шинжилгээ болон бусад шаардлагатай зүйлсийг хянасан эсэхийг нягтална.
- Шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдал болон хэвийн ажиллагааны хяналтын хуудсыг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Мэс заслын өмнө шаардлагатай баримт, бичиг, тоног төхөөрөмжийг шалгах, хянах үйл явцыг хэрэгжүүлдэг байна.
	2	Холбогдох ажилтныг мэс заслын өмнөх баталгаажуулалтын талаар сургалтад хамруулна.
	3	Шаардлагатай баримт бичиг, тоног төхөөрөмжийн баталгаажилтын бүртгэлийг хийж, хадгалсан байна.

	4	Мэс заслын өмнөх баталгаажилтын талаарх тайлан мэдээг хянаж, шаардлагатай тохиолдолд сайжруулах арга хэмжээ хэрэгжүүлдэг байна.
--	---	---

Шалгуур 5.14

Мэс засал болон ажилбар эхлэхийн өмнө зөв өвчтөнд, зөв ажилбарыг, зөв талбайд хийж буй эсэхийг баталгаажуулдаг байна.

Агуулга

Мэс засал болон ажилбар эхлэхийн өмнө зөв өвчтөнд, зөв ажилбарыг, зөв талбайд хийж буй эсэхийг (“Time-out”) баталгаажуулах нь буруу талд мэс засал хийх эрсдэлийг бууруулах батлагдсан арга юм. Эрүүл мэндийн ажилтан нь мэс засал, ажилбар, хийхийн өмнө зөв өвчтөнд, зөв мэс заслыг, зөв талбайд, зөв эрхтэнд, зөв талд хийхээр төлөвлөсөн эсэх, өвчтөнд урьдчилан сэргийлэх антибиотик эмчилгээ хийсэн эсэхийг тус тус шалгах ёстой.

Төв нь ажилбар эхлэхээс өмнө “Time-out” буюу зөв өвчтөнд, зөв ажилбарыг, зөв талбайд, зөв талд хийх үйл явцыг баталгаажуулсан журам боловсруулж, хэрэгжүүлэх ёстой.

Үнэлгээ хийх чиглэл

- Шинжээч нь “Time-out” хийх үйл явцыг зохицуулсан журмыг үзэхийн зэрэгцээ эмнэлгийн ажилтнуудтай ярилцаж, тэдний мэдлэгийг үнэлнэ.
- Ажилбар эхлэхээс өмнө “Time-out” хэрхэн явагдаж буйг ажиглана.
- Мэс засал ба ажилбар хийлгэсэн өвчтөний түүх болон холбогдох бичиг баримтаас түүвэрлэн авч, “Time-out”-г мэс заслын өмнө хийсэн эсэхийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Мэс засал ба инвазив ажилбар эхлэхээс өмнө зөв өвчтөнд, зөв ажилбарыг, зөв талбайд хийж буйг баталгаажуулах журамтай байна.
	2	Мэс засал эсвэл инвазив ажилбар эхлэхээс өмнө “Time-out”-г хэрэгжүүлдэг байна.
	3	Мэс засал ба инвазив ажилбар хийх багийн гишүүд, оператор эмч “Time-out”-д оролцдог байна
	4	“Time-out”-ын үйл явцыг өвчтөний түүхэнд тэмдэглэдэг байна.

БҮЛЭГ 6. ЭМИЙН МЕНЕЖМЕНТ БА ХЭРЭГЛЭЭ

Тойм

Эмийн хэрэглээ тасралтгүй өсөж буй өнөө үед эмийн өвчтөн болон нийгэмд үзүүлэх үр нөлөөг дээд зэргээр хангах нь чухал байна. Эм нь олон төрлийн өвчин, эмгэгийг урьдчилан сэргийлэх, эмчлэх, хянахад чухал үүрэгтэй. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд эмийг хамгийн ихээр хэрэглэдэг.

Эм гэдэгт жороор олгох бүх төрлийн эм болон мансууруулах бодис; ургамлын гаралтай бэлдмэл; амин дэм; хүнсний нэмэлт бүтээгдэхүүн; жоргүй олгодог эм; вакцин; биологийн бэлдмэл, оношилгоо, эмчилгээ, өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хүний биед хэрэглэдэг тодосгогч бодисууд; цацраг идэвхт бодис; амьсгалын замаар хэрэглэх бэлдмэлүүд; судсаар хэрэглэх тэжээл; цус, цусан бүтээгдэхүүн; эмийн бэлдмэл агуулсан бусад бүтээгдэхүүн; электролит болон дуслын уусмалыг хамруулна.

Эмийн менежмент нь байгууллагын чухал хариуцлага юм. Энэхүү нарийн төвөгтэй үйл явц нь олон үе шатаас бүрдэнэ. Үүнд: төлөвлөх, худалдан авах, хадгалах, жор бичих, захиалах, олгох, хэрэглэх, эмийн хяналт, хөтөлбөрийн үнэлгээ. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад антибиотикийн зохистой хэрэглээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх (antibiotic stewardship) нь нянгийн тэсвэржилтээс сэргийлэх, халдварыг үр дүнтэй эмчлэхэд чухал ач холбогдолтой. Эмнэлгийн ажилтан нь өвчтөнд антибиотик хэрэглэх зайлшгүй шаардлага байгаа эсэхийг үнэлэх, боломжтой тохиолдолд эмчилгээний бусад хувилбарыг сонгох, нян болон вирусын халдварыг ялган оношлохыг чухалчилдаг. Антибиотикийн замбараагүй хэрэглээний эрсдэлийн талаар эрүүл мэндийн ажилтан болон өвчтөнд зориулсан сургалт, мэдээлэл олгох нь энэхүү хөтөлбөрийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Зохистой хэрэглээний соёлыг төлөвшүүлснээр антибиотик эмчилгээний үр дүнг сайжруулах, нянгийн тэсвэржилтийг бууруулах, эмнэлгийн халдвартай холбоотой эрүүл мэндийн зардлыг бууруулахад хувь нэмэр оруулна. Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлснээр бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалахаас гадна нянгийн эсрэг бэлдмэлийн ирээдүйд ч эмчилгээний үр дүнтэй байх нөхцөлийг бүрдүүлдэг.

Судалгаанаас үзэхэд эмийн менежментийн бүх үе шатанд алдаа гарч, өвчтөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдөг тул энэ асуудал эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэн тэргүүний зорилт юм. Эмийн хэрэглээ ихсэж, олон шинэ эм зах зээлд нэвтрэх нь эрсдэлийг улам нэмэгдүүлж байгаа нь эмийн аюулгүй байдлыг хангахын чухлыг илэрхийлж байна.

Эмтэй холбоотой тохиолдол хамгийн элбэг бөгөөд эмийн менежментийн бүх шатанд үүснэ. Тохиолдол нь өвчлөлийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн байгууллагын зардалыг ихэсгэхийн зэрэгцээ өвчтөний амьдралын чанарт сөргөөр нөлөөлдөг. Эмтэй холбоотой тохиолдлоос сэргийлэх нь эрүүл мэндийн тогтолцооны нэн тэргүүний зорилт бөгөөд ДЭМБ болон олон улсын байгууллагууд эмийн аюулгүй байдлыг өвчтөний аюулгүй байдлын зорилтод тусгасан байдаг.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад эмийн аюулгүй, зохистой хэрэглээг хангах зорилгоор эмийн менежментийн нарийн стандартыг тогтоодог. Эдгээр стандарт нь сайн туршлагыг дэмжих, эмийг зөв хэрэглэх, эмийн менежментийн үйл явцыг тасралтгүй сайжруулахад чиглэнэ.

Бүлгийн зорилт

1. Эмийн менежментийн бүх үе шатанд эмийг зохистой, үр дүнтэй хэрэглэж, өвчтөнд үзүүлэх үр ашгийг нэмэгдүүлэх.
2. Эмийн менежментийн бүх үе шатанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, сайжруулах тогтолцоог бүрдүүлж, чанарыг тасралтгүй сайжруулах соёлыг төлөвшүүлэх.
3. Эмийн менежментийн бүх үе шатанд гарах эрсдэлийг тодорхойлж, бууруулснаар эмтэй холбоотой тохиолдлыг бууруулах.

Доорх жагсаалтад энэ бүлэгт хамаарах шалгуурыг нэгтгэн харуулав.

6.1	Эмийн менежментийг өвчтөний хэрэгцээнд нийцүүлэн, төвийн тусламж, үйлчилгээний хүрээтэй уялдуулан, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зохион байгуулж, хэрэгжүүлнэ.
6.2	Нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээний хөтөлбөр

6.3	Төвд хэрэглэх эмийг баталсан шалгуурын дагуу сонгож, худалдан авалт хийдэг байна.
6.4	Эм, бэлдмэлийн аюулгүй байдал, чанарыг хангахуйц газарт хадгална.
6.5	Яаралтай тусламжийн эм, бэлдмэл хангалттай хэмжээгээр хүртээмжтэй байх ба хадгалалтын аюулгүй байдлыг хангасан байна.
6.6	Эрсдэл өндөртэй эмүүдийг тодорхойлж, тэдгээрийг хадгалах, бэлтгэх/хуваарилах, олгох/тарих үйл явцыг эрсдэлийг хамгийн бага түвшинд барихуйц байдлаар зохион байгуулсан байна.
6.7	Ижил дуудагддаг нэршилтэй эм, савлагаа нь адил харагддаг эмийн хяналтыг сайжруулна.
6.8	Эмийг татан авах тогтолцоотой байна.
6.9	Өвчтөний эмийн хэрэглээг тогтмол нягтлан шалгаж, бүртгэл мэдээлэлтэй нь нийцүүлэн баталгаажуулна.
6.10	Эмийн захиалга, жор бичилт нь хууль журмын дагуу, аюулгүй байдлыг хангасан байна.
6.11	Эмийн жор бичилтэд хяналт тавьдаг байна.
6.12	Эмийг аюулгүй, зааврын дагуу бэлтгэж, олгож, хэрэглэдэг байна.
6.13	Эмтэй холбоотой тохиолдол, алдах дөхсөн тохиолдол, эмийн гаж нөлөөг илрүүлэн, бүртгэж, хянахын зэрэгцээ бууруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

ШАЛГУУР, АГУУЛГА, ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур 6.1

Эмийн менежментийг өвчтөний хэрэгцээнд нийцүүлэн, ТӨВ-ын тусламж, үйлчилгээний хүрээтэй уялдуулан, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

Агуулга

Эмийн зохисгүй хэрэглээ нь эрүүл мэндийн тогтолцоонд тулгарч буй хамгийн ноцтой асуудлуудын нэг юм. Төвд эмийн менежментийн аюулгүй тогтолцоог хангах нь томоохон сорилт болдог.

Эмийн менежментийн үйл явцыг холбогдох үндэсний хууль тогтоомж, журамд нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай. Төв нь дараах чиглэлүүдийг заавал хамарсан аюулгүй эмийн менежментийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ. Үүнд:

- a) Төлөвлөлт
- b) Сонголт болон худалдан авалт
- c) Хадгалалт
- d) Захиалга болон жор бичилт
- e) Бэлтгэл болон олголт
- f) Хэрэглээ (өвчтөнд хэрэглэх)
- g) Хяналт, үнэлгээ

Эмийн менежментийн (аюулгүй байдлын) хөтөлбөрийг лицензтэй эм зүйч шууд хариуцан удирдана.

Эмийн менежментийн хөтөлбөр нь эмийн хэрэглээ, хадгалалт, олголт, хяналттай холбоотой үйл явцад оролцож буй бүх эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн хамтын, олон салбарын үйл ажиллагаа байна.

Эмийн менежментийн тогтолцоог Эмийн эмчилгээг зохицуулах хороо зохион байгуулж, тогтмол шинэчилнэ. Тус хороо нь тодорхойлсон эрх, үүрэг, үйл ажиллагааны журамтай байна. Эмийн эмчилгээг зохицуулах хороо нь эмийн менежментийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах болон үнэлэх үүрэгтэй. Эмийн менежментийн хөтөлбөрийн үр нөлөө, хэрэгжилтэд жилд нэгээс доошгүй удаа үнэлгээ, дүн шинжилгээ хийнэ.

Эмийн менежментийн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд эмийн талаарх шинэчлэгдсэн, баталгаатай мэдээллийн эх сурвалжууд (цахим болон/эсвэл цаасан хэлбэрээр) эмийн менежментэд оролцож буй бүх эрүүл мэндийн ажилтнуудад хүртээмжтэй байна.

Үнэлгээ хийх чиглэл

- Эмийн менежментийн хөтөлбөрийг шалгах, эмийн аюулгүй байдлын зохицуулалтад оролцож буй ажилтнуутай ярилцлага хийж мэдлэгийг үнэлнэ.
- Эмийн эмчилгээг зохицуулах хорооны үйл ажиллаганы журам, хурлын тэмдэглэл, хөтөлбөрийн тайланг хянана.

Хэмжих үзүүлэлт	1	Холбогдох хууль журамд нийцсэн эмийн менежментийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлдэг байна. Уг хөтөлбөр нь агуулгад (а–g заалт) дурдсан шаардлагыг хангасан байна.©
	2	Хууль, журмын дагуу эмийн менежменттэй холбоотой бүх үйл ажиллагааг мэргэжлийн эрхтэй эм зүйч хариуцан удирдана.
	3	Эмийн эмчилгээг зохицуулах хороотой байх бөгөөд тус хороо нь эмийн менежментийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, тасралтгүй үнэлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно.
	4	Эмийн хэрэглээнд оролцож буй ажилтнуудад эмийн аюулгүй байдлын талаарх мэдээлэл тогтмол хийдэг байна.

Шалгуур 6.2

Нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээний хөтөлбөр

Агуулга

Нянгийн эсрэг эмүүд нь үр дүнтэй, аюулгүй мэт санагддаг тул зарим тохиолдолд заалт тодорхой бус үед эсвэл шаардлагатай хугацаанаас илүү удаан хугацаанд бичигдэх нь элбэг байдаг. Эмэнд тэсвэржилт улам бүр нэмэгдэхийн хэрээр дэлхий нийтэд үр дүнтэй эмчилгээний сонголтгүй болох эрсдэл бий. Иймээс нянгийн эсрэг эмийн тэсвэржилт нь өвчтөний эмчилгээний үр дүнд сөргөөр нөлөөлж, өвчтөний аюулгүй байдалд ноцтой аюул учруулж байна.

Нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нянгийн эсрэг эмийн эмчилгээ шаардлагатай өвчтөнд зөв эмийг, зөв цагт, зөв тунгаар, зөв хугацаанд хэрэглэх зорилгод хүрэхэд тусална. Мөн энэ нь тэсвэртэй нянгийн үүсэл, тархалтыг бууруулж, өвчтөний эмчилгээний үр дүнг сайжруулна.

Нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээний хөтөлбөр нь анхан шатны эрүүл мэндийн айгууллагын тэргүүлэх чиглэлүүдийн нэг байх бөгөөд удирдлагын тууштай дэмжлэг, оолцоотой байна. Удирдлагын дэмжлэгийн жишээнд хариуцлагын баримт бичиг, шаардлагатай хүний нөөцийг хуваарилах, төсвийн төлөвлөгөө, халдварын сэргийлэлт, мэдлэгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн сайжруулалт болон стратегийн төлөвлөгөөнүүд орно.

Энэхүү хөтөлбөрийг анхан шатны эрүүл мэндийн байгууллага өөрийн түвшинд боловсруулж хэрэгжүүлэх эсвэл анхан шатны эрүүл мэндийн байгууллагын гаднах дээд шатны байгууллагаар дамжуулан боловсруулж хэрэгжүүлж болно.

Үр дүнтэй нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээний хөтөлбөр нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хэрэгцээнд нийцсэн, үндэсний болон эсвэл олон улсын удирдамж (жишээ нь ДЭМБ, CDC)-тай уялдсан наад зах нь нэг хөндлөнгийн оролцоог хэрэгжүүлсэн байна. Хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх нь ажилтнуудыг шинэ бодлого, журманд аажмаар дасгах, ачааллыг багасгахад тустай.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хэрэгжүүлж болох хөндлөнгийн оролцооны жишээ

- Орон нутгийн, үндэсний эсвэл олон улсын мэдээлэлд суурилсан клиникийн удирдамж боловсруулж, хэрэгжүүлэх (жишээ нь амьсгалын замын халдвар, шээсний замын халдварын менежмент).

- Парентерал (тарилгын) нянгийн эсрэг эм бичих клиникийн шалгуур, удирдамж боловсруулах.

Нэн тэргүүнд анхаарах нэг буюу хэд хэдэн өвчлөлийг тодорхойлох, тухайлбал:

- Антибиотик хэт их бичигддэг, антибиотик заалтгүй өвчнүүд (жишээ нь хурц бронхит, тодорхойгүй дээд амьсгалын замын халдвар, вирусын гаралтай фарингит).

- Антибиотик хэрэглэх боломжтой ч оношлогоо хэтрүүлэгддэг өвчнүүд (жишээ нь А бүлгийн стрептококкийн шинжилгээ хийлгүйгээр стрептококкт фарингит гэж оношлон антибиотик бичих).

- Антибиотик хэрэглэх заалттай боловч эмийн сонголт, тун, үргэлжлэх хугацаа буруу байдаг өвчнүүд (жишээ нь хурц хүндрэлгүй бактерийн синуситын үед амоксициллин эсвэл амоксициллин/клавуланат биш азитромицин сонгох).

•“Ажиглах хүлээлт” эсвэл хойшлуулсан жор тохиромжтой боловч хангалттай ашиглагддаггүй өвчнүүд (жишээ нь хурц дунд чихний үрэвсэл, хурц хүндрэлгүй синусит).

• Антибиотикийг эхний ээлжинд хэрэглэхийн оронд шүдний эмчилгээг нэн тэргүүнд хийх.

• Нянгийн эсрэг эм бичих үед өвчтөнд дэлгэрэнгүй зөвлөгөө, мэдээлэл өгөх.

Ямар хөндлөнгийн оролцоог хэрэгжүүлэхийг хүний нөөц, өвчтөний бүтэц, боломжит нөөцөд тулгуурлан шийдвэрлэнэ.

Үнэлгээ хийх чиглэл:

- Антибиотик эмчилгээний зохистой менежментийн хөтөлбөрийн баримт бичгүүдтэй (журам, төлөвлөгөө, удирдамж) танилцаж, хяналт хийнэ.
- Эрүүл мэндийн ажилтнуудаас хөтөлбөртэй холбоотой аливаа үйл ажиллагааны талаар (сургалт, эм бичиж өгөх заавар мөрдөлт г.м) ярилцлага хийнэ.
- Антибиотик хэрэглээний чиг хандлага, тэсвэржилт болон зардлын талаарх менежментийн тайланг хянана.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь үндэсний болон олон улсын протокол, удирдамж, дүрэм журамд үндэслэсэн, олон мэргэжлийн баг бүрэлдэхүүнтэй, батлагдсан антибиотик эмчилгээний зохистой менежментийн хөтөлбөртэй байна.©
	2	Төв нь ажилтнууд, өвчтөн болон түүний гэр бүлийнхэнд нянгийн эсрэг бэлдмэлийн зохистой хэрэглээ болон АЭХ практик үйл ажиллагааны талаар сургалт, боловсрол олгоно.
	3	Антибиотик эмчилгээний зохистой менежментийн хөтөлбөр нь байгууллагаас баталсан, шинжлэх ухааны үндэслэлтэй протоколуудыг ашиглана.
	4	Төв нь хөтөлбөрийн хүрээнд гарсан тайлан мэдээлэлд хяналт-шинжилгээ (monitoring) хийж, үйл явцыг хянах эсвэл сайжруулах зорилгоор зохих арга хэмжээг авч ажиллана.

Шалгуур 6.3

Төвд хэрэглэх эмийг баталсан шалгуурын дагуу сонгож, худалдан авалт хийдэг байна.

Агуулга

Эмийг сонгох, худалдан авах үйл ажиллагаа нь олон талын оролцоотой үйл явц бөгөөд (дээд шатны байгууллагаас хангадаггүй бол) үүнд эмийн хэрэгцээг тооцоолох, худалдан авах аргыг сонгох, ханган нийлүүлэгч болон бүтээгдэхүүнийг урьдчилан үнэлэх, баталгаажуулах үйл ажиллагаа хамарна.

Төв нь хэрэглэх бүх эмийн жагсаалтыг боловсруулна. Энэ жагсаалтыг боловсруулахад хүн амын дунд зонхилон тохиолдох өвчлөлийн байдал, эмийн үр нөлөө, аюулгүй байдал болон өртөг-үр ашгийн харьцааг харгалзан үзнэ. Зарим хууль,

дүрэм, журмын дагуу тодорхой эмийг жагсаалтад оруулах шаардлага байдаг. Эмийн жагсаалтад дараах мэдээллийг зайлшгүй оруулна. Үүнд:

- Эмийн нэршил
- Эмийн тун/концентраци.
- Эмийн хэлбэр.
- Хэрэглэх заалт.
- Түгээмэл гаж нөлөө.

Эмийн харилцан үйлчлэл, гаж нөлөө, хэрэглэх заалт, үр дүн, эмтэй холбоотой ноцтой тохиолдол, өвчтөний нас (хүүхэд, ахмад настан), эмийн өртөг гэх мэт тодорхой шалгуурыг үндэслэн эмийн жагсаалтыг шинэчилнэ.

Төв нь эмийн жагсаалтыг хянах, цаг хугацаанд нь шинэчлэх зорилгоор байгууллагын хэмжээнд эмийн хэрэглээг үнэлэх үйл явцыг боловсруулж, хэрэгжүүлнэ. Эмийн хэрэглээг үнэлэх нь эмийг жагсаалтаас хасах, жагсаалтад нэмэх асуудлыг шийдвэрлэх шалгуур болно.

Үнэлгээ хийх чиглэл

- Төвийн эмийн жагсаалтыг үзэж үнэлнэ.
- Эмийн худалдан авалт болон жагсаалтад эм нэмэх/хасах үйл явцын талаар Эмийн эмчилгээний хорооны гишүүдтэй ярилцана.
- Жагсаалтад оруулах, жагсаалтад оруулахгүй боловч түр хугацаанд хэрэглэх эмийг худалдан авах үйл явцын талаар энэ үйл ажиллагаанд оролцдог ажилтнуудтай ярилцаж, мэдээлэл авна.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь агуулгад дурдсан мэдээллийг агуулсан (а-е заалт) эмийн жагсаалттай байна.©
	2	Батлагдсан эмийн жагсаалтын цаасан/эсвэл цахим хувилбар нь эмийн менежментэд оролцдог бүх ажилтнуудад хүртээмжтэй байна.
	3	Эмийн хэрэглээг хянах, эмийн жагсаалтыг шинэчлэх үйл ажиллагааг жилд дор хаяж нэг удаа хийж гүйцэтгэдэг байна.
	4	Эмийн хомсдол, тасалдлын талаар эмч болон бусад эрүүл мэндийн ажилтнуудад үнэн зөв, шуурхай мэдээлэл дамжуулах үйл явцыг хэрэгжүүлдэг байна.

Шалгуур 6.4

Эм, бэлдмэлийн аюулгүй байдал, чанарыг хангахуйц газарт хадгална.

Агуулга

Эм бэлдмэлийн тогтвортой бөгөөд үр нөлөөтэй байдал нь үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу гэрэл, чийгшил, температур зэрэг зохих нөхцөлд хадгалахаас шууд хамаарна. Төв нь эмийн тогтвортой байдлыг хангахын тулд эмийн агуулах, хадгалах

хэсгүүдэд хадгалалтын зохих горимыг (температур, гэрэл, чийгшил) бүрдүүлэх ёстой. Үүнд олон удаа хэрэглэгдэх (олон тунт) эмийн хадгалалт, ашиглалт мөн хамаарна. Хадгалагдаж буй эмийн төрлөөс хамааран эм бэлдмэлийг үрэгдэх, алдагдахаас сэргийлж, тодорхой түвшний хамгаалалтыг бүрдүүлж, эмийн хадгалах хэсэгт нэвтрэх эрхийг хязгаарлах ёстой. Мөн хадгалалтын горим мөрдөгдөж буй эсэхийг хяналт шалгалтаар тогтмол баталгаажуулж байх үүрэгтэй.

Эм, бэлдмэлийн шошгожуулалт

Шошгогүй саванд байгаа эм эсвэл бусад уусмалыг таньж тодорхойлох боломжгүй юм. Эм бэлдмэлийг үйлдвэрийн савнаас нь гаргаж, шошгогүй саванд хийснээс үүдэн заримдаа эмгэнэлтэй алдаанууд ч гардаг. Бүх эм, эмийн сав болон уусмалыг шошгожуулах нь эмийн аюулгүй менежментийн зарчимд нийцсэн, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа юм. Энэхүү дадал нь эм тариа хэрэглэх явцад гарч болох эрсдэлт хүчин зүйлээс сэргийлдэг. Эм бэлдмэлийг стандарт аргаар шошгожуулна. Энэхүү шаардлага нь бэлтгэсэн боловч шууд хэрэглээгүй бүх эмэнд хамаарна (яаралтай тусламжийн үед шууд бэлтгэж хэрэглэсэн эмэнд энэ шаардлага хамаарахгүй). Шошгонд хамгийн багадаа дараах мэдээллийг тусгана (хэрэв үйлдвэрийн хайрцаг, сав, ампул, флакон дээр тодорхой бичигдээгүй бол):

- a) Эмийн нэр
- b) Тун / концентраци
- c) Хэмжээ / тоо ширхэг
- d) Хүчинтэй хугацаа
- e) Найруулснаас эсвэл задалснаас хойш хэрэглэх хугацаа

Үнэлгээ хийх чиглэл

- Шинжээч эмийн хадгалалтын нөхцөл болон шошгожуулалтад үнэлгээ өгөх агуулгаар эмийн хадгалах хэсгүүдийг үзнэ.
- Шинжээч олон тунт эм бэлдмэлийн (жишээ нь: вакцин) шошго дээр задалснаас хойш хэрэглэх хугацааг тэмдэглэсэн эсэхийг үзнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Эм бэлдмэлийг үйлдвэрлэгч эсвэл борлуулах эрх бүхий байгууллагын зөвлөмжийн дагуу цэвэр, эмх цэгцтэй орчинд аюулгүй, найдвартай хадгалсан байна.
	2	Олон тунт эмийн тогтвортой, аюулгүй байдлыг хангахын тулд тэдгээрийг ашиглах, хадгалах тухай батлагдсан журамтай байна.®
	3	Цахилгаан тасарсан үед эм бэлдмэлийн чанар, бүрэн бүтэн байдлыг хангах, ашиглахаас өмнө тэдгээрийг шалгах тодорхой журамтай байна.®
	4	Эмийн хадгалах хэсгүүдэд хадгалалтын зохих нөхцөл мөрдөгдөж буйг баталгаажуулах агуулгаар тогтмол (сард дор хаяж нэг удаа) хяналт шалгалт хийдэг байна.

	5	Бүх эм, эмийн сав болон бусад уусмалууд нь стандарт аргаар тод шошгологдсон байна (хэрэв үйлдвэрийн хайрцаг, сав, ампул, флакон дээр тодорхой бичигдээгүй бол). Шошго нь а)-аас д) хүртэлх заавал байх бүх элементүүдийг агуулсан байна.
--	---	--

Шалгуур 6.5

Яаралтай тусламж эм, бэлдмэл хангалттай хэмжээгээр, хүртээмжтэй байх ба хадгалалтын аюулгүй байдлыг хангасан байна.

Агуулга

Яаралтай тусламж үзүүлэх үед амь насыг дэмжих эм бэлэн байх нь нэн чухал бөгөөд өвчтөний амь насыг аврах ач холбогдолтой. Эмчилгээнд шаардлагатай эмийг хурдан олох боломжтой байдлаар хангалттай хэмжээгээр бэлэн хадгална.

Төв нь яаралтай тусламжийн эм, бэлдмэлийн бэлэн байдлыг хангах зорилгоор журам боловсруулж хэрэгжүүлнэ. Журам дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- а) Яаралтай тусламжийн эм, бэлдмэлийг хангалттай хэмжээгээр, хурдан олоход хялбар байдлаар хадгалах нөхцөлийг бүрдүүлэх.
- б) Яаралтай тусламжийн эм, бэлдмэлийг буруу хэрэглэх, хулгайд алдахаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.
- с) Хэрэглэсэн, гэмтсэн, хүчинтэй хугацаа дууссан яаралтай тусламжийн эм, бэлдмэлийг богино хугацаанд нөхөх боломжийг бүрдүүлэх.

Үнэлгээ хийх чиглэл

- Яаралтай тусламжийн эм, бэлдмэлийн менежментийг зохицуулсан журмыг үзнэ.
- Яаралтай тусламжийн эм, бэлдмэлийг хадгалж буй байршлыг үзэж, ажиглалт хийнэ.

Яаралтай тусламжийн эм, бэлдмэлийг хариуцсан ажилтантай ярилцаж, эмийн бэлэн байдал, хүртээмж, хадгалалтын аюулгүй байдал, шаардлагатай тохиолдолд нөхөх зохицуулалтын талаарх мэдлэгийг нь үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь яаралтай тусламжийн эм, бэлдмэлийн бэлэн байдлыг хангах үүднээс агуулгад (а–с заалт) дурдсан шаардлагыг хангасан журамтай байна.®
	2	Яаралтай тусламжийн эм, бэлдмэл бэлэн, хүртээмжтэй байна.
	3	Яаралтай тусламжийн эм, бэлдмэлийг байршил бүрт ижил зохион байгуулалттайгаар хадгалдаг байна.
	4	Ашиглагдсан, гэмтсэн, хүчинтэй хугацаа дууссан эмийг урьдчилан тогтоосон хугацаанд нөхдөг байна.

Шалгуур 6.6

Эрсдэл өндөртэй эмүүдийг тодорхойлж, тэдгээрийг хадгалах, бэлтгэх/хуваарилах, олгох/тарих үйл явцыг эрсдэлийг хамгийн бага түвшинд барихуйц байдлаар зохион байгуулсан байна.

Агуулга

Өндөр эрсдэлтэй эмийн бэлдмэл гэдэг нь буруу хэрэглэсэн тохиолдолд өвчтөнд ноцтой хор уршиг учруулах магадлал өндөртэй эмийг хэлнэ. Алдаа гарах давтамж ижил байж болох ч, алдааны үр дагавар нь бусад эмтэй харьцуулахад илүү хүнд байдаг. Үүнд гипогликемийн эсрэг эмүүд, эмчилгээний хүрээ нарийн эмүүд, инотроп эмүүд орно.

Төв нь өндөр эрсдэлтэй эмийн жагсаалтыг боловсруулна.

Төв нь өндөр эрсдэлтэй эмийн аюулгүй хэрэглээг хангах батлагдсан бодлого, журам боловсруулж хэрэгжүүлнэ.

Уг бодлогод дор дурдсан асуудлуудыг тусгасан байна. Үүнд:

а) Төвийн өөрийн мэдээлэл болон үндэсний, олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудын (ЭМЯ, ДЭМБ) зөвлөмжид үндэслэсэн өндөр эрсдэлтэй эмийн батлагдсан жагсаалт.

б) Өндөр эрсдэлтэй эмийг санамсаргүйгээр буруу хэрэглэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, стратеги, өндөр концентрацитай электролит хадгалахгүй байх зохицуулалт.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээний жишээ

- Өндөр эрсдэлтэй эмийг бусад эмээс тусгаарлан хадгалах
- Эмийн сангийн ажилтнаар тогтмол хяналт, нөөц нөхөлт хийлгэх
- Анхааруулах тод шошго, тэмдэглэгээ ашиглах

Үнэлгээ хийх чиглэл

- Магадлан итгэмжлэлийн үнэлгээний баг өндөр эрсдэлтэй эмийн аюулгүй хэрэглээг зохицуулсан төвийн бодлого, журмыг хянана.
- Өндөр эрсдэлтэй эмийн жагсаалт болон түүний хүртээмжийг шалгана.
- Эмийн хадгалалтын орчин, кабинетад ажиглалт хийж, хэрэгжүүлж буй арга хэмжээг үнэлнэ.
- Ажилтантай ярилцаж, өндөр эрсдэлтэй эмийн менежмент, урьдчилан сэргийлэх стратегийн талаарх мэдлэг, ойлголтыг үнэлнэ

Хэмжих үзүүлэлт	1	Өндөр эрсдэлтэй эмийн менежментийн батлагдсан журамтай.©
	2	Холбогдох эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд сургалт, чиглүүлэг тогтмол олгодог.
	3	Жил бүр шинэчилсэн, батлагдсан өндөр эрсдэлтэй эмийн жагсаалттай.©
	4	Өндөр эрсдэлтэй эмийн санамсаргүй хэрэглээнээс сэргийлэх үйл явц хэрэгжүүлдэг.
	5	Өндөр эрсдэлтэй эмтэй холбоотой мэдээллийг хянаж, сайжруулах арга хэмжээ авдаг.

Шалгуур 6.7

Ижил дуудагддаг нэршилтэй эм, савлагаа нь адил харагддаг эмийн хяналтыг сайжруулна.

Агуулга

Ижил дуудагддаг нэршилтэй эм, савлагаа нь адил харагддаг эм гэдэг нь ерөнхий хэлбэр, сав баглаа боодол нь хоорондоо төстэй, мөн эмийн нэр нь бичгийн болон авиа зүйн хувьд ижил төстэй эмүүдийг хэлнэ. Эдгээр эмүүдийг андуурах нь ноцтой алдаа гарахад хүргэж болзошгүй.

Эмчилгээний аюулгүй байдлын хүрээлэн нь онцгой хамгаалалтын арга хэмжээ шаардлагатай байж болзошгүй. Ижил дуудагддаг нэршилтэй эм, савлагаа нь адил харагддаг эмийн нэрсийн жагсаалтыг тогтмол шинэчлэн хөтөлдөг. Ижил дуудагддаг нэршилтэй эм, савлагаа нь адил харагддаг эмийн олголтын алдааг бууруулахад зөвлөдөг нэг стратеги нь худалдааны болон олон улсын нэршил, эмийн хэлбэр, тун хэмжээ, хэрэглэх заавар, мөн хэрэглэх заалтыг хамтад нь бичиж оруулах бөгөөд энэ нь ижил төстэй нэртэй эмүүдийг ялган танихад тустай. Хэрэв дээрх эм нь өөр өөр хэрэглэх заалттай бол эмийг тухайн заалттай нь холбон тэмдэглэх нь ижил дуудлагатай өөр эмээс ялгахад хэрэгтэй.

Бусад зөвлөмжид эмийн жорын уншигдах байдлыг сайжруулах, үүнд гар бичмэл болон хэвлэмэл хэлбэрийг сайжруулах орно. Төв нь эм хадгалах хэсэгт эмийг хооронд нь тусгаарлан байрлуулах, ангилан ялгах аргыг ашигласнаар эрсдэлийг бууруулдаг. Үүнээс гадна, зарим тусгай загвартай шошго ашиглах, эсвэл эмийн нэрийн ялгааг тодотгох агуулгаар “том-жижиг үсэг” хослуулсан бичих (жишээ нь, цефотаксим, цефтриаксон) аргыг хэрэглэдэг.

Ижил дуудагддаг нэршилтэй, савлагаа нь адил харагддаг эмийн сөрөг тохиолдлыг бууруулж, өвчтөний аюулгүй байдлыг сайжруулах эрсдэлийн удирдлагын стратеги боловсруулна. Мөн аюулгүй байдлыг хангах бодлого, журмыг боловсруулж хэрэгжүүлнэ. Тус бодлогод дор дурдсан зүйлсийг заавал тусгана. Үүнд:

- Ижил дуудагддаг нэршилтэй, савлагаа нь адил харагддаг эмийн жагсаалт
- Эм хадгалалтын шаардлага
- Эмийн хаяг шошгололтын шаардлага
- Эм олголтын шаардлага

Үнэлгээ хийх чиглэл

1.Ижил дуудагддаг нэршилтэй эм, савлагаа нь адил харагддаг эмийн жагсаалтыг шалгана.

2.Байгууллагын ажилтантай ярилцлага хийж, ижил дуудагддаг нэршилтэй, савлагаа нь адил харагддаг эмийг хэрэглэхтэй холбоотой эрсдэлийг бууруулах үйл явц, арга хэмжээний талаар тодруулж асууна.

3.Ижил дуудагддаг нэршилтэй эм, савлагаа нь адил харагддаг эмийг хооронд нь тусгаарлан байршуулсан байдал болон шошгололтыг ажиглан үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь а)–d)-д дурдсан агуулга, шаардлагыг хамарсан, ижил дуудагддаг нэршилтэй эм, савлагаа нь адил харагддаг эмийг зохицуулах батлагдсан журамтай байна.®
	2	Ижил дуудагддаг нэршилтэй эм, савлагаа нь адил харагддаг эмийн батлагдсан жагсаалт(ууд)-тай бөгөөд уг жагсаалтыг жил бүр шинэчилдэг байна.®

3	Эмийн хадгалалт, хэрэглээнд оролцдог эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулдаг байна.
4	Ижил дуудагддаг нэршилтэй эм, савлагаа нь адил харагддаг эмийг санамсаргүйгээр андуурч хэрэглэхээс урьдчилан сэргийлэх үйл явц, арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.
5	Ижил дуудагддаг нэршилтэй эм, савлагаа нь адил харагддаг эмийн удирдлагатай холбоотой мэдээлэл, тайланг тогтмол хянаж, шаардлагатай тохиолдолд үйл явцыг хянах, сайжруулах арга хэмжээ авдаг байна.

Шалгуур 6.8

Эмийг татан авах тогтолцоотой байна.

Агуулга

Эмийн эмчилгээ нь үр ашиг ихтэй боловч үүнийг дагаад олон төрлийн эрсдэлтэй байдаг. Эдгээр эрсдэл нь эмийн түүхий эдийн шинж чанар, эмийн чанар, зарим тохиолдолд бүтээгдэхүүний өөрийн гэмтэл, доголдлоос үүдэлтэй байж болно.

Аюулгүй байдлын асуудал үүссэн тохиолдолд эмийг татан авах шаардлагатай бөгөөд гэмтэлтэй, шаардлага хангахгүй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч/түгээгчид буцаан татах ёстой. Үүнд хүчинтэй хугацаа дууссан, хуучирсан, гэмтсэн, ашиглагдаагүй, болон/эсвэл бохирдсон эмүүд хамаарна. Мөн татан авсан эм, түүхий эдийг ашиглан бэлтгэсэн ариутгасан болон ариутгагдаагүй найруулмал эмийн бэлдмэлүүд мөн багтана.

Эмийг татан авах үйл явц нь ихээхэн зардалтай бөгөөд тухайн бүтээгдэхүүн эсвэл компанид хандах хэрэглэгчийн итгэлийг алдагдуулах эрсдэлтэй тул компаниуд ийм нөхцөл байдлаас зайлсхийхийн тулд дээд зэргээр хичээдэг.

Төв нь орон нутгийн эрүүл мэндийн байгууллага, үйлдвэрлэгч, эсвэл бусад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаас татан авсан эмүүдийг зөв тодорхойлох, эргүүлэн татах үйл явцыг хэрэгжүүлэх тогтолцоотой байх ёстой. Байгууллага нь татан авсан эмийн удирдлагыг зохицуулах бодлого, журам боловсруулж хэрэгжүүлнэ. Мөн хугацаа дууссан эмийг санамсаргүйгээр түгээх, олгох, хэрэглэхээс сэргийлж ажиллана.

Тус бодлого нь дор дурдсан асуудлуудыг заавал хамарна. Үүнд:

- Эмийг эргүүлэн татах үйл явц
- Эмийн шошгололт ба тусгаарлалт
- Өвчтөнд мэдэгдэх журам (шаардлагатай тохиолдолд)
- Эмийг устгах эсвэл хаях журам

Үнэлгээ хийх чиглэл

1. Эргүүлэн татан авсан эмийн удирдлага, зохицуулалтыг тодорхойлсон байгууллагын бодлого, журмыг хянаж, шалгана.
2. Эм зүйч, сувилагчтай ярилцлага хийж, эмийг татан авсан, хугацаа дууссан, хуучирсан, гэмтсэн болон/эсвэл бохирдсон эмийг удирдан зохицуулах үйл явцын талаар тодруулж асууна.

3. Эмийн сан, эмийн тэрэг, эм хадгалах хэсгүүдэд ажиглалт хийж, татан авсан, хугацаа дууссан, хуучирсан, гэмтсэн болон/эсвэл бохирдсон эм байгаа эсэхийг хянана.		
4. Эмийг татан авах мэдэгдэл хүлээн авснаас эхлээд устгах эсвэл хаях хүртэлх бүх үйл явцыг хянана.		
Хэмжих үзүүлэлт	1	Төв нь (зорилгын a)–d заалт) эмийг татан авах үйл явцыг удирдан чиглүүлэх батлагдсан бодлого, журамтай байна.®
	2	Эмийг татан авах үйл явцад оролцдог ажилтан бодлогын шаардлагыг сайн мэддэг байна.
	3	Татан авсан эм(үүд)-ийг бодлогын дагуу эргүүлэн татаж, шошголон, тусгаарлан хадгалж, устгах арга хэмжээ авсан байна.
	4	Хугацаа дууссан, хуучирсан, гэмтсэн болон/эсвэл бохирдсон эмийг байгууллагын бодлого, журмын дагуу тусад нь хадгалж, аюулгүйгээр устгадаг байна.

Шалгуур 6.9

Өвчтөний эмийн хэрэглээг тогтмол нягтлан шалгаж, бүртгэл мэдээлэлтэй нь нийцүүлэн баталгаажуулна.

Агуулга

Өвчтөн тусламж үйлчилгээний нэг үе шатнаас нөгөөд шилжихдээ шинэ эм бичүүлж авах, эсвэл хэрэглэж байсан эмийг өөрчлөх шаардлага үүсдэг. Ийм шилжилтийн үед шинэ эм бичигдэх, эсвэл өмнөх эмийг дахин бичих явцад эмийн жагсаалтанд санамсаргүй алдаа гарах эрсдэлтэй.

Үүний үр дүнд:

- шаардлагатай эм орхигдох,
- өмнө хэрэглэж буй эмийг давхардуулж бичих,
- тунгийн алдаа гарах магадлалтай бөгөөд эдгээр нь өвчтөнд эмийн гаж нөлөө үүсгэх өндөр эрсдэлтэй.

Эмийн зохицуулалт гэдэг нь ийм төрлийн зөрчил, зөрүүг таслан зогсоох зорилготой үйл явц юм. Тухайлбал, эмчилгээний шилжилтийн мөчид өвчтөний хэрэглэж буй бүх эмийн жагсаалтыг бүрэн гүйцэд хянаж, шинэ нөхцөлд (шинэ үйлчилгээ, шинэ тасаг, шинэ байгууллага гэх мэт) хэрэглэх эмийн хэрэглээтэй харьцуулан нягталж баталгаажуулна.

Энэхүү харьцуулалт, нягтлалт нь урьдчилан тогтоосон хугацааны хүрээнд хийгдэж, хоёр жагсаалтын: давхардал, зөрүү, алдаа, орхигдол зэргийг илрүүлж залруулан өвчтөний эмийн аюулгүй байдлыг хангах үндсэн зорилготой.

Төв нь эмийн зохицуулалтын үйл явцыг хэрэгжүүлэхэд чиглэсэн журам боловсруулж, мөрдүүлнэ.

Журам нь дараах шаардлагыг хангасан байна:

1. Эмийн зохицуулалт хийх шаардлагатай нөхцөл
2. Эмийн зохицуулалт хийх хугацааны хязгаар

3. Холбогдох эрүүл мэндийн ажилтны хариуцлага

4. Эмийн зохицуулалтын үйл явцын алхмууд

i. Өвчтөн тусламж үйлчилгээ эхлэх үед хэрэглэж буй бүх эмийн жагсаалтыг боловсруулах/цуглуулах болон баримтжуулах.

Энэ нь эмчийн жороор бичигдсэн болон жоргүй эм, (витамин, тэжээлийн нэмэлт, вакцин) зэрэг бүх төрлийн эмийн хэрэглээг хамарч, тогтмол цагт уудаг болон шаардлагатай үед хэрэглэдэг эмийг бүрэн бүртгэнэ.

ii. Төвийн хүрээнд тухайн тусламж үйлчилгээний явцад бичигдэх эмийн жагсаалтыг боловсруулах.

iii. Хоёр жагсаалтыг харьцуулж, зөрүүг үнэлэн шийдвэр гаргах.

Энэ харьцуулалтын үндсэн зорилго нь жортой эм болон түүний тун нь зохистой эсэхийг нягтлах бөгөөд эмийн алдаа гарахаас сэргийлнэ:

- эмийн орхигдол,
- тунгийн алдаа,
- буруу эмчилгээг үргэлжлүүлэх,
- эмийн давхардал.

Үнэлгээ хийх чиглэл

- Журмыг хянан үзэж, дараа нь эрүүл мэндийн ажилтантай ярилцаж эмийн зохицуулалтын үйл явц хэрхэн хэрэгжиж буйг тодруулно.
- Өвчтөний эмнэлгийн түүхийг шалгаж, тухайн өвчтөний одоогийн эмийн хэрэглээ хэрхэн бүртгэгдсэнийг үнэлнэ.
- Өвчтөнтэй ярилцаж, эмийн түүхийг хэрхэн авч үнэлдэг талаар тодруулна.
- Өвчтөний хэрэглэж буй эмүүд нь түүхэнд бичигдсэн “одоогийн эмийн жагсаалт”-тай тохирч байгаа эсэх болон эдгээр эмүүд эмийн зохицуулалтын үйл явцад багтсан эсэхийг шалгана.

Хэмжих үзүүлэлт	1	Эмийн түүхийг бүрэн авахтай холбоотой, 1–4 шаардлагыг хангасан батлагдсан журамтай байна.®
	2	Эмийн зохицуулалт хийх үүрэгтэй ажилтан нь эмийн захиалга авах болон эмийн зохицуулалт гүйцэтгэх талаар сургалтанд хамрагдсан байна.
	3	Эмч өвчтөний одоогийн хэрэглэж буй эмийн жагсаалтыг тусламж үйлчилгээний үед бичигдэх эмийн жагсаалттай харьцуулж үнэлгээ хийнэ.
	4	Зохицуулсан эмийн жагсаалт нь тодорхой, бүрэн, ойлгомжтой баримтжуулагдсан байх бөгөөд ажилтанд тухайн мэдээлэл ил тод, ойлгомжтой хэлбэрээр дамжуулагдан хүрсэн байна.

Шалгуур 6.10

Эмийн захиалга, жор бичилт нь хууль журмын дагуу, аюулгүй байдлыг хангасан байна.

Агуулга

Үр дүнтэй эмийн эмчилгээ өвчтөний амьдралын чанарыг сайжруулж, аюулгүй байдал болон эмчилгээний үр дүнг нэмэгдүүлнэ. Эмийг зөв сонгож, эмчилгээний үр дүнг нэмэгдүүлэхэд эмнэлгийн ажилтнаас өндөр мэдлэг, ур чадвар шаардана.

Төв нь эм захиалах, жор бичих үйл явцыг хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцыг зохицуулсан журам хэрэгжүүлнэ. Журамд дараах үйл ажиллагааг тусгана. Үүнд:

- Жор бичих эрхтэй эрүүл мэндийн ажилтан;
- Өвчтөний түүхэнд эм захиалах, жор бичих хэсгийг тодорхой зааж өгөх;
- Эмийн эмчилгээг хуулахыг хориглох;
- Эмийн жорд дараах зүйлсийг бичнэ:
- Өвчтөний мэдээлэл (овог, нэр, төрсөн огноо, цахим дугаар)
- Бусад мэдээлэл (нас, хүйс, гэрийн хаяг, утасны дугаар, яс үндэс гм)
- Эмийн нэр
- Эмийн савлагаа
- Эмийн тун, концентраци
- Хэрэгдэх тун, давтамж
- Хэрэглэх арга
- Яаралтай тусламжийн үед дуслар эмчилгээ хийж байгаа тохиолдолд нэгж хугацаанд дуслыг хэдэн дуслар дусаах тоо, буюу дуслын хурд
- Шаардлагатай үед хэрэглэх эмийн заалт
- Эмийн захиалга хийсэн огноо, цаг
- Жор бичсэн ажилтны мэдээлэл

е) Өвчтөний биеийн жинд тоохуулах тун, яаралтай захиалга, тунг аажмаар нэмэх /бууруулах шаардлагатай эмийн захиалгыг зохицуулах заалт

ф) дутуу, гаргацгүй, эсвэл тодорхой бус эмийн захиалгыг тодруулах тогтсон үйл явц

г) удаан хугацаанд хэрэглэх эмийн жорыг олон мэргэжлийн ажилтны оролцоотойгоор богино хугацаанд, хүндрэл багатайгаар сунгах, эмчилгээний тасралтгүй байдлыг хангах үйл явцыг зохицуулсан заалт гм.

Үнэлгээ хийх чиглэл

- Шинжээч нь эмнэлэгт мөрдөж буй журмыг үзсэний дараа эрүүл мэндийн ажилтантай ярилцан, эмнэлэг болон яаралтай тусламжийн өрөөнд эмийн жор бичилт, захиалгын үйл явцыг хэрхэн өрнөдөг талаар асууж тодруулна.
- Өвчтөний өвчний түүхийг үзэж, эмийн захиалга бүрэн гүйцэд, гаргацтай, ойлгомжтой байгаа эсэхийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад дурдсан (a-г заалт) агуулга бүхий эм захиалах, жор бичих үйл явцыг зохицуулсан журамтай байна.®
	2	Жор барих эрх бүхий эмнэлгийн мэргэжилтнийг тодохойлсон байна.
	3	Эмийн жор, захиалга нь бүрэн гүйцэд, агуулгад дурдсан (i-xi заалт) мэдээллийг агуулна.®
	4	Удаан хугацаанд хэрэглэх эмийн жор сунгах үйл явц журмын дагуу хэрэгждэг байна.

Шалгуур 6.11 Эмийн жор бичилтэд хяналт тавьдаг байна.

Агуулга

Эм зүйч нь эм олгох, түгээх явцад эмийн аюулгүй байдал, эмчилгээний үр дүнг хангаж ажилладаг. Эмийг захиалгын дагуу олгохоос өмнө жор нь зөв бичигдсэн эсэхийг

мэргэжлийн зөвшөөрөлтэй эм зүйч/ эм найруулагч хянаана. Шинээр нэвтрүүлж буй эмийн захиалгад дараах хяналтыг хийнэ. Үүнд:

- Хэрэглэх заалт тохирч байгаа эсэх;
- Эмийн тун, хэрэглэх давтамж, арга, эмчилгээний үргэлжлэх хугацаа зэрэг нь тухайн өвчтөнд тохирч байгаа эсэх;
- Ижил үйлдэлтэй эм байгаа эсэх;
- Эмийн хэрэглэх заалт нь байгууллагын тодорхойлсон заалтаас зөрсөн эсэх
- Эсрэг заалт байгаа эсэх;
- Харшлын талаарх мэдээлэл;
- Бусад эм бэлдмэл, хоол хүнстэй харилцан үйлчлэл;
- Хордлого үүсгэх магадлал.

Төв нь эмийн эмчилгээний зохистой байдлыг хянахад өвчтөний ямар мэдээлэлд тулгуурлахыг тодорхой болгосон байх шаардлагатай.

Үнэлгээ хийх чиглэл

Шинжээч нь эм зүйч, эм найруулагч, сувилагч болон эрүүл мэндийн бусад ажилтнуудтай эмийн эмчилгээний хяналттай холбоотой үйл явцын талаар ярилцаж, ажиглалт хийх замаар үнэлнэ. хийнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Эмийн эмчилгээнд хяналт хийхэд шаардлагатай өвчтөний мэдээллийн төрөл, мэдээллийн эх сурвалжийг тодорхойлж, өгөгдлийн хүртээмжтэй байдлыг хангана.
	2	Эм зүйч/эм найруулагч нь эмийн захиалга бүрт Агуулгад дурдсан агуулгын хүрээнд (a-h заалт) хяналт хийж, баталгаажуулдаг байна.
	3	Мэргэжлийн эм зүйч/ эм найруулагчгүй тохиолдолд тусгайлан бэлтгэсэн эрүүл мэндийн ажилтан нь эмийн захиалга бүрт Агуулгад дурдсан агуулгын хүрээнд (a-h заалт) хяналт хийж, баталгаажуулдаг байна.
	4	Эмийн хяналт хийх явцад эргэлзээтэй асуудал үүсэхэд эмчилгээ бичсэн эмчтэй холбогдож, тодруулга авах үйл ажиллагааг тодорхой болгосон байна.

Шалгуур 6.12

Эмийг аюулгүй, зааврын дагуу бэлтгэж, олгож, хэрэглэдэг байна.

Агуулга

Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, эмтэй холбоотой тохиолдлоос сэргийлэх үүднээс эм олгох үйл ажиллагааг журмын дагуу зохицуулах шаардлагатай. Мэргэжлийн сувилагч, аюулгүй, цэвэр, зохион байгуулалттай ажлын орчин, хангалттай хэмжээний тоног төхөөрөмж, хэрэгсэл, тавиур, баглаа боодол гм-р хангах нь эмийг зөв олгох нөхцөлийг бүрдүүлнэ.

Төв нь эмийг аюулгүй бэлтгэх, олгох, хэрэглэхэд баримтлах шаардлагыг тодорхойлсон байна. Үүнд: эмийн нэр, тунг дахин хянах, ариун, цэвэр орчин бүрдүүлэх, эмийн тун, хэмжээг зөвхөн эмчийн заавраар олгох, өвчтөн болон тэдний гэр бүлд эмийн хадгалалт, аюулгүй, үр дүнтэй хэрэглээний талаар зааварчилгаа өгч, сургалтад хамруулах замаар оролцоог нь нэмэгдүүлнэ. Эмийн эмчилгээний аюулгүй

байдлыг хангах нь эмнэлгийн ажилтнаас мэдлэг, ур чадвар шаардах тул үйл явцыг журамлана. Үүнд:

1. Эмийн захиалга, жор байгаа эсэх
2. Зөв өвчтөнд эмчилгээ хийх гэж байгаа эсэх
3. Эм нь зөв эсэх
4. Эмчилгээний заалт зөв эсэх
5. Эмийн 1 удаагийн тун, давтамж нь зөв эсэх
6. Хэрэглэх арга нь зөв эсэх
7. Хэрэглэх цаг нь зөв эсэх
8. Өвчтөн тухайн эмийн харшилтай эсэх
9. Өвчтөн эмчилгээ хийлгэхээс татгалзсан тохиолдолд авах арга хэмжээ
10. Эмийн эмчилгээг өвчтөний түүхэнд тэмдэглэх

Үнэлгээ хийх чиглэл

- Шинжээч нь эм бэлтгэх, шошгожуулах, олгох үйл явцыг ажиглана.
- Сувилагчтай ярилцаж, үйл явцын талаар тодруулна, ажиглана.
- Эм олгох, тарих үйл явцыг ажиглана.

Өвчтөн болон түүний гэр бүлтэй ярилцаж, эмийн эмчилгээний талаар заавар, зөвлөгөө авсан, сургалтад хамрагдсан талаар асууж тодруулна.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь хууль, журамд заасан шаардлагыг хангаж буй мэргэжлийн зөвшөөрөл бүхий сувилагчтай байна.
	2	Эм бэлтгэх, хадгалах орчин нь цэвэр, эмх цэгцтэй, шаардлагатай хэрэгслээр хангагдсан байна.
	3	Эм олгох үйл явцыг тасаг, нэгжүүдэд ижил стандартын дагуу хэрэгжүүлдэг байна.
	4	Эмийн шошго дээр шаардлагатай мэдээллийг бичиж, тэмдэглэсэн байна.
	5	Өвчтөний түүхэнд хийгдсэн эмийн эмчилгээний талаар агуулгад дурдсан мэдээлэл бүхий (1-10 заалт) тэмдэглэл хийсэн байна.
	6	Өвчтөн болон түүний гэр бүлийг эмийн заавар, хэрэглээний талаар мэдээллээр (аман болон бичгээр) хангасан байна.

Шалгуур 6.13

Эмтэй холбоотой тохиолдол, алдах дөхсөн тохиолдол, эмийн гаж нөлөөг илрүүлэн, бүртгэж, хянахын зэрэгцээ бууруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

Агуулга

Эмтэй холбоотой тохиолдол, алдах дөхсөн тохиолдол нь дэлхийн хэмжээнд тулгамдсан асуудлын нэг бөгөөд жор бичих, эмийг хэрэглэх гм бүх үе шатанд тохиолддог. Эмтэй холбоотой ноцтой тохиолдлын тоо цөөн боловч давтамж ихтэй. Төв нь эмтэй холбоотой тохиолдол, алдах дөхсөн тохиолдол, эмийн эмчилгээтэй холбоотой тулгамдсан асуудлыг илрүүлэх, бүртгэх тогтолцоог бүрдүүлнэ. Тогтолцоо нь эмийн тунг хэтрүүлэх, эмэнд хордох, буруу хэрэглэх, жирэмсэн болон хөхүүл үеийн эмийн нөлөөлөл гэх мэт аюулгүй байдал алдагдахаас сэргийлэх, алдагдсан үед

хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулна. Эмийн нөлөөг хянах гэдэгт эмийн гаж нөлөөг илрүүлэх, бүртгэж, мэдээлэх үйл явцыг хамааруулах бөгөөд эрүүл мэндийн ажилтныг энэ чиглэлийн сургалтад хамруулсан байна. Батлагдсан дүрэм, журамд заасны дагуу эмтэй холбоотой тохиолдлыг богино хугацаанд эрх бүхий байгууллагад мэдээлнэ. Төв нь эмтэй холбоотой тохиолдол, алдах дөхсөн тохиолдол, эмийн эмчилгээтэй холбоотой асуудал, эмийн гаж нөлөөг илрүүлэх, бүртгэх, мэдээлэх үйл явцыг зохицуулах үйл ажиллагааг төлөвлөсөн байна. Төлөвлөлтөд эмийн менежментийн бүх үе шатанд хамаарал бүхий талуудын хамтын оролцоог хангана. Эмтэй холбоотой тохиолдлыг мэдээлэх нь тусламж, үйлчилгээний чанар сайжруулах болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны салшгүй хэсэг юм.

Эмтэй холбоотой тохиолдлыг дараах байгууллагад мэдээлнэ. Үүнд:

- Эмийн эмчилгээг төлөвлөсөн эмч
- Эмчилгээний хороо
- Чанарын алба /баг
- Байгууллагын удирдлага
- Журамд заасны дагуу холбогдох дээд шатны байгууллага

Үнэлгээ хийх чиглэл

- Шинжээч нь эмийн эмчилгээний зохицуулалтыг үнэлэх явцад холбогдох эмнэлгийн мэргэжилтэнтэй ярилцаж, эмтэй холбоотой тохиолдол, эмийн гаж нөлөөг илрүүлэх, дүн шинжилгээ хийх, бүртгэх, мэдээлэх талаарх мэдлэг, хандлага, үйл ажиллагааг үнэлнэ.
- Эмтэй холбоотой тохиолдлын бүртгэлийг хянана.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь эмтэй холбоотой тохиолдлыг илрүүлэх, мэдээлэх, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явцыг тусгасан журамтай байна.
	2	Эмтэй холбоотой тохиолдлыг холбогдох (зорилгын а-е заалт) ажилтан, байгууллагад мэдээлж, хариу арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.
	3	Эмтэй холбоотой тохиолдлыг давтан алдаа гаргахаас сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөхөд ашигладаг байна.
	4	Өвчтөнд илэрсэн эмийн гаж нөлөө болон түүнийг бууруулах, арилгах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааг өвчтөний түүхэнд тэмдэглэнэ.
	5	Эмтэй холбоотой тохиолдлыг улсын хэмжээнд мөрдөх журмын дагуу мэдээлсэн байна

II ХЭСЭГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТ

БҮЛЭГ 7. ЗАСАГЛАЛ УДИРДЛАГА МАНЛАЙЛАЛ

Тойм

Байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, чиг үүрэг, өмчийн хэлбэрээс хамааран төвийн засаглал болон хариуцлагын тогтолцоо ямар байж болохыг энэ бүлэгт тайлбарласан болно.

Засаглалын бүтцийг тодорхой болгосноор эцсийн шийдвэр гаргах болон төвийн үйл ажиллагааг чиглүүлэх, хяналт тавих эрх мэдэл хэнд байгаа нь ойлгомжтой болно.

Засаглал нь төвийн үйл ажиллагааг хянах, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй ч, байгууллагыг үр ашигтай удирдах нь төвийн болон нэгжийн удирдах ажилтны идэвх зүтгэл, төлөвлөлтийг хэр үр дүнтэй хийж байгаагаас ихээхэн хамаарна.

Үр дүнтэй төлөвлөлт нь тусламж, үйлчилгээнд оролцогч талуудын эрэлт, хэрэгцээг тодорхойлж, түүнд нийцсэн тусламж, үйлчилгээг төлөвлөхөөс эхэлдэг. Төвийн төлөвлөгөө нь төрөөс хэрэгжүүлж буй үндэсний арга хэмжээ, хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдсан байна.

Төвийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үүднээс удирдлагын түвшин бүрт хүлээх үүрэг, хариуцлагыг оновчтой хуваарилан, үр дүнтэй харилцах талаар энэ бүлэгт тайлбарласан болно.

Эрүүл мэндийн салбар чанарт суурилсан ирээдүй болон үр дүнд тулгуурласан санхүүжилтийн загвар руу эрчимтэй шилжиж байгаатай холбоотойгоор тусламж, үйлчилгээний үр ашигтай байдал чухал байр суурь эзлэх болж, эмнэлгийн практикт амжилтад хүрэх хүчин зүйлс маш хурдтай өөрчлөгдөж байна

Тус бүлэгт гэрээгээр хийлгэх үйлчилгээ, ёс зүйтэй холбоотой асуудлын менежмент, ажилтны оролцоо зэрэг үр дүнтэй, үр ашигтай хамтын удирдлагын талаар авч үзнэ.

Шинжээчийн баг нь төвийн удирдлага болон ажилтантай ярилцлага хийх, ажиглах, үйл явцыг үнэлэх замаар засаглал болон удирдлагын бүтцийн үр ашиг, үр нөлөөг үнэлнэ. Ажилтныг урамшуулж, манлайлан чиглүүлэх нь тусламж, үйлчилгээний чанар сайжруулахад чухал үүрэгтэй бөгөөд үнэлгээний явцад энэ чадварыг цогцоор нь үнэлнэ.

Бүлгийн зорилго:

Төвийн удирдлага, зохион байгуулалтын тогтвортой байдал, чадавхийг дараах чиглэлээр үнэлнэ. Үүнд:

1. Төвийн удирдлага нь өөрийн чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлж буй байдал
2. Төвийн үйл ажиллагааг үр дүнтэй чиглүүлж буй эсэх
3. Үр дүнтэй манлайлж буй эсэх
4. Санхүүг үр дүнтэй удирдаж буй эсэх
5. Хийсэн гэрээний үр ашигтай байдал
6. Ёс зүйтэй удирдлага
7. Эрүүл мэндийн ажилтны оролцоо, эрүүл мэнд, аюулгүй байдлыг үр дүнтэй удирдаж буй байдал

Доорх жагсаалтад энэ бүлэгт хамаарах шалгуурыг нэгтгэн харуулав.

7.1	Төвийг удирдан чиглүүлэх, хянах чиг үүрэг бүхий дээд шатны удирдлагатай байна.
-----	--

7.2	Төвийн даргыг холбогдох хууль тогтоомжийн дагуу томилно.
7.3	Эмнэлзүйн засаглалын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
7.4	Төвийн удирдлагын үүрэг хариуцлагыг тодорхойлсон байна.
7.5	Стратеги төлөвлөгөөг дээд шатны удирдах албан тушаалтны хяналт, зааварчилгааны дагуу боловсруулсан байна.
7.6	Стратеги төлөвлөгөөнд тусгасан зорилго, зорилтод хүрэхийн тулд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан байна.
7.7	Бараа материал, нөөцийг холбогдох журмын дагуу хадгалдаг байна.
7.8	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээг сонгох, гэрээний хэрэгжилтийг үнэлэх, тасралтгүй хянах үйл явцыг бүрдүүлсэн байна.
7.9	Ажлын байрны эерэг соёлыг бүрдүүлсэн байна.
7.10	Ажилчдын амрах өрөөтэй байна.
7.11	Ажилтны эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг холбогдох хууль, журмын дагуу жил бүр үнэлдэг байна.

ШАЛГУУР, АГУУЛГА, ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур 7.1

Төвийн үйл ажиллагааг чиглүүлэх, хянах чиг үүрэг бүхий дээд шатны албан тушаалтан байна.

Агуулга

Сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг чиглүүлэх, хянах үүргийг тухайн Сумын Засаг дарга, өрхийн эрүүл мэндийн төвийн хувьд тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргааны нэгжийн Засаг дарга болон аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга хэрэгжүүлж, үйл ажиллагааг нь орон нутгийн хөгжлийн бодлого, зорилттой уялдуулан чиглүүлэх үүрэгтэй ажиллана. Тэд гэрээний хэрэгжилтийг үнэлэх замаар төвийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үр ашигтай, оновчтой байдлыг нь хангадаг. Төвийн үйл ажиллагааг хянах дээд шатны албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг гэрээнд заасны дагуу хэрэгжүүлэн ажиллана. Албан тушаалтан дараах үүрэгтэй. Үүнд:

- a) Төвийн эрхэм зорилго, алсын харааг тодорхойлоход зөвлөх, чиглүүлэх
- b) Төвийн гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын соёл, эрсдэлийн удирдлагыг төлөвшүүлэх үйл ажиллагааг дэмжих, хянах, сайжруулах
- c) Төвийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны эрэмбийг тухайн орон нутгийн хүн амын өвчлөлийн онцлог, хөгжлийн бодлого, зорилт гм-д тохируулан тогтоох
- d) Төвийн удирдлагатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлэх шалгуурыг тодорхой болгох, нөөцийн хуваарилалтыг шударга, ил тод байлгах
- e) Төвийн засаглал, үйл ажиллагааг хянах, тайланг тогтмол хүлээн авах
- f) Дараах бичиг баримтыг батлах. Үүнд:

- I. Төвийн стратеги төлөвлөгөө
- II. Төвийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, хөрөнгө оруулалт
- III. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө, эрсдэлийн удирдлага, гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөө

IV. Харъяалах хүн амын эрэлт хэрэгцээний судалгаа, хүн амын оролцоог хангах хөтөлбөр, төлөвлөгөө

Төвийн удирдлага, удирдлагын баг болон ажилтнуудын дээд шатны албан тушаалтантай мэдээлэл солилцох хэлбэр, сувгийг (нийгмийн сүлжээ, хурал, цуглаан, сар бүрийн, жилийн эцсийн уулзалт гэх мэт) тодорхойлох шаардлагатай.

Үнэлгээ хийх чиглэл

- Төвийн үйл ажиллагаатай танилцах, баримт бичгийг хянах, ярилцлага хийх үед түүнийг хянах дээд шаатны албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагын мэдээлэл авна. Мөн шаардлагатай бичиг, баримттай дэлгэрэнгүй танилцах, тодруулж асуух, баталгаажилтыг нь үзэх, тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнтэй танилцах замаар үнэлнэ.
- Төвийн эрхэм зорилгыг тусгасан баримт бичгийг үзэж, түүнийг шинэчилсэн эсэх, утга төгөлдөр, уялдаа холбоотой, ил тод байршуулсан байна.
- Дээд шатны албан тушаалтан болон төвийн хооронд нээлттэй харилцаа үүссэн эсэх, мэдээлэл солилцох давтамж, тайлан, мэдээнд хариу үйлдэл үзүүлдэг (эргэх холбоо) эсэхийг нотлох баримтаар үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төвийн үйл ажиллагааг чиглүүлэх, хянах дээд шатны албан тушаалтан нь тодорхой байна.©
	2	Албан тушаалтан нь төвийн удирдлагын багтай тодорхой хугацаанд хуралдаж, хурлын тэмдэглэлийг хөтөлсөн байна.©
	3	Төвийн алсын хараа, эрхэм зорилгыг ил тод байршуулсан байна.
	4	Албан тушаалтан нь агуулгад тусгасан (а-е заалт) хариуцлага, чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд нөөцийг хуваарилах, эрэмбийг тогтооход тодорхой шалгуурыг баримталдаг байна.©
	5	Албан тушаалтан нь төвийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, чанарын сайжруулалт болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд хяналт тавин, тухай бүр шинэчилдэг байна.©
	6	Албан тушаалтан болон төвийн удирдлага, удирдлагын багтай мэдээлэл солилцох, харилцах сувгийг тодорхойлсон байна.

Шалгуур 7.2 Төвийн даргыг холбогдох хууль тогтоомжийн дагуу томилно.

Агуулга

Төв нь хууль тогтоомжийн дагуу томилогдсон гүйцэтгэх удирдлага, орлох албан тушаалтныг томилсон байна. Дарга нь албан тушаалын тодорхойлолтод заасны дагуу эрүүл мэндийн удирдлагын чиглэлээр сургалтад хамрагдсан, ажлын туршлагатай байна. Даргын албан тушаалын тодорхойлолт дараах агуулгатай байна. Үүнд:

- a) Төвийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих
- b) Төвийн үзүүлэх тусламж, үйлчилгээ болон цагийн хуваарийг олон нийтэд ил тод, үнэн зөв мэдээлэх
- c) Төвийн хэмжээнд мөрдөх дүрэм, журмыг боловсруулахад ажилтнуудын оролцоог хангах, хэрэгжүүлэн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх
- d) Хүний нөөц, санхүү болон материаллаг нөөцийг хуваарилах, удирдах

- e) Төвийн жилийн үйл ажиллагааг үнэлэх
- f) Холбогдох дээд шатны байгууллага, ялангуяа магадлан итгэмжлэлийн байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлэх
- g) Гүйцэтгэлийг сайжруулах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг удирдах хангалттай нөөц бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- h) Төвийн нэгж хооронд болон бусад байгууллагатай хамтран ажиллах үйл ажиллагааг зохицуулах
- i) Хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг дээд шатны албан тушаалтанд тайлагнах

Дэвшүүлсэн зорилгод хүрэх нь хамтын ажиллагаа болон ажилтны идэвх, оролцооноос шууд хамаардаг. Үүнд мэдлэг, туршлагыг бусадтай хуваалцах, шийдвэр гаргахад төвийн ажилтныг татан оролцуулах зэрэг болно. Зөв шийдвэр гаргахад туслах зорилгоор чиглэл бүрийн багийг томилон ажиллуулж болно. Баг бүрт олон мэргэжлийн оролцоог хангаж, уулзалт, хурлыг тогтмол зохион байгуулах нь бүтээмжийг нэмэгдүүлнэ.

Үнэлгээ хийх чиглэл:

- Төвийн даргын албан тушаалын тодорхойлолттой танилцана.
- Ажилтнуудын хувийн хэрэгтэй танилцаж, албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжил, ажлын туршлагад тавих шаардлагад нийцэж буй эсэхийг үнэлнэ.
- Төвийн нэгж, багийн чиг үүргийг баталсан даргын тушаалыг хянаж үзнэ.
- Төвийн даргатай ярилцаж, үүрэг, хариуцлага, тулгамдаж буй асуудал, цаашдын чиг хандлагыг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Холбогдох хууль, тогтоомжийн дагуу төвийн даргыг томилсон байна. ⑥
	2	Даргын албан тушаалын тодорхойлолтод агуулгад дурдсан (a-i заалт) чиг үүргийг тусгасан байна. ⑥
	3	Дарга нь албан тушаалын тодорхойлолтын шаардлагад нийцсэн мэргэжил, ажлын туршлагатай байна. ⑥
	4	Төвийн үйл ажиллагаа, уялдаа холбоог хангахад тодорхой эрх, үүрэг бүхий багуудыг томилно. Багийн хурлын тэмдэглэлийг хөтөлж, үйл ажиллагааг хянаж, үнэлдэг байна. ⑥
	5	Тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой тайланг жил бүр удирдах дээд шатны албан тушаалтанд хүргүүлдэг байна.
	6	Шаардлагатай тохиолдолд төвийн даргын хэрэгжүүлэх зарим чиг үүргийг шилжүүлдэг байна.

Шалгуур 7.3

Төв нь эмнэлзүйн засаглалын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Агуулга

Эмнэлзүйн засаглал гэдэг нь эмнэлзүйн үр дүн, эрсдэлийн удирдлага, үйлчлүүлэгч/өвчтөний оролцоо, харилцаа, эмнэлзүйн аудит болон эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй хөгжилд тулгуурлан тусламж, үйлчилгээний чанарыг

сайжруулах, эмнэлзүйн заавар, удирдамж, стандартын мөрдөлтийг хангахад чиглэсэн тогтолцоо юм.

Эмнэлзүйн аудит гэдэг нь тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу тусламж, үйлчилгээний явцыг тогтмол хянах замаар эмчилгээ, үйлчилгээ, түүний үр дүнг сайжруулах үйл явц юм.

Эмнэлзүйн засаглал гэдэг ойлголтод эмч, эмнэлгийн мэргэжилтэн бүр тусламж, үйлчилгээний аюулгүй байдал, чанар, үр дүнд хариуцлага хүлээж буйг ухамсарлах явдал хамаарна.

Төв нь эмнэлзүйн засаглалын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Энэ нь дархлаажуулалт, архаг өвчний урьдчилан сэргийлэлт, эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, тогтвортой байдлыг хангах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг дэмжих зорилготой.

Төв нь эмнэлзүйн засаглалыг хэрэгжүүлэх, хянах чиг үүрэг бүхий мэргэшсэн ажилтныг томилно.

Эмнэлзүйн засаглалын хөтөлбөр нь дараах агуулгатай байна. Үүнд:

1. Эмнэлзүйн аудит: стандарт, бодит гүйцэтгэлийн зөрүүг хянах
2. Эрсдэлийн удирдлага: алдаа, эрсдэлээс сэргийлэх, бүртгэх
3. Эмнэлзүйн үр ашиг: нотолгоонд суурилсан удирдамж ашиглах
4. Сургалт, хөгжил: ажилтны мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх
5. Өвчтөний оролцоо: үйлчлүүлэгчийн санал хүсэлт, сэтгэл ханамжийг тусгах
6. Мэдээллийн менежмент: өгөгдөл мэдээлэлд суурилж шийдвэр гаргах
7. Ажилтны зохион байгуулалт: мэргэшсэн хүний нөөц, аюулгүй орчныг бүрдүүлэх

Төв нь эмнэлзүйн засаглалын хэрэгжилтийн тайланг удирдах дээд шатны албан тушаалтанд сар бүр хүргүүлнэ.

Үнэлгээ хийх чиглэл:

- Эмнэлзүйн засаглалын хөтөлбөртэй танилцана. ⑥
- Эмнэлзүйн засаглалын хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцсан ажилтан болон эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй ярилцаж, хөтөлбөрийн талаарх мэдлэгийг шалгана.
- Тусламж, үйлчилгээ нь батлагдсан эмнэлзүйн заавар, удирдамжид нийцэж байгаа эсэхийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь агуулгад тусгасан (a-f заалт) агуулга бүхий эмнэлзүйн засаглалын хөтөлбөртэй байна. ⑥
	2	Хөтөлбөрийг хянах чиг үүрэг бүхий мэргэшсэн ажилтныг томилсон байна.
	3	Эмнэлгийн мэргэжилтнүүд хөтөлбөрийн талаар мэдлэгтэй байна.
	4	Эмнэлзүйн тусламж, үйлчилгээний тайланг удирдах дээд шатны албан тушаалтанд улирал тутам хүргүүлдэг байна.

5	Эмнэлзүйн тусламж, үйлчилгээг батлагдсан заавар, удирдамжийн дагуу үзүүлдэг байна.
6	Эмнэлзүйн засаглалын хөтөлбөрийг жил бүр үнэлж, шинэчилдэг байна.

Шалгуур 7.4

Төвийн удирдлагын үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байна.

Агуулга

Удирдах дээд шатны албан тушаалтан (Засаг дарга) нь тусламж, үйлчилгээтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааны шийдвэр гаргах үүргийг төвийн даргад нь хариуцуулна. Төвийн даргын хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байна. Үүнд:

a) Төвийн бүтцийг тодорхойлох

- I. Төвийн бүтэц, орон тоо, ажилтны албан тушаалын тодорхойлолтыг хамтран боловсруулах
- II. Ажилтныг сургалтад хамруулах нөхцөл, боломжоор хангах, сургалтын хэрэгцээг, тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, сургалтын үр дүнг үнэлэх
- III. Шаардлагатай журам, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах
- IV. Стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тусламж, үйлчилгээний чанар, үр ашгийн нэмэгдүүлэх тоног, төхөөрөмж, хэрэгслээр хангах

b) Өдөрт тутмын үйл ажиллагааг удирдах:

- i. Тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдол, эмнэлгийн алдаа болон гомдлыг мэдээлэх, түүнээс суралцах замаар аюулгүйн соёлыг төлөвшүүлэх; эмч, эмнэлгийн мэргэжилтэн тохиолдлыг айдасгүй мэдээлэх боломжоор хангах, мэдээлсэн ажилтны нэрийг нууцлах, мэдээллийг тусламж, үйлчилгээг сайжруулахад ашигладаг байх
- ii. Тусламж үйлчилгээний тасралтгүй байдал, уялдаа холбоог сайжруулах, эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх
- iii. Холбогдох дүрэм, дүрэм журмын дагуу тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангах

c) Хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийх:

- i. Чанарын хяналтыг тогтмол хийж, шаардлагатай тохиолдолд сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж буйг хянах
- ii. Барилга байгууламжийн хяналт, шалгалтын зөвлөмж, шаардлагыг биелүүлэх
- iii. Төлөвлөсөн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн хэрэгцээг тодорхойлох, хангах
- iv. Тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдол, эмнэлгийн алдаа, эрсдэлийн мэдээллийг удирдах шатны албан тушаалтан, холбогдох байгууллагад мэдээлэх аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, төвийн статистик үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргахад ашигладаг байх

d) Тусламж, үйлчилгээг тасралтгүй сайжруулах

Үнэлгээний хийх чиглэл:

Төвийн даргатай ярилцаж, түүний үүрэг хариуцлагын талаар үнэлнэ.

Даргын албан тушаалын тодорхойлолтыг үзэж үнэлнэ.		
Хэмжих үзүүлэлт	1	Төвийн даргын албан тушаалын тодорхойлолтод түүнд тавигдах шаардлага (мэргэжил), үүрэг, хариуцлагыг тусгасан байна.
	2	Дарга нь агуулгад тусгасан (a-d заалт) үүрэгтэй.©
	3	Дарга нь өөрийн үүрэг хариуцлагыг мэддэг, хэрэгжүүлдэг байна.
	4	Дарга нь сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд биечлэн оролцоно.
	5	Дарга нь төвийн аюулгүй байдлын тойрон үзлэгт оролцож, тусламж, үйлчилгээтэй холбоотой тохиолдол, эрсдэлийг мэдээлэх үйл ажиллагааг дэмждэг байна.
	6	Дарга нь тусламж, үйлчилгээний чанар болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах санаа санаачилга, үйл ажиллагааг дэмжин, үр дүнг хянадаг байна.©

Шалгуур 7.5

Стратеги төлөвлөгөөг дээд шатны удирдах албан тушаалтны хяналт, зааварчилгааны дагуу боловсруулсан байна.

Агуулга

Стратеги төлөвлөлт гэдэг нь байгууллагын алсын хараа, эрхэм зорилгод хүрэхийн тулд урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, стратегийн томоохон зорилтуудыг тодорхойлох үйлц явц юм.

Стратеги төлөвлөгөө нь урт хугацааг хамардаг ба байгууллагын одоогийн нөхцөл, байдал, удирдлагын багийн хүрэхийг зорьж буй цэг, түүнд хүрэх арга зам болон зорилгод хүрсэн гэдгийг хэрхэн мэдэх зэргийг тодорхойлно. Мөн оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг, оролцоог тодорхой болгоно. Оролцогч талын идэвх чармайлт, тууштай байдлыг хангах үүднээс төлөвлөгөө боловсруулах явцад тэднийг татан оролцуулах нь нэн чухал юм.

Стратеги төлөвлөгөөг төвийн даргын оролцоотойгоор удирдах дээд шатны албан тушаалтан боловсруулж болдог.

Үнэлгээ хийх чиглэл:

- Стратеги төлөвлөгөөг үзэж, үнэлнэ.
- Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний тайланг үнэлнэ.
- Удирдлагын багтай ярилцлага хийж, стратеги төлөвлөгөө боловсруулах болон хэрэгжилтэд хяналт тавих үйл явцад тэдний оролцоог үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Тодорхой зорилго, зорилт бүхий стратеги төлөвлөгөөтэй байна.©
	2	Төлөвлөгөөг төвийн ажилтан, удирдлагын баг болон бусад оролцогч талууд хамтран боловсруулсан байна.
	3	Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүр хянадаг байна.©

Шалгуур 7.6

Стратеги төлөвлөгөөнд тусгасан зорилго, зорилтод хүрэхийн тулд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан байна.

Агуулга

Арга хэмжээний төлөвлөгөө бол байгууллагыг эрхэм зорилгод нь хүргэх үндсэн хэрэгсэл юм. Төлөвлөгөө нь тодорхой цаг хугацаанд зорилтот түвшинд хүрэхийн тулд хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардлагатай нөөцийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг агуулдаг. Төлөвлөгөө нь дараах агуулгатай байна. Үүнд:

- a) Зорилго, зорилт (SMART зорилт)
- b) Хэрэгжүүлэх арга хэмжээ
- c) Хэрэгжүүлэх хугацаа
- d) Хариуцах албан тушаалтан
- e) Шаардлагатай төсөв, түүний эх үүсвэр

Төвийн дарга нь арга хэмжээний төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг жил бүр дүгнэж, давуу болон сул тал, анхаарах асуудал, сургамжийг тодорхойлон, дараагийн төлөвлөлтөд тусгах шаардлагатай.

Үнэлгээ хийх чиглэл:

- Удирдлагын баг, ажилтантай ярилцаж, төлөвлөгөөний талаарх тэдний мэдлэг, төлөвлөгөөг боловсруулахад оруулсан санал зэргийг асууж үнэлнэ.
- Төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, гүйцэтгэлийг сайжруулах арга хэмжээг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь агуулгад тусгасан (a-e заалт) арга хэмжээний төлөвлөгөөтэй байна.©
	2	Ажилтан нь төлөвлөгөөг боловсруулахад оролцсон байна.
	3	Төлөвлөгөөний биелэлтийг улирал тутамд үнэлдэг байна.©
	4	Удирдлагын баг нь төлөвлөгөөний хэрэгжилтийн жилийн эцсийн тайланд үнэлгээ өгч, үр дүнг дараа жилийн төлөвлөгөөнд тусгадаг байна.

Шалгуур 7.7

Бараа материал, нөөцийг холбогдох журмын дагуу хадгалдаг байна.

Агуулга

Төв нь хэсэг хугацааны дараа ашиглах нөөц, бараа материалын бүртгэлийг хөтөлж, агуулахад хадгалж, хамгаална. Бүртгэлийн тогтолцоо нь ямар бараа материалыг хэр хэмжээгээр хадгалах, нөхөн бүрдүүлэх, захиалах тоо хэмжээг тодорхойлох, хянах, зохицуулах дүрэм, журмаас бүрдэнэ.

Нөөцийн хяналт нь ямар өртөгтэй, ямар бараа материалыг, хэр хэмжээгээр, хаана хадгалах, нөөцийг зүй зохистой ашиглах талаар шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой.

Шаардлагатай нөөцийн хомсдол нь төвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй. Бараа материалын хяналт нь нөөцийг үр ашигтай, оновчтой ашиглах, түүний хомсдолоос сэргийлэхэд тусална. Төв нь “шаардлагатай” нөөцийн жагсаалтыг гаргаж, нөөцийг тасралтгүй хангаж ажиллана.

Нөөцийн үр ашигтай удирдлага нь хэрэглэх болон худалдан авах эмнэлгийн хэрэгсэл, бараа материалыг эрэмбийг тогтоохыг шаарддаг. Төв нь дараах агуулга бүхий журам боловсруулан, мөрдөж ажиллана. Үүнд:

- a) Нөөц бүрдүүлэх, хадгалах талаар гарсан хууль тогтоомж, шийдвэртэй нийцсэн байх
- b) Нөөцийг аюулгүй, үр ашигтай удирдах
- c) Бараа материал, нөөцийн удирдлага болон нөөцийн ашиглалтын хяналт
- d) Дараах агуулга бүхий нөөцийн бүртгэлтэй. Үүнд:
 - i. хүлээн авсан огноо
 - ii. цувралын дугаар, хүчинтэй хугацаа
 - iii. Нөөцөд бүртгэх шалгуурыг хангасан эсэх
 - iv. Хэрэглээнд гаргасан эсхүүл устгасан огноо гм

Үнэлгээ хийх чиглэл:

- a) Бараа материал, нөөц болон нөөцийн удирдлага, агуулахтай холбоотой журмыг үзэж үнэлнэ
 - b) .Холбогдох ажилтантай ярилцаж, журмын талаарх мэдлэгийг нь үнэлнэ.
- Нөөц, бараа материалын бүртгэлийг түүвэрлэн хянаж, үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад тусгасан (a-d заалт) утга бүхий нөөцлөх бараа материал, түүнийг бүртгэх, хадгалах үйл ажиллагааг зохицуулсан журамтай байна.©
	2	Бараа материал, нөөцийн бүртгэл (агуулгын i-iv заалт)-тэй байна.©
	3	Бүрдүүлэх бараа материал, нөөцийн хэмжээ, худалдан авалт хийх хугацаа гм-ийг хянах тогтолцоог бүрдүүлсэн байна.
	4	Нэн чухал “шаардлагатай” нөөц, бараа материалын жагсаалтыг гаргаж, тасралтгүй хангасан байна.©

Шалгуур 7.8

Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээг сонгох, гэрээний хэрэгжилтийг үнэлэх, тасралтгүй хянах үйл явцыг бүрдүүлсэн байна.

Агуулга

Төв нь гэрээгээр гүйцэтгүүлэх эмнэлзүйн болон эмнэлзүйн бус (жишээлбэл: тээвэрлэлт, цэвэрлэгээ, угаалга, ариутгал, угаалга болон бусад) ажил, үйлчилгээний төрөл болон хүрээг тодорхойлно. Холбогдох нэгжийн удирдлага нь гэрээгээр нийлүүлж буй ажил, үйлчилгээ байгаль орчин болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, чанарын болон холбогдох стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг үнэлэх, тасралтгүй хянах үйл явцад оролцоно.

Төв нь гэрээт ажилтны мэргэжил, ур чадвар, мэргэжлийн тусгай зөвшөөрөл, ур чадварыг тасралтгүй сайжруулж буй эсэхэд анхаарал хандуулах шаардлагатай.

Гэрээт ажил, үйлчилгээг жил бүр гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (KPI)-ээр хянаж, гэрээг сунгах, цуцлах эсэхийг шийдвэрлэнэ.

Үнэлгээ хийх чиглэл:

- Ажил, үйлчилгээ нийлүүлэх гэрээ, гэрээтэй холбоотой бусад бичиг баримтыг хянаж үнэлнэ.
- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ тус бүрийг сонгох шалгуурыг үзэж, үнэлнэ.
- Гэрээний хэрэгжилтийг хянаж, үнэлсэн талаарх нотлох баримттай танилцаж үнэлнэ.
- Холбогдох нэгжийн удирдлага, ажилтантай ярилцаж, гэрээний хэрэгжилт, хяналт, үнэлгээ болон сунгах үйл явцын талаар асууж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээг сонгох, гэрээний хэрэгжилтийг үнэлэх, тасралтгүй хянах журамтай байна.®
	2	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний жагсаалттай байна.
	3	Нэгжийн удирдлага нь гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээг сонгох, гэрээний хэрэгжилтийг үнэлэх, хянах үйл явцад оролцдог байна.
	4	Жил бүр гэрээний хэрэгжилтийг үнэлж, сунгадаг эсвэл цуцалдаг байна.

Шалгуур 7.9

Ажлын байрны эерэг соёлыг бүрдүүлсэн байна.

Агуулга

Эмнэлгийн мэргэжилтэнд ажлын аюулгүй, тав тухтай орчныг бүрдүүлэх нь чухал байдаг. Төв нь ажлын байрны эерэг соёлыг төлөвшүүлэх зорилгоор дараах агуулга бүхий журамтай байна. Үүнд:

- a) Цэвэр, аюулгүй, хамгаалалттай ажлын байр
- b) Ажлын байрны хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт болон дарамт шахалтыг зохицуулах
- c) Ажилтан болон удирдлага хоорондын харилцааны сувгууд
- d) Ажилтны санал хүсэлт (тусламж, үйлчилгээг сайжруулах тухай)-ийг хүлээн авах
- e) Ажилтны хөгжил, дэвшил

Үнэлгээ хийх чиглэл:

- Ажлын байрны эерэг соёлыг бүрдүүлэх тухай журмыг хянан үзнэ.
- Ажлын байран дахь соёлын талаар ажилтнаас асууж тодруулж, ярилцах замаар үнэлнэ. Мөн ажлын байрыг ажиглаж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Ажлын байрны эерэг соёлыг бүрдүүлэх тухай журам (агуулгын а - е заалт)-тай байна.©
	2	Ажлын байр нь цэвэр, аюулгүй, хамгаалалттай байна.
	3	Ажлын байрны хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, дарамт шахалтын эсрэг арга хэмжээг хэрэгжүүлдэг.
	4	Ажилтан болон удирдлага хооронд харилцах сувгийг тодорхойлсон байна.
	5	Ажилтны санал хүсэлтийг хүлээн авч, сэтгэл ханамжийг үнэлдэг байна.©

Шалгуур 7.10

Ажилчдын амрах өрөөтэй байна.

Агуулга

Гар угаах, хувцас солих, амрах, хооллох, унтах зориулалттай ажилчдын амралтын өрөөтэй байна. Ажилтныг тав тухтай, хэрэгцээнд нийцсэн амрах өрөөгөөр хангах нь тэдний ажлын эрч хүч, бүтээмжийг нэмэгдүүлэх, тогтвортой ажиллуулахад чухал юм. Амрах өрөө нь агааржуулалт сайтай, гэрэлтүүлэгтэй, цэвэрхэн, зай талбай ихтэй, аюулгүй байх ёстой.

Үнэлгээ хийх чиглэл:

- Амрах өрөөг үзэж, агааржуулалт сайтай, ажилтны аюулгүй байдлыг хангасан эсэхийг биечлэн үзэж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Амрах өрөө нь агааржуулалт сайтай, гэрэлтүүлэгтэй, цэвэр байна.
	2	Амрах өрөө давчуу биш, зай талбай хангалттай байна.
	3	Амрах өрөөнд гадны хүн нэвтрэх боломжгүй байна.

Шалгуур 7.11

Ажилтны эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг холбогдох хууль, журмын дагуу жил бүр үнэлдэг байна.

Агуулга

Төв нь ажилтны аюулгүй байдлыг хангах үүднээс ажлын байрны онцлогт тохирсон эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн зорилго нь ажлын байр тус бүрт үүсч болох аюул, эрсдэлийг илрүүлэн, үнэлж, түүний хор уршгийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино. Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг төвийн бүх ажилтны оролцоотойгоор хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн агуулга:

- a) Ажилд орохын өмнө ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байх
- b) Ажилтныг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах
- c) Ажилтанд халдвар авах эрсдэл болон дархлаа тогтоцын шинжилгээ хийх
- d) Ажлын байрны аюул, эрсдэлээс хамгаалах, удирдах:
 - i. Өвчтөн, багаж, тоног төхөөрөмж өргөх, зөөх, нэгэн төрлийн хөдөлгөөнийг давтамжтайгаар хийх, буруу суух зэргээс үүсэх ажлын байрны хүчин зүйлтэй холбоотой эрсдэл
 - ii. Гэрэлтүүлэг, чимээ, шуугиан, агааржуулалт, цахилгаан зэрэг физикийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэл
 - iii. Цус болон агаар дуслын замаар дамжих халдвар зэрэг биологийн эрсдэл
- e) Ажлын байр болон ажил, үүрэгтэй холбоотой эрсдэлийн талаар эмнэлгийн ажилтанг сургалтад хамруулах
- f) Эрүүл мэндийг дэмжих уриалгыг нэвтрүүлэх (тамхинаас гарах, дасгал хөдөлгөөн хийх)
- g) Ажилтныг товллын болон шаардлагатай дархлаажуулалтад тогтмол хамруулах
- h) Ажилтны осол, гэмтэл, өвчлөлийг бүртгэн, шалтгааныг арилгах, давтан гарахаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
- i) Ажил, үүргийг аюулгүй гүйцэтгэх боломжийг хангах үүднээс ажилтныг эрүүл мэндийн нарийвчилсан үзлэг, шинжилгээнд тогтмол хамруулна. Ажилтан хортой бодисын нөлөөлөлд өртсөн бол тохирсон үзлэг, шинжилгээг хийнэ. Үзлэг, шинжилгээний хариу, дүгнэлтийг ажилтны эрүүл мэндийн хуудас/дэвтэрт тэмдэглэн, ажилтанд зөвлөгөө өгөх ба шаардлагатай эмчилгээнд хамруулна.
- j) Халдвар тарах эрсдэл өндөр байдаг тул эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд халдварын сэргийлэлт, хяналтын ажилтанг оролцуулна.
- к) Ажилтны эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний хариу, дархлаажуулалт, ажлын байрны осол, гэмтэл г.м-ийг бүртгэж баримтжуулан, хууль журмын дагуу хадгална.

Үнэлгээ хийх чиглэл:

- Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцсон ажилтантай ярилцаж, хөтөлбөрийн агуулга, ажлын байрны эрсдэл, ажилтанд өгсөн зааварчилгаа, сургалтын бүртгэлийг үзэж үнэлнэ.
- Ажилтн
- ы эрүүл мэндийн хуудас/дэвтрийг үзэж, үзлэг, шинжилгээ, заавар зөвлөгөөний талаарх баримтжуулалтыг үзэж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	Холбогдох хууль, журмын дагуу ажилтны эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр (агуулгын а-к заалт)-ийг хэрэгжүүлнэ.©
	Ажлын байрны эрсдэлийн үнэлгээг хийсэн байна.©

	Ажилтан нь ажлын байр болон ажлын чиг үүрэгтэй холбоотой үүсэх эрсдэл, түүнээс сэргийлэх талаар сургалтад хамрагдаж, эрүүл мэндийг дэмжих санаа, санаачилга, эрүүл мэндийн тогтмол үзлэгийн талаар мэдлэгтэй байна.
	Ажилтан бүр дархлаажуулалтын хөтөлбөрт хамрагдана. Холбогдох дүрэм, журмын дагуу ажилтанд тавих эрүүл мэндийн шаардлагыг мөрдөж ажиллана. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний хариу болон дархлаажуулалтын талаарх мэдээллийг ажилтны эрүүл мэндийн дэвтэр/ хуудасд бүртгэсэн байна.
	Ажлын байртай холбоотой эрсдэлд өртсөний дараах шаардлагатай арга хэмжээ болон эмчилгээг хийж, баримтжуулсан байна.
	Үзлэг, шинжилгээгээр ямар нэгэн өөрчлөлт илэрсэн тохиолдолд ажилтанд мэдэгдэж, хэрэгжүүлсэн арга хэмжээг баримтжуулсан байна.

БҮЛЭГ 8. ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ

Тойм

Байгууллагын хөгжлийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, тусламж, үйлчилгээний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн чадварлаг, мэргэшсэн, идэвх санаачилга бүхий ёс зүй, зөв хандлага, ур чадварыг үнэлэх замаар хүний нөөцийг бүрдүүлнэ.

Энэхүү бодлогын хүрээнд хүний нөөцийг төлөвлөх, судлах, сонгох, томилох, сэлгэн болон шилжүүлэн ажиллуулах, албан тушаалын үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, албан тушаал дэвшүүлэх, бууруулах, албанаас чөлөөлөх, халах, тэтгэвэрт гаргах, шийдвэрийг танилцуулах, ажил хүлээлцэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Байгууллагын алсын хараа, стратеги, үйл ажиллагааны зорилгоо хэрэгжүүлэхэд шаардагдах албан тушаал, ажилтны тоо, мэргэшсэн байдал зэргийг тусгасан үр дүнтэй хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллана.

Албан тушаалын тодорхойлолт гэж тухайн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын тусгай шаардлагыг баталгаажуулсан баримт бичгийг ойлгоно.

Энэхүү бүлэгт эмнэлгийн удирдлага нь хууль тогтоомж, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг дараах чиглэлээр тодорхойлно. Үүнд: эмч, эмнэлгийн мэргэжилтний бичиг баримтын баталгаажуулалт, багц цагийн тасралтгүй сургалт, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, дүрэм, журмын мөрдөлт, байгууллагын тасаг, орон тооны бус зөвлөл, нэгжийн үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах, гүйцэтгэлийг үнэлэх сайжруулах зэрэг болно.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандартыг хангахын тулд эмнэлгийн мэргэжилтэн нь тасралтгүй сургалтанд хамрагдаж, мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх шаардлагатай.

Байгууллага нь эмч, эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн чадвараа дээшлүүлэх, тасралтгүй сургалтад хамруулах, ажлын байрны таатай нөхцөлөөр хангах үүрэгтэй. Учир нь хүний нөөц нь байгууллагын үнэт зүйл бөгөөд тогтвортой, амжилттай үйл ажиллагааны үндэс болдог.

Дэлхий даяар эрүүл мэндийн мэргэжилтний дутагдалтай байна. Олон улсад эмнэлзүй болон сувилахуйн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагааг хянах байгууллагууд байдаг бөгөөд эрүүл мэндийн мэргэжилтний гүйцэтгэлийг үнэлэх, зэрэглэл тогтоох чиг хандлага нэмэгдэж байна. Үүнтэй холбоотой олон улсад эрүүл мэндийн тогтолцооны гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн загварыг нэвтрүүлж байна.

Шинжээч нь эрүүл мэндийн хууль дүрэм, байгууллагын эмнэлзүйн болон сувилахуйн дүрэм, журам, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх зорилгоор тасаг/нэгж/багийн удирдлага болон ажилтнуудтай ярилцлага хийх, эрүүл мэндийн ажилтны хувийн хэрэг, баримт бичгийг хянана.

БҮЛГИЙН ЗОРИЛГО

Байгууллага нь хүний нөөцийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог хэрэгжүүлж, хэвшүүлсэн байна. Энэхүү бүлэгт дараах зорилтуудыг тусгасан болно.

1. Хүний нөөцийн үр ашигтай төлөвлөлт.
2. Шинэ ажилтныг чиглүүлэх сургалт, эмнэлзүйн болон эмнэлзүйн бус тасралтгүй сургалтын хөтөлбөртэй байх
3. Стандартад заагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтнээр бүрэн хангагдсан байх
4. Эмч, эмнэлгийн мэргэжилтний гүйцэтгэлийг үнэлэх журамтай байх

Доорх жагсаалтад энэ бүлэгт хамаарах шалгуурыг нэгтгэн харуулав.

8.1	Байгууллагын хүний нөөцийн төлөвлөлт нь стандарт шаардлагад нийцсэн байна.
8.2	Байгууллага нь албан тушаалын тодорхойлолтод албан тушаал бүрийн чиг үүрэг, хариуцлагыг тусгасан байна.
8.3	Удирдлагын оролцоотойгоор хүний нөөцийг байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нээлттэй зарчмаар сонгон шалгаруулах үйл явцыг бүрдүүлсэн байна.
8.4	Байгууллагын эмч, эмнэлгийн ажилтан бүрийн материалыг бүрдүүлж хувийн хэрэг хөтлөнө.
8.5	Байгууллага нь шинэ ажилтныг чиглүүлэх, дадлагажуулах хөтөлбөртэй, шинэ ажилтныг бүрэн хамруулсан байна.
8.6	Тасралтгүй боловсрол, сургалтын хөтөлбөртэй байна
8.7	Ажилтны гүйцэтгэл болон мэргэжлийн чадамжийг тогтмол хугацаанд үнэлдэг байна.
8.8	Эмнэлгийн ажилтнууд нь батлагдсан, хүчинтэй бөгөөд тодорхой заагласан мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй байна.

ШАЛГУУР, АГУУЛГА, ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур 8.1

Байгууллагын хүний нөөцийн төлөвлөлт нь стандарт шаардлагад нийцсэн байна.

Агуулга

Хүний нөөцийн төлөвлөлт гэдэг нь байгууллагын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай бүтэц орон тоогоор хангах үйл явц юм. Үүний хүрээнд албан тушаал, түүнд ажиллах орон тоо, мэргэжлийн зорилго ур чадвар, хөгжих боломж зэрэг мэдээллийг байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөнө.

Хүний нөөцийн төлөвлөлтийг тогтмол хугацаанд хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчилдэг байна. Төвийн удирдлага нь тухайн эрүүл мэндийн төвийн ажлын байранд тавигдах шаардлагыг тодорхойлно.

Байгууллага нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд шаардагдах ажилтны тоо, ур чадварын түвшинг аюулгүй, зохистой хэмжээнд хадгалах ёстой. Төвийн удирдлага хүний нөөцийн хэрэгцээг тооцоолон төлөвлөхдөө дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- a) Байгууллагын эрхэм зорилго, стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө.
- b) Байгууллагаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгч/өвчтөний өвчний байдал, өвчний хүндийн зэрэг
- c) Байгууллагын үзүүлж буй тусламж, үйлчилгээний төрөл, цар хүрээ.
- d) Өвчтөнд тусламж, үйлчилгээ үзүүлэхэд ашиглаж буй технологи, тоног төхөөрөмж.
- e) Ажлын цагийн ачаалал болон ээлж, цагийн хуваарийн онцлог.

Үнэлгээ хийх чиглэл:

1. Байгууллагын хүний нөөцийн төлөвлөгөөг хянаж үнэлнэ.
2. Ажилтны хувийн хэрэг, бичиг баримтын бүрдлэлийг нягтлан үзэж, хүний нөөцийн төлөвлөгөө нь хууль тогтоомж, холбогдох дүрэм журам болон мэргэжлийн үйл ажиллагааны зөвлөмжүүдэд нийцэж байгаа эсэхийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Хүний нөөцийн төлөвлөгөө нь байгууллагын эрхэм зорилго, стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөтэй нийцсэн байна. ⑤
	2	Хүний нөөцийн төлөвлөгөө нь хууль тогтоомж, дүрэм журам болон мэргэжлийн зөвлөмжийг хангасан байна. ⑤
	3	Хүний нөөцийн төлөвлөгөөнд төвийн хэрэгцээг хангахад шаардлагатай эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо, ур чадвар, мэргэшлийг тодорхойлсон байна. ⑤
	4	Хүний нөөцийн төлөвлөгөөг жилд нэг удаа хянан үнэлж, шинэчилдэг байна. ⑤

Шалгуур 8.2

Байгууллага нь албан тушаалын тодорхойлолтод албан тушаал бүрийн чиг үүрэг, хариуцлагыг тусгасан байна.

Агуулга

Албан тушаалын тодорхойлолт нь ажлын байрны чиг үүрэгт үндэслэсэн хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн байна. Тухайн ажлын байрны үүрэг, зорилго, шаардагдах мэдлэг, туршлага, хариуцлага, хэм хэмжээ, ажлын хамрах хүрээ болон хөдөлмөрийн нөхцөлийг ерөнхийд нь тусгасан байна. Албан тушаалын тодорхойлолт нь эмч, эмнэлгийн мэргэжилтэн бүрт заавал (гэрээгээр, цагаар, туршилтын, дадлагажигч, зайнаас) байх шаардлагатай.

Итгэмжлэл (Credentials) гэдэг нь хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаас олгогддог, тодорхой шаардлагыг хангаж дуусгасан эсвэл үйл ажиллагаа эрхлэх эрхтэйг нотлох баримт бичгийг хэлнэ. Үүнд мэргэжлийн диплом, үндсэн мэргэжил болон төрөлжсөн мэргэжил, багц цагийн сургалт, мэргэжлийн холбооны шаардлагыг хангасныг батлах баримт, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл зэрэг орно.

Байгууллага нь ажилтныг ажилд авахдаа мэргэшлийн баримт бичгийг шалган баталгаажуулж, албан тушаалын шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлнэ.

Үнэлгээ хийх чиглэл:

1. Эмч, эмнэлгийн мэргэжилтний хувийн хэргээс гарын үсгээр баталгаажсан албан тушаалын тодорхойлолт болон шаардлагатай тохиолдолд мэргэшлийн баримт бичгүүд байгаа эсэхийг шалгах зорилгоор түүвэрлэн хянаж үнэлнэ.
2. Ажилтантай ярилцаж, албан тушаалын тодорхойлолтын талаар мэдлэг, ойлголттой эсэхийг нягталж үнэлнэ.
3. Төвийн удирдлагатай ярилцаж, стандарт шаардлагыг мөрдөж байгаа эсэхийг үнэлнэ.
4. Ажилтны мэргэшлийн бичиг баримтыг үнэлэхдээ нэг ижил, жигд байдлаар хэрэгжүүлсэн эсэхийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Албан тушаал бүрд албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан байна.©
	2	Албан тушаалын тодорхойлолтод тухайн албан тушаал бүрт тавигдах шаардлага (мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, гэрчилгээ эсвэл бүртгэл, боловсрол, ур чадвар, мэдлэг, туршлага) болон чиг үүрэг, хариуцлагыг тусгасан байна.
	3	Албан тушаалын тодорхойлолтыг ажилтанд танилцуулж, баталгаажсан тодорхойлолтыг ажилтны хувийн хэрэгт баримтжуулсан байна.©
	4	Албан тушаал бүрт шаардагдах мэргэшлийн баримт бичгийг ажилтны хувийн хэрэгт хадгалдаг байна.©

Шалгуур 8.3

Удирдлагын оролцоотойгоор хүний нөөцийг байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нээлттэй зарчмаар сонгон шалгаруулах үйл явцыг бүрдүүлсэн байна.

Агуулга

Ажилтан сонгон шалгаруулах, ажилд авах гэдэг нь ажлын байрны сул орон тоог боломжит сувгаар зарлан нээлттэй сонгон шалгаруулалт явуулан ажлын байранд мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэн ажиллуулахыг хэлнэ. Байгууллага нь сул орон тоонд хүний нөөцийг бүрдүүлэн ажиллуулж, байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, засаглалыг сайжруулахад оршино. Уг үйл явц нь дор дурдсан нийтлэг шаардлагыг хангасан байна.

- а) Ажлын байрны хэрэгцээг тодорхойлох зорилгоор нэгжийн удирдлагатай хамтран ажиллах
- б) Сул орон тооны сонгон шалгаруулалтын зарыг бэлтгэн, нээлттэй, ил тод, ойлгомжтой байдлаар олон нийтэд хүргэх
- в) Сонгон шалгаруулалтын нийтлэг шаардлага, үе шатыг бүрэн тусгана
- г) Өргөдөл, материал хүлээн авах үйл явцыг тодорхойлох
- д) Ажилтан сонгон шалгаруулах, ажилд авах журам, үйл явцыг тодорхойлох

Үнэлгээ хийх чиглэл:

1. Ажилтан сонгон шалгаруулах үйл явцыг байгууллага өөрөө зохион байгуулдаг бол үйл ажиллагааны чиглэл, онцлог, цар хүрээг харгалзан ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах журам байгаа эсэхийг хянана.
2. Байгууллагын бодлого, журамд нийцэж байгаа эсэхийг үнэлэх зорилгоор ажилтны хувийн материалыг түүвэрлэн хянана.
3. Ажилтан сонгон шалгаруулах үйл явцад оролцож буй ажилтантай ярилцлага хийж, уг үйл явцын хэрэгжилтийг үнэлж дүгнэнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (а–е заалт) тусгасан, байгууллагын батлагдсан ажилтан сонгон шалгаруулах бодлого, журамтай байна.®
	2	Ажилтан сонгон шалгаруулах үйл явцад оролцож буй ажилтан нь байгууллагын бодлого, журмыг сайн мэддэг байна.
	3	Ижил төрлийн албан тушаалын ажилтанд хамаарах сонгон шалгаруулах үйл явцыг байгууллагын хэмжээнд нэг стандартын дагуу хэрэгжүүлнэ.
	4	Ажилтан сонгон шалгаруулах үйл явцыг хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн хэрэгжүүлдэг байна.
	5	Байгууллагын удирдлага ажилтан сонгон шалгаруулах үйл явцад оролцдог байна.
	6	Сонгон шалгаруулах шалгуурыг ажилтны хувийн хэрэгт баримтжуулан хадгалсан байна.®

Шалгуур 8.4

Байгууллагын эмч, эмнэлгийн ажилтан бүрийн материалыг бүрдүүлж хувийн хэрэг хөтлөнө.

Агуулга

Байгууллага нь ажилтан бүрд ажилтны хувийн хэрэг хөтлөх нь чухал юм. Үнэн зөв, бүрэн бүрдэл бүхий ажилтны хувийн хэрэг нь тухайн ажилтан ажлын үүргээ гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, чадамж, сургалтын мэдээллийг баримтжуулан хадгалах боломжийг бүрдүүлнэ.

Хувийн хэрэгт бүрдүүлсэн мэдээлэл нь ажилтанг албан тушаалд томилох, шатлан дэвшүүлэх, шагнаж урамшуулах, хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлаар эрх бүхий этгээд шийдвэр гаргахад тулгуурлах үндэслэл, эх сурвалж болно.

Ажилд орсны дараа эмч, эмнэлгийн ажилтан бүрийн материалыг бүрдүүлж, хувийн хэрэг хөтлөн үйл ажиллагааг нь тогтмол үнэлж хянана. Үүнд: тухайн ажилтны мэргэшлийн диплом, эрүүл мэндийн үзлэгийн хуудас, шинэ ажилтны чиглүүлэх сургалт, мэргэшил олгох дээшлүүлэх сургалтанд хамрагдсан нотолгоо, үнэлгээний үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын туршлага зэрэг багтана.

Ажилтны хувийн хэргийг байгууллагын дүрэм, журамд заасны дагуу нэг загвараар хөтөлж, тогтмол шинэчилнэ. Ажилтны хувийн хэрэг нь нууцлалтай, хувийн мэдээлэл агуулж болзошгүй тул нууцлалыг чандлан хадгална.

Байгууллага нь ажилтны хувийн хэргийг удирдан зохицуулах бодлого, журам боловсруулж хэрэгжүүлэх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна.

- a) Ажилтны хувийн хэргийг нээх, эхлүүлэх үйл явц.
- b) Агуулгад багтах шаардлага:
 - i. Боловсрол, сургалт, мэргэжлийн зөвшөөрөл, бүртгэл зэрэг мэргэшлийн талаарх мэдээлэл (шаардлагатай тохиолдолд).
 - ii. Ажлын туршлага, ажилласан түүх.
 - iii. Мэргэшлийн баримт бичгийг үнэлсэн болон анхдагч эх сурвалжаар баталгаажуулсан баримтжуулалт.
 - iv. Одоогийн мөрдөж буй ажлын байрны тодорхойлолт.
 - v. Ажилтныг тухайн албан тушаалын үүргийг гүйцэтгэх чадвартай, сонгон шалгаруулалтын үнэлгээ.
 - vi. Шинээр ажилд орсон ажилтанд олгосон ажлын байртай холбоотой чиглүүлэх сургалтын баримтжуулсан нотолгоо.
 - vii. Тасралтгүй дотоод сургалт болон мэргэжлийн боловсролд хамрагдсан тухай мэдээлэл.
 - viii. Ажилд орсноос хойш 3 сарын дотор хийсэн үнэлгээний хуулбар болон жил бүрийн гүйцэтгэлийн үнэлгээний хуулбарууд
- c) Хувийн хэргийн агуулгыг шинэчлэх журам
- d) Хадгалалт, хамгаалалтын зохицуулалт
- e) Хадгалах хугацаа
- f) Устгах журам

Үнэлгээ хийх чиглэл:

1. Ажилтны хувийн хэрэг хөтлөх байгууллагын бодлого, журмыг хянана.
2. Хувийн хэргийг хөтлөх (бүрдүүлэх, бүрдлийг хянах, баяжуулах, хадгалах, шилжүүлэх, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгалах) үйл ажиллагаанд оролцдог ажилтантай ярилцлага хийж, тэдний мэдлэг, ойлголтыг үнэлнэ.
3. Ажилтны хувийн хэргийн агуулга нэг загварын дагуу бүрдсэн эсэхийг үнэлэх зорилгоор ажилтны хувийн хэргийг түүвэрлэн хянана.
4. Ажилтны хувийн хэрэг хадгалагдаж буй орчныг ажиглаж, хадгалалтын нөхцөл, хадгалах хугацаа, нууцлал болон устгах үйл явцыг үнэлнэ.

1	Агуулгад (а–е заалт) тусгасан байгууллагын батлагдсан ажилтны хувийн хэргийг хөтлөх бодлого, журамтай байна.©
----------	---

Хэмжих үзүүлэлт	2	Ажилтны хувийн хэргийг бүрдүүлэх, хадгалах, ашиглах үйл ажиллагаанд оролцож буй ажилтнууд хувийн хэрэг удирдах бодлого, журмыг сайн мэддэг байна.
	3	Ажилтны хувийн хэргийг хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгалах нууцлалтайгаар хадгалж, хамгаалсан байна.
	4	Ажилтны хувийн хэрэгт зорилгод заасан i)-ээс viii) хүртэлх бүх шаардлагатай баримт бичиг бүрэн багтсан байна.©
	5	Ажилтны хувийн хэргийг устгах үйл ажиллагааг хувийн хэрэг удирдах бодлого, журмын дагуу хэрэгжүүлдэг байна.©

Шалгуур 8.5

Байгууллага нь шинэ ажилтныг чиглүүлэх, дадлагажуулах хөтөлбөртэй, шинэ ажилтныг хамруулсан байна.

Агуулга

Шинээр ажилд орж буй ажилтан нь байгууллагын бүтэц, зорилго, алсын хараа, ажлын арга барилд богино хугацаанд дасан зохицож, бүтээмжтэй ажиллах нь чухал юм. Байгууллага нь тухайн ажилтныг ерөнхий, үйлчилгээний, тусгай чиглүүлэх сургалтанд хамруулна.

Чиглүүлэх сургалт нь шинэ ажилтанд тухайн байгууллагын бүтэц, үйл ажиллагааг танилцуулж, аюулгүй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх үр дүнтэй баг бүрдүүлэхэд тусалдаг. Байгууллага нь хөдөлмөрийн харилцааны хэлбэрээс үл хамааран шинэ ажилтанд зориулсан иж бүрэн чиглүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Ажилтны чиглүүлэх сургалт нь дараах гурван түвшинд явагдана. Үүнд: ерөнхий чиглүүлэх сургалт, үйлчилгээ/нэгжийн чиглүүлэх сургалт, ажлын байрны тусгай чиглүүлэх сургалт.

Ерөнхий чиглүүлэх сургалт нь дараах шаардлагыг хамарсан байна.

- Байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсийн танилцуулна
- Байгууллагын зохион байгуулалтын бүтэцтэй танилцана
- Орчны аюулгүй байдал, халдварын сэргийлэлт хяналт, гүйцэтгэлийг сайжруулахтай холбоотой байгууллагын бодлого, журамтай танилцана
- Өвчтөний аюулгүй байдал болон эрсдэлийн удирдлагатай танилцана
- Ёс зүйн тогтолцоо, ёс зүйн дүрэмтэй танилцана.

Үйлчилгээний чиглүүлэх сургалт нь дараах асуудлуудыг хамарна.

- Холбогдох тусламж үйлчилгээний стандарт, дүрэм журам эмнэлзүйн заавар удирдамжуудтай танилцана.
- Төвийн үйл ажиллагааны явцтай танилцана
- Багийн үйл ажиллагаа, дээд шатны байгууллагын уялдаа холбоотой танилцана

Ажлын байрны тусгай чиглүүлэх сургалт нь дараах асуудлуудыг хамарна.

- Албан тушаалын тодорхойлолтод заасан үүрэг, хариуцлага
- Түгээмэл болон өндөр эрсдэлтэй гардан үйлдлүүд
- Технологи, тоног төхөөрөмжийн ашиглалт.
- Ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал

Төв нь дотоод журмаа шинэ ажилтан бүрд танилцуулна.

Үнэлгээ хийх чиглэл:

<ol style="list-style-type: none"> 1. Ажилтантай ярилцаж, чиглүүлэх сургалтын үйл явцын талаар асууж тодруулж үнэлнэ. 2. Ерөнхий, үйлчилгээний болон тусгай чиглүүлэх сургалтад хамрагдсан баримтыг ажилтнуудын хувийн хэргээс түүвэрлэн хянаж үнэлнэ. 		
Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (a–e заалт) тусгасан чиглүүлэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна.©
	2	Агуулгад (f-h заалт) тусгасан үйлчилгээ/нэгжийн чиглүүлэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна.©
	3	Агуулгад (i-l заалт) тусгасан ажлын байрны тусгай чиглүүлэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна.©
	4	Бүх шинэ ажилтан, шинэ гэрээт ажилтан, чиглүүлэх сургалтад хамрагддаг байна.
	5	Шинэ ажилтны чиглүүлэх хөтөлбөрт хамрагдсан тухай баримтыг хувийн хэрэгт бүрдүүлэн хадгална.©

Шалгуур 8.6

Тасралтгүй сургалтын хөтөлбөртэй байна

Агуулга

Төв нь байгууллагын эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн тулд тусламж, үйлчилгээгээ тасралтгүй хүргэх боломж, бололцоо бүхий хүний нөөцөөр хангагдсан эсэхийг нягтална.

Байгууллагын өөрчлөлт, хөгжил, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, стратеги зорилт, хувь хүний мэдлэг, ур чадварыг үндэслэн хүний нөөцийн тасралтгүй сургалтын хэрэгцээг тодорхойлно. Хөтөлбөрийг тусламж, үйлчилгээний онцлог, шинэ мэдээлэл, ажилтны хэрэгцээнд үндэслэн боловсруулсан байна.

Байгууллага нь сургалтыг ажилтны чиг үүрэг, хэрэгцээнд нийцүүлсэн байна. Энэхүү хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- а) Өвчтөний үнэлгээ
- б) Халдварын сэргийлэлт хяналтын бодлого, журам, эмнэлгийн ажилтан зүүнд хатгуулах, хурц үзүүртэй, иртэй багажинд зүсэгдэх болон халдварын өртөлтөөс урьдчилан сэргийлэх, авах арга хэмжээ
- в) Орчны аюулгүй байдлын төлөвлөгөө
- г) Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэл, аюулгүй ажиллагааны журам, түүний дотор хувийн хамгаалах хэрэгслийг хэрэглэх
- д) Мэдээллийн удирдлага, үүнд ажил үүрэг, албан тушаалын тодорхойлолтод нийцүүлэн өвчтөний эрүүл мэндийн бүртгэлийн шаардлага
- е) Өвдөлтийн үнэлгээ, эмчилгээ
- ж) Байгууллагад мөрдөгдөж буй эмнэлзүйн удирдамж, заавар
- з) Шууд өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлдэг бүх ажилтан хоёр жил тутамд нэг удаа хийх зүрх-уушгины сэхээн амьдруулах (CPR) сургалтад хамрагдах
- и) Чанарын ойлголт, гүйцэтгэлийг сайжруулах, өвчтөний аюулгүй байдал, эрсдэлийн удирдлага
- й) Өвчтөний эрх, өвчтөний сэтгэл ханамж, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл явц
- к) Тусламж үйлчилгээний нэгдмэл байдал, хамтын шийдвэр гаргалт, мэдээлэлд суурилсан зөвшөөрөл, өвчтөн-ажилтан, ажилтан хоорондын харилцаа, мөн үйлчлүүлж буй бүлгүүдийн соёлын үнэт зүйлс, хэрэгцээ, онцлог

- l) Хүчирхийлэл, үл хайхрах
- m) Эмнэлгийн тоног төхөөрөмж болон инженерийн дэд системийн ашиглалт, засвар үйлчилгээ

Үнэлгээ хийх чиглэл:

1. Ажилтантай ярилцлага хийж, тасралтгүй сургалтын үйл явцын талаар тодруулж асууна.
2. Ажилтны хувийн хэргээс түүвэрлэн тасралтгүй сургалтын хөтөлбөрт хамрагдсан талаарх нотолгоо (оролцоо, бүртгэл) байгаа эсэхийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (a-m заалт) тусгасан бүх ажилтныг хамарсан тасралтгүй сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг байна.©
	2	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц болон бусад нөөцөөр (санхүү, сургалтын материал, тоног төхөөрөмж зэрэг) хангагдсан байна.
	3	Сургалтын хөтөлбөр нь бүх ажилтны хэрэгцээнд үндэслэн боловсруулагдсан байна.
	4	Ажилтны гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг сургалтын хөтөлбөрийн төлөвлөлт, загварт тусган хэрэгжүүлсэн байна.

Шалгуур 8.7

Ажилтны гүйцэтгэл болон мэргэжлийн чадамжийг тогтмол хугацаанд үнэлдэг байна.

Агуулга

Ажилтны гүйцэтгэлийн үнэлгээ нь тасралтгүй явагддаг үйл явц юм. Гүйцэтгэлд суурилсан урамшууллын тогтолцоог бүрдүүлэн ажилтны нийгмийн баталгааг хангах замаар үйл ажиллагааг идэвхжүүлж, ажлын бүтээмжийг дээшлүүлэх бодлого баримтална.

Чадамж гэдэг нь ажилтан тухайн албан тушаалын үндсэн үүрэг хариуцлагыг гүйцэтгэх чадвартай эсэхийг тодорхойлох үйл явцыг хэлнэ. Тодорхой, ил тод, албан тушаалын чиг үүрэгт нийцсэн, шалгуурт тулгуурласан гүйцэтгэлийн үнэлгээ нь хувь хүн, баг хамт олныг байгууллагын түвшинд сайжрахад үр дүнтэй хувь нэмэр оруулна.

Гүйцэтгэлийн үнэлгээ нь ажилтан болон удирдлагын хоорондын харилцааг дэмжиж, хүний нөөцийн төлөвлөлт, сонгон шалгаруулалт, урамшуулал, сургалт, боловсрол, ажил мэргэжлийн хөгжлийн талаарх шийдвэрийг нотолгоонд суурилан гаргах боломжийг бүрдүүлдэг. Ажилтанд давуу тал болон сайжруулах шаардлагатай чиглэлийн талаар нууцлалтай, хүндэтгэлтэй байдлаар санал хүсэлт өгөх боломж олгож, суралцахад дэмжлэг үзүүлнэ.

Байгууллага нь ажилтанг ажил үүргээ гүйцэтгэх, зорилтдоо хүрэхэд шаардлагатай шалгуурыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд гүйцэтгэлийн үнэлгээг ашиглана.

Ажилтны гүйцэтгэлийн үнэлгээний үйл явцыг дараах байдлаар баримтжуулна. Үүнд: гүйцэтгэлийн үнэлгээний арга, хэрэглэгдэх хэрэгсэл, үнэлгээний хэмжээс, шалгуур, үнэлгээ хийх давтамж, гомдол гаргах үйл явц, ажилтны ангилал бүрт хариуцсан этгээдийг тодорхойлно.

Эмнэлгийн ажилтны гүйцэтгэлийн үнэлгээнд өвчтөний эмнэлгийн баримт бичиг болон эмийн хэрэглээтэй холбоотой дараах шалгуурыг хамарсан байна. Үүнд:

- a) Өвчтөний эмнэлгийн түүх, баримт бичгийн бүрэн гүйцэд байдал, цаг хугацаандаа хөтлөгдсөн эсэх
- b) Эмийн зохистой хэрэглээ
- c) Батлагдсан эмнэлзүйн удирдамжийг мөрдөж буй байдал
- d) Эмчилгээний хүндрэл, тусламж үйлчилгээний үр дүн, нас баралт, өвчлөлийн тоо
- e) Мэргэжлийн хувьд тасралтгүй сургалтад хамрагдсан байдал

Үнэлгээ хийх чиглэл:

1. Төвийн удирдлагатай ярилцлага хийж, ажилтны гүйцэтгэлийн үнэлгээнд ашиглаж буй хэрэгсэл, аргачлалын талаар асууж тодруулна.
2. Гүйцэтгэл болон чадамжийн үнэлгээ бүрэн хийгдсэн эсэхийг шалгах зорилгоор ажилтны хувийн хэргээс түүвэрлэн хянана.

Хэмжих үзүүлэлт	1	Ажилтан бүрийн гүйцэтгэл болон чадамжийн үнэлгээг улирал тутамд хийдэг байна.©
	2	Гүйцэтгэл болон чадамжийн үнэлгээг ажлын байрны тодорхойлолтод үндэслэн хийж, үр дүнг ажилтны хувийн хэрэгт хадгалдаг байна.©
	3	Гүйцэтгэл болон чадамжийн үнэлгээтэй холбоотойгоор ажилтнаас авсан санал хүсэлт, хариу өгсөн нотолгоо байна.©
	4	Гүйцэтгэл хангалтгүй байгаа тохиолдлыг үр дүнтэй удирдах тодорхой, ойлгомжтой журам хэрэгждэг байна.
	5	Эмнэлгийн ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний баримт бичигт зорилгын а)-аас е) хүртэлх бүх шаардлагыг хамарсан байна.©

Шалгуур 8.8

Эмнэлгийн ажилтан нь батлагдсан, хүчинтэй бөгөөд тодорхой заагласан мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй байна.

Агуулга

"Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл" гэж хүний их эмч, уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмч, эх баригч, эм зүйч, эм найруулагч, сувилагч мэргэжлээр ажиллахыг баталгаажуулсан баримт юм.

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь тухайн мэргэжилтэн **ямар оношилгоо, эмчилгээ, үйлчилгээг гүйцэтгэх эрхтэйг** нарийвчлан тогтоохыг хэлнэ.

Энэ үйл явц нь эрүүл мэндийн ажилтан өөрийн боловсрол, сургалт, туршлага, чадамжид нийцсэн ажиллах нөхцөлийг бүрдүүлж, үйлчлүүлэгч/өвчтөний аюулгүй байдлыг хангах, тусламж үйлчилгээний стандартыг хадгалахад чиглэгддэг.

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл тогтмол хугацаанд хянаж, шинэчилж байх нь анагаах ухааны салбарын хөгжил болон ажилтны чадамжтай нийцүүлэхэд зайлшгүй шаардлагатай. Уг бодлого нь дор дурдсан шаардлагыг тусгасан байна. Үүнд:

- a) Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий эмнэлгийн мэргэжилтэн нь байгууллагын дүрэм, журманд захирагдана.
- b) Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь тухайн эмнэлгийн ажилтан өвчтөнд тусламж, үйлчилгээ үзүүлэх эрхтэй эсэхийг тодорхой заасан байна.
- c) Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий мэргэжилтний үзүүлэх тусламж, үйлчилгээний хүрээ болон гүйцэтгэх боломжтой үйл ажиллагааг тодорхойлсон байна.
- d) Эмчлэх, сувилах, эм барих, эх барих үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь туршлага, боловсрол, мэргэшил, гэрчилгээ, ур чадвар зэрэг чадамжийг нотолсон баримт бичиг бөгөөд хүчин төгөлдөр бүхий байна.
- e) Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь эмнэлгийн ажилтан тухайн үйлчилгээг үзүүлж буй төвд хэрэгжих боломжтой байна.
- f) Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн ажилтнууд нь өөрсдөд олгогдсон эрхийн хүрээнээс хэтрүүлэн ажиллахгүй байна.

Үнэлгээ хийх чиглэл:

1. Мэргэжлийн үйл ажиллагааны зөвшөөрлийг шалгана.
2. Байгууллагын ажилтантай ярилцлага хийж, клиник эрх олголтын бодлого, журмын талаарх тэдний мэдлэг, ойлголтыг нягтална.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад (a-f заалт) тусгасан байгууллагын батлагдсан бодлого, журамтай байна.©
	2	Эмчлэх эрх бүхий их эмч нарын хувийн хэрэгт мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, шаардлагатай тохиолдолд сунгалтын мэдээллийг бүрэн хадгалсан байна.

БҮЛЭГ 9. ЧАНАР БА ГҮЙЦЭТГЭЛИЙН САЙЖРУУЛАЛТ

Тойм

Байгууллага нь тасралтгүй сайжруулалт болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг дэмжих тогтолцоотой байх шаардлагатай. Энэхүү тогтолцоо нь удирдлагын дэмжлэг, тогтвортой үйл явц, удирдлага болон ажилтан бүрийн идэвхтэй оролцоонд тулгуурлана. Гүйцэтгэлийн сайжруулалт ба эрсдэлийн удирдлага нь байгууллагын стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсэг юм.

Төв нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах соёлыг төлөвшүүлэх ёстой.

Өвчтөний аюулгүй байдал, эрсдэлийн удирдлага, гүйцэтгэлийг сайжруулахад олон талт оролцоог хангасан хүчирхэг тогтолцоог бий болгох шаардлагатай байдаг.

Чанар сайжруулах төлөвлөгөө, үр дүнтэй эрсдэлийн удирдлага, тохиолдол мэдээлэх тогтолцоо, ноцтой тохиолдлын менежмент зэрэг нь энэхүү тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсгүүд юм. Эдгээр нь байгууллагын үйл ажиллагаанд сайжруулах шаардлагатай үзүүлэлтийг системтэйгээр тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлснээр өвчтөнд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар болон ажилтнуудын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн тасралтгүй сайжруулалтын хандлагыг төлөвшүүлнэ.

Төв нь гүйцэтгэлийг тасралтгүй хянах, эрсдэлийг удирдах зэрэг арга хэмжээг уялдуулан хэрэгжүүлснээр чанартай тусламж, үйлчилгээг тогтвортой хадгалах боломжтой болно.

Өвчтөний урсгал болон нөөцийн ашиглалтыг онцгойлон анхаарч удирдах нь тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах чухал нөхцөл болдог.

Төвийн ажилтан бүр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахад өөрийн үүрэг, оролцоог сайн мэддэг, яагаад чухал вэ гэдгийг ойлгож оролцдог байх хэрэгтэй. Үүнд: удирдлагын дэмжлэг, тасаг/нэгжийн оролцоо, тоон мэдээ, мэдээллийг цуглуулах, тасралтгүй сайжруулалт хийх зэрэг асуудлууд багтана. Эдгээр шалгуурын хэрэгжилт нь холбогдох эрх зүйн зохицуулалтын шаардлагад бүрэн нийцсэн байх ёстой.

Төвийн чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дараах зорилтуудыг тусгана. Үүнд:

1. Удирдлагын үр дүнтэй дэмжлэг
2. Тасаг/нэгж, ажилтны идэвхтэй оролцоо
3. Тоон мэдээ, мэдээллийн менежмент, гүйцэтгэлийн үр дүнг хэмжих
4. Үр дүнтэй, тасралтгүй сайжруулалт

Доорх жагсаалтад энэ бүлэгт хамаарах шалгуурыг нэгтгэн харуулав.

9.1	Төвийн удирдлага нь байгууллагын хэмжээнд хэрэгжих чанар ба өвчтөний аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг боловсруулж баримтжуулан, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийдэг.
9.2	Төв нь үндсэн үйл ажиллагаанд ач холбогдол бүхий гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, тэдгээрийг системтэйгээр хянаж, хэмжиж, явцын болон гүйцэтгэлийн хяналт-үнэлгээ хийдэг байна.

9.3	Төв нь статистик мэдээллийг нэгтгэх болон дүн шинжилгээг тогтсон хугацаанд хийх зохих туршлага, мэдлэг, ур чадвартай ажилтныг албан ёсоор томилсон байна.
9.4	Статистик мэдээллийн баталгаажуулалтыг (data validation) урьдчилан тодорхойлсон шалгуурын дагуу гүйцэтгэдэг байна.
9.5	Төв нь эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө / хөтөлбөрийг боловсруулсан байна.
9.6	Төв нь тохиолдол мэдээлэх тогтолцоог (incident-reporting system) боловсруулсан байна.
9.7	Төв нь ноцтой тохиолдлыг тодорхойлж, шалгаж, дүн шинжилгээ хийж, тайлагнан, хор уршгийг арилгах болон дахин давтагдахаас сэргийлэх засах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.
9.8	Төв нь батлагдсан хугацааны хүрээнд тогтвортой, тасралтгүй сайжруулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

ШАЛГУУР, ЗОРИЛГО, ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур 9.1

Төвийн удирдлага нь байгууллагын хэмжээнд хэрэгжих чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг боловсруулан, баримтжуулж, хэрэгжилтийг, хянаж үнэлдэг байна.

Агуулга

Байгууллага нь тасралтгүй сайжруулалт болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг дэмжих тогтолцоог бүрдүүлэх ёстой. Энэхүү тогтолцоо нь удирдлагын дэмжлэг, тогтвортой үйл явц, удирдлага болон ажилтны идэвхтэй оролцоонд тулгуурлана.

Төвийн удирдлага нь үзүүлж буй тусламж, үйлчилгээний нэр төрөл, тулгамдаж буй асуудал, хамрах хүрээнд нийцүүлэн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, өвчтөний аюулгүй байдлыг хангах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зэргийг багтаасан цогц төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.

Төлөвлөгөөнд дараах агуулгыг тусгана. Үүнд:

- a) Төвийн эрхэм зорилгыг хангахад чиглэсэн төлөвлөгөөний зорилго, зорилт
- b) Чанар сайжруулах үйл ажиллагааг хариуцах ажилтанг тодорхойлох
- c) Тоон мэдээ, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх арга хэрэгсэл болон баталгаажуулалтын үйл явц;
- d) Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг эрэмбэлэн сонгох
- e) Чанар сайжруулах арга, хэрэгслийг ашиглах
- f) Мэдээллийн урсгал болон тайлагнах давтамж;
- g) Чанар сайжруулах болон эрсдэлийн удирдлагын сургалт;
- h) Төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хугацаанд үнэлэх

Төвийн удирдлага нь чанар, аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах, хянах үүрэг бүхий ЭМТҮЧАБ-ын чанарын багийн гишүүдийг томилж, тэднийг дэмжиж ажиллана.

ЭМТҮЧАБ-ын баг нь удирдлага болон эмч, ажилтныг шаардлагатай бүх мэдээллээр хангана.

Баг нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын үр нөлөө, үр ашиг, зохистой байдалд тогтмол хяналт тавьж, тохиолдол, эрсдлийг удирдлагад танилцуулж, хариу арга хэмжээг цаг алдахгүй авах шийдвэр гаргуулж ажиллана.

Баг нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж, байгууллагын чанарын соёлыг төлөвшүүлнэ. Үүнд:

1. Чанар сайжруулах үйл ажиллагаанд тусламж, үйлчилгээний нэгж бүрийн оролцоог хангах
2. Тоон мэдээлэл, өгөгдөлийг цаг хугацаандаа цуглуулах, шалгуур үзүүлэлтийн үр дүнд үнэлгээ хийж, хянаж байгаа эсэх
3. Тусламж, үйлчилгээтэй холбоотой тохиолдолд шалтгаан хамаарлын дүн шинжилгээ хийж, дахин давтагдахаас сэргийлэх
4. Өвчтөний аюулгүй байдлыг сайжруулах, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх
5. Чанар, аюулгүй байдалтай холбоотой хууль, эрхзүйн зохицуулалт болон магадлан итгэмжлэлийн шалгуур, стандарт удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавих
6. Чанарын шалгуур үзүүлэлтийг үнэлж, сайжруулах
7. Гүйцэтгэлийн үнэлгээний мэдээлэл болон чанар сайжруулах үйл ажиллагааны мэдээллийг Төвийн удирдлага, холбогдох ажилтан болон нийт ажилтнуудад тодорхой хугацаанд тайлагнах

Үнэлгээ хийх чиглэл

1. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө, түүнтэй холбоотой баримт бичгийг үзнэ.
2. Төвийн удирдлага болон чанарын багийн гишүүнтэй ярилцаж, төлөвлөгөөний агуулга, чанарын сургалт, тоон мэдээллийн дүн шинжилгээ, төлөвлөгөөний хэрэгжилт зэргийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь зорилгын 1-4 дүгээр шаардлагыг хангасан чанар, аюулгүй байдлыг сайжруулах батлагдсан төлөвлөгөөтэй байна.
	2	Чанарын багт мэргэшсэн ажилтныг томилсон байна.
	3	Чанар, аюулгүй байдал сайжруулах төлөвлөгөөг боловсруулахад хамаарах талуудын оролцоог бүрэн хангасан байна.
	4	Чанарын баг нь агуулгад дурдсан (1-7 заалт) үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
	5	Чанарын баг нь төлөвлөсөн хугацаанд хуралдаж, хурлын тэмдэглэлийг баримтжуулсан байна.
	6	Чанар, аюулгүй байдал сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг жилд 1-с доошгүй удаа үнэлж, шинэчлэн сайжруулдаг байна.

Шалгуур 9.2

Төв нь үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, тогтмол хэмжиж, тэдгээрийг системтэйгээр хянадаг байна.

Агуулга

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт нь Төвийн гүйцэтгэл, давуу тал, сайжруулах боломжит чиглэлийг харуулдаг хэмжүүр юм. Шалгуурыг зөв тодорхойлсноор гүйцэтгэлийн үнэлгээг бодит болгоно.

Төв нь өвчтөн болон ажилтанд эрсдэл үүсгэдэг, давтамжтай тохиолддог, зардал өндөр үйл ажиллагааг үнэлэх гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн зохистой багцыг сонгон ашиглана.

Багцад дараах шалгуур үзүүлэлтийг оруулна. Үүнд:

- a) Хүлээлгийн дундаж хугацаа;
- b) Өвчтөний бүртгэлийн хүртээмжтэй байдал;
- c) Өвчтөний бүртгэлийн бүрэн хөтлөлт
- d) Халдварт өвчний илрүүлэг;
- e) Халдварт бус өвчний илрүүлэг;
- f) Эрүүл мэндийн боловсрол олголт;
- g) Дархлаажуулалт;
- h) Эмийн алдаа, алдах дөхсөн тохиолдол, ноцтой тохиолдол;
- i) Өвчтөн түүний гэр бүлийн сэтгэл ханамжийн түвшин;
- j) Өвчтөний санал, гомдол;
- k) Ажилтны сэтгэл ханамж;
- l) Ажилтны санал, гомдол;
- m) Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авалт;
- n) Ажилтны гүйцэтгэл;
- o) Аюулгүй байдлын шаардлагууд;
- p) Барилга байгууламжийн менежмент.

Өгөгдлийг хангалттай хугацаанд цуглуулан, дүн шинжилгээ хийж, шаардлагатай үйл явцын сайжруулалтыг хэрэгжүүлнэ.

Гүйцэтгэлийн үзүүлэлтийг үнэлэхэд ашиглах өгөгдөл нь мэдээллийг тайлагнах давтамж, тохиолдол хэр ойрхон гарч байгаагаас хамааран харилцан адилгүй байна.

Төв нь чанар, аюулгүй байдлыг сайжруулах явцыг үнэлэхэд олон төрлийн график, диаграмм ашиглана.

Төв нь гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг олон нийтэд ил тод мэдээлнэ.

Үнэлгээ хийх чиглэл

1. Ажилтантай ярилцаж, тасаг/нэгжийн гүйцэтгэлийн үнэлгээ болон түүнийг сайжруулах мэдлэг, ойлголтыг үнэлнэ.
2. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлттэй холбоотой баримт бичгийг хянаж, шалгуурыг сонгосон эрэмбэ, хэрэгжилтийг үнэлэх зорилгоор идэвхтэй хэлэлцүүлэг хийнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь өөрийн үйлчилгээний хамрах хүрээнд нийцсэн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна.
	2	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн өгөгдлийг тогтмол цуглуулж, дүн шинжилгээ хийн, байгууллагын удирдлагад улирал тутам тайлагнана.
	3	Байгууллагын удирдлага нь гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн үр дүнд үндэслэн зохих шийдвэр гаргадаг байна.
	4	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн мэдээллийг шаардлагатай тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад тайлагнадаг байна.

Шалгуур 9.3

Төв нь өгөгдөл нэгтгэх, дүн шинжилгээ хийх мэдлэг, ур чадвар, туршлага бүхий мэргэжлийн ажилтантай байна.

Агуулга

Өгөгдлийн удирдлага нь төвийн гүйцэтгэлийг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Өгөгдлийг нэгтгэх нь төвийн өнөөгийн гүйцэтгэлийн талаар үнэ цэнтэй ойлголт өгч, сайжруулалт хийх шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлоход дэмжлэг үзүүлнэ. Өгөгдлийн удирдлагын үр нөлөөг сайжруулахын тулд төв нь өгөгдөл цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийж, хандлагыг тодорхойлох ур чадвар, туршлагатай мэргэжлийн ажилтныг томилж ажиллуулна. Ажилтан нь өгөгдлийг батлагдсан хугацаанд нэгтгэн шинжлэх үүрэг хүлээнэ.

Үнэлгээ хийх чиглэл

1. Шинжээч нь өгөгдлийн удирдлагын хэрэгжилт болон мэргэжлийн ажилтны өгөгдөлд дүн шинжилгээ хийх ур чадварыг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь өгөгдлийн удирдлагын үйл явц (өгөгдөл цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийж, хандлагыг тодорхойлох)-ыг зохицуулах батлагдсан журамтай байна.
	2	Өгөгдөл цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийж, хандлагыг тодорхойлдог мэргэжлийн ажилтан нь өөрийн үүргийн талаар мэдлэгтэй байна.
	3	Өгөгдлийг тодорхой хугацаанд нэгтгэн, дүн шинжилгээ хийдэг байна.

Шалгуур 9.4

Өгөгдлийг тодорхой шалгуурын дагуу баталгаажуулдаг байна.

Агуулга

Өгөгдлийн баталгаажуулалт гэдэг нь өгөгдлийг ашиглахаас өмнө түүний эх сурвалжийн үнэн зөв, баталгаатай байдлыг шалгах үйл явц юм. Өгөгдлийн баталгаажуулалт нь өгөгдлийн үнэн зөв, ашиглахад тохиромжтой байдлыг хангахад зайлшгүй чухал юм. Баталгаатай өгөгдөл нь өгөгдөлд итгэх итгэлийг бий болгож, түүнд суурилсан шийдвэр гаргах боломжийг олгодог.

Төв нь өгөгдлийн чанарыг дараах хэмжээсийн дагуу баталгаажуулна. Үүнд:

- a) Хүчин төгөлдөр байдал (Validity): өгөгдөл нь хэмжих ёстой зүйлийг бодитойгоор хэмжиж байгаа эсэх;
- b) Найдвартай байдал (Reliability): хүн бүр өгөгдлийг ижил аргачлалын дагуу тодорхолж, хэмжиж, цуглуулж байгаа эсэх;
- c) Бүрэн байдал (Completeness): гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тооцоолоход шаардлагатай бүх утгууд тусгагдсан эсэх;
- d) Нарийвчлал (Precision): өгөгдөл нь хангалттай хэмжээний мэдээлэл агуулж байгаа эсэх;
- e) Цаг үеэ олсон байдал (Timeliness): өгөгдөл нь цаг хугацаандаа шинэчлэгддэг эсэх.
- f) Үнэн, зөв байдал (Integrity): өгөгдөл нь бодит, үнэн зөв эсэх

Үнэлгээ хийх чиглэл

1. Шинжээч нь төвийн өгөгдлийг хянах, баталгаажуулах үйл явцыг зохицуулсан журмыг хянаж болно.
2. Өгөгдөлд дүн шинжилгээ хийх мэргэжлийн ажилтантай ярилцаж, өгөгдөл баталгаажуулалтын үйл явцыг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь өгөгдөл хянах, баталгаажуулах үйл явцыг зохицуулсан журамтай байна.®
------------------------	----------	---

2	Өгөгдлийг хянадаг ажилтан өөрийн үүрэг, хариуцлагын талаар мэдлэгтэй байна.
3	Өгөгдлийг зорилгод дурдсан (a-f заалт) хэмжээсийн дагуу баталгаажуулна. ©
4	Өгөгдлийг нийтлэх, гадны байгууллагад илгээх, мэдээлэл цуглуулах арга, хэрэгсэл, хариуцсан ажилтан, үйл явцад өөрчлөлт орсон тохиолдолд өгөгдлийн баталгаажуулалтыг заавал гүйцэтгэдэг байна.

Шалгуур 9.5

Төв нь эрсдэлийн удирдлагын хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Агуулга

Эрсдэлийн удирдлага гэдэг нь төвд нөлөөлж болзошгүй эрсдэлийг урьдчилан тодорхойлсноор байгууллагын эд хөрөнгө, үзүүлж буй тусламж, үйлчилгээ, эрүүл мэндийн ажилтанг хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа юм.

Эрсдэлийн удирдлагыг үр нөлөөтэй хэрэгжүүлснээр төвийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангана. Эрсдэлийн удирдлагын чухал алхамуудын нэг нь эрсдэлийн шинжилгээ бөгөөд түүний тусламжтайгаар өндөр эрсдэлтэй үйл явцыг илрүүлдэг.

Төв нь эрсдэлийн удирдлагын хүрээнд урьдчилан сэргийлэх чиглэлийг баримталж, эрсдэлийг бууруулах стратегийг хэрэгжүүлж ажиллана. Эрсдэлийг удирдах хариу урвалын (reactive) болон урьдчилан сэргийлэх (proactive) арга хэмжээг хослуулан хэрэгжүүлэх шаардлагатай. Төв нь дараах агуулгатай эрсдэлийн удирдлагын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ. Үүнд:

- a) Эрсдэлийн үнэлгээ хийх хүрээ, зорилго болон шалгуур;
- b) Эрсдэлийн удирдлагын үүрэг, хариуцлага, чиг үүрэг;
- c) Эрсдэлийн удирдлагын тогтолцоог дэмжих бодлого, үйл ажиллагаа;
- d) Эрсдэлийн удирдлага, ашиглах арга хэрэгслийн талаарх эмнэлгийн ажилтны сургалт;
- e) Эрсдэлийг тодорхойлох үйл явц, эрсдэлийн бүртгэл;
- f) Эрсдэлийг эрэмбэлэх, ангилах (жишээлбэл: стратегийн, үйл ажиллагааны, санхүүгийн болон бусад);
- g) Ноцтой болон өндөр эрсдэлээс эхлэн бууруулах үйл ажиллагааг төлөвлөх
- h) Эрсдэлийн бүртгэл, удирдах дээд шатны болон холбогдох байгууллагад мэдээлэх үйл ажиллагаа;
- i) Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг жил бүр шинэчлэх.

Төв нь эрсдэлийг урьдчилан илрүүлэх, бууруулах зорилгоор идэвхтэй (proactive) эрсдэлийн үнэлгээний арга хэрэгсэл ашиглах ёстой. Үүний нэг жишээ нь **Failure Mode and Effects Analysis (FMEA)** буюу алдаа гарах боломжит хэлбэр, түүний үр дагаврын шинжилгээ юм.

Үнэлгээ хийх чиглэл

1. Шинжээч нь эрсдэлийн удирдлагын хөтөлбөр, төлөвлөгөө, эрсдэлийн бүртгэл болон эрсдэлийн үнэлгээний үйл явцыг хянаж болно.
2. Бүртгэсэн эрсдэлийг удирдах үйл ажиллагааг хянах зорилгоор эрсдэлийг бууруулах үйл явцын хэрэгжилтийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь агуулгад дурдсан (a-i заалт) бүхий эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байна.
	2	Эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн зохих арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.
	3	Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүнг удирдах шатны байгууллагад улирал тутам тайлагнана.
	4	Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө болон эрсдэлийн бүртгэлийг жил бүр үнэлж, төлөвлөгөөг шинэчилдэг байна.
	5	Жилд дор хаяж нэг удаа ноцтой болон өндөр эрсдэлийг бууруулах хэрэгсэл (жишээлбэл, RCA,FMEA)-ийг ашигласан байна.

Шалгуур 9.6

Төв нь тохиолдол мэдээлэх тогтолцоог бүрдүүлсэн байна.

Агуулга

Тохиолдол эрсдэлийг бүртгэн мэдээлэх нь эрсдэлийн удирдлагын мэдээлэх тогтолцооны чухал хэсэг юм. Уг тогтолцоо нь өвчтөн болон ажилтны аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй аливаа үйл явдлыг (incident) тодорхойлох боломжийг олгоно.

Тохиолдол, эрсдэлийг мэдээлэх нь өвчтөний аюулгүй байдлыг сайжруулахад чухал нөлөө үзүүлдэг. Эдгээр мэдээлэл нь өвчтөн хэрхэн, яагаад хохирч болзошгүйг ойлгоход үнэ цэнтэй мэдээлэл өгдөг.

Төвд эмнэлгийн орчны гэмтэл, бэртэл, өвчтөний гомдол,эмийн алдаа, тоног төхөөрөмжийн эвдрэл, доголдол, эмийн эмчилгээтэй холбоотой таагүй тохиолдол, болон тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдол зэргийг заавал бүртгэх тогтолцоотой байна.

Тохиолдол эрсдэлийг бүртгэх, мэдээлэх журам нь эрсдэлийг илрүүлэх, хянах, үнэлэх, бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх бөгөөд дор дурдсан бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулна. Үүнд:

- a) Зайлшгүй мэдээлэх тохиолдол, алдах дөхсөн тохиолдол (near-miss), таагүй тохиолдол (adverse event), ноцтой тохиолдол (sentinel event)-ын жагсаалт
- b) Тохиолдол эрсдэлийг удирдах үйл явц, түүний дотор хэн, хэрхэн, хэзээ мэдээлэх болон хэрхэн шалгаж, судлах
- c) Удирдлагад нэн даруй мэдэгдэх шаардлагатай тохиолдлын төрлүүд
- d) Тохиолдол эрсдэлийг ангилах, дүн шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах
- e) Нарийвчилсан дүн шинжилгээ (intensive analysis) хийх шаардлагатай нөхцөл болон түүний үйл явц

Төв нь ноцтой тохиолдолд өртсөн өвчтөн болон ажилтнуудад сэтгэл зүйн шуурхай болон үргэлжилсэн дэмжлэгийг цогцоор үзүүлэхэд анхаарна.

Үнэлгээ хийх чиглэл

1. Тохиолдол эрсдэлийг бүртгэх, мэдээлэх журам, тохиолдлын жагсаалт, бүртгэл, баримтуудыг хянаж, сайжруулах арга хэмжээнүүдийг үнэлж болно.
2. Ажилтантай ярилцлага хийж, тэдний тохиолдол, эрсдэл бүртгэх, мэдээлэх тогтолцооны талаарх мэдлэг, ойлголтыг (тохиолдлыг зөв бүртгэх, дүн шинжилгээ хийх, дахин давтагдахаас сэргийлэх зорилгоор сайжруулах арга хэмжээ авсан эсэх) үнэлж болно.

Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад дурдсан (а-е хүртэлх) бүх асуудлыг хамарсан, албан ёсоор батлагдсан тохиолдол бүртгэх, мэдээлэх журамтай байна.®
	2	Бүх ажилтнууд гэрээт, гүйцэтгэгч байгууллагын ажилтан хүртэл тохиолдол бүртгэх, мэдээлэх журмын талаар мэдлэгтэй байна.
	3	Мэдээлэгдсэн тохиолдлыг шалгаж, тодорхой хугацаанд засаж сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.
	4	Тохиолдолд өртсөн өвчтөн, үйлчлүүлэгчид болсон үйл явдлын талаарх мэдээллийг зөв хүргэж, сэтгэл зүйн болон бусад тусламж, дэмжлэгийг үзүүлдэг байна.
	5	Тохиолдолд өртсөн ажилтнуудад сэтгэлзүйн болон мэргэжлийн дэмжлэгийг үзүүлдэг байна.

Шалгуур 9.7

Төв нь ноцтой тохиолдлыг тодорхойлж, шалгаж, дүн шинжилгээ хийж, тайлагнан, үр дагаварыг арилгах болон дахин давтагдахаас сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.

Агуулга

Ноцтой тохиолдол нь гэнэтийн байдлаар нас барах, эсвэл бие махбодын болон сэтгэлзүйн ноцтой гэмтэл учруулах болон учруулж болзошгүй үйл явдлыг хэлнэ. Ноцтой гэмтэлд тодорхой эрхтэн, мөчдийн хөдөлгөөний алдагдал эсвэл үйл ажиллагааны байнгын алдагдал хамаарна.

Ноцтой тохиолдол нь нэн даруй шалгаж хариу арга хэмжээ авах шаардлагатайг илтгэнэ.

Төв нь ноцтой тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах журамтай байна.

Журамд дараах асуудлыг тусгана. Үүнд:

a) Ноцтой тохиолдлын тодорхойлолт ба жишээг дурьдах. Үүнд:

1. Өвчтөний өвчний явц, суурь эмгэгтэй холбоогүйгээр гэнэтийн нас баралт эсвэл эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны байнгын алдагдалтай болох
2. Буруу өвчтөнд, буруу талбайд, буруу мэс ажилбар болон мэс засал хийх
3. Өвчтөний амиа хорлолт, эсвэл амиа хорлох оролдлогоос үүдэн нас барах
4. Төрсний дараах эхийн нас баралт
5. 2500 граммаас дээш жинтэй нярайд тохиолдсон, төрөлхийн эмгэгтэй холбоогүй перинатал нас баралт

b) Ноцтой тохиолдлын эмнэл зүйн дотоод хэлэлцүүлэг;

c) Ноцтой тохиолдлын эмнэл зүйн гадаад хэлэлцүүлэг;

d) Олон мэргэжлийн багийн оролцоо;

e) Үндсэн шалтгааны дүн шинжилгээ;

f) Сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө;

Бүх ноцтой тохиолдлыг тухайн үйл явдал гарснаас хойш эсвэл мэдсэнээс хойш 48 цагийн дотор мэдэгдэнэ. Ноцтой тохиолдлын тодорхойлолтод хамаарах бүх тохиолдолд тогтолцооны сул талыг тодорхой ойлгохын тулд үндсэн шалтгааны шинжилгээг заавал гүйцэтгэнэ.

Шинжилгээ болон засах арга хэмжээг тухайн үйл явдал гарснаас хойш эсвэл мэдсэнээс хойш 45 хоногийн дотор бүрэн гүйцэтгэнэ.

Үнэлгээ хийх чиглэл

<ol style="list-style-type: none"> 1. Ноцтой тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах журмыг хянана. 2. Мэдээлэгдсэн ноцтой тохиолдлуудын жишээ баримтуудаас хянаж, хийсэн үнэлгээ, үндсэн шалтгааны дүн шинжилгээ болон авсан хариу арга хэмжээнүүдийг үнэлнэ. 3. Эмнэлгийн удирдлагуудтай ярилцлага хийж ноцтой тохиолдол ба хариу арга хэмжээний талаарх мэдлэг, ойлголтыг үнэлнэ. 		
Хэмжих үзүүлэлт	1	Агуулгад дурдсан (a-f хүртэлх) шаардлагуудыг хамарсан ноцтой үйл явдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах журамтай бөгөөд удирдлагууд уг журмын талаар мэдлэгтэй байна.©
	2	Бүх ноцтой үйл явдлуудыг удирдлагаас тогтоосон, тухайн үйл явдал гарсан эсвэл мэдсэн өдрөөс хойш 45 хоногоос хэтрэхгүй хугацаанд үндсэн шалтгааны шинжилгээ хийж, дүн шинжилгээ болон мэдээллийг холбогдох түвшинд хүргэдэг байна.
	3	Бүх ноцтой үйл явдлыг тухайн үйл явдал гарсан эсвэл мэдсэнээс хойш 48 цагийн дотор мэдээлдэг байна.
	4	Үндсэн шалтгааны дүн шинжилгээгээр ноцтой тохиолдлын гол шалтгаануудыг тодорхойлж, удирдлага нь цаашид дахин давтагдахаас сэргийлэх болон сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлдэг байна.

Шалгуур 9.8

Төв нь чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Агуулга

Сайжруулалтын үр дүнг тогтвортой хадгалахын тулд төвийн ажилтнуудыг чанар сайжруулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг шаарддаг. Ажилтнууд тасралтгүй сайжруулалтын үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг боловч тэднийг сургах, эрх мэдэл олгох, санаачилга гаргахыг дэмжих нь удирдлагын үүрэг юм. Чанарыг тасралтгүй сайжирч байгааг тогтмол хэмжих шаардлагатай ба эргэн мэдээлэлтэй байх нь үр дүнг илэрхийлэх гол нөхцөл болно. Чанарыг тасралтгүй сайжруулах шинэ санаа, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхлэхдээ эмнэлгийн суурь гүйцэтгэлийг хэмжиж үзсэн байх шаардлагатай. Сайжруулалтын арга хэрэгслүүд нь сайжруулалтын явцыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр турших, үнэлэх боломжийг олгодог. Энэхүү мөчлөг нь суурь түвшин болон зорилтот түвшний хоорондын гүйцэтгэлийн ялгааг хэмжих замаар тасралтгүй сайжруулалтыг хангана.

Чанар сайжирч байгаа эсэхийг хэмжсэний үр дүн нь ашигласан арга хэрэгслүүд хэр үр дүнтэй байгааг шууд илэрхийлэх боломжтой.

Үнэлгээ хийх чиглэл

1. Сайжруулалтын үйл ажиллагааг хянаж, эмнэлгийн суурь гүйцэтгэлийг хэрхэн ашиглан сайжруулах боломжийг тодорхойлсон болон авсан арга хэмжээний нөлөөллийг хэрхэн үнэлсэн талаар судална.
2. Хүрсэн сайжруулалтын үр дүнг тогтвортой хадгалахад чиглэсэн төвийн дотоод болон чанарын хяналтын уялдаа холбоог үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Сайжруулалтын хөтөлбөр, төлөвлөгөө гарган баталгаажуулж, сайжруулах арга хэрэгслүүдийг ашигласан байх.©
	2	Илэрсэн асуудлыг засах арга хэмжээнүүдийг батлагдсан хугацааны хүрээнд авч хэрэгжүүлдэг байна.
	3	Сайжруулалтын үйл ажиллагааг туршиж, түүний үр дүнг баримтжуулан хэрэгжүүлдэг байна.
	4	Сайжруулалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж, хүрсэн үр дүнг тогтвортой хадгалдаг байна.

БҮЛЭГ 10. ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТ

Тойм

Халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаа нь өвчтөн болон эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэхэд оршино. Халдварын сэргийлэлт, хяналт /цаашид ХСХ гэх/ нь өвчтөний аюулгүй байдал болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын салшгүй хэсэг бөгөөд эрүүл мэндийн байгууллага бүр ажилтан, өвчтөн, ЭМБ-аар үйлчлүүлэгчийг халдвараас сэргийлэх, тусламж үйлчилгээний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн ХСХ-ын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. ХСХ-ын хөтөлбөр нь байгууллагын үйл ажиллагаанд тохирсон, эрсдэлд суурилсан, эрсдэлийг эрт илрүүлэх түүнийг засаж сайжруулахад чиглэсэн зорилтот арга хэмжээг тусгасан байна.

Төв бүр ХСХ-ын багтай байх ба багийн гишүүд нь хөтөлбөрийг хэрэгжүүлж, удирдан зохион байгуулах үүрэгтэй, үүргийг албан тушаалын тодорхойлолтод заасан байх шаардлагатай.

Эрүүл мэндийн байгууллага ХСХ-ын үйл ажиллагаанд анхаардаггүй, хөтөлбөр зөвхөн цаасан дээр байдаг, эмч, мэргэжилтэн, удирдлагын түвшинд дэмжиж ажилладаггүйгээс өвчтөн, эрүүл мэндийн ажилтан халдварт өртөж амь нас, эрүүл мэндээрээ хохирдог.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын мэдээлснээр, эмнэлэгт хэвтсэн 100 өвчтөн тутмын 7 нь өндөр орлоготой улс оронд, 15 нь бага ба дундаж орлоготой улс оронд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар (ЭТҮХХ) авах бөгөөд эмнэлэгт хэвтэж буй 10 өвчтөн тутмын 1 нь ЭТҮХХ-ын улмаас нас бардаг байна. Дэлхий нийтийг хамарсан цартахал, халдварт өвчний дэгдэлт, олон хүнийг хамарсан өвчлөл гамшиг, осол зэрэг нийгмийн эрүүл мэндэд ноцтой байдал үүссэн үед эмнэлгийн ачаалал ихэсч халдварт өртөх хамгийн эрсдэлтэй орчин болдог.

Түүнчлэн олон эмэнд тэсвэржсэн бичил биетний халдвар, өвчлөлийн асуудал дэлхий нийтийн тулгамдсан асуудал болсон. Эмэнд тэсвэртэй бичил биетэн эмнэлгийн орчинд тархах эрсдэл хамгийн их байдаг. Иймд халдвар авах, халдвар тархах боломжийг бууруулахын тулд эмнэлгүүд халдварын сэргийлэлт ба хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Доорх жагсаалтад энэ бүлэгт хамаарах шалгуурыг нэгтгэн харуулав.

10.1	Байгууллагын бүтцэд халдварын сэргийлэлт, хяналтын хөтөлбөр, журам, зааврын хэрэгжилтийн асуудлыг хариуцсан баг, мэргэжилтэн ажилладаг байна.
------	---

10.2	Эрсдэлд суурилсан ХСХ-ын хөтөлбөртэй, үйл ажиллагааг жил бүр төлөвлөж үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан байна.
10.3	Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх бодлогыг хэрэгжүүлж ажилладаг байна.
10.4	Гар угаах, халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлж, гарын ариун цэвэр сахилтыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.
10.5	Аюулгүй байдлыг хангасан багаж, хэрэгслээр тусламж, үйлчилгээ үзүүлнэ.
10.6	Ариутгалын процесст чанарын хяналтыг тогтмол хийж хэвшсэн байна.
10.7	Эмнэлгийн орчинд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийж халдварын эрсдэлийг бууруулна.
10.8	Эмнэлгийн зөөлөн эдлэлийг угааж, халдваргүйжүүлнэ.
10.9	Үйлчлүүлэгчид ээлтэй, халдварын эрсдэлгүй орчинг бүрдүүлнэ.
10.10	ЭТҮХХ-ын тандалт хийж хариу арга хэмжээ хэрэгжүүлнэ.
10.11	Халдварын сэжигтэй үйлчлүүлэгчийг тусгаарлаж, хариу арга хэмжээ хэрэгжүүлнэ.
10.12	Эмнэлгийн аюултай хог хаягдлын менежментийг хэрэгжүүлнэ.

Шалгуур 10.1

Байгууллагын бүтцэд халдварын сэргийлэлт, хяналтын хөтөлбөр, журам, зааврын хэрэгжилтийн асуудлыг хариуцсан баг, мэргэжилтэн ажилладаг байна.

Агуулга

Төвд ХСХ-ын орон тооны бус баг ажиллана. Тус баг нь халдварын эрсдэлийг илрүүлэх, халдвараас сэргийлэхэд чиглэсэн бүх үйл ажиллагааг эмнэлгийн хэмжээнд удирдан зохион байгуулж, чиглүүлж ажилладаг байна. Багийн ахлагч, гишүүд ХСХ-ын чиглэлээр сургагдсан байх бөгөөд тогтмол мэдлэгээ дээшлүүлэх, туршлага судлах, өөрийгөө хөгжүүлж, бусдад манлайлж ажиллана.

ХСХ-ын баг нь дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- a) ХСХ-ын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг хангуулах;
- b) Бүх ажилтанд мэдлэг олгох, үүрэг, хариуцлагыг нь ойлгуулах сургалт зохион байгуулах;
- c) Хяналт үнэлгээ хийж эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, түүнийг засах арга хэмжээ авах,
- d) Шийдвэрлэх асуудлаа удирдах түвшинд танилцуулдаг байх;
- e) ХСХ-ын чиглэлээр тоон мэдээлэл цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, дараагийн шатлалд илгээх;
- f) Бусад ажиллагсдыг үйл ажиллагаандаа татан оролцуулах.

Үнэлгээ хийх чиглэл:

- ХСХ-ын бүтэц, тогтолцоо, үйл ажиллагаа хэрхэн хэрэгждэг талаар эмнэлгийн удирдлага, хариуцсан баг, мэргэжилтэнтэй ярилцлага хийнэ.

- ХСХ-ын баг томилсон тушаал, шийдвэр, ХСХ-ын асуудал хариуцсан мэргэжилтэн, багийн ахлагч, гишүүдийн албан тушаалын тодорхойлолтод ХСХ-ын асуудал хариуцсан эсэхийг баримт, бичгээс үзэж үнэлнэ.
- Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт үнэлгээ, сургалт зэрэг ХСХ-ын багийн хийсэн ажил, хүрсэн үр дүнг тайлантай танилцах, тойрон үзлэг хийх явцад ажиглалт хийх, эмч, мэргэжилтэн, ажиллагсадтай ярилцах байдлаар үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	ХСХ-ын баг томилсон тушаалтай байна.©
	2	Багийн гишүүд нь ХСХ-ын чиглэлээр эрх бүхий байгууллагын сургалтад хамрагдсан байна.
	3	Албан тушаалын тодорхойлолтод үүрэг хүлээсэн байна.
	4	ХСХ баг байнгын, тасралтгүй үйл ажиллагаа явуулсан байна.
	5	Хяналт үнэлгээ хийж, эрсдэлийг тогтоосон, үр дүн гаргасан байна.©
	6	Багаар ажиллаж, байгууллагын удирдлага, шийдвэр гаргах түвшинд асуудлаа хэлэлцүүлсэн байна.

Шалгуур 10.2

Эрсдэлд суурилсан ХСХ-ын хөтөлбөртэй, үйл ажиллагааг жил бүр төлөвлөж үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан байна.

Агуулга

Төв нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон ХСХ-ын хөтөлбөртэй байна. Хөтөлбөр нь ЭТҮХХ гарах эрсдэлийг бууруулахад чиглэгдэнэ. Байгууллагын эрсдэлийн үнэлгээ, бодлогын баримт бичигт үндэслэн хөтөлбөрийг боловсруулна. Хөтөлбөр нь байгууллагын бүх хэсгийг хамрах ба өвчтөн, ажилтан, үйлчлүүлэгчид чиглэсэн байна. Хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд жил бүр ХСХ-ын хийх ажлаа төлөвлөж хэрэгжүүлнэ.

Хөтөлбөр нь дараах үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг тусгасан байна.

- Хамрах хүрээ болон зорилтууд
- Баримтлах бодлого, журам
- Халдварын эрсдэл өндөр байж болзошгүй тусламж, үйлчилгээ, тасаг нэгжийн эрсдэлийн үнэлгээ
- ХСХ-ын зарчим, дадлын талаар ажиллагсдад сургалт, боловсрол олгох
- Дэгдэлтийн менежмент
- Дархлаажуулалт
- Нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг дэмжих антибиотикийн зохистой хэрэглээний хөтөлбөр
- Хөтөлбөрийг тогтмол үнэлж, шинэчилдэг байх (шаардлагатай үед болон хамгийн багадаа жилд нэг удаа)

Үнэлгээ хийх чиглэл

- Батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөтэй танилцаж үнэлнэ.
- Хэрэгжилтийг тойрон үзлэг хийх явцдаа ажиглах, ажиллагсдаас асууж ярилцах байдлаар үнэлнэ.

1	Зорилгын (a-h) хэсгийг багтаасан ХСХ-ын хөтөлбөртэй байна.©
----------	---

Хэмжих үзүүлэлт	2	ХСХ-ын чиглэлээр хийх үйл ажиллагааг жил бүр төлөвлөж, гол асуудлаа шийдвэрлэж ажилласан байна.
	3	Төлөвлөгөөг хэрэгжүүлэх нөөц (санхүү, хүний нөөц гэх мэт) боломж бүрдсэн байна.

Шалгуур 10.3 Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх бодлогыг хэрэгжүүлж ажилладаг байна.

Агуулга

Эрүүл мэндийн ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртдөг. ХДХВ, гепатитын В, С, Д вирусийн халдвар, эмэнд тэсвэртэй нян, томуу, томуу төст өвчин, сүрьеэ, улаанбурхан зэрэг бүх л халдварт өвчинд өртөж өвдөх, халдвар авах тохиолдол их байдаг. Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх бодлогыг хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

- a) Урьдчилан сэргийлэх, жил бүр тогтмол үзлэг, шинжилгээнд хамруулна:
 - Гепатитын В, С, ХДХВ-ийн халдвар илрүүлэх, В гепатитын вакцин хийлгэсэн бол дархлаа тогтоцын шинжилгээнд 5 жил тутамд($\geq 100\text{IU/mL}$)
 - Сүрьеэ илрүүлэг болон МТСА колонизаци эсэхийг тодорхойлох
- b) ЭМА-д мэдлэг олгох, баталгаажуулах, шинэ ажилтанд баримжаа олгох сургалт хийх
- c) Дархлаажуулалтад хамруулах, дархлаажуулалтын нэгдсэн бүртгэл судалгаатай байх
- d) Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслээр тасралтгүй хангах
- e) Ажлын байранд халдвар авах эрсдэлд хүчин зүйлд өртөх, өртөлтийн дараа халдвараас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
- f) Ажилтны халдварт өртөх эрсдэлийн үнэлгээг жилд 1-ээс доошгүй удаа хийх

Үнэлгээ хийх чиглэл

- Ажиллагсдын үзлэг, шинжилгээ, сургалт, дархлаажуулалт, өртөлтийн бүртгэл зэрэг баримт бичгийг үзэж, ажиллагсдын халдварт өртөх эрсдэл, хамгаалах хувцас, хэрэгслийн хангамж нөөц, хэрэглээ зэргийг ажиглалт хийж үнэлнэ.
- Ажиллагсдыг халдвараас сэргийлэх журам, зааврыг хэрэгжүүлж байгаа эсэх, тэдгээрийн мэдлэг, дадал, хандлагыг тойрон үзлэг хийх явцад ажиглалт хийх, ярилцах, асуулт асуух байдлаар үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулсан байна.
	2	Дархлаажуулалтын нэгдсэн санг файл хэлбэрээр бүрдүүлж нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр хийсэн байна. ©
	3	Ажилтантай ярилцаж, ХСХ-ын мэдлэгийг үнэлнэ.

4	Өртөлтийг бүртгэж, халдвараас сэргийлэх арга хэмжээг хугацаанд нь авсан байна. ©
5	Тусламж үйлчилгээнд биечлэн оролцдог ажиллагсад ХСХ-ын сургалтад жилд 1-ээс доошгүй удаа хамрагдсан байна. ©
6	Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслээр тасралтгүй хангасан байна.

Шалгуур 10.4

Гар угаах, халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлж, гарын ариун цэвэр сахилтыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

Агуулга

Гар угаах (ус, саван ашиглаж угаах), гар халдваргүйжүүлэх (спиртэн суурьтай антисептик бодис) нь эрүүл мэндийн байгууллагад халдвар дамжихаас сэргийлэх хамгийн үр дүнтэй арга. Эрүүл мэндийн байгууллагын ажилтан, дадлагажигч эмч, оюутан, өвчтөн түүний асран хамгаалагчид бүгд гарын ариун цэвэр сахина.

Эрүүл мэндийн байгууллага нь гарын ариун цэвэр сахилтыг сайжруулах дараах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

1. Гарын ариун цэвэр сахих нөхцлийг бүрдүүлсэн байна.
 - a) Гарын угаалтуур ажилбарын өрөө бүрт мэдрэгчтэй эсвэл хөл тохойгоор ажилладаг, халуун, хүйтэн устай, ажилбарын цэг, цэвэр хэсгээс 1м хол зайд байрласан, ус цацагдах эрсдэлгүй байна. Гooжyурт yгaагyур ашиглаж байгаа бол ус нөөцлөх тагтай савтай байна.
 - b) Шингэн саван
 - c) Нэг удаагийн цаасан арчуур
 - d) Спиртэнд суурилсан гар халдваргүйжүүлэх бодис, зөвшөөрөгдсөн байх
 - e) Угаалтуурын дэргэд хогийн сав байрлуулах
2. ЭМА гарын ариун цэвэр сахих мэдлэг, зөв дадлыг эзэмшсэн байна.
 - a) Ажилбарын төрөл, эрсдэлд суурилж гарын ариун цэвэр сахих аргыг сонгох мэдлэгтэй
 - b) Гар угаах, халдваргүйжүүлэх зөв техник эзэмшсэн
 - c) Гарын ариун цэвэр сахих заалтууд
 - d) Урт ургуулсан хумс, гоёл чимэглэлийн зүйлгүй гарын ариун цэвэр сахих
3. Гарын ариун цэвэр сахилтын байдалд хяналт, үнэлгээ хийдэг байна.
 - a) Гарын ариун цэвэр сахилтын ажиглалтын үнэлгээ
 - b) Гар халдваргүйжүүлэх бодисын хэрэглээг үнэлэх
 - c) ЭМА-ын мэдлэг, дадал, хандлага
 - d) Гарын ариун цэвэр сахих нөхцөл бүрдсэн эсэх
 - e) Сургалтын хэрэгцээг тогтоох үнэлгээ

Үнэлгээ хийх чиглэл

- Гарын эрүүл ахуйн сургалт, хяналт, үнэлгээний дүн зэрэг баримт бичгүүдийг харж үнэлгээ хийнэ.
- Ажилтнуудаас гарын эрүүл ахуйн техник, ДЭМБ-ын “5 мөч”-ийн талаар мэдлэгийг үнэлнэ.

		<ul style="list-style-type: none"> • Гар угаах орчин, хангамж (саван, цаасан алчуур, гар ариутгагч гэх мэт)-ийг тойрон үзлэгийн явцад харж үнэлнэ. • Ажилтнууд гарын эрүүл ахуйн дүрмийг мөрдөж буй эсэхийг ажиглана.
Хэмжих үзүүлэлт	1	Гарын ариун цэвэр сахилтын байдалд үнэлгээ хийж, сахилтын түвшинг тогтоосон байна. ☹
	2	Сургалтад ажиллагсдын 80-аас доошгүй хувь нь хамрагдсан байна.
	3	Гарын ариун цэвэр сахих нөхцөл бүрдсэн байна.
	4	Хяналт үнэлгээний үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, сайжруулалт хийгдсэн.

Шалгуур 10.5

Аюулгүй байдлыг хангасан багаж, хэрэгслээр тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

Агуулга

Өвчтөнд эмнэлгийн тусламж үзүүлэх багаж, хэрэгсэл нь гэмтсэн болон гэмтээгүй арьс, салстад хүрэлцэж, зөөлөн эд, яс, биеийн хөндийд нэвтэрдэг тул халдварын эрсдэлтэй. Багаж хэрэгслийн эрсдэлд үндэслэн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгалыг хийнэ. Ариутгалын процессыг ариутгалын мэргэшсэн ажилтан, ариутгалын тасаг/нэгжид хийнэ. Ариутгалын нэгж нь нэг чигийн зөв урсгалтай байна.

Ариутгалын нэгж зохион байгуулах боломжгүй эрүүл мэндийн байгууллага нь мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

Төвийн ариутгал нь дараах шаардлагуудыг хангасан байх ёстой.

- Цэвэр, бохир хэсгээр тусгаарлагдсан өрөө
- Мэргэшсэн ажилтан
- Багаж хэрэгслийг угаах, зөөх, хатаах хэрэгсэл, тоног төхөөрөмж
- Ариутгах төхөөрөмж (автоклав)
- Хадгалах шүүгээ
- Савлах, багцлах хэрэгсэл
- Ариутгалд ашиглах усыг шүүх, зөөлрүүлэх
- Ариутгалын чанарт хяналт тавих тестүүд
- Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн бодис
- Багаж арчилгааны хэрэгсэл (тослох, зэв арилгах гэх мэт)
- Багаж хэрэгслийн эрсдэлийн ангилалд тохируулан ариутгах процессыг гүйцэтгэдэг байх
- Ариутгалын процессыг бүртгэх журнал хөтлөх

Үнэлгээ хийх чиглэл

- Автоклав хэвийн ажиллаж байгаа эсэх
- Бохир болон цэвэр бүсээр тусгаарлагдсан эсэх
- Агаарын урсгал нэг чиглэлтэй зохион байгуулагдсан эсэх
- Ажилтнууд ариутгалын процессыг зөв гүйцэтгэх чадвартай эсэхийг ажиглана.

Хэмжих үзүүлэлт	1	Зорилго (a-i) хэсгийн тавигдах шаардлагыг хангах
	2	Ариутгалын ажилтан мэргэшсэн байх

	3	Багаж хэрэгслийг эрсдэлийн ангилалд тохируулж цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгал хийдэг байх
	4	Тоног төхөөрөмж хүрэлцээтэй
	5	Багажийн арчилгаа хийж зэвтэй багажийн зэвийг арилгах, эвдрэл гэмтэл зассан байх
	6	Ариутгасан материал хадгалалтын явцад бохирдохоос сэргийлэгдсэн байх

Шалгуур 10.6

Ариутгалын процесст чанарын хяналтыг тогтмол хийж хэвшсэн байна

Агуулга

Багаж хэрэгслийн халдваргүйжүүлэлт, ариутгал маш чухал процесс юм. Ариутгалын процессийн хяналтыг тогтмол хийж багаж, хэрэгслийг ашиглахад аюулгүй болсон гэдгийг баталгаажуулах шаардлагатай.

Ариутгалын процессийг чанарын дараах үзүүлэлтүүдээр хяналт хийнэ.

- Физик үзүүлэлтүүд – Температур – Хугацаа – Даралт
- Химийн үзүүлэлтүүд – Химийн индикаторууд ариутгасан багажийн дотор болон гадна шалгана
- Биологийн индикатор – Дор хаяж сард 1 удаа
- Уур нэвтрэлт болон агаарын зайлуулах сорил (Bowie-Dick test)- Автоклавыг өдөр тутам ажиллуулахын өмнө уур хангалттай нэвчиж байгаа эсэх, агаарыг бүрэн шахаж гаргаж чадаж байгаа эсэхийг шалгах сорил Class 2 дотоод химийн индикатор өдөр бүр заавал хийнэ.
- Ариутгалын мониторингийн бүхий л мэдээллийг журнал дээр бүрэн хөтөлж бүртгэнэ.

Үнэлгээ хийх чиглэл

- Ариутгалын тасаг/нэгж дээр чанарын хяналт хэрхэн хэрэгжиж байгааг ажиглана.
- Ариутгалын ажилтан болон бусад эрүүл мэндийн ажилтнуудаас чанарын хяналтын талаарх мэдлэгийг асууж үнэлнэ.
- Сав баглаа боодлын чанар, механик мониторинг, химийн болон биологийн индикаторууд стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг шалгана.
- Автоклав тус бүрийн биологийн болон химийн индикаторын бүртгэлийн журналуудыг шалгана.

Хэмжих үзүүлэлт	1	Сав баглаа боодол, химийн болон биологийн индикаторууд нь шаардлагад нийцсэн байх
	2	Ариутгалын ажилтнууд чанарын хяналт хийх чадвартай, сургалтад хамрагдсан байх
	3	Ариутгалын чанарын хяналтын сорилуудыг зааврыг дагуу тогтмол хийдэг байх ©
	4	Хяналтын бүх процесс бүртгэгдсэн, баримтжуулалттай байх

Шалгуур 10.7

Эмнэлгийн орчинд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийж халдварын эрсдэлийг бууруулна.

Агуулга

Эрүүл мэндийн байгууллагын орчны цэвэрлэгээ хийх нь эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгч, үйлчлүүлэгчийн ар гэр, олон нийтэд цэвэр ая тухтай байдлыг хангахаас гадна орчны эд зүйл, гадаргуу дахь өвчин үүсгэгч бичил биетнүүдийн тархалтыг багасгаж аюулгүй байдлыг хангахад оршино.

Эмнэлгийн орчинд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг дараах байдлаар хийж гүйцэтгэнэ.

- a) Эмнэлгийн дотоод орчинд хамаарах талбайг тасаг, нэгжийн үйл ажиллагаа, халдварын эрсдлийн зэргээр А, В, С бүсэд хуваан, бүс тус бүрт тохирсон цэвэрлэгээг хийнэ.
- b) Хана, шал, тааз, тавилга зэргийг хамарсан орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн тодорхой хуваарь, аргачлалтай байна. Энэ нь бүсийн ангилал, эрсдэлийн түвшинтэй нийцсэн байна.
- c) Орчны цэвэрлэгээний хуваарийг өдөр бүр, ээлж бүрт, их цэвэрлэгээ гэж гаргана.
- d) Бохирдох эрсдэл өндөр, хүрэлцэх давтамж их (хаалганы бариул, өвчтөний ор, ширээ, гэрлийн унтраалга) гадаргуу болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэггүй хүрэлцэх давтамж бага гадаргууд өдөр тутмын цэвэрлэгээг тодорхой давтамжтай хийж гүйцэтгэнэ.
- e) Халдварын сэргийлэлт, хяналтын баг нь эрүүл мэндийн ажиллагсдад цэвэрлэгээ хийх давтамж, цэвэрлэгээний материалыг цэвэрлэх, хадгалах, цэвэрлэгээ хийх уусмалыг бэлтгэх талаар сургалтыг зохион байгуулна.
- f) Цэвэрлэгээ хийхэд шаардлагатай хувийн хамгаалах хэрэгсэл, багаж хэрэгсэл, цэвэрлэгээний материалыг угааж, халдваргүйжүүлэх, хадгалах нөхцөлөөр бүрэн хангасан байна.

Үнэлгээ хийх чиглэл:

- Цэвэрлэгээ хийх багаж, хэрэгсэл, угаалгын бодисын хүртээмж, ашиглалтыг ажиглана.
- Хувийн хамгаалах хувцас хэрэгслийн хүртээмж, хэрэглээ, зөв хэрэглэж буй эсэхийг шалгаж ажилтантай ярилцана.
- Хүний гар хүрэлцэх давтамж ихтэй хэсгийн цэвэрлэгээг хийж байгаа эсэхийг ажиглана.

Хэмжих үзүүлэлт	1	Зорилго a-f хэсгийн тавигдах шаардлагыг хангах
	2	Бүс бүрийн цэвэрлэгээний хуваарь, цэвэрлэгээ хийх зааврыг гаргасан байх
	3	Эмнэлгийн орчин цэвэр, цэмцгэр, тавилга хэрэгсэл тоосгүй, нүдэнд харагдах бохирдолгүй байх
	4	Цэвэрлэгээний хэрэгсэл, тоног төхөөрөмж, угаах, халдваргүйжүүлэх бодис хүрэлцээтэй байх

	5 Үйлчилгээний ажилчид стандарт урьдчилан сэргийлэх арга хэмжээний сургалтад хамрагдсан байх
--	--

Шалгуур 10.8

Эмнэлгийн зөөлөн эдлэлийг угааж, халдваргүйжүүлнэ.

Агуулга

Бохирдсон зөөлөн эдлэл нь халдвар үүсгэгчийг дамжуулах эрсдэлтэй. Цагаан хэрэглэл, гудас, матрас зэрэг зөөлөн эдлэлийг зохих ёсоор угааж, халдваргүйжүүлж, хадгалахгүй байх нь зөвхөн өвчтөн төдийгүй түүнийг зөөвөрлөж буй ажилтанд халдварын эрсдэл үүсгэнэ.

Иймээс эрүүл мэндийн байгууллага нь орны тоо, хүчин чадалдаа тохирсон зөөлөн эдлэл, цагаан хэрэглэл, ЭМА-ны ажлын хувцас угаах угаалгын газартай байна. Угаалгын хэсэг нь дараах шаардлагыг хэрэгжүүлж ажиллана.

- a) Угаалгын газар нь нэг чиглэлийн урсгалтай, бохир, цэвэр хэсэгтэй байна. Бохир хэсэгт бохир хэрэглэлийг ангилан ялгах, угааж халдваргүйжүүлэх, цэвэр хэсэгт индүүдэх, хадгалах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.
- b) Цэвэр, бохир усны шугамд холбогдсон, зөөврийн усан хангамжтай үед угаалгын үйлчилгээнд хүрэлцэхүйц хэмжээний ус зөөх, нөөцлөх савтай, халаах хэрэгслээр хангагдсан байна.
- c) Угаалгын машинтай, хатаах, индүүдэх тоног төхөөрөмж, хэрэгсэлтэй байна.
- d) Угаалгын бодис, халдваргүйжүүлэх бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу ашиглана.
- e) Бохир хэрэгслийг цуглуулах, угаах үйл явц (усны температур, угаалгын бодис, халдваргүйжүүлэгчийн хэрэглээ), цэвэр хэрэгслийг хадгалах, түгээх, угаалгын машины арчилгаа, засвар үйлчилгээ зэрэг процессын зураглалтай байна.

Үнэлгээ хийх чиглэл:

- Угаалгын үйл ажиллагааны зураглалтай танилцана.
- Холбогдох ажилтнаас үйл ажиллагааны зураглалыг асууж үнэлнэ.
- Угаалгын хэсэгт очиж орчны зохион байгуулалт, ажиллаж буй угаалгын машин, чанарын хяналтын журнал, бичилтүүдийг шалгана.

Хэмжих үзүүлэлт	1	Зорилго (a-e) хэсгийн тавигдах шаардлагыг хангах
	2	Угаалгын үйл ажиллагааны зураглалыг баталсан, хэрэгжүүлж ажилладаг байх
	3	Тоног төхөөрөмж хүрэлцээтэй байх
	4	Угаагч бодис, халдваргүйжүүлэх бодисыг зааврын дагуу ашигладаг байх
	5	Угаалгын газар нь нэг чиглэлийн урсгалтай цэвэр, бохир хэсгээр тусгаарлагдсан байх

6

Ажилтан бохир хэсэгт хамгаалах хувцас хэрэгсэл хэрэглэдэг байх

Шалгуур 10.9

Үйлчлүүлэгчид ээлтэй, халдварын эрсдэлгүй орчинг бүрдүүлнэ.

Агуулга

Эмнэлгийн орчинд шавж, мэрэгч үүрлэх нь халдварт өвчнийг дамжуулах эрсдэлтэйгээс гадна өвчтөнд таагүй байдлыг үүсгэдэг. Эмнэлгийн ор, ариун цэврийн байгууламж, орчны эд зүйлс тохь тухтай халдварын эрсдэлгүй байх хэрэгтэй. Эрүүл мэндийн байгууллагын бүхий л хэрэгсэл угааж, халдваргүйжүүлэх боломжтой, тав, тухтай өвчтөний сэтгэл зүйд эерэг нөлөөлдөг байх нь чухал.

- Эмнэлгийн орчинд шавж мэрэгч үүрлэхээс сэргийлж мэргэжлийн байгууллагаар устгал хийлгэнэ.
- Тусгай хэрэгцээт үйлчлүүлэгчид зориулсан налуу зам, ханын бариул, зөөврийн суултуур, түших, татаж босох зориулалттай бариулууд, хүүхдэд зориулсан тоноглолуудтай байна.
- Гарын угаалтуур, суултуур стандартад заасан хэмжээнээс багагүй байна.
- Хэвтэн эмчлүүлэх хэсэгт 1 оронд ноогдох талбайн хэмжээ, ор хоорондын зай зэргийг баримтална.
- Эмнэлгийн зориулалтын ор, матрасыг ашиглаж үйлчлүүлэгч хооронд цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.
- Цагаан хэрэглэл нэг өнгийн, цэвэр, өнгө үзэмжтэй байна.
- Гудасны углаа, хөнжил, дэрийг үйлчлүүлэгч хооронд угааж хэрэглэнэ.

Үнэлгээ хийх чиглэл:

- Эмнэлгийн орчныг харж үнэлнэ.
- Шаардлагатай бол баримт бичгийг шалгана.

Хэмжих үзүүлэлт	1	Зорилго (a-g) хэсгийн тавигдах шаардлагыг хангах
	2	Шавж, мэрэгч устгал хийлгэсэн акттай байх ☺
	3	Тусгай хэрэгцээт үйлчлүүлэгчийн өрөөтэй
	4	Ор хоорондын зай, 1 оронд ноогдох талбайн хэмжээ стандартын дагуу байх
	5	Эмнэлгийн орчин тохь тухтай, цэвэр цэмцгэр байх

Шалгуур 10.10

ЭТҮХХ-ын тандалт хийж хариу арга хэмжээ хэрэгжүүлнэ.

Агуулга

ЭТҮХХ-ыг эмнэлзүйн шинж тэмдэгээр илрүүлэх тандалтыг хийнэ. ЭТҮХХ-ыг илрүүлэх нь тухайн эмнэлэгт байгаа эрсдэлийг тогтоож, түүн рүү чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлж ахин эрсдэл гарахаас сэргийлнэ.

ЭТҮХХ-ыг шинж тэмдгээр тандах тандалтын хуудсыг ашиглан тандалт хийхээс гадна, өөрийн эмнэлгийн үйл ажиллагааны онцлогт тохируулан тандалтын хуудас, судалгааны хуудсыг боловсруулан тандалтад ашиглаж болно.

Төв нь дараах тандалтыг хийнэ:

- a) Уян зүү, төвийн венийн гуурс тавих ажилбар хийсэн бол “Судасны гуурстай холбоотой халдварын тандалт”
- b) Поликатетр 48 цагаас дээш хугацаанд тавьсан бол “Шээлгүүртэй холбоотой бөөр шээсний замын халдварын тандалт”
- c) Мэс засал хийлгэсэн үйлчлүүлэгчид “Мэс заслын дараах шархны халдварын тандалт” хийнэ.

ЭТҮХХ-ын тохиолдлыг илрүүлэн бүртгэн, дээд шатны байгууллагад мэдээлнэ. Халдварын түвшинг ажилбар тус бүрээр гаргана.

Үнэлгээ хийх чиглэл:

- Тандалтын хуудас, илрүүлсэн халдвар, авсан арга хэмжээний тайлантай танилцана.
- Эмч, мэргэжилтнүүдтэй ярилцаж халдвар илрүүлэх мэдлэг, хандлагыг шалгана.

Хэмжих үзүүлэлт	1	Тандалтын хуудсаар халдвар илрүүлэх тандалт хийгдсэн байх Ⓟ
	2	ЭТҮХХ-ын тохиолдлыг илрүүлж бүртгэн, дээд шатны байгууллагад мэдээлсэн байх
	3	Бүртгэсэн тохиолдлын судалгааг хийж, хариу арга хэмжээ, үр дүнг хэлэлцэж дүн шинжилгээ хийж ажилласан байх
	4	Эрсдэлт хүчин зүйлийг тогтоож эрсдэлийг арилгах арга хэмжээ авсан байх

Шалгуур 10.11

Халдварын сэжигтэй үйлчлүүлэгчийг тусгаарлаж, хариу арга хэмжээ хэрэгжүүлнэ.

Агуулга

Халдварт өвчний дэгдэлтийн үед эмнэлгийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй, хэрэгжүүлж ажиллана.

Тусгаарлан сэргийлэлтийн бэлэн байдлыг хангана. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ үзүүлдэг бүх эрүүл мэндийн байгууллага, тасаг, нэгж бүрт стандарт тусгаарлах өрөөтэй байна. Тусгаарлалт хийгээгүй үед өрөөг өдөр тутмын тусламж, үйлчилгээнд ашиглана.

Халдвартай болон халдварын сэжигтэй үйлчлүүлэгч илэрвэл түр тусгаарлах боломжийг бүрдүүлсэн байна.

Тусдаа хүлээлгийн өрөө байхгүй үед өвчтөний хоорондох зайг дор хаяж 1м түүнээс дээш байлгах хэрэгтэй. Амьсгалын замын халдварын эмнэлзүйн шинжтэй

өвчтөнүүдэд амьсгалын замын халдвараас сэргийлэх арга хэмжээ авч амны хаалт зүүлгэнэ.

Амьсгалын замаар дамждаг халдвартай өвчтөнийг сөрөг даралттай өрөөнд, хэрэв сөрөг даралттай өрөө байхгүй бол зөөврийн өндөр үр дүнтэй агаарын тоосонцор (HEPA) шүүлтүүрийг өрөөнд байрлуулж өвчтөнд амны хаалт зүүлгэнэ. ЭМА-ууд амьсгалын замын халдвараас сэргийлэх арга хэмжээг тогтмол хийх ёстой.

Орчны арга хэмжээ: Хамгийн их хүрэлцдэг гадаргууг тогтмол стандартын дагуу цэвэрлэх. Цэвэрлэгээ хийдэг ажилчид АЗХ-тай өвчтөний өрөөнд орохдоо N95 маскийг зүүх хэрэгтэй. Өвчтөн гарсны дараа үзлэгийн өрөө хангалттай хугацаанд (ойролцоогоор нэг цаг) хоосон байх ёстой.

Үйлчлүүлэгчдэд зориулан халдвараас сэргийлэх санамж, анхааруулга өгнө.

Үнэлгээ хийх чиглэл:

- Тусгаарлалт зохион байгуулах боломж нөхцөл бүрдсэн эсэхийг харж үнэлнэ.
- Тусгаарлалт хийх, халдвартай өвчтөн ирсэн үед авах арга хэмжээг кэйс ажиллуулж үнэлнэ.
- Эмч, мэргэжилтнүүдтэй ярилцаж халдвар илрүүлэх мэдлэг, хандлагыг шалгана.

Хэмжих үзүүлэлт	1	Хамгаалах хувцас хэрэгсэл хэрэглэхэд бэлэн, тусламж үйлчилгээний цэгт байх
	2	Шүүлтүүртэй амны хаалт, амны хаалт, комбинзон, халад, нүдний шил, нүүрний хамгаалалт, хормогч, ханцуйвч, усны гутал, гутлын гадуурх улавч, бээлий зэрэг нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгслийн нөөцийг хүрэлцэхүйц хэмжээгээр бүрдүүлсэн байх
	3	Хамгаалах хувцас хэрэгслийн үзүүлэлт, чанар нь халдвартай орчинд хэрэглэх шаардлага хангасан байх
	4	Үзлэг нь тусгаарлан үзэх, хэвтүүлэн эмчлэх хэсэг нь тусгаарлан эмчлэх боломжтой байх
	5	Тусгаарлах өрөө нь ариун цэврийн өрөөтэй, тусгаарлалтын шаардлага хангасан байх
	6	Халдварт өвчний дэгдэлтийн үед дуугүй хөтөч, хөтөч ажилтан ажиллуулдаг байх

Шалгуур 10.12

Эмнэлгийн гаралтай аюултай хог хаягдлын менежментийг хэрэгжүүлнэ.

Агуулга

Хог хаягдлын чиглэлээр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллана.

Хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөөтэй, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг орон нутгийн болон байгууллагын төсөвт тусгана.

Үүсэж байгаа хог хаягдлын байдалд дүн шинжилгээ хийж аюултай хог хаягдлын хэмжээг бууруулах бодлого баримтлана.

Хог хаягдлын менежментэд шаардлагатай багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, дахин ашиглах, боловсруулах, зөвшөөрөгдсөн аргаар устгахад зарцуулагдах санхүүгийн тооцоо судалгааг хийж төсөвт тусгадаг байна.

Олон улсын болон Монгол улсын стандартад нийцсэн хог хаягдлын уут, сав, аюулгүй хайрцаг ашиглана. Хог хаягдалтай харьцаж ажиллаж байгаа ажиллагсдыг чанарыг шаардлага хангасан хамгаалах хувцас, хэрэгслээр хангана.

Хог хаягдлын менежментийн асуудлыг хариуцсан мэргэжилтэн, ажилтныг томилж ажиллуулна.

Хог хаягдлын менежментийн хэрэгжүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудаас дэмжлэг туслалцаа авч ажиллана.

Аюултай хог хаягдлын мэдээг хавсралт хүснэгтийн дагуу өдөр бүртгэж, дээд шатны эрүүл мэндийн байгууллагад тогтмол мэдээлнэ.

Үнэлгээ хийх чиглэл:

- Хог хаягдлыг зөв ангилан ялгаж, цуглуулах, зөөх, боловсруулах, устгалын байдлыг ажиглана.
- Аюултай хог хаягдлыг үнэн зөв бүртгэж, тэмдэглэж байгаа байдлыг үнэлнэ.
- Зөвшөөрөгдсөн аргаар устгаж байгаа эсэхийг ажиглана.
- Эмч, мэргэжилтний мэдлэг, хандлагыг ярилцаж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг зөв ангилсан байх
	2	Хог хаягдал цуглуулах уут сав нь шаардлага хангасан байх
	3	Түр хадгалах байр шаардлага хангасан байх
	4	Түр хадгалах байранд ирж байгаа хогийг хэмжих жин, гар угаах угаалтууртай байх
	5	Аюултай хог хаягдал тус бүрээр кг-аар тооцож бүртгэсэн байх
	6	Эмнэлгээс гарч байгаа аюултай хог хаягдлыг нэгтгэн сар бүр мэдээлдэг байх
	7	Хог хаягдлын ажилтан хамгаалах хувцас хэрэгслээр хангагдсан байх

БҮЛЭГ 11. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Тойм

Төв нь хүн амын хэрэгцээнд нийцүүлэн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулснаар тэгш, хүртээмжтэй үр дүнг бий болгодог.

Төвд олон нийтийн оролцооны хөтөлбөр хэрэгжүүлэх нь өвчтөнтэй бат бөх харилцаа тогтоох, эрүүл мэндийн хэрэгцээг тодорхойлох, үйлчилгээний тасалдлыг арилгах,

хамтын ажиллагааны боломжийг нэмэгдүүлнэ. Олон нийтийг оролцуулсан амжилттай хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд оролцогч талуудын идэвхтэй оролцоо шаардлагатай. Үүнд: эрүүл мэндийн ажилтан, өвчтөн түүний гэр бүл, орон нутгийн засаг захиргаа, нийгмийн эрүүл мэнд, төрийн бус, боловсролын байгууллагууд хамаарна.

Төв нь олон нийтийн оролцоог судалгаа, бүлгийн ярилцлага, уулзалт, форум, цахим сүлжээ, вэбсайт зэрэг харилцааны сувгаар хангаж болно. Олон нийтийн эрүүл мэндийн үнэлгээ нь үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээний хүрээг тодорхойлох боломжийг олгодог. Үүнд: өвчлөлийн тархалт, эрүүл мэндийн зан үйл, нийгмийн эрүүл мэндийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг цуглуулж, шинжлэх багтана.

Төв нь тамхинаас татгалзах, эрүүл хооллолт, эрүүл амьдралын хэв маяг, нөхөн үржихүйн эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэнд (сэтгэл гутрал, донтох эмгэг) зэрэг үйл ажиллагааг зохион байгуулна.

Төвд хоол тэжээлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх нь орон нутгийн олон нийтийн бүлгийн олон талт хэрэгцээг хангаж өгдөг. Хөхөөр хооллолтыг дэмжих, олон найрлагат бичил тэжээл, эрүүл хооллолтын дадал зэрэг чухал сэдвийг багтаасан хөтөлбөр нь хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй.

Хөхөөр хооллолтыг дэмжих нь дархлаа дэмжиж, хүүхдийн өсөлт бойжилтонд эерэгээр нөлөөлдөг. Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл нь жирэмсэн эмэгтэйчүүд, бага насны хүүхэд зэрэг эмзэг бүлгийн хүн амд ноцтой эрүүл мэндийн асуудал үүсгэж болзошгүй дутагдлуудыг арилгахад тусалдаг. Эрүүл хооллолтыг дэмжих нь хүн ам, гэр бүлийг тэнцвэртэй мэдээлэлд суурилсан эрүүл хооллолт сонгох соёлыг төлөвшүүлж, урт хугацаандаа эрүүл мэндэд эерэгээр нөлөөлдөг.

Эцэст нь, төвийн хоол тэжээлийг дэмжих хөтөлбөрийн цогц хандлага нь хоол тэжээлийн дутагдлыг бууруулахаас гадна эрүүл нийгмийг бий болгох, хүүхдийн хөгжлийг сайжруулах, эрүүл мэндийн зардлыг урт хугацаанд бууруулах үндэс суурийг тавьдаг.

Олон нийтийн оролцооны хөтөлбөрийг тогтмол үнэлэх нь түүний үр дүнтэй байдал болон иргэдийн өөрчлөгдөж буй хэрэгцээнд нийцүүлж буйг баталгаажуулахад зайлшгүй чухал юм. Төв нь үйл ажиллагаагаа тогтмол үнэлэх, олон нийтийн санал хүсэлтийг авах, тогтоосон стандартад нийцүүлдэг.

Бүлгийн зорилго:

1. Олон нийтийн үнэлгээний үүргийг ойлгох.
2. Гол оролцогч талууд болон түншүүдийг тодорхойлох.
3. Үр дүнтэй харилцааны сувгийг бий болгох.
4. Магадлан итгэмжлэл болон чанарын соёлыг дэмжих.

Доорх жагсаалтад энэ бүлэгт хамаарах шалгуурыг нэгтгэн харуулав.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	
11.01	Төв нь үйлчлэх хүрээний хүн амын мэдээллийг тодорхойлно.
11.02	Төв нь олон нийтийн оролцооны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
11.03	Төвийн сургалт сурталчилгааны материал нь холбогдох хууль, журам болон эрүүл мэндийн мэргэжлийн холбооны ёс зүйн хэм хэмжээнд нийцсэн байна.
11.04	Төв нь эрүүл мэндийн боловсролын хөтөлбөртэй байна.
11.05	Төв нь зорилтот бүлэгт шим тэжээлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
11.06	Халдварт болон эндемик өвчний тандалт, үр дүнг дээд шатны байгууллагад тайлагнах үйл явцыг ЭМЯ/ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлнэ.
11.07	Олон нийтийн орчны ариун цэвэр, аюулгүй усан хангамжийг хууль, журмын дагуу үр дүнтэй хянаж, хэрэгжүүлнэ.
11.08	Олон нийтийн үнэлгээ ба оролцооны хөтөлбөрийн үр дүнг хянаж, үнэлнэ.

Шалгуур 11.01

Төв нь үйлчлэх хүрээний хүн амын мэдээллийг тодорхойлно.

Агуулга

Үйлчлэх хүрээний хүн ам гэдэг нь хувь хүн, гэр бүл, байгууллага, эсвэл нийтлэг үйл ажиллагаанд хамтран оролцож, асуудлыг шийдвэрлэдэг, тухайн байгууллагын үйлчилдэг газарзүйн бүсэд оршин суудаг хүмүүсийн бүлгийг хэлнэ. Хүн амыг тодорхойлохдоо нийгмийн эмзэг бүлэг, бага орлоготой болон цөөнхийн хүн амыг оруулж тооцно.

Хүн амын мэдээллийг журмын дагуу тогтмол шинэчилж, шинэ өгөгдөл гарсан даруйд ашиглах нь нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжиж, эрүүл мэндийн хөтөлбөрийн үр ашиг хүртээмжийг оновчтой болгодог. Орон нутгийн хүн амын мэдээлэлд хүн ам зүй, эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн тодорхойлогч хүчин зүйлс багтаж болно.

Цуглуулах мэдээллийн төрлүүд нь:

Демографик мэдээлэл: нас, хүйс, хүн амын хэмжээ.

Эрүүл мэндийн байдал: өвчлөл, нас баралт, түгээмэл өвчнүүд.

Эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлс: амьдралын хэв маяг, орчин, нийгмийн нөхцөл.

Байгаль орчны онцлог: усны эх үүсвэр, ариун цэврийн нөхцөл, эрсдэлүүд.

Нийгэм, эдийн засгийн онцлог: боловсрол, орлого, ажил эрхлэлтийн байдал.

Улс төр, эдийн засгийн бүтэц: орон нутгийн засаглал, эдийн засгийн бүтэц.

Байгууллага, үйлчилгээний төвүүд: сургууль, эмнэлэг, нийгмийн төвүүд.

Эдийн засгийн үйл ажиллагаа: газар тариалан, бизнес, ажил эрхлэлт.

Нийгмийн байгуулалт: нийгмийн бүлгүүд, зан заншил, удирдлага өргөн хүрээний мэдээллийг бүртгэхийг хэлнэ.

Төв нь хамрах хүрээний олон нийтийг тодорхойлж, эрүүл мэндийн зорилтот арга хэмжээг үр дүнтэй төлөвлөнө. Дараа нь төв нь олон нийтийн түншийг тодорхойлж (ажилтан, өвчтөн болон түүний гэр бүл) эрүүл мэндийн асуудлаар хамтран ажиллах албан ёсны гэрээ байгуулна.

Үнэлгээ хийх чиглэл:

- Төвийн хамрах хүрээг тодорхойлсон баримт бичгийг /газрын зураг, хүн амын тоо, нягтрал/ үзнэ.
- Олон нийтийн хамтын ажиллагааны бичгээр хийсэн гэрээ үзнэ.
- Ажилтантай ярилцаж, үйлчлэх хүрээний хүн амын талаарх мэдлэгийг нь үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төвийн хамрах хүрээ тодорхойлсон байна.
	2	Төв нь хүн амын мэдээллийг авах, шинэчлэх баримтжуулсан байна.
	3	Хүн амын мэдээллийн эх сурвалж тодорхой байна.
	4	Мэдээлэл цуглуулах, эрүүл мэндийн төлөвлөлтөд оролцуулах түншүүдтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулсан байна.
	5	Эрүүл мэндийн шийдвэр гаргалт, үйлчилгээ сайжруулалтанд ашигласан байна.

Шалгуур 11.02

Төв нь олон нийтийн оролцооны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Олон нийтийн оролцооны хөтөлбөр нь дээрх 1–7 зүйлд нийцсэн агуулгыг тодорхойлсон журамтай байна.
	2	Олон нийтийн оролцооны үйл ажиллагаа, олон нийттэй харилцах ажлыг зохицуулах хариуцсан ажилтан томилогдсон байна.
	3	Эрүүл мэндийн хэрэгцээг үнэлэх, сайжруулах үйл ажиллагаа олон нийтийн гишүүдтэй хамтран хийгдсэн тайлан байна.
	4	Сонгосон шийдлийг олон нийтэд зарласан болон нийтэлсэн байна.
	5	Олон нийтийн оролцооны үйл ажиллагаа хэрэгжсэн тайлан байна.

Шалгуур 11.03

Төвийн сургалт сурталчилгааны материал нь холбогдох хууль, журам болон эрүүл мэндийн мэргэжлийн холбооны ёс зүйн хэм хэмжээнд нийцсэн байна.

Агуулга

Зөв сурталчилгаа нь олон нийтэд Төвөөс үзүүлж буй үйлчилгээний талаар илүү сайн ойлголт өгөхөд тусалдаг. Төв нь баннер, танилцуулга, гарын авлага, вэбсайт, цахим сүлжээний хуудас, дуудлагын төв болон бусад мэдээллийн хэрэгслийг ашиглан үйлчилгээний талаар мэдээлэл хүргэнэ.

Эмч, сувилагч, эм зүйч болон бусад мэргэжлийн холбооны ёс зүйн хэм хэмжээнд үнэнч байдал, ил тод байдлыг хамгийн чухал үнэт зүйлс гэж тодорхойлсон байдаг. Төв нь төлөвлөгөөндөө сурталчилгаа явуулахдаа холбогдох хууль, журам, ёс зүйн хэм хэмжээг судалж, стандартыг баримтална.

Үйлчилгээний төрөл, эрүүл мэндийн ажилтан, үйлчилгээний үнэ, ажлын цагийн хуваарийн талаархи мэдээлэл нь үнэн зөв, шинэчлэгдсэн, тодорхой байх ёстой.

Үнэлгээ хийх чиглэл

- Төвийн магадлан итгэмжлэлд хамрагдах хүсэлт хүлээн авснаас эхлэн шинжээч томилогдох, үнэлгээний тайлан илгээх хүртэлх хугацаанд төвийн ямар ч сурталчилгаа, мэдээллийн хэрэгслийг шалгах боломжтой. Сурталчилгаа болон олон нийттэй харилцах агуулгыг үнэлгээний тайланд тусгасан мэдээлэл болон газар дээрх үнэлгээний үеийн ажиглалттай тулган нягталж болно.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь үйлчилгээний сурталчилгааг тодорхой, шинэчлэгдсэн, үнэн зөвөөр хүргэх үйл явцыг удирдах батлагдсан журамтай байна.
	2	Зар сурталчилгаа нь хууль, журам болон эрүүл мэндийн мэргэжлийн холбоодын ёс зүйн хэм хэмжээтэй нийцсэн байна.
	3	Өвчтөн болон түүний гэр бүл Төвийн үйлчилгээ, эрүүл мэндийн ажилтан, ажлын цагийн хуваарийн талаар тодорхой, шинэчлэгдсэн, үнэн зөв мэдээлэл авдаг байна.
	4	Өвчтөн болон түүний гэр бүл үйлчилгээний төлбөрийн талаар ойлгомжтой хэл, хэлбэрээр мэдээлэл авдаг.

Шалгуур 11.04

Төв нь эрүүл мэндийн боловсролын хөтөлбөртэй байна.

Агуулга

Төвийн эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр нь нийгмийн эрүүл мэндийг дэмжихэд чухал үүрэгтэй. Хүн бүрт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын хэв маягийг бий болгоход шаардлагатай мэдлэг, ур чадварыг олгодог.

Эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр нь хоол тэжээл, дасгал хөдөлгөөн, дархлаажуулалтын талаарх мэдлэг, архаг өвчний хяналт, ариун цэврийн дадал зэрэг сэдвийг хамардаг. Хөтөлбөрийг сургалт, зөвлөгөө, олон нийтэд чиглэсэн арга хэмжээгээр дамжуулан хэрэгжүүлнэ. Энэ нь хүмүүсийг эрүүл мэндийн талаарх зөв шийдвэр гаргахад тусалдаг.

Эрүүл мэндийн боловсролын хөтөлбөрт сургалтын агуулга, зорилтот бүлэг, сургалтын үр дүн зэргийг тусгасан байна. Төвийн эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр нь орон нутгийн эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх тусламжийг дэмжих замаар үр дүн үзүүлдэг.

Төв нь эрүүл мэндийн боловсролын хөтөлбөрийг боловсруулж, дор дурдсан бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаах ёстой:

1. Эрүүл мэндийн боловсролын хэрэгцээ болон асуудлууд. (Орон нутгийн хүн амын эрүүл мэндийн байдал, өвчлөл, эрсдэлт хүчин зүйлийн үнэлгээнд үндэслэн тодорхойлсон байх)
2. Эрүүл мэндийн боловсролын зорилтот бүлгүүд. (Нас, хүйс, эрсдэлт бүлэг, архаг өвчтэй хүмүүс, жирэмсэн эхчүүд зэрэг ангиллаар тодорхой бичигдсэн байх)
3. Эрүүл мэндийн боловсролын арга зүй. (Лекц, зөвлөгөө, бүлгийн сургалт, интерактив сургалт, олон нийтийн арга хэмжээ гэх мэт)
4. Эрүүл мэндийн гол мэдээлэл. (Тодорхой, шинжлэх ухаанд суурилсан, зорилтот бүлэгт ойлгомжтой контент)
5. Эрүүл мэндийн боловсрол олгогчид болон дэмжих баг, бүлгүүд. (Сургалт явуулах эрх бүхий мэргэжилтэн болон орон нутгийн байгууллага, сайн дурын бүлгүүдийн оролцоо)

6. Цагийн хуваарь (Жилийн, улирлын, сарын төлөвлөгөө, сургалтын давтамжийн тоо)
7. Олон нийттэй харилцах сувгууд. (Орон нутгийн радио, сошиал медиа, олон нийтийн самбар, сургуулиуд, ТББ-уудтай хамтын ажиллагаа)
8. Хөтөлбөрийг Төв дотор (Танхимын сургалт, хүлээн авах хэсэгт өгч буй богино зөвлөгөө, уулзалтын өрөөнд зохион байгуулсан бүлгийн хичээл) болон гадна (Сургууль, цэцэрлэг, ажлын байр, олон нийтийн талбай, гэрийн эргэлт зэрэгт чиглэсэн сургалт, урьдчилан сэргийлэх мэдээлэл түгээх ажлууд) хэрхэн хэрэгжүүлэх.
9. Үнэлгээний хэрэгсэл. (Оролцогчийн бүртгэл, өмнөх/дараах үнэлгээний сорил, тайлан, гүйцэтгэлийн үзүүлэлт зэрэг)

Эрүүл мэндийн боловсрол олгож буй ажилтан мэргэжлийн ур чадвартай байх ёстой. Эрүүл мэндийн боловсролыг өвчтөнд хүрэхэд хялбар, тохиромжтой байршилд, шаардлагатай тооны суудалтай, гэрэлтүүлэг болон агааржуулалттай, хүний үндсэн хэрэгцээг хангах нөхцөл бүхий орчинд зохион байгуулах ёстой.

Хүртээмжтэй байршил:

Үйлчлүүлэгчид очиход амархан, үйлчилгээний урсгалд саад болохгүй.

Тохиромжтой суудлын тоо:

Сургалтын зорилтот бүлгийн тоо хэмжээнд нийцсэн байх.

Зөв гэрэлтүүлэг, агааржуулалт:

Хичээлийн орчны тав тух, аюулгүй байдлыг хангана.

Үндсэн хэрэгцээг хангах нөхцөл:

Цэвэр ус, ариун цэврийн өрөө, температурын тохиромжтой нөхцөл зэргийг хамарна.

Сургалтын хэрэгсэл гэдэг нь сургалтын материалыг үр дүнтэйгээр танилцуулахад ашиглагддаг төхөөрөмжүүдийг хэлнэ. (самбар, компьютер, проектор гэх мэт). Харин сургалтын материал нь хүнийг мэдээллийг илүү хурдан, илүү тогтвортой ойлгох, санахад дэмжлэг үзүүлдэг хэрэгслүүд (хана зураг, зураг, телевизийн нэвтрүүлэг, дуу бичлэг, видео гэх мэт)

1. Сургалтын хэрэгсэл

- **Тоног төхөөрөмжийн бэлэн байдал** – Самбар, компьютер, проектор зэрэг нь ажиллагаатай, сургалтад ашиглахад бэлэн байх.
- **Орчин нөхцөлд тохирсон байдал** – Өрөөний хэмжээ, гэрэлтүүлэг, агааржуулалт, цахилгааны аюулгүй байдал.
- **Хэрэглэх чадвар** – Сургалт удирдагч төхөөрөмжийг зөв, үр дүнтэй ашиглах мэдлэгтэй эсэх.

2. Сургалтын материал

- **Хүртээмжтэй, ойлгомжтой** – Дүрслэл, зураг, график, видео нь зорилтот бүлэгт ойлгомжтой байх.
- **Шинэчлэгдсэн, нотолгоонд суурилсан** – Агуулга нь сүүлийн удирдамж, эмнэлзүйн нотолгоотой нийцсэн байх.
- **Тогтоох, ойлгох чадварыг дэмжсэн** – Ханын зурагт самбар, бичлэг, зурагт хөтөлбөр зэрэг нь мэдээллийг ой тойнд тогтвортой үлдээхэд туслах

Үнэлгээ хийх чиглэл

- Эрүүл мэндийн боловсролын хөтөлбөрийг шалгаж, шаардлагатай бүх бүрэлдэхүүн хэсгийг хамарсан эсэхийг үнэлнэ.
- Ажилтантай ярилцаж, хөтөлбөрийн талаарх мэдлэг, ойлголтыг үнэлнэ

<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд хөтлөгдсөн үйл ажиллагааны бичилт, нотлох баримтуудыг шалгаж үнэлнэ. (сургалтын бүртгэл, оролцогчдын тоо, сургалтын материал, тайлангууд, өмнөх/дараах сорил г.м) • Төвд ашиглаж буй сургалтын хэрэгслийг ажиглана. 		
Хэмжих үзүүлэлт	1	Төвийн дотор болон гадна зохион байгуулагдаж буй Эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр нь зорилгын 1-9 хэсгийг хамарсан бүтэцтэй байна.
	2	Нийгэмд чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох үүрэг бүхий ажилтан нь шаардлагатай мэдлэг, ур чадвар, чадамжийг бүрэн эзэмшсэн байна.
	3	Эрүүл мэндийн боловсролын үйл ажиллагаа бодитоор хэрэгжиж буйг нотлох баримтууд бүрдсэн байна.
	4	Эрүүл мэндийн боловсролын хөтөлбөрийн үр нөлөөг үнэлдэг байна.
	5	Эрүүл мэндийн боловсролын хөтөлбөрийн бүх үйл ажиллагааг бүрэн баримтжуулсан байх.

Шалгуур 11.05

Төв нь зорилтот бүлэгт шим тэжээлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Агуулга

Зөв хооллолтыг дэмжих нь олон нийтийн хоол хүнсний хэрэглээтэй холбоотой мэдлэг, хандлага, дадлыг сайжруулж, тэдний эрүүл мэндийг хамгаалах, архаг өвчний эрсдлийг бууруулахад чиглэдэг. Шим тэжээлийн дэмжих хөтөлбөрүүд нь ихэвчлэн тодорхой зорилтот бүлгүүдэд чиглэгддэг. Хөхөөр хооллолт, бичил тэжээл болон хүнсний нэмэлт, эрүүл хооллолтын дадал зэрэг чиглэлүүдийг хамардаг.

Төв нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаасан шим тэжээлийг дэмжих хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх ёстой:

1. Орон нутгийн хоол тэжээлийн асуудал, тэргүүлэх хэрэгцээг тодорхойлох. (Анхдагч болон хоёрдогч мэдээллийн эх сурвалж, архаг өвчний тархалт, хоол тэжээлийн дутагдал, хооллолтын буруу дадал, тэргүүлэх эрсдлийн бүлгүүдийн тодорхойлолт)
2. Зорилтот бүлгийг тодорхойлох. (Жирэмсэн ба хөхүүл эх, хүүхэд, өндөр настан, архаг өвчтэй хүмүүс, хоол тэжээлийн эрсдэлт бүлэг)
3. Хөхөөр хооллолтыг дэмжих. (Мэдээлэл, зөвлөгөө, Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих сургалт, нотолгоо, бүртгэл)
4. Бичил тэжээл болон хүнсний нэмэлт. (Төмөр, Д аминдэм, фолийн хүчил, йод, олон төрлийн витаминууд, эрсдэлт бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн хэрэгжилт, хэрэглээний зөвлөмж ба хяналт)
5. Шим тэжээлийн боловсролын хэрэгцээ. (Орон нутгийн хүн амын хооллолтын зан үйл, нийтлэг алдаатай хэв маяг, мэдлэгийн түвшин)
6. Хөтөлбөрт оролцох ажилтнуудад шаардлагатай сургалтыг зохион байгуулах. (Шим тэжээлийн суурь мэдлэг, эхийн сүүгээр хооллолтыг дэмжих алхамууд, нотолгоонд суурилсан зөвлөх арга зүй)
7. Хөтөлбөрийн үр дүнг хянах (БЖИ, холестерин, цусны даралт, суурь ба дараах үр нөлөөний харьцуулалт, тайлангийн тогтолцоо гэх мэт)

Үнэлгээ хийх чиглэл:

- Шим тэжээлийн хөтөлбөрийг шалгаж, шаардлагатай бүх бүрэлдэхүүн хэсгийг хамарсан эсэхийг үнэлнэ.
- Ажилтантай ярилцаж, шим тэжээлийг дэмжих хөтөлбөрийн талаарх мэдлэгийг нь үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь дээр дурдсан 1-7 хэсгийг хамарсан бүтэцтэй шим тэжээлийн дэмжих хөтөлбөртэй байна.
	2	Орон нутгийн олон нийтийн хоол тэжээлийн тулгамдсан асуудлыг үнэлэх үйл явц бүрдсэн байна. Үүнд: Хүн амын мэдээллийн эх сурвалж (өвчлөл, эрсдэлт бүлэг, антропометрийн өгөгдөл) Мэдээлэл цуглуулах арга ба ашигласан хэрэгсэл тодорхойлсон хоол тэжээлийн асуудал (төмрийн дутагдал, Д аминдэм, хэт таргалалт, хооллолтын буруу хэв маяг г.м багтсан байна.
	3	Төв нь олон нийтийн хоол тэжээлийн асуудлыг эрэмбэлж, тэргүүлэх чиглэлүүдийг тогтоосон байна. Эрэмбэлэлт нь: <ul style="list-style-type: none"> • Эрсдлийн түвшин • Олон нийтийн хэрэгцээ • Нөөц боломж • Өндөр ач холбогдолтой зорилтот бүлгийн эрсдлийн суурьтай байх ёстой.
	4	Жирэмсэн болон хөхүүл эхчүүдэд хөхүүл хооллолтын ач тус, зөв менежментийн талаар мэдээлэл өгч, зөвлөгөө үзүүлдэг байна. (Зөвлөгөө авсан эхчүүдийн бүртгэл, хөхөөр хооллолтын талаар тараасан материал, Зөвлөх үйлчилгээний журам, хөхөөр хооллолтыг дэмжих бодлого (хэрэв байгаа бол)
	5	Хөтөлбөрийн үр дүнг үнэлдэг.

Шалгуур 11.06

Халдварт болон эндемик өвчний тандалт, үр дүнг дээд шатны байгууллагад тайлагнах үйл явцыг ЭМЯ/ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлнэ.

Агуулга

Төв нь халдварт болон эндемик өвчний тохиолдлыг мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, тайлбарлах үйл явцтай байх ёстой. Өвчний тандалтын үндсэн зорилго нь халдварын тархалтын цар хүрээг тодорхойлох, өвчин дамжих эрсдлийг үнэлэх бөгөөд ингэснээр урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлснээр өвчлөл, нас баралтыг бууруулна. Хавьтлыг илрүүлэх, мөшгих нь халдварт өвчнийг хянах үндсэн арга юм.

Төв нь халдварт өвчний тандалт, тайлагналтын үйл явцыг удирдах бодлого, журам боловсруулж хэрэгжүүлэх ёстой.

Журам нь дор дурдсан зүйлсийг багтаах шаардлагатай:

1 Тайлагнах шаардлагатай халдварт болон эндемик өвчний жагсаалт.

- 2 Халдварт болон эндемик өвчний тохиолдлын тодорхойлолт.
- 3 Халдвар авсан хүмүүсийн шинж тэмдгийг илрүүлэх.
- 4 Удирдлага, эмчилгээний протокол болон тайлагнах шаардлага.
- 5 Өвчнийг үр дүнтэй хянах, цаашид дамжихаас урьдчилан сэргийлэхийн тулд хоёрдогч тохиолдлыг эрт тусгаарлах, үнэлэх, эмчлэх.

Үнэлгээ хийх чиглэл

- Төвийн тандалтын хөтөлбөрийн баримт бичиг, бүртгэлийг шалгаж, шаардлагатай бүх бүрэлдэхүүн хэсгийг хамарсан эсэхийг үнэлнэ.
- Ажилтнуудтай ярилцаж, тандалтын хөтөлбөрийн талаарх мэдлэгийг нь үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь зорилгын 1-5 хэсгийг хамарсан халдварт болон нутгийн өвчний тандалтын бодлоготой байна.
	2	Хариуцсан ажилтнууд халдварт өвчний жагсаалтын талаар мэдлэгтэй бөгөөд тэдгээрийг илрүүлэх сургалтад хамрагдсан байна.
	3	Хариуцсан ажилтан дэгдэлтийн менежментийн протоколын талаар сургалтанд хамрагдсан байна.
	4	Халдварт болон эндемик өвчинтэй өвчтөнг батлагдсан удирдамжийн дагуу илрүүлж, хянадаг байна.
	5	Халдварт болон эндемик өвчинтэй өвчтөнг хууль, журмын дагуу тайлагнадаг байна.
	6	Хавьтагч илрүүлэх, илрүүлэг шинжилгээ хийх, мөшгих, хяналт тавих тогтолцоотой байна.

Шалгуур 11.07

Олон нийтийн орчны ариун цэвэр, аюулгүй усан хангамжийг хууль, журмын дагуу үр дүнтэй хянаж, хэрэгжүүлнэ.

Агуулга

Аюулгүй ундны ус, орчны ариун цэвэр нь хүний эрүүл мэндийг, ялангуяа хүүхдийг эрүүл мэндийг хамгаалахад чухал ач холбогдолтой. Усны бохирдолтой холбоотой өвчнүүд нь хөгжиж буй орнуудын иргэдийн дунд өвчлөл, нас баралтын хамгийн түгээмэл шалтгааны нэг хэвээр байна. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) мэдээлснээр аюулгүй ундны ус, орчны ариун цэвэрт анхаарах нь нэн тэргүүний зорилт юм. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээлснээр, аюулгүй ундны ус ба ариун цэврийн зохистой үйлчилгээ нь дэлхийн эрүүл мэндийн тэргүүлэх чиглэлийн нэг бөгөөд: Хүний үнэт зүйлсийг хүндэтгэх нь зайлшгүй бөгөөд энэ нь эрүүл мэндийг хамгаалж, эдийн засгийн үр өгөөжийг баталгаажуулдаг.

Усны аюулгүй байдал, чанар нь хүний хөгжил, эрүүл амьдрахын үндэс юм. Ус, агаар, хоол, бохир усны ариун цэвэр зэрэг байгаль орчны эрүүл мэнд нь дэлхийн эрүүл мэндийн тэргүүлэх чиглэлд хамаардаг. Байгаль орчны эрүүл мэндийн аливаа асуудлыг илрүүлэх нь түүнийг шийдвэрлэх эхний алхам юм.

ТӨВ нь аюулгүй ундны усны үнэлгээний тогтолцоотой байх ёстой бөгөөд олон нийтийн газраас усны дээжийг тогтмол авч, бактериологийн болон химийн шинжилгээг ЭМЯ болон/эсвэл ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу хийдэг байх шаардлагатай.

Үнэлгээ хийх чиглэл

- Төв нь орчны эрүүл ахуйн хөтөлбөр бодитоор хэрэгжиж байгаа эсэх, усны аюулгүй байдлын хяналт тогтмол хийгдэж байгаа эсэхийг баримтаар шалгана.
- Ажилтнуудтай ярилцаж, орчны ариун цэвэр, усан хангамжийн хөтөлбөрийн талаарх мэдлэгийг нь үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Аюулгүй ундны ус, орчны ариун цэврийг хянах үйл явцыг тодорхойлсон, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар тодорхой заасан баталгаажсан журамтай байна.
	2	Хариуцсан ажилтан нь боловсрол, туршлагын хувьд шаардлага хангасан байна.
	3	Байгаль орчны эрүүл мэндийн асуудлуудыг тодорхойлсон байна.
	4	Үйлчлэх хүрээний олон нийтийн газраас усны дээж авч, шинжилгээ хийдэг байна.
	5	ТӨВ нь усны шинжилгээний эх хувийг эсвэл хуулбарыг хадгалдаг байна.
	6	Шаардлага хангаагүй шинжилгээний үр дүн гарсан тохиолдолд холбогдох байгууллагуудтай хамтран зохих арга хэмжээ авдаг байна.

Шалгуур 11.08

Олон нийтийн үнэлгээ ба оролцооны хөтөлбөрийн үр дүнг хянаж, үнэлнэ.

Агуулга

Олон нийтийн эрүүл мэндийн хэрэгцээг үнэлэх нь Төвийн эрхэм зорилго, үйлчилгээний чиглэлүүдийг орон нутгийн эрүүл мэндийн бодит асуудалтай уялдуулахад чухал үүрэгтэй. Ингэснээр нөөцийг илүү оновчтой хуваарилах, олон нийтийн эрүүл мэндийг сайжруулах боломж бүрддэг. Хөтөлбөрийн үйл ажиллагааг үнэлэх нь тэдгээрийн үр нөлөөг баталгаажуулах, мөн үйл явцын туршид олж авсан сургамжийг тодорхойлох чухал ач холбогдолтой. Олон нийтийн санал хүсэлт, гомдолд үндэслэн арга хэмжээ авах нь иргэдэд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гол тулгуур зарчим юм. Байгууллага нь өвчтөнтэй хариуцлагатай, ил тод, харилцаатай байна.

Төв нь олон нийтийн оролцооны хөтөлбөрийн үнэлгээг дараах байдлаар хийж болно:

- а) Олон нийтийн хэрэгцээ, эрсдлийг хоёр жилд нэгээс доошгүй удаа үнэлэх.
- б) Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөөг үнэлэх.
- в) Нийгмийн үйл ажиллагаанд оролцсон иргэдийн сэтгэл ханамжийг хэмжих.
- д) Олон нийт болон гадаад үйлчлүүлэгчдийн гомдлыг шийдвэрлэх.
- е) Олон нийтийн үйл ажиллагааны үеэр гарч болох түрэмгий, хүндрэлтэй нөхцөл байдлыг удирдах.
- ф) Хэвлэл мэдээлэл болон цахим орчинтой харилцах менежмент.

Үнэлгээ хийх чиглэл

1. Олон нийтийн үнэлгээ, оролцооны төлөвлөгөөг шалгаж, үр дүнг хэмжсэн эсэхийг үнэлнэ.
2. Удирдлагатай ярилцаж, төлөвлөгөөний талаар лавлана.

3. Ажилтантай ярилцаж, олон нийтийн санаачилгын талаарх мэдлэгийг нь шалгана.		
Хэмжих үзүүлэлт	1	Олон нийтийн хэрэгцээ, эрсдлийг хоёр жил тутамд үнэлдэг байна
	2	Олон нийтийн байдалд хөндлөнгийн оролцооны өмнөх болон дараах үеийн харьцуулалт хийдэг байна.
	3	Олон нийтэд үзүүлсэн нийгмийн үйл ажиллагааны сэтгэл ханамжийг олон төрлийн аргаар хэмждэг байна.
	4	Олон нийт болон гадаад үйлчлүүлэгчдийн гомдлыг шийдвэрлэдэг байна.
	5	Түрэмгий нөхцөл байдлыг удирдах арга хэмжээ (шаардлагатай тохиолдолд цагдаа дуудах гэх мэт) хэрэгждэг.
	6	Хэвлэл мэдээлэл болон цахим орчинтой харилцах албан ёсны үйл явц хэрэгждэг байна.

БҮЛЭГ 12. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Тойм

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний байгууллага /цаашид ТӨВ гэх/ нь үйлчлүүлэгч/өвчтөн, ажилтны аюулгүй байдлыг хангахын тулд орчин болон барилга байгууламжийн менежментэд онцгой анхаарах шаардлагатай.

Хүрээлэн буй орчин, барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангахад байгаль орчны аюулгүй байдлыг хангахаас эхлээд гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, гамшиг, ослын үеийн бэлэн байдал, эрүүл мэндийн ажилтныг бэлтгэх, сургах хүртэл асуудлууд хамаарна.

Төв нь байгаль орчин, барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах барилгын норм, дүрэм, стандарт, галын аюул, эрсдэлээс сэргийлэх хууль тогтоомжийг дагаж мөрдөх ёстой.

Байгууллага нь барилга байгууламжийн бүрэн бүтэн байдлыг хангах, галын аюулгүй байдал болон барилгын норм, дүрмийг мөрдөх, болзошгүй аюул, эрсдэлийг илрүүлэх, арилгах зорилгоор тогтмол үзлэг, шалгалт хийнэ. Мөн гамшигийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх бөгөөд ингэснээр байгалийн гамшгаас эхлээд хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй онцгой байдалд үр дүнтэй хариу арга хэмжээ авах боломж бүрдэнэ. Байгаль орчин болон барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах, гамшиг ослын үеийн бэлэн байдлыг хангахад ажилтныг сургах зайлшгүй шаардлагатай. Ажилтнууд осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, онцгой байдалд хариу арга хэмжээ авах, хувийн хамгаалах хэрэгслийг зөв ашиглах чадвартай байх ёстой.

Эдгээр сургалт нь тасралтгүй явагдаж, дараах сэдвүүдийг хамарна. Үүнд:

- Аюултай бодистой харьцах
- Гал түймэр, химийн бодис асгарах үед хариу арга хэмжээ авах
- Онцгой байдлын үед өвчтөнийг аюулгүй нүүлгэн шилжүүлэх

Мөн эрчим хүчний хэмнэлттэй систем нэвтрүүлэх, галд тэсвэртэй материал ашиглах, усны хэрэглээг бууруулах нь барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангахаас гадна байгаль орчинд ээлтэй, тогтвортой байдлыг хангах зорилгод нийцнэ.

Энэ бүлэг нь байгууллагын байгаль орчин, барилга байгууламжийн аюулгүй байдлыг төлөвлөх, үр дүнтэй удирдахад чиглэнэ. Үүнд байгаль орчин, барилга байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах, сайжруулах, үнэлэх, жил бүр шинэчлэх шаардлагыг тодорхойлно.

Үндсэн зорилт нь байгууллага аюулгүй байдлын асуудлыг тодорхойлж, байгаль орчны аюулгүй байдлыг хадгалах, сайжруулахад чиглэсэн үр дүнтэй төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхэд оршино. Бүлэг нь дараах үндсэн чиглэлүүдийг хамарна.

1. **Аюулгүй байдал**— Барилга, байгууламж, барилгын талбай, орчин, тоног төхөөрөмж нь үйлчлүүлэгч/өвчтөн, ажилтанд аюул, эрсдэл учруулахгүй байх;
2. **Хамгаалалт (Security)**— Ажилтан, үйлчлүүлэгчдийн эд хөрөнгийг алдах, хулгай, эвдрэл, гэмтэл, зөвшөөрөлгүй нэвтрэх, ашиглахаас хамгаалахын тулд эрсдэлийг үнэлэх;
3. **Галын аюулгүй байдал**— Гал түймрээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, зохистой хариу арга хэмжээ авах, галын үед аюулгүй нүүлгэн шилжүүлэх стратеги; **Эм**
4. **Эмнэлгийн тоног төхөөрөмж**— Эмнэлгийн тоног төхөөрөмжийг сонгох, шалгах, турших, засварлах, аюулгүй ашиглах үйл явц;
5. **Инженерийн системүүд (Utility systems)**— Цахилгаан, ус, халаалт, агааржуулалт зэрэг бүх инженерийн системийн үр ашиг, найдвартай ажиллагааг хангах зорилгоор тогтмол шалгалт, засвар, туршилт хийх;
6. **Гамшгийн үеийн бэлэн байдал, удирдлага**— Байгууллагын онцлогт тохирсон байгалийн болон бусад онцгой нөхцөл байдалд бэлтгэх, хариу арга хэмжээ авах, аюулгүй орчин бүрдүүлэх.

Байгууллага дотор эмнэлгийн бус нэгжүүд (жишээ нь: бие даан ажилладаг кофе шоп, бэлэг дурсгалын дэлгүүр) байгаа тохиолдолд тухайн байгууллагын аюулгүй байдлын хөтөлбөрт нийцүүлэн ажиллуулна.

Шалгуур үзүүлэлтүүд:

12.1	Төвийн орчин, барилга, инженерийн байгууламж нь хууль, тогтоомжийн шаардлага, хэвийн ажиллагааг хангасан байна.
12.2	Барилга, инженерийн байгууламжийн аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах, арилгах арга хэмжээ хэрэгжүүлдэг байна.
12.3	Төв нь хууль, дүрэм, журамд нийцүүлэн галын аюулгүй байдлыг ханган ажиллаж, дасгал, сургуулилт хийдэг байна.
12.4	Гал, утааг эрт илрүүлэх дохиолол, гал унтраах, галын аюулгүй байдлыг хангах тоног төхөөрөмж, хэрэгслээр хангагдсан, барилгын хийц материал нь галд тэсвэртэй байна.
12.5	Байгууллага нь үүсч болзошгүй гамшиг, осолд хариу арга хэмжээ авах гамшгийн онцгой байдлын бэлэн байдлын төлөвлөгөөтэй, төлөвлөгөөнд жил бүр тодотгол хийж бэлэн байдлыг хангаж ажилладаг байна.

12.6	Байгууллага нь үйлчлүүлэгч болон ажилтны амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж ажиллана.
12.7	Эрүүл мэндийн байгууллага нь “Тамхигүй орчин”-г бүрдүүлсэн байна.
12.8	ЭМБ нь “Ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн бодлого”-ыг дэмжиж, хэрэгжүүлж ажилладаг байна.
12.9	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, засвар, техникийн үйлчилгээ

ШАЛГУУР, ЗОРИЛГО, ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур 12.1

Төвийн орчин, барилга, инженерийн байгууламж нь хууль, тогтоомжийн шаардлага, хэвийн үйл ажиллагааг хангасан байна.

Агуулга

Хүрээлэн буй орчин, барилга байгууламж нь үйлчлүүлэгч/өвчтөн болон эрүүл мэндийн ажилтанд таатай нөхцлийг бүрдүүлэхээс гадна химийн аюултай бодис, гал түймэр зэрэг аюул, эрсдэлийн үед нүүлгэн шилжүүлэх, аюулгүй байдлыг хангасан байна.

Барилгын гарц, коридорын өргөн, хүлээлгийн хэсгийн зохион байгуулалт зэрэг нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахуйц байх шаардлагатай.

Эрсдэлээс сэргийлэх зорилгоор байгууллагууд холбогдох хууль, журам, стандартын хэрэгжилтийг хангаж, мөрдөж ажилладаг, барилга, инженерийн байгууламжийн хэвийн ажиллагааг хянан шалгаж, сайжруулдаг тогтолцоо бүрдсэн байна. Хяналт шалгалтын явцад зөрчил илэрсэн тохиолдолд засаж сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх үүрэгтэй.

Байгууллага нь барилга, инженерийн байгууламжийн байршил, бүрэлдэхүүн хэсгүүдийг харуулсан схем, зураглалтай, аюулгүй байдлыг сайжруулах, тоног төхөөрөмж шинэчлэх, солиход шаардагдах төсөв, орчны болон байгууламжийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөтэй, орчны эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна.

Үнэлгээ хийх чиглэл:

- Барилга, инженерийн байгууламжийн байршил, бүрэлдэхүүн хэсгүүдийг харуулсан схем, зураглалыг үзнэ.
- Төсвийн төлөвлөгөөг үнэлнэ.
- Хяналтын байгууллагын болон өөрсдийн хяналт, үнэлгээний дүгнэлт, тайлантай танилцана.
- Илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээний төлөвлөгөө, тайлан, шийдвэрлэсэн байдалтай танилцана.
- Тойрон үзлэгийн явцад хууль, дүрэм, журмын хэрэгжилт болон орчны зохион байгуулалт, барилгын орц, гарц, коридори, өрөө тасалгааны талбайн хэмжээ, урсгал зэрэг нь тасаг, нэгжийн үйл ажиллагаанд нийцэж буй эсэхийг ажиглан үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Барилга, инженерийн байгууламжийн байршил, бүрэлдэхүүн хэсэг /цахилгаан, сантехник, агааржуулагч, дохиолол холбоо, хийн систем/ бүрийг тухайн мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан схем, зураглалтай байна.
	2	Барилга, инженерийн байгууламжид үзлэг, шалгалт хийсэн тэмдэглэл, баримтжуулалттай байна.
	3	Барилга, инженерийн байгууламжийн хэвийн ажиллагааг хянаж шалгаж, зөрчлийг арилгах, хэвийн ажиллагааг хангах төлөвлөгөө, хэрэгжилтийг баримтжуулсан байна.
	4	Барилгын урсгал засвар, тоног төхөөрөмж, дэд бүтцийн шинэчлэх төлөвлөгөө, төсөвтэй байна.
	5	Байгууллагын гадна орчин нь стандартын шаардлага хангасан байна.

Шалгуур 12.2

Барилга, инженерийн байгууламжийн аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах, арилгах арга хэмжээ хэрэгжүүлдэг байна.

Агуулга

Төв нь жил бүр барилга, инженерийн байгууламжийн эрсдэлийн үнэлгээ хийж эрсдэлийг тодорхойлно. Дараах эрсдэлүүдийг үнэлж болно.

- Цахилгаан хангамж тасалдах, цахилгааны аюулгүй байдал алдагдахтай холбоотой эрсдэл;
- Галын аюулгүй байдал алдагдсантай холбоотой эрсдэл;
- Газар хөдлөлт, үер зэрэг байгалийн гамшиг ослын эрсдэл;
- Усан хангамжаас гаралтай Legionella болон бусад үүсгэгчийн шалтгаантай халдварын дэгдэлтийн эрсдэл;
- Сантехник эсвэл дээврийн ус алдагдсанаас болж хөгц үүсэх эрсдэл;
- Эмнэлгийн хий, вакуум системийн дэлбэрэлттэй холбоотой эрсдэл;
- Барилгын тоосжилт болон мөөгөнцрийн спорын тархалтаас өвчтөнд үүсэх эрсдэл;
- Барилгын хийц материалтай холбоотой (асбест) холбоотой эрсдэл.

Эрсдэлийг тодорхойлж, эрэмблэн, бууруулах, арилгах арга хэмжээ авна.

Аюулгүй байдлын эрсдэл, гэмтэл учруулж болзошгүй жишээнд:

- Хурц иртэй болон эвдэрсэн тавилга, эвдэрсэн цонх,
- Ус алдах,
- Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэл (жишээ нь, өвчтөн эсвэл хүнд зүйл зөөх үед ажилтнуудад үүсэх эрсдэл),
- Унаж гэмтэх эрсдэл (жишээ нь, жигд бус эсвэл гулгамтгай шал, бариулын дутуу байх) орно.

Аюулгүй байдлын эрсдэлийг тогтмол үзлэг хийх, жил бүрийн эрсдэлийн үнэлгээ хийх нь эмнэлэгт сайжруулалтыг тодорхойлох, эрэмбэлэх, төлөвлөх, хэрэгжүүлэхэд тусалдаг.

Эрэмбэлэлт, төлөвлөлтөд мөн байгууламж, систем, тоног төхөөрөмжийг урт хугацаанд шинэчлэх эсвэл солих төсөвлөлт багтана.

Үнэлгээ хийх чиглэл:

- Барилга, инженерийн байгууламжтай холбоотой жил бүр хийсэн эрсдэлийн үнэлгээний тайланг үнэлнэ.
- Эрсдэлийг бууруулах чиглэлээр хийсэн үйл ажиллагаатай танилана.
- Тойрон үзлэгээр барилга, инженерийн байгууламжтай холбоотой ажилтан, үйлчлүүлэгч/өвчтөнд учирч болох эрсдэл байгаа эсэхийг харж үнэлнэ.
- Үнэлгээний явцад гарсан эрсдэлийг байгууллага өөрөө эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлж, арилгах арга хэмжээг төлөвлөсөн эсэхийг баримт бичгээс харж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт:	1	Жил бүрийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.
	2	Эрсдэлийг зөв тодорхойлж гаргасан байна.
	3	Инженерийн байгууламж, дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.
	4	Барилга, байгууламжийн аюулгүй байдал алдагдаж эрсдэл үүссэн тохиолдлыг мэдээлж, дүн шинжилгээ хийж, арга хэмжээ авдаг байна.
	5	Эрсдэл үүссэн үед дохио өгөх дохиоллын систем, цаг алдалгүй хариу арга хэмжээ авах хамгаалалтын бүх тоног төхөөрөмж, системийг шалгаж, үнэлж, засвар үйлчилгээ хийнэ.

Шалгуур 12.3

Төв нь хууль, дүрэм, журамд нийцүүлэн галын аюулгүй байдлыг ханган ажиллаж, дасгал, сургуулилт хийдэг байна.

Агуулга

Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн галын аюулаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй байна.

Галын аюулгүй байдлын төлөвлөгөө дараах асуудлыг багтаасан байна.

- Гар гарсан, гал гарах эрсдэл үүссэн тохиолдлыг мэдээлэх, хариу арга хэмжээ авах зураглал;
- Өндөр шатамхай бодисыг аюулгүй хадгалах, ашиглах;
- Гал гарсан үед аюулгүйгээр нүүлгэн шилжүүлэх төлөвлөлт;
- Хууль дүрмийн дагуу тамхи татахгүй байх бодлогыг мөрдүүлэх;
- Галын аюулгүй байдлын эрсдэлийг үнэлэх;
- Гал гарсан үед ажилтнуудын хариуцах үүрэг;
- Галын дохиолол ажиллуулах;
- Ажиллагсдын дасгал, сургуулилт, сургалт зэрэг багтсан байна.

Ажиллагсад жилд дор хаяж 1 удаа галын аюулгүй байдлын сургуулилтад хамрагдана. Байгууллагын бүх ажилтан гал унтраах хэрэгслийг зөв ашиглах мэдлэгтэй байна.

Галын дадлага сургуулилт нь ажилтнуудыг галын аюулгүй байдлын төлөвлөгөөг бүрэн ойлгож, онцгой нөхцөлд хурдан, аюулгүй, эмх цэгцтэй, өөртөө итгэлтэй хариу үйлдэл үзүүлэх чадварт сургах зорилготой. Энэ нь өвчтөнүүдийг гарцаар аюулгүй нүүлгэн шилжүүлэх чадварыг сайжруулна.

Галын аюулгүй байдлын дасгал, сургуулилалтыг бодитоор хийж ажилтнууд юу хийх, хэрхэн гарц руу гарах, хаана цуглах (цуглах цэгүүд) талаар сургагдсан байх ёстой.

Галын аюулгүй байдлын хөтөлбөрийг үнэлэх өөр нэг жишээ нь нэгж бүрт “галын хяналтын ажилтан” (fire marshal) томилж, ажилтнуудаас тухайн нэгж дээр гал гарвал юу хийх талаар санамсаргүй байдлаар асуулт тавих юм. Жишээ нь:

- “Хүчилтөрөгчийн хаах хавхлага хаана байдаг вэ?”
- “Хэрэв хүчилтөрөгчийн хавхлагыг хаах шаардлагатай бол хүчилтөрөгч шаардлагатай өвчтөнүүдийг хэрхэн арчлах вэ?”
- “Танай нэгжид галын хор хаана байрладаг, ямар нөхцөлд, хэрхэн ашиглах вэ?”
- “Галын үед өвчтөнүүдийг хэрхэн хамгаалах вэ?”

Ажилтнууд эдгээр асуултад зөв хариулах чадвартай байх ёстой. Галын хяналтын ажилтан оролцсон хүмүүсийн бүртгэлийг хөтөлнө.

Үнэлгээ хийх чиглэл:

- Галын аюулгүй байдлын төлөвлөгөө
- Галын аюулгүй байдлын үзлэг шалгалтын тайлан
- Галын системийн засвар үйлчилгээний бүртгэл
- Гал унтраах хэрэгслийг ашиглах чадавхийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Галын аюулгүй байдлын төлөвлөгөөтэй байна.
	2	Галын эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.
	3	Харьяалах нутаг дэвсгэрийн Онцгой байдлын газар/ хэлтэстэй хамтран ажиллагсад жилд 1-2 удаа галын аюулгүй байдлын дадлага, сургалтыг зохион байгуулж, баримтжуулсан
	4	Ажиллагсад дадлага, сургалтад хамрагдаж гал унтраах хэрэгслийг ашиглаж сурсан
	5	Харьяа аймаг, дүүргийн Онцгой байдлын газар, хэлтсээс жил бүр галын байцаагчийн дүгнэлт гаргуулсан байх

Шалгуур 12.4

Гал, утааг эрт илрүүлэх дохиолол, гал унтраах, галын аюулгүй байдлыг хангах тоног төхөөрөмж, хэрэгслээр хангагдсан, барилгын хийц материал нь галд тэсвэртэй байна.

Агуулга

Барилгын зураг төсөл, зохион байгуулалт, барилгын хийц, дотор заслын материалын шатамхай чанар зэрэг нь гал түймрээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой.

Гал түймрийн үед галын дохиолол, гал унтраах төхөөрөмж нь бэлэн хүртээмжтэй байх ёстой.

Гал гарсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авах тусгай тэмдэг бүхий гарц, схем зураглалтай байна. Мөн галын аюулын үед сэрэмжлүүлэх дуудлагын болон дохиоллын хэрэгсэлтэй байна.

Галын аюулгүй байдлын тоног төхөөрөмж, хэрэгсэлд дараах зүйлс орно:

- Дулаан болон утаа мэдрэгч
- Галын дохиолол
- Галын насос

- Ус дамжуулах хоолойн систем (standpipe systems)
- Ус цацагч систем (sprinklers)
- Зөөврийн галын хор
- Галын гарц, түүнд саадгүй нэвтрэх боломж, ойлгомжтой тэмдэг, тэмдэглэгээ (жишээлбэл: дүрс тэмдэг эсвэл олонх нь ойлгодог хэл дээр)
- Ослын үеийн гэрэлтүүлэг

Гал, ослын үеийн тэмдэг тэмдэглэгээ нь үйлчлүүлэгч/өвчтөн, ажилтан, зочид байгууламжаас аюулгүй гарах эсвэл барилгын доторх аюулгүй байрлалд хүрэх замын зураг болно.

Байгууллага нь галын аюулгүй байдлын тоног төхөөрөмж, хэрэгслийн хэвийн ажиллагааг тогтмол шалгана.

Үнэлгээ хийх чиглэл:

- Галын дохиолол, гал унтраах болон утаа хянах систем нь хэвийн ажиллаж буй эсэхийг шалгана.
- Галын гарц, схем зураглал, зураглалын дагуу аюулгүй гарах боломж байгаа эсэхийг үнэлнэ.
- Үнэлгээний баг нь ажилтнуудтай ярилцлага хийж галын аюулгүй байдлын төлөвлөгөөний талаарх мэдлэгийг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Гал болон утаа мэдрэх дохиололтой байна.
	2	Гал унтраах хэрэгслээр хангагдсан, шаардлагатай цэгүүдэд байршуулсан байна.
	3	Галын дохиолол, унтраах хэрэгслийн хэвийн ажиллагааг хангасан байна.
	4	Галын аюулаас урьдчилан сэргийлэх буланг шаардлагатай цэгүүдэд байршуулсан
	5	Аврах гарцын схем, тэмдэг тэмдэглэгээнүүдийг шаардлагатай цэгүүдэд байршуулсан
	6	Галын аюулгүй байдлын үед ашиглах дуут дохио, холбоо хэрэгслээр хангасан
	7	Аваарын гэрэлтүүлэгтэй байна.

Шалгуур 12.5

Байгууллага нь үүсч болзошгүй гамшиг, осолд хариу арга хэмжээ авах гамшгийн онцгой байдлын бэлэн байдлын төлөвлөгөөтэй, төлөвлөгөөнд жил бүр тодотгол хийж бэлэн байдлыг хангаж ажилладаг байна.

Агуулга

Уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчны бохирдол, технологийн хурдацтай хөгжилтэй холбоотойгоор дэлхий даяар үер, ган, газар хөдлөлт, хөрсний гулгалт зэрэг байгалийн гамшгийн эрсдэл нэмэгдэж байна. Эдгээр гамшигаас бүрэн урьдчилан сэргийлэх боломжгүй ч гарах үр нөлөөг нь үр дүнтэй төлөвлөлтөөр бууруулах боломжтой. Мөн осол, гал, усны эрсдэл, үймээн, самуун, террорист халдлага, үйлдвэрийн осол, дэлбэрэлт зэрэг олон хүнийг хамарсан осол болоход эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдал хангалтгүй байснаар хүний амь нас,

эрүүл мэндийн хохирол улам нэмэгддэг.

ЭМБ нь тохиолдох магадлалтай гамшиг, ослын нөлөөлөлд суурилсан бэлэн байдлын төлөвлөгөөтэй байна. Төлөвлөгөө нь дараах агуулгыг багтаана. Үүнд:

- a) Харилцаа холбоо/дотоод харилцаа холбоо, ажилтны албан тушаал, холбоо барих дугаар, гадаад харилцаа холбоо-онцгой байдал, түргэн тусламж, цагдаа гэх мэт байгууллагуудтай холбогдох дугаарууд, мэдээ мэдээллийн схемүүд/
- b) Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, ажил үүргийн хуваарь
- c) Онцгой байдлын үед шаардагдах эм тариа, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, хүн хүч, машин техникийн бэлэн байдлын судалгаа
- d) Үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө
- e) Яаралтай тусламжийн үед авах арга хэмжээ
- f) Ажилтны үндсэн үүргийг хадгалах
- g) Нөөц байршил, нөөц дэд систем
- h) Яаралтай үед өвчтөн тээвэрлэх зохион байгуулалт гэх мэт

Байгалийн гамшиг (үер, газар хөдлөлт гэх мэт), дотоод ба гадаад аюул, дулааны хэт халалт, дайн, бөмбөгийн аюул, террорист халдлага, зам тээврийн осол, цахилгааны тасалдал, гал түймэр, хийн алдагдал зэрэг аюулуудад эрсдэлийн үнэлгээ хийнэ.

Дадлага сургалтын төлөвлөгөө, онцгой байдлын сургуулилтыг жилд дор хаяж 1 удаа зохион байгуулна.

Бэлэн байдлын төлөвлөгөөг жил бүр болон шаардлагатай үед үнэлж, шинэчилнэ.

Үнэлгээ хийх чиглэл:

- Бэлэн байдлын төлөвлөгөө болон холбогдох баримт бичгүүдийг хянаж, бүх тодорхойлосон эрсдэлийг хамруулсан эсэхийг баталгаажуулна.
- Тоног төхөөрөмж, эм, хэрэгсэл, нөөц материал, үйл ажиллагааны карт болон бусад бэлтгэлийг үйл ажиллагааны явцад шалгана.
- Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах чиглэлээр хийж байгаа үйл ажиллагаатай танилцаж үнэлнэ.
- Ажилтны сургалтыг сургалтын баримт бичиг болон ярилцлагаар үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт:	1	Зорилго хэсгийн a–h бүх шаардлагыг тусгасан батлагдсан бэлэн байдлын төлөвлөгөөтэй байна.
	2	Ажилтнууд уг төлөвлөгөөний дагуу сургалтад хамрагдсан, онцгой байдлын үед хүлээх үүргээ мэддэг байна.
	3	Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулсан байна.

Шалгуур 12.6

Байгууллага нь үйлчлүүлэгч болон ажилтны амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж ажиллана.

Агуулга

Эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгч/өвчтөн, тэдгээрийн ар гэрт чиглэсэн бие махбодын болон үг хэлээр доромжлох, хүчирхийлэл, дарамт, эмнэлгийн бичиг баримтын аюулгүй байдал, кибер аюулгүй байдал, эд хөрөнгө хулгайлах зэрэг аюулгүй байдал алдагдах эрсдэл эрүүл мэндийн байгууллагад тохиолддог.

Аюулгүй байдлыг хангах зорилгоор ЭМБ нь хяналтын камер (CCTV), харуул хамгаалалтын ажилтан ажиллуулах, өндөр эрсдэлтэй бүсийг тодорхойлж ажилтан,

үйлчлүүлэгч/өвчтөн, зочдыг хамгаалах байдлаар эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ.

Аюулгүй байдлыг хангаж ажиллах чиглэлээр ажилтнуудад сургалт зохион байгуулна.

Үнэлгээ хийх чиглэл:

- Өндөр эрсдэлтэй бүсүүдэд хяналт, аюулгүй байдлыг хангах зохицуулалт хийсэн эсэхийг шалгана.
- Зорилго хэсэгт дурдсан аюулгүй байдал алдагдсан тохиолдлуудад хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ, шийдвэрлэлт.
- Хяналтын камержуулалт, кибер аюулгүй байдлын хамгаалалт зэргийг харж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт:	1	Аюулгүй байдал алдагдсан үед шийдвэрлэсэн байдал,
	2	Эрсдэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ .
	3	Хяналтын камержуулалт
	4	Кибер аюулгүй байдал
	5	Хамгаалалтын ажилтан ажилуулдаг эсэх

Шалгуур 12.7

Эрүүл мэндийн байгууллага нь “Тамхигүй орчин”-г бүрдүүлсэн байна.

Агуулга

АНУ-ын Өвчний хяналт сэргийлэлтийн төвийн (CDC) мэдээллээр уушгины хорт хавдрын нас баралтын ойролцоогоор 90%, уушгины архаг бөглөрөлт өвчнөөр нас барж буй хүмүүсийн 80% орчим нь тамхидалтаас шалтгаалдаг. ЭМБ дотор тамхи татахыг хориглодог боловч зарим хүмүүс эмнэлгийн гадаад орчин, ариун цэврийн өрөөнд тамхи татсанаар дам тамхидалт, орчны бохирдол, галын эрсдэл, сөрөг зан үйлийн үлгэр дуурайл үүсэх нөхцөл бүрддэг. Тамхигүй орчны бодлого нь тамхины хэрэглээ болон түүнтэй холбоотой өвчлөлийг бууруулахад чухал ач холбогдолтой. ЭМБ нь тамхигүй орчны бодлого, журамтай, өвчтөн, ажилтан, зочдод тамхигүй орчныг бүрдүүлж, дам тамхидалтаас үүдэлтэй эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Эмнэлгийн орчинд тамхи татсан үед зөрчлийн хариуцлага тооцох, гадна хэсэгт тусгай тамхи татах цэгтэй байна.

Үнэлгээ хийх чиглэл:

- Ажилтан болон үйлчлүүлэгч/өвчтөнтэй ярилцлага хийж, байгууллагын тамхигүй бодлогын талаарх мэдлэгийг үнэлнэ.
- Тамхи татах бүсийн байршил
- Тамхи татсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар ойлголтыг үнэлнэ.
- Үнэлгээний явцад зөвшөөрөгдөөгүй бүсэд тамхи татах зөрчил байгаа эсэхийг ажиглаж үнэлнэ. Үүнд: Тамхины иш, тамхины хайрцаг

Хэмжих үзүүлэлт:	1	“Тамхигүй орчин” бүрдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүн.
	2	Ажилтан, үйлчлүүлэгч/өвчтөн, зочид нь байгууллагын “Тамхигүй орчин” бүрдүүлэх талаар мэдлэгтэй байна.
	3	Байгууллагын дотоод орчинд тамхи татаагүй байна.

Шалгуур 12.8

ЭМБ нь “Ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн бодлого”-ыг дэмжиж, хэрэгжүүлж ажилладаг байна.

Агуулга

Эрчим хүчний хомсдол, байгаль орчны доройтол нэмэгдэж буй өнөө үед анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн дадлыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага болж байна. ЭМБ нь чанартай тусламж үзүүлэхийн зэрэгцээ байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

“Ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн бодлого”-д дараах ойлголтууд багтана. Үүнд:

- a) Байгаль орчинд ээлтэй тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд удирдлагын манлайлал, ажилтны санал санаачлагыг дэмжих, оролцоог хангаж байгаа эсэх;
- b) Нөөцийн зөв хуваарилалт, хэрэглээний зохистой менежмент;
- c) Хог хаягдлын менежмент, хог хаягдлыг бууруулах, зөв ангилан ялгах, байгаль орчинд халгүй аргаар устгах зарчимд суурилсан цогц арга хэмжээ;
- d) Ногоон дэд бүтцийн шийдлүүд:
 - Байгалийн гэрлийг илүү ашиглах
 - Гаднах илүүдэл гэрэлтүүлгийг хязгаарлах
 - Эрчим хүчний хэмнэлттэй LED гэрэл ашиглах
 - Хөдөлгөөн мэдрэгчтэй гэрэлтүүлэг ашиглах
 - Агааржуулалтын температурыг 24°C орчимд тохируулах
 - Ажлын бус цагаар тоног төхөөрөмжийг унтраах
 - Ус хэмнэх тоноглол ашиглах зэрэг орно.
- e) **“Ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн бодлого”-ын хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийдэг байна.**

Үнэлгээ хийх чиглэл:

- Байгууллагын түвшинд бодлогыг хэрэгжүүлж байгаа эсэхийг хянаана.
- Байгууллагын удирдлага, ажилтнуудтай ярилцлага хийж, **“Ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн бодлого”-ын талаар ойлголт, мэдлэг, хандлага, цаашид хийх ажлын төлөвлөлт, хэрэгжилтийг үнэлнэ.**
- Хог хаягдлын менежмент, ногоон дэд бүтцийн шийдлийг бодит байдал дээр нь харж үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт:	1	Удирдлагын манлайлал, дэмжлэг
	2	Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны баримт бичиг
	3	Ногоон дэд бүтцийн шийдлүүд

Шалгуур 12.9

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, засвар, техникийн үйлчилгээ

Агуулга

Эмнэлгийн тоног төхөөрөмж нь оношлогоо, эмчилгээний үндсэн хэрэгсэл юм. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, мэргэжилтнүүд тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хариуцдаг. Тоног төхөөрөмжийн хяналт, засвар үйлчилгээ дутмаг байх нь үйл ажиллагааны доголдол үүсч оношлогоо, эмчилгээний чанарт

нөлөөлж өвчтөнд хохирол учруулах эрсдэлтэй.

Иймээс Төв нь тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, засвар үйлчилгээг үйлдвэрлэгчийн заавар болон гэрээт үйлчилгээний дагуу зохион байгуулна.

Төв нь тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- a) Тоног төхөөрөмжийг тогтмол хугацаанд үзлэг, шалгалт, туршилт хийх;
- b) Шинэ төхөөрөмж суурилуулах үед болон ашиглалтын явцад ажилтанд сургалт хийх;
- c) Тоног төхөөрөмжийн бэлэн байдал, ажиллагааны байдалд хяналт тавих. Ялангуяа амь насыг дэмжих чухал төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагаанд хяналт тавих. Жишээ нь: Амьсгалын аппарат, дефибриллятор, AED гэх мэт),
- d) Үйлдвэрлэгчийн зааврын дагуу тогтмол засвар үйлчилгээ хийх. Засвар үйлчилгээний огноо, дараагийн товлосон хугацааг тэмдэглэх, гэмтэлтэй төхөөрөмжийг шошголох.
- e) Эмнэлгийн тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн заавар болон хэрэглээний онцлогт нийцүүлэн тохируулга хийх,
- f) Тоног төхөөрөмжийн эвдрэл, гэмтлийг засварлах, тоног төхөөрөмжтэй холбоотой авсан арга хэмжээ, тоног төхөөрөмжийг шинэчлэх, ашиглалтаас гаргах, солих зэрэг асуудлыг хамруулна.

Үнэлгээ хийх чиглэл:

1. Тоног төхөөрөмжийн бүртгэл
2. Засвар үйлчилгээ, хэмжилт, тохируулгын хуваарь, бүртгэл
3. Ажилтны сургалтын бүртгэл зэргийг харж үнэлгээ хийнэ.
4. Зарим тоног төхөөрөмжийг сонгон ажиллуулах зааврыг үзээд түүний дагуу эмнэлгийн мэргэжилтнээр гардан үйлдэл хийлгэж үр дүнг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт:	1	Тоног төхөөрөмжийн асуудлыг хариуцсан инженер эсвэл техникчийг гэрээгээр ажиллуулдаг.
	2	Хуваарийн дагуу техникийн үзлэг, засвар хийсэн байх
	3	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгаа, хангамж, шалгалт тохируулгад хамруулах, засвар үйлчилгээ хийлгэх төлөвлөгөөтэй байх
	4	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байх. Холбогдох стандартын дагуу тоног төхөөрөмжийн хангалтыг хувиар гаргах.
	5	Хэмжих хэрэгслүүдийг баталгаажуулсан байх. Даралтын аппарат, автоклавын манометр, термометр, жин зэрэг хэмжих хэрэгслүүд.
	6	Бүх тоног төхөөрөмжийн ашиглах болон аюулгүй ажиллагааны үйлдвэрлэгчийн заавар монгол хэл дээр байх
	7	Эмнэлгийн мэргэжилтэнд тоног төхөөрөмжийг ажиллуулах, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгдөг, сургалт хийдэг байх
	8	Тоног төхөөрөмж бүрт техник ашиглалтын паспорттай байх

БҮЛЭГ 13. МЭДЭЭЛЛИЙН УДИРДЛАГА БА ТЕХНОЛОГИ

Тойм

Мэдээллийн удирдлага ба технологи (МУТ) нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үндсэн тулгуур багана юм. Технологийг ашиглан богино хугацаанд шаардлагатай мэдээлэл авснаар, үр дүнтэй тусламж, үйлчилгээ үзүүлэх боломж бий болно. Эмнэлзүй, эмнэлгийн удирдлага зохион байгуулалт болон бусад үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг удирдах үйл явц нь МУТ-ийн гол цөм юм.

МУТ нь тусламж, үйлчилгээний үр дүнг сайжруулах боломж олгох боловч өвчтөний хувийн нууц болон мэдээллийг хэрхэн ойлгохоос хамааран алдаа гарах эрсдэл дагуулдаг. Өвчтөний мэдээллийн нууцыг хангах нь эрүүл мэндийн салбарт маш чухал. Өвчтөний хувийн болон эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг тэдний зөвшөөрөлгүйгээр задруулах нь ёс зүйн болон хууль эрх зүйн ноцтой зөрчил юм. Эрүүл мэндийн салбарт өргөнөөр нэвтэрч буй технологи нь эрүүл мэндтэй холбоотой мэдээллийн эмзэг байдал, түүнтэй холбоотой эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Эрүүл мэндийн байгууллагад өвчтөний мэдээллийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай. Түүнчлэн эмнэлгийн баримт бичигт ашигладаг товчилсон үгс чухал байдаг. Энэ нь аливаа зүйлийг буруу ойлгосноос ноцтой алдаа гарахад хүргэж болзошгүй. Энэ эрсдэлийг бууруулахын тулд ТӨВ нь үйл ажиллагаанд ашиглах товчилсон үгс, түүнийг хэрхэн ойлгох талаар жагсаалт баталж, мөрдөх ёстой. Эрүүл мэндийн салбарт телемедицин буюу зайн анагаах ухаан, хиймэл оюун ухаан, цахим бүртгэл, түүх зэрэг олон төрлийн технологи нэвтэрч байна. Хөгжил дэвшил нь өвчтөнд үзүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх боломж олгоно. Мөн өвчтөний аюулгүй байдал, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдал, мэдээллийн аюулгүй байдалд анхаарах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Шинжээч нь төвд мэдээллийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой баримт бичигтэй танилцах, өвчтөнг мөшгөх, эмнэлгийн ажилтантай ярилцах замаар үнэлгээг хийнэ. Мөн эмнэлгийн удирдлагатай энэ сэдвийн хүрээнд ярилцаж болно.

Бүлгийн зорилт:

1. Мэдээллийн удирдлагын үйл явцын үр дүнтэй байдлыг хангах
2. Мэдээллийн нууцлал болон аюулгүй байдлыг хангах
3. Өвчтөний цахим бүртгэлийн хүртээмжтэй байдлыг хангах
4. Эрүүл мэндийн мэдээллийн технологийн үр ашгийг нэмэгдүүлэх

Шалгуур нь цаасан болон цахим мэдээлэл, өгөгдөлд хамаарна.

Доорх жагсаалтад энэ бүлэгт хамаарах шалгуурыг нэгтгэн харуулав.

Үр дүнтэй мэдээллийн удирдлагын үйл явц

13.01	АШЭМБ нь хэрэгцээ, шаардлага, хууль, журамд нийцүүлэн мэдээллийн удирдлагын үйл явцыг төлөвлөж, хэрэгжүүлнэ.
13.02	АШЭМБ нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд хөтлөх баримт бичгийн хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.
13.03	АШЭМБ нь хэрэглэх тэмдэг, тэмдэглэгээ болон товчилсон үгийн стандарттай байна.
13.04	АШЭМБ нь өгөгдөл болон мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг ханган ажиллана.
13.05	Өвчтөний бичиг баримт, мэдээллийг алдах, устгах, өөрчлөх, зөвшөөрөлгүй нэвтрэх, ашиглахаас хамгаалсан байна.
13.06	Бичиг баримт, өгөгдөл, мэдээллийг холбогдох хууль тогтоомж, журамд заасан хугацаанд хадгална.
13.07	Өвчтөний цахим бүртгэлийг тусламж, үйлчилгээний үр дүнг сайжруулахад ашиглана.
13.08	АШЭМБ өвчтөний цахим бүртгэлийг үр дүнтэй ашиглана.
13.09	АШЭМБ нь өвчтөний цахим бүртгэлийг хянах үйл явцыг тодорхойлж, хэрэгжүүлнэ.
13.10	Цахим мэдээллийн технологийг нэвтрүүлэхээс өмнө үнэлж, туршина.
13.11	Мэдээллийн системийн төлөвлөгөөт болон гэнэтийн гэмтлийн үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээг туршиж, үнэлсэн байна.
13.12	Мэдээллийг хадгалах үйл явцыг тодорхойлсон байна.

ШАЛГУУР, ЗОРИЛГО, ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур 13.01

Төв нь хэрэгцээ, шаардлага, хууль, журамд нийцүүлэн мэдээллийн удирдлагын үйл явцыг төлөвлөж, хэрэгжүүлнэ.

Агуулга

Төвд цуглардаг мэдээллийг үр ашигтай удирдах үндсэн зарчмыг улсын хэмжээнд мөрдөх хууль, дүрэм, журамд тодорхойлсон байдаг. Үүнд мэдээллийн нууцлал, мэдээллийг задруулах үйл явц, баримт бичгийн хадгалах хугацаа, хяналт шалгалт болон бусад байгууллагад мэдээлэл өгөх зэрэг асуудлууд багтана. Мэдээллийн удирдлагын төлөвлөгөө нь Төвд шаардлагатай мэдээллийн төрлийг тодорхойлох, түүнтэй холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцыг зохицуулна. Төлөвлөгөө нь богино хугацаанд үнэн зөв, иж бүрэн мэдээллээр хангаснаар нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлнэ.

Төв нь мэдээллийн удирдлагатай холбоотой хууль, дүрэм журамд нийцсэн үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлнэ. Үүнд:

- a) Эмнэлзүйн болон удирдлагын мэдээллийн хэрэгцээг тодорхойлох
- b) Гадны эрх бүхий байгууллагад хүргүүлэх шаардлагатай мэдээллийг тодорхойлох
- c) Тусламж, үйлчилгээний төрөл, цар хүрээ
- d) Мэдээлэл цуглуулах шаардлагатай хугацаа
- e) Оношийн болон гардан үйлдлийн код нь удирдах байгууллага болон тусламж, үйлчилгээг худалдан авагч байгууллагын кодтой тохирч байх
- f) Ажилтнуудын ажил үүргийн хуваарь, ажил үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийн хэрэгцээний дагуу сургалтад хамруулсан байх

Үнэлгээ хийх чиглэл

- Төвийн мэдээллийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үзнэ.
- Төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх зорилгоор эмнэлгийн ажилтнуудтай ярилцаж, мэдээллийн хэрэгцээг тодорхойлсон үйл явц, хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай танилцана.
- Мэдээллийн хэрэгцээг тодорхойлох үйл явц болон хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд хяналт, шалгалтын байгууллагын зөвлөмжийг үзнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төвийн удирдлага нь мэдээллийн хэрэгцээг тодорхойлох үнэлгээг тогтмол хийнэ.
	2	Төв нь зорилгод дурдсан заалтыг (a–f заалт) бүрэн тусгасан мэдээллийн удирдлагыг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.
	3	Төв нь баримт бичиг болон мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу хадгална
	4	Төв нь эрх бүхий байгууллагаас шаардсан тайлан, мэдээллийг хугацаанд нь гаргаж өгнө
	5	Аливаа үйл явцын баримтжуулалтыг холбогдох хууль, журмын дагуу хийж гүйцэтгэдэг байна.

6	Зөрчил илэрсэн тохиолдолд хууль, журмын дагуу түүнийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.
---	--

Шалгуур 13.02

Төв нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд хөтлөх баримт бичгийн хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.

Агуулга

Төвд хөтлөх бичиг, баримтыг боловсруулах, батлах, мөрдөх, шинэчлэхэд баримтлах стандартыг тогтоох нь мэдээллийн давхардал, ойлгомжгүй байдал үүсэх, мэдээллийг буруу тайлбарлах, мэдээлэл орхигдох зэрэг эрсдэлийг бууруулна. Бичиг баримтын хяналтын тогтолцоог нэвтрүүлснээр холбогдох дүрэм, журмын талаар ажилтнуудад мэдлэг олгодог. Төв нь бичиг баримтын хяналтын тогтолцоог бүрдүүлэх үүднээс журам боловсруулж, хэрэгжүүлнэ.

Журамд дараах агуулгыг тусгана. Үүнд:

- a) Бичиг, баримт хөтлөх стандарт загвартай байх
- b) Бичиг, баримттай танилцсан болон түүнд өөрчлөлт хийснийг хянах тогтолцоог бүрдүүлэх
- c) Бичиг, баримт бүрийг түүний нэр, үүсгэсэн, өөрчилсөн хугацаа, шинэчилсэн хувилбар, хуудасны тоо, баталсан, хянасан албан тушаалтны нэрээр хайж олох боломжтой байх
- d) Баталсан журам, төлөвлөгөө, удирдамжийн дагуу холбогдох ажилтнуудыг мэдээллээр хангасан байх
- e) Ажилтнууд нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай баримт, бичгийг хайж олох талаар мэдлэгтэй байх
- f) Баримт бичгийг хэрхэн хаах талаарх мэдээлэл
- g) Журмын өөрчлөлттэй холбоотой заалт

Үнэлгээ хийх чиглэл

- Төвд баримт бичгийн стандарт формат, баталгаажуулсан албан тушаалтан, засварласан хугацаа зэргийг хянах үйл ажиллагааг зохицуулсан журам байгаа эсэхийг үзнэ.
- Холбогдох ажилтнуудтай ярилцаж, баримт бичгийг боловсруулах, батлах, хянах, засварлах үйл явцын талаар мэдлэгтэй эсэхийг шалгана.
- Эмнэлгийн ажилтнуудтай ярилцаж, шаардлагатай баримт бичгийг хайж олох, засвар орсон эсэхийг хянах, баримт бичгийг хаах зэрэг үйл явцын талаар мэдлэгтэй эсэхийг шалгана.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь агуулгад дурдсан заалт бүхий (a–g заалт) журамтай байна.
	2	Төвийн удирдах болон холбогдох албан тушаалтнууд нь журмын талаар мэдлэгтэй байна.
	3	Эмнэлгийн ажилтан өөрийн чиг үүрэгтэй холбоотой баримт бичгийг харах боломжтой байна.
	4	Бүх баримт бичгийг стандарт форматын дагуу боловсруулж, журамд заасны дагуу хянах боломжтой байна.

	5	Ажилтнууд баримт бичгийн хамгийн сүүлийн хувилбартай танилцсан байна.
	6	Журмыг гурван жил тутамд шинэчилдэг байна.

Шалгуур 13.03

Төв нь ашиглах тэмдэг, тэмдэглэгээ болон товчилсон үгийн жагсаалттай байна.

Агуулга

Тэмдэг, тэмдэглэгээ болон товчилсон үгийг цаг, зай хэмнэх зорилгоор өргөн хэрэглэдэг боловч энэ нь эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн харилцаанд үл ойлголцол үүсгэж, тусламж, үйлчилгээний эрсдэлийг нэмэгдүүлнэ. Иймд төв нь үйл ажиллагааны цар хүрээнд нийцүүлэн ашиглаж болох, ашиглаж болохгүй тэмдэг, тэмдэглэгээ, товчилсон үгийн хэрэглээний талаар журам боловсруулна. Уг журамд дараах асуудлыг тусгана. Үүнд:

- a) Ашиглаж болох тэмдэг тэмдэглэгээ, товчилсон үгийн жагсаалт.
- b) Ашиглахыг хориглосон тэмдэг, тэмдэглэгээ, товчилсон үгийн жагсаалт
- c) Гар бичмэл ашиглахыг хориглох
- d) Ашиглаж болох тэмдэг тэмдэглэгээ, товчилсон үгийн жагсаалтад багтсан ч тэдгээрийг хэрэглэхийг хориглосон тохиолдлууд, Ж: таниулсан зөвшөөрөл, үзүүлсэн тусламж, үйлчилгээний талаар өвчтөн, түүний гэр бүлд олгох бичиг баримт

Үнэлгээ хийх чиглэл

- Шинжээч нь тэмдэг, тэмдэглэгээ болон товчилсон үгийн талаар баталсан журмыг үзнэ.
- 10-аас доошгүй өвчний цахим бүртгэлийг сонгон, тэмдэг, тэмдэглэгээ болон товчилсон үгийн хэрэглээг хянаж үзнэ.
- Тэмдэг, тэмдэглэгээ болон товчилсон үг хэрэглэхийг хориглох тохиолдлын талаарх мэдлэг, ойлголтыг үнэлэх зорилгоор эмнэлгийн ажилтнуудтай ярилцлага хийнэ

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь зорилгод дурдсан заалт (a-d) бүхий батлагдсан журамтай байна.
	2	Өвчтөний цахим бүртгэлд бичилт хийдэг бүх ажилтан уг журмын талаар сургалтад хамрагдсан байна.
	3	Ашиглахыг зөвшөөрсөн тэмдэг тэмдэглэгээ, товчилсон үгийг журмын дагуу зөв хэрэглэдэг байна.
	4	Хориотой тэмдэг, тэмдэглэгээ, товчилсон үгийг хэрэглэж байгаа эсэхийг хянаж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

Шалгуур 13.04

Төв нь өгөгдөл болон мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллана.

Агуулга

Мэдээллийн аюулгүй байдал гэдэг нь мэдээлэл болон мэдээллийн системд зөвшөөрөлгүй нэвтрэх, түүнийг ашиглах, задруулах, өөрчлөх, устгах, системийн үйл ажиллагааг тасалдуулах зэргээс хамгаалах үйл ажиллагааг хэлнэ. Мэдээллийн аюулгүй байдал нь мэдээллийн нууцлал, мэдээллийн бүрэн бүтэн байдал болон хүртээмжтэй байдлыг хангах замаар хэрэгжинэ. Мэдээллийн нууцлалыг хангах гэдэгт зөвшөөрөлгүй хүнд мэдээлэл дамжуулахгүй байхыг ойлгоно. Харин мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангах гэдэг нь албан ёсны зөвшөөрөлгүйгээр мэдээллийг өөрчлөхгүй, устгахгүй байх явдал юм. Мэдээлэл хүртээмжтэй байх гэдэгт эрх бүхий ажилтан мэдээллийг ашиглах боломжтой байхыг ойлгоно.

Төв нь эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, харах эрх бүхий албан тушаалтныг тодорхой болгон, мэдээллийг өвчтөн, түүний гэр бүл, байгууллагад хэдийд, хэрхэн олгох талаар журам баталж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллана. Журамд дараах заалтыг тусгана. Үүнд:

- a) Өгөгдөл болон мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа
- b) Эмнэлгийн ажилтны хандах боломжтой өгөгдөл болон мэдээллийн төрөл
- c) Мэдээлэлд хандах боломжтой хугацаа, нөхцөл байдал
- d) Өвчтөний мэдээлэлд хандах эрх бүхий ажилтнуудтай нууцын гэрээ байгуулах
- e) Өвчтөний мэдээллийн нууцлал болон кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа
- f) Мэдээллийн нууцлал, аюулгүй байдал алдагдсан тохиолдолд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Эрүүл мэндийн ажилтан дээрх журмын агуулгыг бүрэн ойлгож, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллах хариуцлагыг ухамсарлаж байгааг баталгаажуулах үүднээс төвтэй мэдээллийн нууцын гэрээ байгуулна.

Үнэлгээ хийх чиглэл

- Шинжээч нь мэдээллийн нууцлал ба аюулгүй байдлын журам, өвчтөний мэдээлэлд нэвтрэх эрх бүхий ажилтнуудын жагсаалт, тэдэнтэй байгуулсан нууцын гэрээ зэрэг бичиг баримттай танилцана.
- Мэдээллийн нууцлалыг хангах үйл ажиллагааны хэрэгжилтийг хянана. Үүнд: өвчтөний мэдээллийг хадгалсан байршил, ажилтнуудын нэвтрэх эрх, нууц үгийн хэрэглээ, ажилтнуудын чиг үүрэгтэй холбогдолгүй мэдээлэлд нэвтрэх эрхийг хязгаарласан байдал
- Ажилтнуудтай ярилцаж, мэдээллийн нууцлалын арга хэмжээний талаарх мэдлэг, ойлголтыг нь үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь зорилгод заасан (a-f хүртэл заалт) шаардлагын дагуу мэдээллийн нууцлал ба аюулгүй байдлыг хангах журамтай байна.
	2	Ажилтнууд уг журмын талаар мэдлэгтэй байна.
	3	Өвчтөний цахим түүх, бүртгэлд нэвтрэх эрхтэй ажилтнуудын жагсаалттай байна.
	4	Зөвхөн эрх бүхий ажилтнууд өвчтөний мэдээлэлд нэвтрэх боломжтой байна.

	5	Ажилтны хувийн хэрэгт гарын үсэг бүхий нууцын гэрээг хадгална.
	6	Мэдээллийн нууцлал болон аюулгүй байдал алдагдсан тохиолдолд хэрэгжүүлэх үйл ажиллагаа хэрэгждэг байна.

Шалгуур 13.05

Өвчтөний эмнэлгийн баримт бичиг, мэдээллийг алдах, устгах, өөрчлөх, зөвшөөрөлгүй нэвтрэх, ашиглахаас хамгаалсан байна.

Агуулга

Өгөгдлийн бүрэн бүтэн байдал нь мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг илэрхийлнэ. Мэдээллийг хадгалах, сэргээх, боловсруулах явцад санаатай болон санамсаргүйгээр мэдээлэл өөрчлөгдөхийг (цахим халдлага, техникийн эвдрэл, хүний алдаа гэх мэт) өгөгдлийн бүрэн бүтэн байдал алдагдсанд тооцно. Өвчтөний мэдээлэл байнгын хамгаалалтад байх ёстой бөгөөд эрүүл мэндийн байгууллага нь үер, гал түймэр, бусад эвдрэл гэмтэл, зөвшөөрөлгүй ажилтан мэдээлэлд нэвтрэхээс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай. Мэдээллийн аюулгүй байдлын журмыг тогтмол шинэчилж, мэдээлэлд зөвшөөрөлгүйгээр нэвтрэх, түүнийг ашиглах, задруулах, өөрчлөх, устгах эрсдэлийг бууруулж ажиллана. Мэдээллийг хадгалах явцад мөн хамгаалах арга хэмжээг (нэвтрэх эрхийн хязгаарлалт, гал унтраагуур гм) хэрэгжүүлнэ.

Үнэлгээ хийх чиглэл

- Ажилтнуудтай ярилцаж, мэдээлэл алдах, устгах, өөрчлөх, зөвшөөрөлгүй нэвтрэх, ашиглахаас хамгаалах үйл явцыг үнэлнэ.
- Өвчтөний мэдээллийг хэрхэн хамгаалж байгааг үнэлнэ. Архив болон сервер байрлуулсан хэсэгт галын хор байгаа эсэхийг ажиглана.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь өвчтөний баримт бичиг, мэдээллийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.
	2	Эмнэлгийн орчин болон архив, серверийн өрөөнд мэдээллийн аюулгүй байдлыг хангана.
	3	Архивт мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.
	4	Мэдээлэл алдагдсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Шалгуур 13.06

Бичиг баримт, өгөгдөл, мэдээллийг холбогдох хууль тогтоомж, журамд заасан хугацаанд хадгална.

Агуулга

Өвчтөний түүх, баримт бичиг, мэдээлэл нь хууль журмын дагуу баримтжуулалт хийх, тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, сургалт болон эрүүл мэндийн боловсрол олгоход чухал үүрэгтэй тул Төв нь тэдгээрийг зохих хугацаанд хадгалах үүрэгтэй. Хууль эрх зүй болон хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг хадгалах хугацаа, архивлах зааврыг (өгөгдлийн формат, түүнийг шифрлэх,

хадгалах, хайх) өгөгдөл хадгалах журмаар батална. Төв нь өгөгдөл, мэдээллийг хадгалах журам боловсруулж, хэрэгжүүлнэ. Журамд дараах асуудлыг тусгана. Үүнд:

- a) Баримт бичгийн төрөл тус бүрийн хадгалах хугацаа.
- b) Хадгалах хугацааны туршид мэдээллийн нууцлалыг хангах.
- c) Архивлах шаардлагатай баримт бичгийг тодорхойлох арга.
- d) Мэдээллийг архивлах журам, хадгалах нөхцөл, өгөгдлийн формат, мэдээллийг хайх, нэвтрэх, шифрлэх арга.
- e) Өгөгдөл устгах арга.

Үнэлгээ хийх чиглэл

- Төвийн өгөгдөл, мэдээлэл хадгалах хугацааг тодорхойлсон журмыг үзнэ.
- Мэдээллийн төрлөөс хамаарч түүнийг хадгалах хугацааг ялгавартайгаар тодорхойлсон жагсаалтыг харна.
- Ажилтнуудын баримт бичгийг хадгалж, устгаж буй үйл явцыг ажиглана.
- Баримт бичгийг устгасан, архиваас хассан тухай бүртгэлтэй танилцана.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь зорилгод дурдсан шаардлага бүхий (a–e хүртэлх заалт) журамтай байна.
	2	Бүх ажилтнууд журамд заасан шаардлагын талаар мэдлэгтэй байна.
	3	Мэдээллийг хадгалах хугацаанд нууцлалыг нь хангаж ажиллана.
	4	Баримт бичгийг батлагдсан хугацаанд архивлана.
	5	Баримт бичиг, өгөгдөл, мэдээллийг холбогдох хууль тогтоомж болон журмын дагуу устгадаг, системээс хасдаг байна.
	6	Эмнэлгийн орчин болон архив, серверт мэдээллийн аюулгүй байдлыг хангана.
	7	Архивын нэгжид мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.
	8	Мэдээлэл алдагдсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Шалгуур 13.07

Өвчтөний цахим бүртгэл, түүхийг тусламж, үйлчилгээний үр дүнг сайжруулахад ашиглана.

Агуулга

Өвчтөний цахим бүртгэл, түүх нь өвчтөний мэдээллийг хурдан шуурхай харах, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, өвчтөний сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Цахим бүртгэл, түүхийг хөтлөөгүй тохиолдолд эмнэлгийн ажилтнуудын дунд өвчтөний талаар нэгдсэн мэдээлэл солилцох боломжгүй болно. Төвд хандсан, эмчлүүлсэн өвчтөн бүр өвчтөний цахим бүртгэл, түүхтэй байна. Бүртгэл, түүх нь давтагдашгүй дугаартай байна.

Цахим бүртгэл, түүхэнд орох мэдээлэл нь өвчтөн бүрт адил агуулга, дэс дараалалтай байх бөгөөд өвчний түүх болон өвчтөнд үзүүлсэн тусламж, үйлчилгээг баримтжуулах боломж олгоно. Цахим бүртгэл нь мэдээллийн хүртээмжийг сайжруулах, өвчтөнд илүү үр дүнтэй, үр ашигтай тусламж, үйлчилгээ үзүүлэхэд ач холбогдолтой.

Төв нь цахим бүртгэл, түүхтэй холбоотой журам боловсруулж, хэрэгжүүлнэ. Журамд дараах асуудлыг тусгана. Үүнд:

- a) Өвчтөний цахим бүртгэл, түүхийн удирдлага: цахим бүртгэл, түүхийг нээх, давтагдашгүй дугаар (ID) үүсгэх, цахим бүртгэл, түүхийг хөтлөх, хадгалах, шаардлагатай үед хэрэглэхэд бэлэн байлгах.
- b) Цахим бүртгэл, түүхэнд байх мэдээллийн агуулга, дараалал.
- c) Цахим бүртгэл, түүхийг ашиглах заавар.
- d) Цахим бүртгэл, түүхээс мэдээлэл олгох заавар.
- e) Их өгөгдлийн мэдээллийн удирдлага.

Үнэлгээ хийх чиглэл

- Өвчтөний цахим бүртгэл, түүхийн тухай журмыг үзнэ.
- Өвчтөн бүрийн цахим бүртгэл, түүхийн давтагдашгүй дугаар, цахим бүртгэл дахь мэдээллийн агуулга, загвар, нэвтрэх хэсэг, өөрчлөлтийн явцыг хянана.
- Эрүүл мэндийн ажилтан нь шаардлагатай үед өвчтөний цахим бүртгэл, түүхэнд нэвтэрч чадаж байгаа эсэх, доторх мэдээлэл нь хугацаандаа шинэчлэгдэж буйг ажиглана.
- Эрүүл мэндийн ажилтантай ярилцаж, өвчтөний цахим бүртгэлийн талаарх мэдлэг, ойлголтыг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь зорилгод дурдсан агуулга бүхий (a–e заалт) цахим бүртгэлийн журамтай байна.
	2	Өвчтөний цахим бүртгэл, түүхийг ашигладаг ажилтнууд уг журмыг мэддэг, мөрдөж ажилладаг байна.
	3	Өвчтөн бүр давтагдашгүй цахим дугаартай байна.
	4	Цахим бүртгэл, түүхийн мэдээллийн агуулга, загвар, нэвтрэх хэсэг нэг стандарттай байна.
	5	Цахим бүртгэл, түүхийн мэдээллийг хугацаанд нь шинэчилсэн, эрүүл мэндийн ажилтан шаардлагатай үед хугацаа алдалгүй мэдээлэл авч чадаж байгаа эсэхийг үнэлнэ.
	6	Цахим бүртгэл, түүхэнд орсон мэдээллийн өөрчлөлтийг мөшгөж үзэх боломжтой, мэдээллийн байршлыг харах боломжтой эсэхийг хянана.

Шалгуур 13.08

Төв нь өвчтөний цахим бүртгэл, түүхийг үр дүнтэй ашиглана.

Агуулга

Цахим бүртгэл, түүхийн агуулга нь өвчтөний эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн, хууль эрх зүй болон бусад журмын шаардлагыг хангасан, тусламж, үйлчилгээний чанар, тасралтгүй байдлыг хангах үүднээс иж бүрэн мэдээлэл агуулсан,

дэлгэрэнгүй байна. Төв нь өвчтөний цахим бүртгэл, түүхийн хэрэглээг зохицуулсан журам, үйл явцтай байна. Журамд дараах асуудлуудыг тусгана. Үүнд:

- a) Өвчтөний цахим түүх, бүртгэлд нэвтрэх эрхтэй ажилтнууд.
- b) Өвчтөний цахим түүх, бүртгэлд нэвтэрсэн ажилтны нэр, хугацааг тодорхойлох боломжтой байх.
- c) Цахим бүртгэлийн мэдээллийг засварлах аргачлал тодорхой байх.
- d) Их өгөгдлийн удирдлагын асуудлыг тусгасан байх.

Үнэлгээ хийх чиглэл

- Өвчтөний цахим түүх, бүртгэлийн хэрэглээг зохицуулсан журамтай танилцана.
- Эмнэлгийн ажилтнуудтай ярилцаж, өвчтөний цахим түүх, бүртгэлийн хэрэглээний талаарх мэдлэг, ойлголтыг үнэлнэ.
- Өвчтөний цахим түүх, бүртгэлийн хэрэглээний явцыг ажиглаж болно.

Хэмжих үзүүлэлт	1	Төв нь зорилгод (а–с заалт) дурдсан агуулга бүхий журам, үйл явцтай байна.
	2	Эмнэлгийн ажилтнууд журмын талаар мэдлэгтэй байна.
	3	Зөвхөн эрх бүхий ажилтнууд өвчтөний цахим түүх, бүртгэлд нэвтэрдэг байна.
	4	Өвчтөний цахим түүх, бүртгэлд нэвтэрсэн хүний нэр, хугацаа нь тодорхой, оруулсан мэдээлэл нь хууль, журамд нийцсэн байна.

Шалгуур 13.09

Төв нь өвчтөний цахим түүх, бүртгэлийг хянах үйл явцыг тодорхойлж, хэрэгжүүлнэ.

Агуулга

Цахим түүх, бүртгэлд буй мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэд, эмнэлзүйн хувьд ач холбогдолтой, цаг хугацаандаа шинэчлэгдэж, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад чиглэх ёстой. Мөн цахим түүх, бүртгэлтэй холбоотой асуудал гарсан тохиолдолд засч залруулах арга хэмжээг төлөвлөх шаардлагатай. ТӨВ нь өвчтөний цахим түүх, бүртгэлийг хянах журмыг боловсруулж, хэрэгжүүлнэ. Журамд дараах асуудлуудыг тусгасан байна. Үүнд:

- a) Тусламж, үйлчилгээг бүхэлд нь төлөөлөх чадвартай тусламж, үйлчилгээг сонгож, хяналт хийх.
- b) Бүх мэргэжлийн чиглэлээр хяналт хийх.
- c) Цахим түүх, бүртгэлд нэвтэрч буй эмнэлгийн ажилтны мэргэжлийн чиглэл бүрийн төлөөллийг хяналт хийх үйл явцад оролцуулах.
- d) Цахим түүх, бүртгэл дэх мэдээлэл иж бүрэн, ойлгомжтой байгаа эсэхэд хяналт тавих.
- e) Хяналтыг улирал тутам хийх.
- f) Санамсаргүй түүврийн аргаар өвчтөний цахим түүх, бүртгэлийн 5%-ийг сонгон хянах.

Үнэлгээ хийх чиглэл

- Өвчтөний цахим түүх, бүртгэлийг хянах журмыг үзнэ.

<ul style="list-style-type: none"> • Өвчтөний цахим түүх, бүртгэлийг хянах үйл явцын талаар ажилтнуудын мэдлэг, ойлголтыг үнэлэх зорилгоор тэдэнтэй ярилцана. • Өвчтөний цахим түүх, бүртгэлийн хяналтын үр дүн, түүнийг сайжруулах зорилгоор хэрэгжүүлсэн арга хэмжээг үнэлнэ. 		
Хэмжих үзүүлэлт	1	Төв нь зорилгод (a–f заалт) дурдсан агуулга бүхий журамтай байна.
	2	Өвчтөний цахим түүх, бүртгэлийг ашигладаг ажилтнууд журмын талаар мэддэг, мөрдөж ажилладаг байна.
	3	Хяналтын үр дүнг төвийн удирдлагад тайлагнасан байна.
	4	Шаардлагатай тохиолдолд өвчтөний цахим түүх, бүртгэлийн хяналтыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Шалгуур 13.10

Цахим мэдээллийн технологийг нэвтрүүлэхээс өмнө үнэлж, туршина.

Агуулга

Эрүүл мэндийн мэдээллийн технологи нь эмнэлгийн ажилтны ажлыг хөнгөвчлөх, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах боломжийг бүрдүүлдэг. Мэдээллийн технологийг сонгож, нэвтрүүлэхэд оролцогч талуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа чухал бөгөөд тухайн технологийн бусад үйл ажиллагаатай уялдаатай ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг. Технологийг нэвтрүүлсний дараа түүний ашиглалт, үр нөлөө, үр ашиг, мөн өвчтөний аюулгүй байдалд үзүүлэх нөлөөг үнэлэх ёстой.

Үнэлгээ хийх чиглэл

- Ажилтнуудын мэдээллийн технологийн системийг сонгох, нэвтрүүлэх, үнэлэх үйл явцын талаарх мэдлэг, ойлголтыг тодруулах зорилгоор тэдэнтэй ярилцана.
- Мэдээллийн технологийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор холбогдох баримт бичиг, системийн үнэлгээний үр дүнтэй танилцана.

Хэмжих үзүүлэлт	1	Эрүүл мэндийн мэдээллийн технологийн оролцогч талууд нь технологийг сонгох, нэвтрүүлэх, үнэлэх үйл явцад оролцоно.
	2	Эрүүл мэндийн мэдээллийн технологийн системийг хэрэгжүүлэхээс өмнө үнэлж, туршсан байна.
	3	Эрүүл мэндийн мэдээллийн технологийг нэвтрүүлсний дараа ашиглахад хялбар байгаа эсэх, түүний үр нөлөө, ялангуяа өвчтөний аюулгүй байдалд үзүүлэх нөлөөг үнэлсэн байна.
	4	Зөрчил илэрсэн тохиолдолд залруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Шалгуур 13.11

Мэдээллийн системийн төлөвлөгөөт засвар үйлчилгээ болон гэнэтийн гэмтлийн үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээг туршиж, үнэлсэн байна.

Агуулга

Мэдээллийн системийн гэмтэл гэдэг нь эрүүл мэндийн мэдээллийн технологийн систем, компьютерыг ашиглах боломжгүй болох эсвэл түүнийг төлөвлөгөөт журмаар таслахыг хэлнэ. Гэмтэл нь системийн засвар үйлчилгээ, шинэчлэл хийх зорилгоор төлөвлөгөөт байхаас гадна гэнэтийн эвдрэл, гэмтлээс шалтгаалдаг. Энэ үед тусламж, үйлчилгээний аюулгүй байдалд ноцтой эрсдэл үүсэх ба мэс засал тасалдах, мэдээлэл алдагдах эрсдэл үүснэ.

Төв нь мэдээллийн системийн төлөвлөгөөт засвар үйлчилгээ болон гэнэтийн гэмтлийн үед тусламж, үйлчилгээний аюулгүй, тасралтгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ. Үүнд: мэдээллийн цаасан маягт болон бусад нөөц эх үүсвэрийг ашиглах шийдэл, гэмтлийн дараах сэргээн засварлах үйл явц зэргийг тусгана. Эмнэлгийн ажилтнууд нь мэдээллийн системийн гэнэтийн гэмтлийн үед тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлэх ур чадвар олгох сургалтад хамрагдсан байна.

Үнэлгээ хийх чиглэл

- Мэдээллийн системийн төлөвлөгөөт засвар үйлчилгээ болон гэнэтийн гэмтлийн үед хэрэгжүүлэх арга хэмжээний журмыг хянаж, хэрэгжилтийг дараах баримтуудаар шалгаж болно. Үүнд засвар үйлчилгээ болон гэнэтийн гэмтлийн үеийн ажлын урсгал, ажлын заавар, орлуулан ашиглах маягтын нөөц, үйл ажиллагааг жил бүр туршиж, үнэлгээ хийсэн үр дүн.
- Эмнэлгийн ажилтнуудтай ярилцаж, төлөвлөгөөт болон гэнэтийн гэмтлийн үед авах арга хэмжээний талаарх тэдний мэдлэг, ойлголтыг үнэлнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Төлөвлөгөөт засвар үйлчилгээ болон гэнэтийн гэмтлийн үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулсан байна
	2	Төлөвлөгөөнд гэмтлийн дараах сэргээн засварлах үйл явцыг тусгана.
	3	Ажилтнууд нь мэдээллийн системийн гэмтлийн үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу сургалтад хамрагдсан байна.
	4	Төв нь төлөвлөгөөний үр дүнтэй байдлыг хангах зорилгоор жилд нэгээс доошгүй удаа туршиж, үнэлсэн байна.

Шалгуур 13.12

Мэдээллийг хадгалах үйл явцыг тодорхойлсон байна.

Агуулга

Мэдээллийг хадгалах гэдэг нь мэдээлэл алдагдсан тохиолдолд анхны өгөгдлийг сэргээх зорилгоор түүний хуулбарыг анхдагч эх үүсвэрээс өөр байршилд хадгалах үйл явцыг хэлнэ. Мэдээллийг хамгаалах зорилгоор түүнийг хадгалах зайлшгүй шаардлагатай бөгөөд өгөгдөл алдагдахаас урьдчилан сэргийлж, тогтмол хугацаанд архивлана. Архивыг байгууллагын дотор эсвэл гадна хадгалах ба хадгалах явцад мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, зөвхөн эрх бүхий ажилтан ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

Үнэлгээ хийх чиглэл

- Мэдээллийг архивлах үйл явцын талаар холбогдох ажилтнаас асуух, хэрэгжилтийн үйл явцыг шалгах замаар үнэлгээг хийнэ.

Хэмжих үзүүлэлт	1	Архивт хадгалах мэдээллийн төрөл, архивд мэдээлэл шилжүүлэх давтамж, архивын байршлыг тодорхойлсон үйл явцтай байна.
	2	Мэдээллийг архивлах хугацааг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн тогтсон хуваарийн дагуу хийж, гүйцэтгэнэ.
	3	Шинээр нэвтрүүлж буй мэдээллийн системийг архивлах хуваарь гаргаж, өгөгдлийг сэргээх үйл ажиллагааг туршиж үзсэн байна.
	4	Архивын мэдээллийг хайх, дамжуулах, хадгалах, сэргээх зэрэг бүх шатанд аюулгүй байдлыг хангана.
	5	Архивын бүртгэлийг тогтмол хянаж, алдаа илэрвэл, засч залруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.